

ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР

СУДАЛГААНЫ ТАЙЛАН 5



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНЦЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН



ТӨВИЙН БҮСИЙН ГОВИЙН ДЭД БҮСИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ, БАЙРШЛЫН БОДЛОГЫН СУДАЛГАА



ЭЦСИЙН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2019

Эрүүл мэндийн судлаачдын баг:

Зөвлөх – Батмөнхийн Цэцэгсайхан, Анагаах Ухааны доктор (ОХУ), Эрүүл мэндийн удирдлага, нийгмийн эрүүл мэндийн магистр (Австрали), Хавдрын Үндэсний Зөвлөлийн гүйцэтгэх захирал

Судлаач – Аюурзанын Өнөржаргал, Эрүүл Мэндийн Удирдлагын магистр (Япон), Эрүүл мэндийн яамны мэргэжилтэн

Энэхүү тайланд захиалагч болон санхүүжүүлэгчийн байр суурийг биш, харин судлаачдын байр суурийг илэрхийлсэн болно.

Агуулга

Талархал

Товчилсон үгийн жагсаалт

Хүснэгтийн жагсаалт

Зургийн жагсаалт

Хураангуй

Судалгааны зорилго, зорилт, арга аргачлал

Бүлэг 1. Эрүүл мэндийн салбарын хөгжлийн өнөөгийн байдал

Эрүүл мэндийн салбарын хөгжлийн олон улсын чиг хандлага

Эрүүл мэндийн салбарын SWOT, PESTEL дүн шинжилгээ

Эрүүл мэндийн салбарын хөгжлийн өнөөгийн байдал

Үндэсний түвшинд

Бүсийн түвшинд

Аймгийн түвшинд

Бүлэг 2. Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүй ба бодлогын харилцан хамаарлын шинжилгээ

Дүгнэлт

Санал, зөвлөмж

Ашигласан материал

Хавсралт 1-14

Талархал

Энэхүү судалгааг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн Үндэсний Хөгжлийн Газар, Оюу Толгой ХХК, МУИС-ийн Эдийн засгийн хүрээлэн, Эрүүл мэндийн яам, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь амйгуудын эрүүл мэндийн газар, бодлогын зөвлөмж өгсөн бусад судлаач, эрдэмтэд, мэргэжилтнүүдэд талархал илэрхийлье.

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЭЛЭН

Товчилсон үгийн жагсаалт

БЗДХ – Бэлгийн замаар дамжих халдвар

ДЭМБ – Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага

ДОХ – Дархлалын Олдмолын Хамшинж

ЗГ – Засгийн Газар

ЗГХЭГ – Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар

ИТХ – Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

МХЗ – Мянганы Хөгжлийн Зорилт

НҮБ – Нэгдсэн Үндэсний Байгууллага

ТХЗ – Тогтвортой Хөгжлийн Зорилт

ХДХВ – Хүний Дархлал Хомсдлын Вирус

УИХ – Улсын Их Хурал

ЭМ – Эрүүл мэнд

ЭМТ – Эрүүл мэндийн төв

СЭМТ – Сумын эрүүл мэндийн төв

SWOT - Strength, Weakness, Opportunity, Threat

PESTELI – Political, Economic, Socio-cultural, Environmental, Legal, Industrial

WHO – World Health Organization

GIS – Geographic Information System

Хүснэгтийн жагсаалт

1. SWOT дүн шинжилгээ
2. PESTELI дүн шинжилгээ
3. Зүрх судасны тогтолцооны өвчин, 2007-2017
4. Орон нутгийн хөгжлийн индекс доторх эрүүл мэндийн индексийн үзүүлэлтүүд
5. Эрүүл мэндийн үзүүлэлтийн матрикс
6. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг аймгийн дундажтай харьцуулсан байдал

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН

Зургийн жагсаалт

1. ДЭМБ-ын 6 тулгуур бүрэлдэхүүн хэсэг
2. Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1000 амьд төрөлтөнд, 2007-2017
3. Эхийн эндэгдэл, 100000 амьд төрөлтөнд, 2008-2017
4. Сүрьеэгийн өвчлөл, нас баралтын түвшин, 100000 хүн амд, 2007-2017
5. Эрүүл мэндийн салбарын зардал, 2000-2017
6. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд хөдөө орон нутгаас ирж эмчлүүлэгчдийн эзлэх хувь, 2017
7. Эрүүл мэндийн салбарын хүний нөөц, 2012-2017
8. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал, шатлалаар, хувиар, 2017 он
9. Аймгийн эрүүл мэндийн индекс, бүсээр
10. Эрүүл мэндийн үзүүлэлтийн матрикс, аймгаар
11. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн сумдын эрүүл мэндийн индекс, эрүүл мэндийн байгууллагын байршил
12. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийн харьцуулалт
13. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийн харьцуулалт - хүний нөөц
14. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийн харьцуулалт – тогтвортой хөгжлийн зорилтод туссан шалгуур үзүүлэлтүүд
15. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийн харьцуулалт – зонхилон тохиолдох өвчлөл
16. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийн харьцуулалт – тусламж үйлчилгээний үзүүлэлтүүд
17. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийн харьцуулалт – тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд

Хураангуй

Монгол улсын эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлогыг эрүүл мэндийн салбарын бодлоготой уялдуулан, асуудлыг улс үндэсний (олон улсын түвшинд), бүсийн, төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн түвшинд харьцуулан судалж, шийдвэрлэх хувилбаруудыг тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг Өмнийн говийн Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудыг хамруулан хийлээ. Судалгаанд эрүүл мэндийн салбарын одоо мөрдөгдөж буй хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, уялдаж буй байдал, бодлогын хэрэгжилтийн үйл явцад үүссэн, шийдэх шаардлагатай асуудлыг тодорхойлох, задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх, харьцуулалт хийх /synopse/ зэрэг судалгааны аргыг ашигласан болно. Түүнчлэн, эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлыг ДЭМБ-ын суурь 6 блокийн дагуу тодорхойлох, Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 1-р сарын 24-ний өдрийн 20-р тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн индекс тодорхойлох” аргачлалын дагуу дараах 6 үзүүлэлтүүдийг тооцоолж, олон улсад ашиглагддаг Data Envelopment Analysis аргатай харьцуулах, эрүүл мэндийн салбарт урт, дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай арга хэмжээ, тэдгээрийн үр ашиг, хэтийн нөлөөллийг SWOT, PESTELI аргуудаар үнэлэх, үндэсний түвшинд эрүүл мэндийн 6 бүлэг 29 суурь үзүүлэлт, Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн хувьд 6 бүлэг 35 үзүүлэлтийг сүүлийн 22 жилийн дунджаар тооцоолох, Монгол улсын “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого”-ын атласт тусгах Өмнийн говийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын зураглалыг газар зүйн байршлын GIS систем ашиглан боловсруулах зэрэг аргачлалуудыг ашиглалаа.

Монгол Улс “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030”-ийн “Эрүүл мэндийн чанартай хүртээмжтэй тогтолцоо” бүлэгт эрүүл мэндийн чиглэлээр 4 үндсэн зорилтын хүрээнд 9 шалгуур үзүүлэлт тусгасныг НҮБ-аас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилтод эрүүл мэндийн чиглэлээр 9 үндсэн зорилттой 70 орчим шалгууртай харьцуулж үзэхэд дараах асуудлууд тусгагдаагүй байна. Үүнд: ХДХВ, халдварт болон халдварт бус өвчин, хорт зуршил, архи, тамхи, орчны эрүүл мэнд, осол гэмтэл г.м. Мөн, эрүүл мэндийн тогтолцоо, тусламж хүртээмжийн талаар зорилт дэвшүүлэн, эрүүл мэндийн даатгал, урьдчилан сэргийлэлт, илрүүлэг, тандалтын талаар тусгасан нь сайшаалтай ч, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой тусгаагүй байна. **Эрүүл мэндийн тухай хууль болон Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуульд** 2014 онд нэмэлт өөрчлөлт орсон боловч хуулийн хэрэгжилт өнөөг хүртэл хангалтгүй байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулинд сум дундын эмнэлэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв-ийн нэр томъёо байхгүй, бүсчилсэн хөгжлийн асуудал огт тусгагдаагүй байна.

Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 2016-2020, Нийгэм эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд Эрүүл мэндийн салбарын, ялангуяа урт хугацааны бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа бага тусгагдсан бөгөөд гол төлөв тоног төхөөрөмж, байрилга байгууламжийн хөрөнгө оруулалт давамгайлж байна.

Өнөөгийн байдлаар эрүүл мэндийн салбарт үндэсний, салбарын болон салбар хоорондын түвшинд урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр нийт 16 хууль, 6 бодлогын бичиг баримт, 12 үндэсний хөтөлбөр, 100 гаруй стандарт, дүрэм, журам мөрдөгдөж байна. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгцээ, шаардлагын үндэслэл, тооцоо, судалгаа нь хангалттай түвшинд хийгдэж, санхүүгийн эх үүсвэртэй зохистой түвшинд уялдаагүй, хэрэгжих хугацаа, зорилго, зорилт давхацсан, хоорондын уялдаа сул байна. Энэ нь бодлогын хэрэгжилт хүсэн хүлээсэн үр дүнд хүрэхэд эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгааг харуулж байна. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгуудад эрүүл мэндийн чиглэлээр үндэсний түвшний 20, бүсийн түвшний 1, аймгийн түвшний 27, сумын

Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа

түвшний 49 бодлогын баримт бичиг хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Бүх аймгууд Засаг даргын мөрийн хөтөлбөртэй, Дорноговь, Өмнөговь аймгууд дэд хөтөлбөртэй, Говьсүмбэр, Дундговь аймагт бие даасан дэд хөтөлбөрүүд байхгүй, бөгөөд 3 аймагт тодорхой байршил заагаагүй, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд тодорхой бус байна.

Эрүүл мэндийн салбарын өнөөгийн нөхцөл байдлын хувьд эрүүл мэндийн тэгш бус байдал, хүрээлэн буй орчны бохирдол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар зэрэг нь бүс нутгийн хувьд маш ялгаатай, олон асуудлууд тулгамдсан, өнөөгийн тусламж үйлчилгээ нь хүн амын хэрэгцээтэй нийцэхгүй хэвээр байна. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хангалтгүй, халдварт болон халдварт бус өвчний өндөр байна. Хүний нөөцийн хуваарилалтад тэнцвэргүй байдал ажиглагдаж байна. Эмч ба сувилагчийн харьцаа (1:1.2) нь ихэнх орнуудаас өндөр байгаа бөгөөд эмнэлгийн 1 оронд ногдох эмнэлгийн мэргэжилтний тоо хот, хөдөөд зөрүүтэй байна. Санхүүжилтийн болон нөөц хуваарилалтын одоогийн тогтолцоо нь тусламж үйлчилгээний тэгш байдал болон хүртээмжид сөргөөр нөлөөлж байна. Эрүүл мэндийн 29 үзүүлэлт бүхий матриц аргаар үнэлгээ хийхэд төв, хангайн бүсийн аймгуудын (Архангай, Булган, Хөвсгөл, Өмнөговь, Баянхонгор, Төв, Өвөрхангай, Увс, Дорноговь) эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тэргүүний ээлжинд анхаарах шаардлагатай байна.

Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 (Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь) аймгийг эрүүл мэндийн 6 бүлэг 35 үзүүлэлтээр үнэлэхэд эдгээр үзүүлэлтийн 23 нь 1996 – 2017 оныг дуустал буюу 22 жилээр, 8 үзүүлэлт нь 11- 20 жилээр, 4 үзүүлэлт нь 1-3 жилээр байна. Эдгээр матрикс үзүүлэлтийг дээрх хугацааны аймгийн дундаж үзүүлэлттэй харьцуулан үзэхэд Говьсүмбэр аймгийн үзүүлэлтүүдийн 58%, Дорноговь аймгийн 65%, Дундговь аймгийн 20%, Өмнөговь аймгийн 71% нь аймгийн дунджаас доогуур үзүүлэлттэй гарсан.

Орны тоо, вируст гепатитын өвчлөлийн үзүүлэлт нь эдгээр 4 аймагт бүгдэд нь улсын дунджаас өндөр байна. Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудад үндсэн оношийн зөрүү, 10000 хүн амд ногдох хүн амын өвчлөл, амьсгалын тогтолцоо, хоол боловсруулах тогтолцоо, зүрх судасны өвчлөл, гадны шалтгаант нас баралт, үр хөндөлт зэрэг нь улсын дунджаас өндөр байна. 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл Өмнөговь аймагт 83,2 буюу аймгийн дунджаас 21,8-аар илүү, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 34,1 байгаа нь нь цаашид анхаарах асуудлын нэг мөн байна. Говьсүмбэр аймагт их эмчийн тоо, үндсэн оношийн зөрүү аймгийн дунджаас өндөр, 10 000 хүн амд ногдох орны тоо аймгийн дунджаас бараг 2 дахин өндөр байна.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд дундаж наслалтын хувьд Дорноговь аймаг (70.6), 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин Өмнөговь аймаг (76,9), 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд Дундговь (15,9), Өмнөговь аймаг (20), нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд Өмнөговь аймаг (16.1), зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт Говьсүмбэр (18.6), Дундговь (21.7), Өмнөговь аймаг (18.6), хорт хавдраас шалтгаалсан нас баралт баралт Говьсүмбэр (15.1), Дорноговь (12.3), Дундговь (14.4), 10 000 хүн амд вируст сүрьеэгийн өвчлөл Говьсүмбэр аймаг (16.3) байгаа нь 2016-2020 онд дэвшүүлсэн зорилтод хүрээгүй байна. 100,000 хүн амд ногдох сэргийлж болох нас баралтын үзүүлэлтээр Өмнөговь аймагт хамгийн өндөр буюу 321,9, Дундговь аймагт 312,2, Говь сүмбэр аймагт 208, Дорноговь аймагт 205,7 байсан нь Улаанбаатар хотын дундажтай (226,2) харьцуулахад тусламж үйлчилгээний чанар ихээхэн ялгаатай байгааг харуулж байна. Эмнэлгийн үр дүнтэй тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлж чадсан тохиолдолд сэргийлж болох нас баралтын дийлэнх хувийг зүрх судасны тогтолцооны өвчин дангаараа эзэлж байна.

Судалгааны зорилго, зорилт, арга аргачлал

Үндэслэл

“Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д Монгол хүний эрүүл урт удаан амьдрах нөхцлийг хангаж, дундаж наслалтыг 78-д хүргэн, 1) урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгах, 2) нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулах, 3) зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулах, 4) халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакциныг хүн бүрт хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулах зорилтыг дэвшүүлсэн байна.

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг 2001 онд баталсан бөгөөд одоогийн Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, олон улсын харилцаа тухайн үеийн нөхцөл байдлаас ихээхэн өөрчлөгдөөд байна. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд үндэслэн боловсруулсан Монгол Улсын баруун, хангайн, төвийн, зүүн, Улаанбаатарын бүсийн хөгжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжих хугацаа (нэгдүгээр үе шат – 2006 – 2010 он, хоёрдугаар шат – 2011 – 2015 он) дууссан.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийг Дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр, “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030”, Засгийн Газрын 2016 – 2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдуулан Өмнийн говийн 4 аймгийн эрүүл мэндийн салбарын хөгжил байршлын нэгдсэн төлөвлөлт, зураглалыг боловсруулах, Монгол улсын “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах” бодлого, Өмнийн говийн хөгжлийн хөтөлбөр, говийн 4 аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгах шаардлагатай байна.

Судалгааны ажлын зорилго

Судалгааны зорилго нь Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн (Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь) эрүүл мэндийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, учир шалтгааныг илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлж, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах” бодлого, Төвийн бүсийн говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөр, говийн 4 аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгах болно.

Судалгааны зорилтууд

1. Бүсчилсэн хөгжлийн болон эрүүл мэндийн салбарын одоо мөрдөгдөж буй хууль тогтоомж, говийн бүсийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, уялдаа холбоонд дүн шинжилгээ хийх,
2. Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлох, нэгдсэн дүгнэлт өгөх
3. Бодлогын өөрчлөлт хийх боломжит хувилбаруудыг тодорхойлох, тэдгээрийн үр ашиг, хэтийн нөлөөллийг тооцоолох, урьдчилан үнэлэх

4. Шийдвэрлэх арга зам, бодлого төлөвлөлтийн оновчтой хувилбарыг тодорхойлох, хөгжил, байршлын зураглал боловсруулах

Судалгааны хамрах хүрээ

Монгол улсын эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлогыг эрүүл мэндийн салбарын бодлоготой уялдуулан, асуудлыг улс үндэсний (олон улсын түвшинд), бүсийн, төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн түвшинд харьцуулан судалж, шийдвэрлэх хувилбаруудыг тодорхойлно. Энэхүү судалгаа нь газар зүйн нутаг дэвсгэрийн хувьд Говийн дэд бүсийн Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудыг хамарна.

Судалгааны арга зүй, аргачлал

Судалгааг хоорондоо харилцан уялдаатай бодлогын судалгаа, бодлогын шинжилгээ гэсэн 2 үе шаттайгаар хийнэ. Бодлогын судалгаа нь “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 4-т заасан “нөхцөл байдлын дүн шинжилгээ”-г, бодлогын шинжилгээ нь журмын 5-д заасан “нөлөөллийн урьдчилсан үнэлгээ”-г хийхэд тус тус чиглэгдэнэ.

1. Эрүүл мэндийн салбарын одоо мөрдөгдөж буй хууль, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, уялдаж буй байдал, бодлогын хэрэгжилтийн үйл явцад үүссэн, шийдэх шаардлагатай асуудлыг тодорхойлох, задлан шинжлэх ба нэгтгэн дүгнэх, харьцуулалт хийх /synopse/ зэрэг судалгааны аргыг ашиглана.
2. Эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлыг ДЭМБ-ын суурь 6 блокийн дагуу (WHO, 6 building blocks of health system) тодорхойлно.
3. Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 1-р сарын 24-ний өдрийн 20-р тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн индекс тодорхойлох” аргачлалын дагуу дараах 6 үзүүлэлтүүдийг тооцоолж, олон улсад ашиглагддаг Data Envelopment Analysis аргатай харьцуулна¹².
4. Эрүүл мэндийн салбарт урт, дунд хугацаанд тулгамдаж байгаа зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай арга хэмжээ, тэдгээрийн үр ашиг, хэтийн нөлөөллийг SWOT, PESTEL аргуудаар үнэлнэ.
5. Үндэсний түвшинд эрүүл мэндийн 6 бүлэг 29 суурь үзүүлэлт, Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн хувьд 6 бүлэг 35 үзүүлэлтийг сүүлийн 22 жилийн дунджаар тооцоолно.
6. Монгол улсын “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого”-ын атласт тусгах Өмнийн говийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын зураглалыг газар зүйн байршлын GIS систем ашиглан боловсруулна.

¹ *Procedia Economics and Finance 10 (2014)*

² *Health Economics Reveiw 2018*

Бүлэг 1. Эрүүл мэндийн салбарын хөгжлийн өнөөгийн байдал**Эрүүл мэндийн салбарын хөгжлийн олон улсын чиг хандлага**

ДЭМБ-ын 191 гишүүн орнуудын эрүүл мэндийн салбарын үр ашигтай байдлыг чанартай, тэгш хүртээмжтэй тусламж үйлчилгээ, санхүүжилтийн тогтолцоо зэргээр үнэлж харьцуулсан судалгаагаар манай улс дэлхийд 145-р байранд орсон бөгөөд үр ашгийн индекс нь 0,2-0,36 буюу үр ашиг багатай орнуудын тоонд орж байсан^{3 4}.

Дэлхий дахинаа эрүүл мэндийн салбарт дараах зарчмуудыг баримталж байна. Үүнд:

Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх

Олон улсад анхан шатны тусламж үйлчилгээ эрүүл мэндийн салбарын цөм, тулгуур нь байдаг. Эрүүл мэндийн салбарын зардлаа хянаж, үр ашгийг нэмэгдүүлэх нэг арга нь анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх, зөв зохион байгуулах замаар өндөр өртөг бүхий II, III шатлалын эмнэлгийн тусламж, үйлчилгээг багасгах, шаардлагагүй эмнэлэгт хандалтыг бууруулах гэж үздэг⁵.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг түлхүү хөгжүүлэх зарчим

Нийгмийн эрүүл мэндийн гол зарчим бол олон салбарын хамтын ажиллагаа, энгийн хялбар технологи болон орон нутгийн нөөц боломжийг ашиглах, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх асуудал бөгөөд хүн амын ундны ус, хүнсний хангамж болон зохистой хооллолтыг сайжруулах, тэднийг эрүүл мэндийн талаар өөрийгөө зөв авч явах мэдлэг, хандлага, дадлагатай болгох, халдварт өвчнөөс сэргийлэх тарилганд зохих насны хүн амыг өргөн хамруулах, эх нялхсын эрүүл мэндийг хамгаалан, гэр бүл төлөвлөлтийг зохицуулах, нутагшмал өвчин эмгэгтэй тэмцэх, зонхилон тохиолдох өвчин гэмтлийг оношлон эмчлэх, нэн чухал эмээр хангах зэрэг үйл ажиллагаануудыг анхан шатны тусламжийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг гэж авч үздэг.

Бүх нийтийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулах зарчим

Дэлхий нийтээрээ эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд бүх нийтийг хамруулах боломжийг бүрдүүлэхээр зорьж байна. НҮБ-ын гишүүн 193 орон 2015 онд Тогтвортой хөгжлийн зорилт /ТХЗ/-ууд дээр санал нэгдсэн бөгөөд 2030 он гэхэд илүү аюулгүй, тэгш, эрүүл дэлхийг бий болгох өндөр түвшний зорилтуудыг тавьсан билээ. Энэхүү зорилт нь олон салбарыг хамарсан өргөн хүрээтэй ба бидний зорьж буй илүү эрүүл дэлхийг бүтээхэд гол чиглүүлэгч нь болох юм. ТХЗ-ын 3.8 дах заалт нь Бүх нийтийн эрүүл мэндийн хамралт бөгөөд хүн бүр чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хэрэгцээтэй үедээ, хаана амьдарч байгаагаас үл хамааран, санхүүгийн хүндрэлгүйгээр авах боломжтой байхыг хэлнэ⁶.

Монгол Улсын эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдлын судалгааг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас зөвлөмж болгодог 6 тулгуур бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд авч үзлээ. Үүнд:


³ World Health Organization, GPE Discussion Paper Series: No.30, 2000

⁴ Health systems around the world – a comparison of existing health system rankings

⁵ https://www.who.int/publications/almaata_declaration_en.pdf

⁶ <https://unstats.un.org/sdgs/report/2016/leaving-no-one-behind>

Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа



Зураг 1. ДЭМБ-ын 6 тулгуур бүрэлдэхүүн хэсэг

Эрүүл мэндийн салбарын SWOT, PESTEL дүн шинжилгээ

Хүснэгт 1. SWOT дүн шинжилгээ

<p>Давуу тал</p> <p>3 шатлалтай систем Дэд бүтэц сайн хөгжсөн ДЭМБ-ын гишүүн орон Гадаад хамтын ажиллагаа сайн Тогтвортой санхүүжилтийн тогтолцоо Эрүүл мэндийн даатгалын хамралт сайтай Өндөр чадамжтай боловсон хүчин Хангалттай тооны эмч Эрүүл мэндийн зарим үзүүлэлтүүд дунджаас дээгүүр Уламжлалт анагаах ухаан</p>	<p>Боломж</p> <p>Хөрөнгө оруулалт, зээл тусламж Эдийн засгийн өсөлт Нарийн мэргэжлийн эмч нар Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын бие даасан байдал Технологийн хөгжил Төвлөрлийг сааруулах Урамшууллын механизм Санхүүжилтийн нөөц, хуваарилалт Өндөр технологийн хөгжил Эм зүйн удирдлагын тогтолцоотой мэдээллийн систем бүхий эм ханган нийлүүлэх тогтолцоо</p>
<p>Сул тал</p> <p>ДНБ-д эзлэх эрүүл мэндийн зардлын хэмжээ бага Шаардлагагүй хэвтэлт Хэвтэн эмчлүүлэх хугацаа урт Эмнэлгүүдийн ачаалал их Хяналт, үнэлгээний тогтолцоо сул Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зохион байгуулалт хангалтгүй Засаглал, хяналт, хариуцлагын тогтолцоо сул Санхүүжилтийн тогтолцоо нэгдмэл бус, саланги Тусламж үйлчилгээний удирдлага, чанарын тогтолцоо сул Эмнэлгийн барилга байгууламж муу Шаардлагагүй худалдан авалт</p>	<p>Аюул занал</p> <p>Мэдээллийн системийн аюулгүй байдал Эрүүл мэндийн ажилтнуудын тогтвор суурьшилгүй байдал Нийтийг хамарсан халдварт өвчин, байгалийн гамшиг, эрсдэл Орчны бохирдол Хүнсний аюулгүй байдал Ядуурал, ажилгүйдэл, инфляц Нийгмийн хариуцлага</p>

Эрүүл мэндийн салбарын PESTEL дүн шинжилгээ

Хүснэгт 2. PESTEL дүн шинжилгээ

Political Улс төр	Эрүүл мэндийн салбарын хууль дүрэм, журам тогтмол өөрчлөгддөг Эмнэлгийн ажилчдын цалин хөлс, нийгмийн асуудалтай холбоотой суулт, ажил хаялт Эм хангамжийн нэгдсэн бодлого Улс төрчдийн лобби, нөлөөлөл Татварын хууль Эрүүл мэндийн даатгалын удирдлага зохион байгуулалт
Economic Эдийн засаг	Инфляц, хүүгийн өөрчлөлтийн хөрөнгө оруулалтад үзүүлж буй нөлөөлөл Ажилгүйдэл Эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулахад шаардлагатай хөрөнгө оруулалт
Socio cultural Нийгэм соёл	Хүн ам зүй 2025 он гэхэд насжилтын асуудал тавигдаж эхэлнэ, 0-14 насны хүүхэд зонхилж байна Үргүйдэл Жендерийн асуудал Нийгмийн үзэл бодол, үнэт зүйл – эрүүл мэндийн салбарт илтгэх итгэл буурсан
Technology Технологи	Технологийн хөгжил дэвшил бага нэвтэрсэн Эмчилгээний шинэ аргууд удаан нэвтэрч байгаа Шинэ тоног төхөөрөмжийн хангамж хангалтгүй Интернетийн хэрэглээ эмч болон үйлчлүүлэгчийн амьд харилцааг багасгаж байна
Legal Хууль	Хууль дүрмийн хэрэгжилт хангалтгүй
Environment Байгаль орчин	“Ногоон” хөгжлийн асуудал орхигдсон Байгаль орчинд ээлтэй барилга байгууламжийн асуудал хангалтгүй

Эрүүл мэндийн салбарын хөгжлийн өнөөгийн байдал

Үндэсний түвшинд

Эрүүл мэндийн салбарын өнөөгийн тусламж үйлчилгээ нь хүн амын хэрэгцээтэй нийцэхгүй, бүсчлэн хөгжүүлэх боломж хязгаарлагдмал байна. Олон улсад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үр дүнг үнэлэхэд хүн амын дундаж наслалт, эх хүүхэд, 15-59 насны хүн амын эндэгдэл, өвчлөлийн үзүүлэлтийг ашигладаг.

Манай улсын хувь эрэгтэйчүүдийн дундаж наслалт 65,88, эмэгтэйчүүдийнх 75,44, дэлхийн дунджаас хоёр дахин их насны зөрүүтэй байгаа нь монгол эрчүүдийн цаг бус эндэгдлийн түвшин дэлхийд өндөрт тооцогдож буйтай холбоотой⁷. Монгол улсын 15 буюу түүнээс дээш насны 1000 эрэгтэй тутмын 490 нь 60 нас хүрэлгүй цаг бусаар эндэж байгаа нь эмэгтэйчүүдээс 2,5 дахин их⁸ бөгөөд нас баралтын 2/3 нь осол гэмтэл, хорт хавдрын шалтгаантай байна. Дэлхий нийтэд 15-59 насны буюу залуу, хөдөлмөрийн насны хүн амыг харьцангуй эрүүл гэж үздэг. Манай улсын хувьд, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал сайнгүй байна. Монгол улс насанд хүрсэн эмэгтэйчүүдийн нас баралтын үзүүлэлтийн хувьд ижил түвшний улс орнуудтай, харин насанд

⁷ Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгааны тайлан, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага, 2016

хүрсэн эрэгтэйчүүдийн нас баралтын үзүүлэлтийн хувьд хүний хөгжлөөр муу улс орнуудын түшинд байна⁹.

Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 оноос хойшхи 20 жилийн хугацаанд эрчимтэй буурч байгаагийн илрэл нь 1 000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2017 онд 1990 оны түвшинтэй харьцуулахад 5.2 дахин ба нялхсын эндэгдэл 4.7 дахин тус тус буурсан нь МХЗ-т хүрсэн томоохон үр дүнд тооцогдож байна. Гэсэн хэдий ч, хүүхдийн эндэгдлийн үзүүлэлтэд хот, хөдөөгийн болон баян ядуугийн ялгаа их байна¹⁰.



Зураг 2. Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1 000 амьд төрөлтөд, 2008-2017

Эхийн эрүүл мэндийн хувьд 2015 онд Монгол улс эхийн эндэгдлийн түвшинг 100 000 амьд төрөлтөд 26 хүртэл бууруулж чадсанаар эхийн эндэгдлийг бууруулах Мянганы хөгжлийн зорилтод хүрсэн дэлхийн 9 орны нэг болж, эхийн эндэгдэл өндөр орноос эхийн эндэгдэл дунд зэрэгтэй орны түвшинд хүрсэн. Энэ нь 1990 оноос хойш эхийн эндэгдлийг 4.6 дахин буюу 75¹¹ хувиар бууруулсан сайн үзүүлэлт байсан хэдий ч 2016 онд эхийн эндэгдэл огцом өсч, 2017 онд буцаж 2015 оны түвшин рүү хүрсэн нь тусламж үйлчилгээний чанар хангалтгүй түвшинд байгааг илтгэж байна¹².


⁹ Эрүүл мэндийн үзүүлэлт - 2017

¹⁰ ЭМЯ, НҮБ-ын ХАС, 2018

¹¹ Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн баримтын хуудас, ЭМЯ, НҮБ-ын ХАС, 2018

¹² Эх яагаад эндэв судалгаа, ЭМЯ, НҮБ-ын ХАС, 2016

Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа



Зураг 3. Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд, 2008-2017

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хангалтгүй, **халдварт болон халдварт бус өвчний тархалт (double burden of disease)** өндөр байна. Насанд хүрсэн 10 хүн тутмын 8 нь зүрх судасны эмгэг, хорт хавдар, осол гэмтлийн улмаас нас барж, энэ нь халдварт өвчин, эхийн болон нялхсын эндэгдлээс шалтгаалсан нас баралтаас 16 дахин өндөр үзүүлэлт байна¹³.

Хүснэгт 3. Зүрх судасны тогтолцооны өвчин, 2007-2017

Үзүүлэлт	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2020
Зүрх-судасны тогтолцооны өвчин												
Нийт	21.92	20.54	21.74	23.61	22.58	20.91	19.60	19.11	18.86	17.45	17.45	17.4 ^е
Эрэгтэй	25.21	22.02	24.19	27.33	26.65	25.02	22.70	22.10	21.66	20.54	21.06	-
Эмэгтэй	18.80	18.76	19.41	20.29	18.73	17.04	16.70	16.20	15.40	14.46	13.97	-

Ихэнх халдварт бус өвчин нь архи, тамхины хэрэглээ, эрүүл бус хоол хүнс, хөдөлгөөний хомсдол зэрэг эрсдэлт хүчин зүйлтэй шууд холбоотой. 2013 оны “Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын шаталсан судалгаа”-гаар 15-64 насны нийт хүн амын 27 хувь, эрэгтэйчүүдийн тал орчим хувь нь тамхи хэрэглэдэг, нийт хүн амын 66 хувь нь сүүлийн 1 жилд согтууруулах ундаа хэрэглэсэн, 1 удаад хэрэглэх хэмжээ нь 2009 оны түвшингээс нэмэгдсэн эрсдэлтэй бөгөөд 2 хүн тутмын нэг нь илүүдэл жинтэй, 5 хүн тутмын нэг нь таргалалттай, хүн амын 96% нь жимс, ногоог хоногт хэрэглэх хэмжээнээс бага хэрэглэдэг байна¹⁴. Тогтвортой хөгжлийн зорилгод зааснаар 2020 он гэхэд 10 000 хүн амд сүрьеэгийн өвчлөлийг 14,4 болгож бууруулах зорилт тавьсан байдаг бол 2017 оны байдлаар энэ үзүүлэлт 12,4 байсан байна¹⁵.

¹³ Эрүүл мэндийн салбар 2012, Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын жил, Эрүүл мэндийн яам, 2013

¹⁴ Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын гуравдугаар судалгаа – 2013


¹⁵ Эрүүл мэндийн статистик үзүүлэлт - 2017

Сүүлийн 5 жилийн байдлаар жилд дунджаар 4000 гаруй сүрьеэгийн шинэ тохиолдол бүртгэгдэж байна^{16,17}.



Зураг 4. Сүрьеэгийн өвчлөл, нас баралтын түвшин, 10000 хүн амд, 2007-2017 он

Семашко загварын эрүүл мэндийн тогтолцоо бүхий орнуудын адилаар, манай эрүүл мэндийн салбарт эмнэлэгт суурилсан тогтолцоо зонхилж байна¹⁸. 2005 онд салбарын нийт зардлын 53,5%, 2009 онд 54,8%, нь хэвтүүлэн эмчлэх зардал зарцуулагддаг байсан¹⁹ бөгөөд дөнгөж 6 хувь нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зарцуулагддаг нь олон улсаас зөвлөмж болгодог 30%-иас доошгүй хувьд хүргэх зорилтоос 5 дахин бага үзүүлэлт юм²⁰. Санхүүжилтийн болон нөөц хуваарилалтын одоогийн тогтолцоо нь тусламж үйлчилгээний тэгш байдал болон хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.



Зураг 5. Эрүүл мэндийн салбарын зардал, 2000 - 2017 он

Анхан шатны тусламж үйлчилгээний чанар төдийлөн сайн биш, зохицуулалт сул, хамралт хангалтгүй байгаатай холбоотой шаардлагагүй хэвтэлт их байна. Дундаж ор хоног ихэнх орнуудаас өндөр (9-с дээш) байгаа нь эмчилгээний арга барил үр дүн, үр ашиг муутай, амбулаторийн эмчилгээ үйлчилгээ (өдрийн мэс засал, өдрийн эмчилгээ) дутагдалтай, нийгмийн

¹⁶ Монгол улс дахь сүрьеэгийн тархалтын анхын судалгааны тайлан 2014-2015, 2016

¹⁷ Сүрьеэгийн тандалтын тайлан мэдээний эмхэтгэл 2012-2016, 2017


¹⁸ The Mongolian health system at a crossroads an incomplete transition to a Post-Semashko model Paper, 2007

¹⁹ Mongolia Health System Review, WHO, 2013

²⁰ Нийгмийн эрүүл мэндийн төлөв байдал, 2000-2010, 2011

Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа


шалтгааны улмаас эмнэлэгт хэвтэх шаардлага өндөр, хүн тээврийн тогтолцоо муу, эмнэлэгт хэвтэх хандлага байсаар байгаа зэрэг хүчин зүйлүүдээс хамаарч байна²¹.



Зураг 6. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдэд хөдөө орон нутгаас ирж эмчлүүлэгчдийн эзлэх хувь, 2017 он

Бүсийн оношилгоо, эмчилгээний төв болон эмнэлэг хоорондын тусламж үйлчилгээний зохион байгуулалт хангалтгүй, эмнэлгүүд нарийн мэргэшсэн маягийн загвартай байгаа байгаа нь тусламж үйлчилгээний чанар үр ашигт сөргөөр нөлөөлж байна. Орон нутгийн өвчтний урсгалын талаар тоо, баримт байхгүй байгаа тул орон нутаг дах эмнэлгийн сүлжээний бүтэц, зохион байгуулалтыг зохистой болгож, нөөцийг үр ашигтай зарцуулдаг болгохын тулд эмнэлгийн тусламж, үйлчилгээний хуваарилалт, бүсчлэлийг дахин хянаж, өөрчлөх хэрэгтэй.

Хүний нөөцийн хуваарилалтад тэнцвэргүй байдал ажиглагдаж байна. Эмч ба сувилагчийн харьцаа (1:1.1) нь ихэнх орнуудаас өндөр байгаа бөгөөд эмнэлгийн 1 оронд ногдох эмнэлгийн мэргэжилтний тоо хот, хөдөөд зөрүүтэй байна²².



Зураг 7. Эрүүл мэндийн салбарын хүний нөөц, 2012-2017 он

Манай улсад аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүд нь үйлчлүүлэгчдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах эхний цэг болж байгаа нь анхан шатны тусламж үйлчилгээ хангалтгүй түвшинд байгааг харуулж байна. Харьцангуй хөнгөн өвчтэй үйлчлүүлэгчид өртөг өндөртэй лавлагаа эмнэлэгт эмчлүүлж, мэргэшсэн боловсон хүчний цагийг шаардлагагүй зүйлд үрж, энэ нь нэг өвчтөнд зарцуулах

²¹ Эмнэлгийн тусламж үйлчилгээний бодлогын дүн шинжилгээ, 2011

²² Эрүүл мэндийн үзүүлэлтүүд - 2017

Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа

цагийг багасган, үйлчлүүлэгчдийн бухимдлыг бий болгож, эцэстээ тусламж үйлчилгээний чанар, үр ашигт сөргөөр нөлөөлж байна²³.



Зураг 8. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардал, шатлалаар, хувиар, 2017 он

Нэг хэвтэн эмчлүүлэгчид ногдох зардлын хувьд хоёрдогч ба гуравдагч шатлалын эмнэлгүүдийн хооронд ялгаа байхгүй байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгт нэг хэвтэн эмчлүүлэгчид ногдох зардал нь лавлагаа тусламж үйлчилгээ үзүүлдэг гуравдагч шатлалын эмнэлэгтэй ойролцоо зардалтай байна²⁴.

Үйлчлүүлэгчид шаардлагагүй оношилгоо эмчилгээ хийх нь манай улсын эрүүл мэндийн салбарт төдийгүй, дэлхийн бусад улс оронд нэн тулгамдсан асуудал болж байна. Эрүүл мэндийн салбарт урьдчилан сэргийлэлт, эмчилгээ оношилгооны арга, технологийн үр дүн, үр ашгийг судалж, тэдгээрийг практикт нэвтрүүлэх эсэх, нэгэнт нэвтэрсэн аргыг үргэлжлүүлэн ашиглах эсэхийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоодог ажиллагаа ихээхэн дутагдалтай байна.

Нийт хэвтэлтийн 30-40 хувь нь шаардлагагүй буюу анхан шатны байгууллагад, эсвэл амбулаторид шийдвэрлэх боломжтой тохиолдлууд байсан гэж Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэй хэрэгжсэн Эрүүл мэндийн салбар хөгжил хөтөлбөр-3 төслийн зөвлөхүүд дүгнэсэн байна. Эмнэлгийн дотоод болон эмнэлэг хоорондын тусламж үйлчилгээний зохион байгуулалт хангалтгүй байгаа нь тусламж үйлчилгээний чанар, үр ашигт сөргөөр нөлөөлж байна. Шаардлагагүй тусламж үйлчилгээний томоохон сөрөг үр дагавар нь эрүүл мэндийн салбар болон хувь хүнд санхүүгийн асар их дарамт учруулдаг тул цаашид зайлсхийвэл зохих эмчилгээ, оношилгооны арга технологийн жагсаалтыг гаргаж, салбарт нэвтрүүлэх нь зүйтэй.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж буй нэг асуудал бол эмнэлгүүдийн хоорондын уялдаа холбоо юм. Хэдийгээр, өвчтөн шилжүүлэх тогтолцоотой боловч үр дүн муутай байна²⁵. Анхан болон хоёрдогч шатлалд эмчлэх боломжтой тохиолдлуудыг дараагийн шатлалд шилжүүлдэг, олон тооны өвчтөн анхан шатыг алгасдаг нь статистик үзүүлэлтээс харагдаж байна. 2011 оны судалгаагаар гуравдагч шатлалын эмнэлэгт шилжин ирсэн өвчтөний 34,3% нь анхан шатнаас, 47,3% нь хоёрдогч шатлалаас ирсэн ба 89% нь тухайн шатлалд ирэх шаардлагагүй тохиолдол байсан байна²⁶.

²³ Эмнэлгийн тусламж үйлчилгээний бодлогын дүн шинжилгээ, 2011

²⁴ Эрүүл мэндийн салбар 2012, Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын жил, Эрүүл мэндийн яам, 2013

²⁵ Эмнэлгийн тусламж үйлчилгээний бодлогын дүн шинжилгээ, 2011

²⁶ Сумын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ирээдүй, 2009

Эрүүл мэндийн 29 үзүүлэлт бүхий матрикс аргаар үнэлгээ хийхэд төв, хангайн бүсийн аймгуудын (Архангай, Булган, Хөвсгөл, Өмнөговь, Баянхонгор, Төв, Өвөрхангай, Увс, Дорноговь) эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тэргүүний ээлжинд анхаарах шаардлагатай байна.

Сэргийлж болох нас баралт: Эрүүл мэндийн үр дүнтэй тусламжийг цаг алдалгүй үзүүлсэн тохиолдолд гаргахгүй байж болох эндэгдлийг тусламж үйлчилгээний чанарын шалгуур болгож олон оронд ашигладаг. Манай улсын аймгууд хүн амын ерөнхий өвчлөл, нийгэм эдийн засгийн байдлын хувьд харьцангуй ижил төстэй байдаг хэдий ч, эмнэлгийн үр дүнтэй тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлж чадсан нөхцөлд сэргийлж болох нас баралтын түвшин асар их ялгаатай байна. Энэ нь эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах талаар аймгуудад нэг нэгнээсээ суралцах зүйл их байгааг харуулж байна²⁷.

Эмнэлгийн үр дүнтэй тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлж чадсан нөхцөлд сэргийлж болох нас баралтын дийлэнх буюу 85 хувийг зүрх судасны тогтолцооны өвчин дангаараа эзэлж байна. Нас баралтын шалтгаан тус бүрээр аймгуудыг харьцуулахад асар их ялгаатай байдал ажиглагдаж байна. Тухайлбал, сүрьеэгийн шалтгаант нас баралт Дархан Уул болон Улаанбаатар хотод улсын дунджаас 2 дахин өндөр, хорт хавдрын шалтгаант нас баралт Дархан Уул, Говьсүмбэр, Завхан аймагт, харин зүрх судасны тогтолцооны эмгэгийн шалтгаант нас баралт Хөвсгөл, Дундговь, Өвөрхангай аймагт хамгийн их байна. Түүнчлэн дотоод шүүрэл, бодисын солилцооны эмгэгийн оношилгоо эмчилгээг Орхон, Өмнөговь, Сүхбаатар аймагт, эпилепсийн тусламж үйлчилгээг Сүхбаатар, Төв, Өмнөговь аймагт, багтраа өвчний тусламж үйлчилгээг Баянхонгор, Хэнтий, Өмнөговь аймагт, ходоод, дээд гэдэсний шархлааны оношилгоо, эмчилгээг Завхан, Баянхонгор, Баян Өлгий аймагт, хэвлийн хөндийн цочмог үрэвсэлт өвчний оношилгоо эмчилгээг Хэнтий, Завхан, Дорнод аймагт, шээс бэлгийн замын тогтолцооны эмгэгийн тусламж үйлчилгээг Өмнөговь, Говь-Алтай, Баян Өлгий аймагт, цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажгийн оношилгоо эмчилгээг Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь аймагт сайжруулах шаардлагатай байна²⁸.

Бүсийн түвшинд

Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 1-р сарын 24-ний өдрийн 20-р тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн индекс тодорхойлох” аргачлалын дагуу дараах 6 үзүүлэлтүүдийг тооцоолж, олон улсад ашиглагддаг Data Envelopment Analysis аргатай харьцуулж үнэлсэн болно.

Хүснэгт 4. Орон нутгийн хөгжлийн индекс доторх эрүүл мэндийн индексийн үзүүлэлтүүд

Эрүүл мэнд	Эмнэлгийн барилгын чанар
	Нэг их эмчид ногдох хүний тоо
	Нэг сувилагчид ногдох хүний тоо
	10000 хүнд ногдох зүрх судасны тогтолцооны өвчнөөр нас барсан хүний тоо
	10000 хүнд ногдох хавдараар нас барсан хүний тоо
	0-4 насны хүн амын нас баралтын дундаж түвшин


²⁷ Эрүүл мэндийн салбар 2012, Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын жил, Эрүүл мэндийн яам, 2013

²⁸ Эрүүл мэндийн салбар 2012, Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын жил, Эрүүл мэндийн яам, 2013

Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа

Аймгийн индексийг эдгээр 6 үзүүлэлтээр үнэлэхэд Баян-Өлгий, Булган, Дархан Уул, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Ховд, Хөвсгөл аймгууд 0,7-оос бага үзүүлэлттэй байлаа.

Аймгийн эрүүл мэндийн индексийг бүсчлэн тооцоолоход баруун бүс – 0,7149, төвийн бүс – 0,7281, зүүн бүс – 0,7184 гарч, харин хангайн бүс – 0,6807 байлаа. Энэ үзүүлэлтээс харахад бүсийн ялгаа төдийлөн байхгүй байсан бөгөөд сумын эрүүл мэндийн индексийн үзүүлэлт 0,6-аас багатай сумууд хангайн бүсэд зонхилж байлаа.



Зураг 9. Аймгийн эрүүл мэндийн индекс, бүсээр

Эрүүл мэндийн салбарын үзүүлэлтүүдийн матриц

Эрүүл мэндийн салбарын үнэлгээнд үндсэн үзүүлэлт 3, хүний нөөцийн үзүүлэлт 3, эрүүл мэндийн үзүүлэлт(сүүлийн гурван жилийн дунджаар) 7, санхүүжилтийн үзүүлэлт 3, эмнэлгийн тусламж үйлчилгээний үзүүлэлт 6, өвчлөлийн үзүүлэлт 7, нийт 29 үзүүлэлтийг ашигласан. Эдгээр үзүүлэлтээс 8 үзүүлэлт нь Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын шалгуур үзүүлэлт бөгөөд эрүүл мэндтэй холбоотой бүх үзүүлэлтийг энэхүү үнэлгээнд ашигласан болно.


Хүснэгт 5. Эрүүл мэндийн үзүүлэлтийн матриц

Үндсэн үзүүлэлт	ЭМ-ийн индекс
	Хүн амын тоо
	Дундаж наслалт*
Хүний нөөц /3 жилийн дундаж/	Их эмчийн тоо, 10 000 хүн амд
	Сувилагчийн тоо, 10 000 хүн амд
	Эмч сувилагчийн харьцаа
Эрүүл мэндийн үзүүлэлт /3 жилийн дундаж/	Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд*
	Нялхсын эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд*
	1000 хүнд ногдох нас баралт
	Хүн амын өвчлөл, 10 000 хүн амд
	Хорт хавдар, 10 000 хүн амд*
	Зүрх судасны өвчлөл, 10 000 хүн амд*
	Осол гэмтэл, 10 000 хүн амд
Орны фонд ашиглалтын хувь	

Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа

Санхүүжилтийн үзүүлэлт	Орны тоо, 10 000 хүн амд
	Нэг хүнд ногдох санхүүжилт, 2017 он
Эмнэлгийн тусламж үйлчилгээний үзүүлэлт	Стационарт хэвтэн эмчлүүлэгчид, 10 000 хүн амд /3 жилийн дундаж/
	Амбулаторт бүртгэгдсэн хүн амын өвчлөл, 10 000 хүн амд /3 жилийн дундаж/
	Эмнэлгийн тусламжгүй төрсөн хүний тоо/5 жил нийлбэр/
	Үндсэн оношийн зөрүү/5 жилийн дундаж/
	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгийн хувь, 2017 он
	Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, 2017 он
Өвчлөлийн үзүүлэлт /3 жилийн дундаж/	Вируст гепатитын өвчлөл, 10000 хүн амд*
	Сүрьеэгийн тохиолдол, 10000 хүн амд*
	Амьсгалын тогтолцооны өвчин, 10 000 хүн амд
	Хоол боловсруулах тогтолцооны өвчин, 10 000 хүн амд
	Шээс бэлгийн тогтолцооны эмгэг, 10 000 хүн амд
	Зүрх-судасны тогтолцооны өвчин, 10 000 хүн амд
	Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан, 10 000 хүн амд

Эрүүл мэндийн 29 үзүүлэлт бүхий матрикс аргаар үнэлгээ хийхэд Архангай -19, Булган-17, Өмнөговь-17, Хөвсгөл-16, Баянхонгор-16, Төв-15, Дорноговь-15, Өвөрхангай-14, Увс-14 үзүүлэлтээр дунджаас доогуур байсан бөгөөд төв, хангайн бүсийн аймгуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хангалтгүй байгааг илтгэж байна.



Зураг 10. Эрүүл мэндийн үзүүлэлтийн матрикс, аймгаар

Аймгийн түвшинд

Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийг (Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь) эрүүл мэндийн 6 бүлэг 35 үзүүлэлтээр үнэлсэн. Эдгээр үзүүлэлтийн 23 нь 1996 – 2017 оныг дуустал буюу 22 жилээр, 8 үзүүлэлт нь 11- 20 жилээр, 4 үзүүлэлт нь 1-3 жилээр байна^{29 30}. Эдгээр үзүүлэлтийн матрицыг дээрх хугацааны аймгийн дундаж үзүүлэлттэй харьцуулан үзэхэд Говьсүмбэр аймгийн эдгээр 35 үзүүлэлтүүдийн 58%, Дорноговь аймгийн 65%, Дундговь аймгийн 20%, Өмнөговь аймгийн 71% нь аймгийн дунджаас доогуур үзүүлэлттэй гарсан байна. Орны тоо, вирүст гепатитын өвчлөлийн үзүүлэлт нь эдгээр 4 аймагт бүгдэд нь улсын дунджаас өндөр байна.

Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудад үндсэн оношийн зөрүү, 10 000 хүн амд ногдох хүн амын өвчлөл, амьсгалын тогтолцоо, хоол боловсруулах тогтолцоо, зүрх судасны өвчлөл, гадны шалтгаант нас баралт, үр хөндөлт зэрэг нь улсын дунджаас өндөр байна. 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл Өмнөговь аймагт 83,2 буюу аймгийн дунджаас 21,8-аар илүү, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 34,1 байгаа нь нь цаашид анхаарах асуудлын нэг мөн байна.

Говьсүмбэр аймагт их эмчийн тоо, үндсэн оношийн зөрүү аймгийн дунджаас өндөр, 10 000 хүн амд ногдох орны тоо аймгийн дунджаас бараг 2 дахин өндөр байна.

Сэргийлж болох нас баралт нь тухайн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээг үр дүнтэй, цаг алдалгүй үзүүлж чадаж буйг харуулдаг үзүүлэлт бөгөөд 10 бүлэг өвчнийг авч үздэг. Эдгээр үзүүлэлтийг 100,000 хүн амд авч үзэхэд Өмнөговь аймагт хамгийн өндөр буюу 321,9, Дундговь аймагт 312,2, Говь сүмбэр аймагт 208, Дорноговь аймагт 205,7 байсан нь Улаанбаатар хотын дундажтай (226,2) харьцуулахад тусламж үйлчилгээний чанар ихээхэн ялгаатай байгааг харуулж байна. Эмнэлгийн үр дүнтэй тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлж чадсан тохиолдолд сэргийлж болох нас баралтын дийлэнх хувийг зүрх судасны тогтолцооны өвчин дангаараа эзэлж байна³¹.

2005 онд хийгдсэн “Монгол улсын булгийн чанарын усны эрүүл ахуйн үнэлгээ”³²-гээр эдгээр 4 аймгийн булгийн усны 40-80% нь гадаргын усны цэврийн зэргийн ангиллаар 3-5 зэрэгт үнэлэгдсэн нь унд, ахуйн усны шаардлага хангахгүй гэсэн дүгнэлт гарч байжээ. 2009 онд хийгдсэн “Өрхийн усны чанар, ариун цэвэр, эрүүл ахуйн талаарх хүн амын мэдлэг, дадал, хандлагыг үнэлэх судалгаа”-нд³³ зөвхөн Дундговь аймгийн өрхүүдийн 34,8% нь долоо хоногт 3-4 удаа усаа авдаг, 7,2% нь ундны усыг огт буцалгаж хэрэглэдэггүй байсан ба 44,2% нь ус уудаггүй, 39,5% нь усыг буцалгаж хэрэглэхгүйгээр сурчихсан гэсэн өгүүлэмжтэй байсан. Бие засах газар, бохир усны нүхний үнэлгээгээр 69% муу үнэлэгдсэн нь өрхүүдийн ариун цэврийн байгууламжийн хүрэлцээ, ашиглалт, эрүүл ахуйн шаардлага хангасан байдал хангалтгүй байгааг илтгэж байна.

²⁹ Эрүүл мэндийн үзүүлэлт 2007-2017

³⁰ Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл 1996 – 2015, 2016

³¹ Эрүүл мэндийн салбар 2012. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын жил, 2013

³² Монгол улсын булгийн чанарын усны эрүүл ахуйн үнэлгээ, 2005

³³ Өрхийн усны чанар, ариун цэвэр, эрүүл ахуйн талаарх хүн амын мэдлэг, дадал, хандлагыг үнэлэх судалгаа, 2009

Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа

Хүснэгт 6. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг аймгийн дундажтай харьцуулсан байдал

№	Бүлэг	Үзүүлэлтүүд	Говьсүмбэр	Дорноговь	Дундговь	Өмнөговь	Аймгийн дундаж	
1	Үндсэн	ЭМ-ийн индекс /3 жилийн дундаж/	0.855	0.722	0.761	0.764	0.7	
2	Үзүүлэлт	Хүн амын тоо /22 жилийн дундаж/	13459.8	56169.5	45503.9	55345.0	0.0	
3		Дундаж наслалт* /20 жилийн дундаж/	69.1	66.5	69.9	68.3	66.7	
4		1000 хүнд ногдох төрөлт /22 жилийн дундаж/	24.0	20.9	20.2	22.4	21.6	
5		1000 хүнд ногдох цэвэр өсөлт /22 жилийн дундаж/	18.4	15.0	14.7	16.4	15.9	
6		Их эмчийн тоо, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	30.3	28.2	21.0	20.9	18.6	
7	Хүний нөөц	Сувилагчийн тоо, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	38.5	30.8	31.0	25.6	28.5	
8		Эмч сувилагчийн харьцаа /22 жилийн дундаж/	1:1.3	1:1.1	1:1.5	1:1.3	1:1.5	
9		Эрүүл мэндийн үзүүлэлт	Эжийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд /15 жилийн дундаж/	55.5	22.2	38.3	83.2	61.4
10		1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1 000 амьд төрөлтөд* /22 жилийн дундаж/	19.3	23.7	19.7	27.3	24.3	
11		5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, 1 000 амьд төрөлтөд* /22 жилийн дундаж/	26.8	31.0	25.9	34.1	31.9	
12		1000 хүнд ногдох нас баралт /22 жилийн дундаж/	5.6	5.8	5.9	5.9	5.7	
13		Санхүүжилт	Орны фонд ашиглалтын хувь /22 жилийн дундаж/	88.6	78.8	76.5	67.0	82.4
14			Орны тоо, 10 000 хүн амд/22 жилийн дундаж/	121.3	75.0	68.9	65.2	64.7
15	Нэг хүнд ногдох санхүүжилт, 2017 он		261161	193120	209570	161777	181768.0	
16	Эмнэлгийн тусламж үйлчилгээний үзүүлэлт	Стационарт хэвтэн эмчлүүлэгчид, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	3032.9	2334.2	2070.3	1976.9	2091.5	
17		Амбулаторт бүртгэгдсэн хүн амын өвчлөл, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	7295.6	6035.5	3985.1	6227.3	5102.2	
18		Нийт төрөлтөд эмнэлгийн тусламжгүй төрсөн хүний эзлэх хувь /22 жилийн дундаж/	0.1	0.2	0.2	0.2	0.2	
19	Хүн амын өвчлөл, 10 000 хүн амд/11 жилийн дундаж/	Үндсэн оношгийн зөрүү /22 жилийн дундаж/	6.6	6.8	4.6	7.0	5.3	
20		Хүн амын өвчлөл, 10 000 хүн амд/11 жилийн дундаж/	8356.8	7165.5	5018.2	8123.1	6315.0	
21		Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгийн хувь,		54.3	70.0		35.2	50.4

Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа

	2017 он	27.4							
22	Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, /13 жилийн дундаж/	94.3	93.7	91.7	92.2	82.9			
23	Жирэмсний эхний 3 сартайд хяналтанд авсан жирэмсэн эмэгтэйчүүд, 1000-д /22 жилийн дундаж/	71.5	82.2	83.3	75.7	78.7			
24	Вируст гепатитын өвчлөл, 10000 хүн амд /15 жилийн дундаж/	26.8	25.6	23.8	27.3	21.9			
25	Сүрьеэгийн тохиолдол, 10000 хүн амд /11 жилийн дундаж/	15.7	13.8	5.3	4.7	15.3			
26	Амьсгалын тогтолцооны өвчин, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	2098	1380.1	812.7	1677.8	1120.7			
27	Хоол боловсруулах тогтолцооны өвчин, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	1168.2	1026.3	736.6	1053.9	849.0			
28	Шээс бэлгийн тогтолцооны эмгэг, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	995.4	796.2	637.2	669.5	733.7			
29	Хорт хавдар, 10 000 хүн амд* /22 жилийн дундаж/	12.5	17.6	17.4	18.8	22.3			
30	Зүрх судасны өвчлөл, 10 000 хүн амд* /22 жилийн дундаж/	824.6	630.5	512.4	690.6	627.9			
31	Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан, 10 000 хүн амд /15 жилийн дундаж/	456.2	340.9	133.0	306.3	209.7			
32	Халдварт ба шимэгчит зарим өвчин, 10 000 хүн амд /20 жилийн дундаж/	166.5	156.9	100.3	95.0	125.9			
33	Үр хөндөлт 1000 амьд төрөлтөд, /22 жилийн дундаж/	136.3	245.7	66.9	254.4	124.3			
34	Мэс заслын хүндрэлийн хувь /22 жилийн дундаж/	0.1	0.4	0.6	0.4	0.5			
35	Сэргийлж болох нас баралт, 10 000 хүн амд, 2011 он	208.0	205.7	312.2	321.9	226.2			
	Аймгийн дунджаас доогуур үзүүлэлтийн тоо, хувь^{34,35}	18 (58%)	20 (65%)	7 (23%)	22 (71%)				


³⁴ Эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2007-2017

³⁵ Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 1996-2015, 2016

Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа




Зураг 11. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн сумдын эрүүл мэндийн индекс, эрүүл мэндийн байгууллагын байршил



Зураг 12. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн эрүүл мэндийн үндсэн үзүүлэлтүүдийн матрикс

Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа



Зураг 13. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн эрүүл мэндийн үзүүлэлтийн харьцуулалт – хүний нөөц



Зураг 14. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн эрүүл мэндийн үзүүлэлтийн харьцуулалт – ТХЗ-д туссан шалгуур үзүүлэлтүүд


Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа



Зураг 15. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн эрүүл мэндийн үзүүлэлтийн харьцуулалт – зонхилон тохиолдох өвчлөл



Зураг 16. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн эрүүл мэндийн үзүүлэлтийн харьцуулалт – тусламж үйлчилгээний үзүүлэлтүүд



Зураг 17. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн эрүүл мэндийн үзүүлэлтийн харьцуулалт – тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтүүд

Бүлэг 2. Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүй ба бодлогын харилцан хамаарлын шинжилгээ

Дэлхийн Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд гарсан 2030 он хүртэлх³⁶ Тогтвортой хөгжлийн зорилтуудын гол цөм нь хүн буюу XXI-р зуунд хөгжлийг хүнээс салгах боломжгүйг хүлээн зөвшөөрч бүх бодлогын цөм нь хүн байхаар тунхагласан байна. Хүн бүрт нийгмийн гарал үүслээс үл хамааран тэгш, хүртээмжтэй, ижил чанартай эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл орчинд өсч хөгжих боломж олгох нь нэн чухал асуудал болсон юм.

УИХ-аар 2016 оны 1 сард батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль, УИХ-ын 2016 оны 2-р сарын 5-ны өдрийн тогтоолоор батлагдсан Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2016-2030 зэргийг бүх салбарын бодлогод тусгах үүднээс бодлогын баримт бичгийг үнэлэх, нөхцөл байдлыг үнэлэх нь ач холбогдолтой юм.

Монгол улсын хувьд эрүүл мэндийн тэгш бус байдал, хүрээлэн буй орчны бохирдол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар зэрэг нь бүс нутгийн хувьд маш ялгаатай, олон асуудлууд тулгамдсан хэвээр байгаа бөгөөд тэдгээрийг бодлогын хүрээнд шийдвэрлэхэд анхаарах, тодорхой шийдлүүдийг олох нь хамгийн чухал байна.

Өнөөгийн байдлаар эрүүл мэндийн салбарт үндэсний, салбарын болон салбар хоорондын түвшинд урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр нийт 16 хууль, 5 бодлогын бичиг баримт, 11 үндэсний хөтөлбөр, 100 гаруй стандарт, дүрэм, журам мөрдөгдөж байна. Эдгээр бодлогын баримт бичгүүд нь үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, үндсэн чиглэл, төлөвлөгөө зэрэг нэршилтэй байна. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгцээ, шаардлагын үндэслэл, тооцоо, судалгаа нь хангалттай түвшинд хийгдэж санхүүгийн эх үүсвэртэй зохистой түвшинд уялдаагүй, хэрэгжих хугацаа, зорилго, зорилт давхацсан, хоорондын уялдаа сул байгаагаас хэрэгжилт хүсэн хүлээсэн үр дүнд хүрэхгүй байна.

Монгол улсын Мянганы хөгжлийн зорилгод эрүүл мэндийн салбарын эрхлэх хүрээний асуудлыг хангалттай түвшинд тусган хэрэгжүүлж, 2014 оны байдлаар эрүүл мэндийн зорилтуудын дийлэнх нь зорилтот түвшиндээ хүрсэн байна. Харин 5-6 насны хүүхдийн дунд шүд цоорох өвчний тархалтын үзүүлэлтийг тооцох тоон мэдээлэл хомс байгаагаас 2015 онд зорилтот түвшин буюу 75 хувьд хүрсэн эсэхийг үнэлэх боломжгүй байна гэж дүгнэсэн байна. Мянганы хөгжлийн зорилтын нийт 12 шалгуураас Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд 7 нь тусгагдаагүй, 1 нь дутуу тусгагдсан байна. Эх нялхсын эндэгдэл, дархлаажуулалт, сүрьеэгийн талаарх шалгуурыг бүрэн тусгажээ. Монгол хүний өвчлөл, нас баралтын тэргүүлэх шалтгааныг халдварт бус өвчин болж байгаатай уялдуулан зүрх судасны өвчлөл болон хавдраас шалтгаалсан нас баралтыг бууруулах зорилтыг тусгасан нь оновчтой болжээ.

Эрүүл мэндийн тухай хууль болон Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуульд 2014 онд нэмэлт өөрчлөлт орсон боловч хуулийн хэрэгжилт өнөөг хүртэл хангалтгүй байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулинд сум дундын эмнэлэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв-ийн нэр томъёо байхгүй, бүсчилсэн хөгжлийн асуудал огт тусгагдаагүй байна.

³⁶ *Transforming our world: the 2030 Agenda for Sustainable Development, 2015*

Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын хамтын ажиллагаа, салбарын удирдлагын менежмент хангалтгүй, аймаг, сумын эрүүл мэндийн салбарын удирдлагыг тухайн аймаг, сумын засаг дарга шийдвэрлэж байгаа нь учир дутагдалтай байна.

Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэхэд хүн амын бүртгэл, өвчлөлийн мэдээллийг бүртгэлжүүлэх, тэдгээрийг тогтмол хянах, цахим компьютерийн сүлжээнд оруулах асуудлын хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Төвлөрлийг сааруулах бодлогыг хэрэгжүүлэхэд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын чадавхийг сайжруулах, чадварлаг боловсон хүчнээр хангах, хөгжүүлэх зэрэг асуудлууд эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдаагүй байгаа тул хууль эрх зүйн орчныг сайжруулах, тогтвортой байдлыг хангахад онцгой анхаарах шаардлагатай байна.

Монгол улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 баримт бичгийн³⁷ “Эрүүл мэндийн чанартай хүртээмжтэй тогтолцоо” гэсэн 2-р бүлэг эрүүл мэндийн чиглэлээр 4 үндсэн зорилтын хүрээнд 9 шалгуур үзүүлэлтийг тусгасан байна. НҮБ-аас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилтод эрүүл мэндийн чиглэлээр 1 үндсэн зорилттой 50 гаруй шалгуурыг санал болгосон байдаг³⁸ бөгөөд манай улсын энэ үзэл баримтлалд эх нялхсын эндэгдэл, дархлаажуулалт, сүрьегийн талаарх шалгуурыг бүрэн тусгасан байна. Харин зайлшгүй оруулах шаардлагатай ХДХВ, халдварт болон халдварт бус өвчний талаарх шалгуур бүрэн, оновчтой байдлаар тусгагдаагүй байна. Түүнчлэн Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтод бие даасан байдлаар тусгагдсан хорт зуршил, архи, тамхи, орчны эрүүл мэнд, осол гэмтлийн талаар огт тусгагдаагүй байна. Нөгөө талаар, эрүүл мэндийн тогтолцоо, тусламж хүртээмжийн талаар зорилт дэвшүүлэн, эрүүл мэндийн даатгал, урьдчилан сэргийлэлт, илрүүлэг, тандалтын талаар тусгасан нь сайшаалтай ч, тэдгээрийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой тусгаагүй байна.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд туссан 9 үндсэн шалгуурыг Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Халдварт өвчнөөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөр, Халдварт бус өвчнөөс хянах сэргийлэх үндэсний хөтөлбөр, Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр зэрэг эрүүл мэндийн салбарын бодлогын баримт бичигт бүрэн нийцүүлсэн байна.

Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 2016-2020-т Эрүүл мэндийн салбарын, ялангуяа урт хугацааны бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа бага тусгагдсан бөгөөд гол төлөв тоног төхөөрөмж, барилга байгууламжийн хөрөнгө оруулалт давамгайлж байна. Мөн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд эрүүл мэндийн талаарх зорилт, төлөвлөсөн ажил нь голчлон барилга байшин, хөрөнгө оруулалтад чиглэсэн байна.

Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж байгаа бодлогын хэрэгжилтийг хянах, үнэлэх бүтэц Эрүүл мэндийн яаманд байдаг бөгөөд Засгийн газрын тогтоолоор батлагдсан журмын дагуу хэрэгжилтийн тайланг жил бүр гарган Засгийн газарт тайлагнадаг. Төгсгөлийн болон хөндлөнгийн үнэлгээ хийдэг боловч хяналт шинжилгээ үнэлгээ хийх чадавхи бүх шатандаа сул, мэргэшээгүй, тогтвор суурьшилгүй, хяналт үнэлгээ хийх нэгдмэл арга зүй байхгүй,

³⁷ Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030

³⁸ World Health Organization: World Health Statistics 2018. Monitoring health for the SDGs WHO, 2018

Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа

нэгдсэн удирдлага сул байна. Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагаа нь удирдлагын түвшинд уялдаа холбоо сул, салангид байгааг цаашид анхаарах нь зүйтэй. Мөн Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, ДОХ, сүрьеэ, хумхаатай тэмцэх Глобал сан, НҮБ-ын Хүн амын сан, Хүүхдийн сан, Мянганы сорилтын сан зэрэг олон төсөл хөтөлбөрийн хүрээнд чиглэл чиглэлээр олон тооны судалгаа, шинжилгээний ажлууд хийгдсэн байдаг боловч тэдгээрийг нэгдсэн бодлогод тусгах, судалгааны үр дүнг практикт хэрэглэх, бодлогын зөвлөмж гаргах асуудал орхигдсон тул тусгайлсан байгууллага /институци/ байгуулах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Мөн бодлогын төлөвлөлт, тайлагналын нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох, удирдлага зохион байгуулалтын бүтцийг сайжруулах, мэргэжлийн боловсон хүчний чадвар, хариуцлагыг нэмэгдүүлэх, төрийн байгууллага хоорондын мэдээллийн нэгдсэн сүлжээ бүрдүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хариуцлагын тогтолцоог бий болгох шаардлагатай байна.

Өнөөгийн байдлаар Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгуудад эрүүл мэндийн чиглэлээр үндэсний түвшний 20, бүсийн түвшний 1, аймгийн түвшний 27, сумын түвшний 49 бодлогын баримт бичиг хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр бодлогын баримт бичгүүдийн хэрэгжих хугацаа, бодлогын зорилго, зорилт давхцсан, хоорондын уялдаа сул, бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдаагүй байгаагаас хэрэгжилт хүсэн хүлээсэн үр дүнд хүрэхгүй байна. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгцээ, шаардлагын үндэслэл, тооцоо, судалгаа нь хангалттай түвшинд хийгдэж санхүүгийн эх үүсвэртэй зохистой түвшинд уялдаагүй, орон нутгийг хөгжүүлэх нэгдмэл алсын хараа дутагдалтай байна.

Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгуудаас Дорноговь аймагт 5 дэд хөтөлбөр, Өмнөговь аймагт 3 дэд хөтөлбөр хэрэгжиж байна. Харин Говьсүмбэр болон Дундговь аймгуудад бие даасан дэд хөтөлбөр байхгүй, үндэсний хөтөлбөрүүдийн зарим заалтуудыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах замаар хэрэгжүүлж байна.

Говьсүмбэр аймгийн хувьд бие даасан дэд хөтөлбөрүүд байхгүй, Засаг даргын мөрийн хөтөлбөр, Аймгийн эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөрт зарим заалтууд туссан бөгөөд тодорхой байршил заагаагүй, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд тодорхой бус байна.

Дундговь аймгийн хувьд 2017 оноос өмнө аймгийн дэд хөтөлбөрүүдийг ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж байсан боловч Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд хийсэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудитын дүгнэлтээр бодлогын баримт бичгүүд зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг тусгасан боловч хууль журамд бүрэн нийцэхгүй байна гэж үзсэн байна. Өнөөдрийн байдлаар Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон “Эрүүл иргэнтэй Дундговь” дэд хөтөлбөр хэрэгжиж байна. Байршлын хувьд Эрдэнэдалай суманд шинэ эмнэлэг, Говь Угтаал, Гурвансайхан, Өлзийт сумын эмнэлгийг их засварын ажил хийхээр туссан байна. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд тодорхой бус байна.

Дорноговь аймгийн хувьд Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах дэд хөтөлбөр, Эх хүүхэд, Нөхөн үржихүйн эрүүл мэнд дэд хөтөлбөр, Элэг бүтэн Дорноговь дэд хөтөлбөр, Эрүүл насжилт, настны эрүүл мэнд дэд хөтөлбөрүүд болон “Эрүүл ирээдүй – Дорноговь” аймгийн дэд хөтөлбөр, “Дорноговь аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах” аймгийн дэд хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Эдгээр 5 дэд

Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа

хөтөлбөрүүдэд тодорхой байршил заагаагүй боловч үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой заасан байна.

Өмнөговь аймгийн хувьд Халдварт бус өвчинтэй тэмцэх дэд хөтөлбөр, Эх хүүхэд, Нөхөн үржихүйн эрүүл мэнд дэд хөтөлбөр, Элэг бүтэн Өмнөговь дэд хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх Аймгийн засаг даргын үйл ажиллагааны “Бид хамтдаа” хөтөлбөрт холбогдох заалтууд туссан байна.

Дүгнэлт

Монгол Улс “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал -2030”-ыг хэрэгжүүлснээр 2030 онд Монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөлийг хангаж, дундаж наслалтыг 78-д хүргэнэ гэж зорилт тавиад байгаа билээ. Энэхүү баримт бичгийн “Эрүүл мэндийн чанартай хүртээмжтэй тогтолцоо” гэсэн 2-р бүлэгт эрүүл мэндийн чиглэлээр 4 үндсэн зорилтын хүрээнд 9 шалгуур үзүүлэлт тусгасныг НҮБ-аас гаргасан Тогтвортой хөгжлийн зорилтод эрүүл мэндийн чиглэлээр 9 үндсэн зорилттой 70 орчим шалгууртай харьцуулж үзэхэд манай улсын энэхүү үзэл баримтлалд эх нялхсын эндэгдэл, дархлаажуулалт, сүрьеэгийн талаарх шалгуурыг бүрэн тусгаж, харин зайлшгүй оруулах шаардлагатай ХДХВ, халдварт болон халдварт бус өвчний талаарх шалгуур бүрэн, оновчтой байдлаар тусгагдаагүй байна. Түүнчлэн Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтод бие даасан байдлаар тусгагдсан хорт зуршил, архи, тамхи, орчны эрүүл мэнд, осол гэмтлийн талаар огт тусгагдаагүй байна. Нөгөө талаар, эрүүл мэндийн тогтолцоо, тусламж хүртээмжийн талаар зорилт дэвшүүлэн, эрүүл мэндийн даатгал, урьдчилан сэргийлэлт, илрүүлэг, тандалтын талаар тусгасан нь сайшаалтай ч, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой тусгаагүй байна.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд туссан 9 үндсэн шалгуурыг Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, Халдварт өвчнөөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөр, Халдварт бус өвчнөөс хянах сэргийлэх үндэсний хөтөлбөр, Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр зэрэг эрүүл мэндийн салбарын бодлогын баримт бичигт нийцүүлсэн.

Эрүүл мэндийн тухай хууль болон Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуульд 2014 онд нэмэлт өөрчлөлт орсон боловч хуулийн хэрэгжилт өнөөг хүртэл хангалтгүй байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулинд сум дундын эмнэлэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв-ийн нэр томъёо байхгүй, бүсчилсэн хөгжлийн асуудал огт тусгагдаагүй байна.

Эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэхэд хүн амын бүртгэл, өвчлөлийн мэдээллийг бүртгэлжүүлэх, тэдгээрийг тогтмол хянах, цахим компьютерийн сүлжээнд оруулах асуудлын хууль эрх зүйн орчин дутагдалтай байна. Төвлөрлийг сааруулах бодлогыг хэрэгжүүлэхэд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын чадавхийг сайжруулах, чадварлаг боловсон хүчнээр хангах, хөгжүүлэх зэрэг асуудлууд эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдаагүй байгаа тул хууль эрх зүйн орчныг сайжруулах, тогтвортой байдлыг хангахад онцгой анхаарах шаардлагатай байна.

Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 2016-2020-т Эрүүл мэндийн салбарын, ялангуяа урт хугацааны бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа бага тусгагдсан бөгөөд гол төлөв тоног төхөөрөмж, байрилга байгууламжийн хөрөнгө оруулалт давамгайлж байна. Мөн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд эрүүл мэндийн талаарх зорилт, төлөвлөсөн ажил нь голчлон барилга байшин, хөрөнгө оруулалтад чиглэдэг.

Өнөөгийн байдлаар эрүүл мэндийн салбарт үндэсний, салбарын болон салбар хоорондын түвшинд урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэхээр нийт 16 хууль, 6 бодлогын бичиг баримт, 12 үндэсний хөтөлбөр, 100 гаруй стандарт, дүрэм, журам мөрдөгдөж байна. Эдгээр бодлогын баримт бичгүүд нь үзэл баримтлал, төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, үндсэн чиглэл, төлөвлөгөө зэрэг нэршилтэй байна.

Бодлогын баримт бичгүүдийн хэрэгцээ, шаардлагын үндэслэл, тооцоо, судалгаа нь хангалттай түвшинд хийгдэж, санхүүгийн эх үүсвэртэй зохистой түвшинд уялдаагүй, хэрэгжих хугацаа, зорилго, зорилт давхацсан, хоорондын уялдаа сул байна. Энэ нь бодлогын хэрэгжилт хүсэн хүлээсэн үр дүнд хүрэхэд эрх зүйн зохицуулалт хангалтгүй байгааг харуулж байна.

Эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд заасан бодлогын бичиг баримт бичгүүдэд орон нутгийг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт хийх асуудлууд туссан боловч тодорхой байршил заасан үйл ажиллагаа, арга хэмжээнүүд тусгагдаагүй байна.

Өнөөгийн байдлаар Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгуудад эрүүл мэндийн чиглэлээр үндэсний түвшний 20, бүсийн түвшний 1, аймгийн түвшний 27, сумын түвшний 49 бодлогын баримт бичиг хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

Говьсүмбэр аймгийн хувьд бие даасан дэд хөтөлбөрүүд байхгүй, Засаг даргын мөрийн хөтөлбөр, Аймгийн эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөрт зарим заалтууд туссан бөгөөд тодорхой байршил заагаагүй, үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд тодорхой бус байна.

Дундговь аймгийн хувьд 2017 оноос өмнө аймгийн дэд хөтөлбөрүүдийг ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж байсан боловч Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд хийсэн Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудитын дүгнэлтээр бодлогын баримт бичгүүд зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг тусгасан боловч хууль журамд бүрэн нийцэхгүй байна гэж үзсэн. Өнөөгийн байдлаар Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон “Эрүүл иргэнтэй Дундговь” дэд хөтөлбөр хэрэгжиж байна. Байршлын хувьд Эрдэнэдалай суманд шинэ эмнэлэг, Говь Угтаал, Гурвансайхан, Өлзийт сумын эмнэлгийг их засварын ажил хийхээр тусгасан ч үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд тодорхой бус байна.

Дорноговь аймгийн хувьд Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах дэд хөтөлбөр, Эх хүүхэд, Нөхөн үржихүйн эрүүл мэнд дэд хөтөлбөр, Элэг бүтэн Дорноговь дэд хөтөлбөр, Эрүүл насжилт, настны эрүүл мэнд дэд хөтөлбөрүүд болон “Эрүүл ирээдүй – Дорноговь” аймгийн дэд хөтөлбөр, “Дорноговь аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах” аймгийн дэд хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Эдгээр дэд хөтөлбөрүүдэд тодорхой байршил заагаагүй боловч үнэлгээний шалгуур үзүүлэлтүүдтэй байна.

Өмнөговь аймгийн хувьд Халдварт бус өвчинтэй тэмцэх дэд хөтөлбөр, Эх хүүхэд, Нөхөн үржихүйн эрүүл мэнд дэд хөтөлбөр, Элэг бүтэн Өмнөговь дэд хөтөлбөрүүд хэрэгжиж байна. Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх Аймгийн засаг даргын үйл ажиллагааны “Бид хамтдаа” хөтөлбөрт холбогдох заалтууд туссан.

Эрүүл мэндийн салбарын өнөөгийн нөхцөл байдлын хувьд эрүүл мэндийн тэгш бус байдал, хүрээлэн буй орчны бохирдол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар зэрэг нь бүс нутгийн хувьд маш ялгаатай, олон асуудлууд тулгамдсан хэвээр байна. Өнөөгийн тусламж үйлчилгээ нь хүн амын хэрэгцээтэй нийцэхгүй байна. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хангалтгүй, халдварт болон халдварт бус өвчний тархалт (double burden of disease) өндөр байна. Дундаж ор хоног ихэнх орнуудаас өндөр (9-өөс дээш) байгаа нь эмчилгээний арга барил үр дүн, үр ашиг муутай, амбулаторийн эмчилгээ үйлчилгээ (өдрийн мэс засал, өдрийн эмчилгээ) дутагдалтай, анхан шатны тусламж үйлчилгээний чанар төдийлөн сайн биш, зохицуулалт сул, хамралт хангалтгүй байгаатай холбоотой. Нөгөө талаас иргэдийн нийгмийн шалтгааны улмаас эмнэлэгт хэвтэх шаардлага өндөр байгаа нь нөлөөлж байна.

Хүний нөөцийн хуваарилалтад тэнцвэргүй байдал ажиглагдаж байна. Эмч ба сувилагчийн харьцаа (1:1.2) нь ихэнх орнуудаас өндөр байгаа бөгөөд эмнэлгийн 1 оронд ногдох эмнэлгийн мэргэжилтний тоо хот, хөдөөд зөрүүтэй байна. Санхүүжилтийн болон нөөц хуваарилалтын одоогийн тогтолцоо нь тусламж үйлчилгээний тэгш байдал болон хүртээмжид сөргөөр нөлөөлж байна.

Эрүүл мэндийн 29 үзүүлэлт бүхий матриц аргаар үнэлгээ хийхэд төв, хангайн бүсийн аймгуудын (Архангай, Булган, Хөвсгөл, Өмнөговь, Баянхонгор, Төв, Өвөрхангай, Увс, Дорноговь) эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тэргүүний ээлжинд анхаарах шаардлагатай байна.

Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 (Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь) аймгийг эрүүл мэндийн 6 бүлэг 35 үзүүлэлтээр үнэлэхэд эдгээр үзүүлэлтийн 23 нь 1996 – 2017 оныг дуустал буюу 22 жилээр, 8 үзүүлэлт нь 11- 20 жилээр, 4 үзүүлэлт нь 1-3 жилээр байна. Эдгээр матрикс үзүүлэлтийг дээрх хугацааны аймгийн дундаж үзүүлэлттэй харьцуулан үзэхэд Говьсүмбэр аймгийн үзүүлэлтүүдийн 58%, Дорноговь аймгийн 65%, Дундговь аймгийн 20%, Өмнөговь аймгийн 71% нь аймгийн дунджаас доогуур үзүүлэлттэй гарсан.

Орны тоо, вируст гепатитын өвчлөлийн үзүүлэлт нь эдгээр 4 аймагт бүгдэд нь улсын дунджаас өндөр байна. Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудад үндсэн оношийн зөрүү, 10000 хүн амд ногдох хүн амын өвчлөл, амьсгалын тогтолцоо, хоол боловсруулах тогтолцоо, зүрх судасны өвчлөл, гадны шалтгаант нас баралт, үр хөндөлт зэрэг нь улсын дунджаас өндөр байна. 100000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл Өмнөговь аймагт 83,2 буюу аймгийн дунджаас 21,8-аар илүү, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 34,1 байгаа нь нь цаашид анхаарах асуудлын нэг мөн байна. Говьсүмбэр аймагт их эмчийн тоо, үндсэн оношийн зөрүү аймгийн дунджаас өндөр, 10 000 хүн амд ногдох орны тоо аймгийн дунджаас бараг 2 дахин өндөр байна.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд дундаж наслалтын хувьд Дорноговь аймаг (70.6), 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин Өмнөговь аймаг (76,9), 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд Дундговь (15,9), Өмнөговь аймаг (20), нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1000 амьд төрөлтөд Өмнөговь аймаг (16.1), зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт Говьсүмбэр (18.6), Дундговь (21.7), Өмнөговь аймаг (18.6), хорт хавдраас шалтгаалсан нас баралт Говьсүмбэр (15.1), Дорноговь (12.3), Дундговь (14.4), 10 000 хүн амд вируст сүрьеэгийн өвчлөл Говьсүмбэр аймаг (16.3) байгаа нь 2016-2020 онд дэвшүүлсэн зорилтод хүрээгүй байна.

Сэргийлж болох нас баралт нь тухайн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээг үр дүнтэй, цаг алдалгүй үзүүлж чадаж буйг харуулдаг үзүүлэлт бөгөөд 10 бүлэг өвчнийг авч үздэг. Эдгээр үзүүлэлтийг 100,000 хүн амд авч үзэхэд Өмнөговь аймагт хамгийн өндөр буюу 321,9, Дундговь аймагт 312,2, Говь сүмбэр аймагт 208, Дорноговь аймагт 205,7 байсан нь Улаанбаатар хотын дундажтай (226,2) харьцуулахад тусламж үйлчилгээний чанар ихээхэн ялгаатай байгааг харуулж байна. Эмнэлгийн үр дүнтэй тусламж үйлчилгээг цаг алдалгүй үзүүлж чадсан тохиолдолд сэргийлж болох нас баралтын дийлэнх хувийг зүрх судасны тогтолцооны өвчин дангаараа эзэлж байна.

Санал, зөвлөмж

Улсын Их Хуралд хүргүүлэх:

- “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д ХДХВ, халдварт болон халдварт бус өвчний зарим, хорт зуршил, архи, тамхи, орчны эрүүл мэнд, осол гэмтлийн талаар шалгуур үзүүлэлтүүдийг нэмж тусгах
- Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулиудад орон нутгийн эмнэлгүүдийн бүтэц, зохион байгуулалттай холбоотой нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах, сум дундын эмнэлэг, хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, бүсийн оношилгоо эмчилгээний төв гэх мэт эрүүл мэндийн байгууллагуудын асуудлыг нарийвчилсан үнэлгээ хийсний үндсэн дээр тодорхой болгох

Засгийн газарт хүргүүлэх:

Хууль эрх зүйн орчны талаар:

- Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай, Эрүүл ахуйн тухай хуулиудын хэрэгжилтийг эрчимжүүлэх
- Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрүүдийг боловсруулахад Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн холбогдох заалтуудад нийцүүлэх
- Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг сайжруулах, эрүүл мэндийн салбарыг өвчлөл, байгууллагад суурилсан загвараас хүн рүү чиглэсэн хүн төвтэй эрүүл мэндийн үйлчилгээний загвар руу шилжүүлэх
- Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тоног төхөөрөмж, барилга байгууламжийн хөрөнгө оруулалт бус эрүүл мэндийн салбарын, ялангуяа урт хугацааны бодлого, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг илүү тусгах
- Бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагааны уялдааг сайжруулж, тэдгээрийг нэгдсэн бодлогод тусгах, судалгааны үр дүнг практикт хэрэглэх, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлогын зөвлөмж гаргах чиглэлээр тусгайлсан байгууллага /институци/ байгуулах

Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа

- Алслагдсан болон говь нутагт ажиллаж байгаа эрүүл мэндийн салбарын ажилтнуудад цалин хөлсний нэмэгдэл урамшуулал олгох, амьдралын нөхцөлийг нь сайжруулах, мэргэжил боловсролоо дээшлүүлэх, тогтвор суурьшилтай аж төрөхөд нь дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэх

Санхүүжилтийн талаар:

- Үр дүнд суурилсан төлбөрийн аргыг нэвтрүүлэх, хүн амын өвчлөл, нас, хүйс, алслагдмал байдал, үзүүлж байгаа тусламж үйлчилгээний нэр төрөл, цар хүрээний ялгаа, бодит хэрэгцээ зэргийг үндэслэн санхүүжилтийг ялгавартай хуваарилах, санхүүгийн эрсдлээс хамгаалах
- Эрүүл мэндийн салбарын үр ашгийг нарийвчлан судлах, нийгмийн эрүүл мэндийн зардлыг нэмэгдүүлэх, шаардлагагүй оношилгоо, эмчилгээг бууруулах, зайлсхийвэл зохих эмчилгээ, оношилгооны арга технологийн жагсаалтыг гаргаж, нэвтрүүлэх

Тусламж үйлчилгээний талаар:

- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бэхжүүлэх, санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх, орон нутагт нийгмийн эрүүл мэндийн төвүүдийг байгуулах
- Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, хяналт, хотжилт болон орчны эрүүл мэндийн асуудал, ялангуяа архины хэрэглээ, эрэгтэйчүүдийн тамхидалт, хордлого болон агаарын бохирдлын асуудалд анхаарах
- Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, менежментийг боловсронгуй болгох, чадварлаг боловсон хүчнээр хангах, тогтвортой байдлыг хангахад онцгой анхаарах
- Төв, хангайн бүсийн аймгуудын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах асуудалд нэн тэргүүний ээлжинд анхаарах
- Мэдээлэл, харилцаа, холбоо болон өвчтөн тээвэрлэх тогтолцоог сайжруулах, яаралтай, түргэн тусламжийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, явуулын тусламж үйлчилгээг хөгжүүлэх
- Хүн ам таруу суурьшсан өргөн газар нутагт эмнэлгийн тусламжийн хүртээмжийг илүү нэмэгдүүлэхийн тулд аймгийн түвшний тусламж үйлчилгээг одоо байгаагаас бэхжүүлэн, ЭМ-ийн тухай хуулийн 16.10 дах заалтын дагуу 7 чиглэлийн тусламж үйлчилгээг аймаг орон нутагт жигд бэхжүүлэхэд онцгой анхаарах
- Дотоод шүүрэл, бодисын солилцооны эмгэгийн оношилгоо эмчилгээг Орхон, Өмнөговь, Сүхбаатар аймагт, эпилепсийн тусламж үйлчилгээг Сүхбаатар, Төв, Өмнөговь аймагт, багтраа өвчний тусламж үйлчилгээг Баянхонгор, Хэнтий, Өмнөговь аймагт, ходоод, дээд гэдэсний шархлааны оношилгоо, эмчилгээг Завхан, Баянхонгор, Баян Өлгий аймагт, хэвлийн хөндийн цочмог үрэвсэлт өвчний оношилгоо эмчилгээг Хэнтий, Завхан, Дорнод аймагт, шээс бэлгийн замын тогтолцооны эмгэгийн тусламж үйлчилгээг Өмнөговь, Говь Алтай, Баян Өлгий аймагт, цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажгийн оношилгоо эмчилгээг Говь Алтай, Говьсүмбэр, Дорноговь аймагт сайжруулах

Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа

- Сумын ЭМТ-ийн орны тоог нэмэгдүүлэхгүй, ашиглалтыг сайжруулах, нэн ялангуяа аймгийн төвөөс 50 км дотор болон 1 цаг хүртлэх хугацаанд зорчих боломжтой 1-р зэрэглэлийн сумдуудад зөвхөн яаралтай төрөх болон ажиглалтын зориулалтаар 5 хүртлэх ор ажиллуулах, харин 2 ба 3 зэрэглэлийн СЭМТ-ийг 8-12 эмнэлгийн ортой г.м. зохицуулалт хийх

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүргүүлэх:

- Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого, үндэсний хөтөлбөрүүдтэй уялдуулан тухайн орон нутагт зонхилж буй өвчлөл, нас баралт зэргийг тооцоолсон, хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлттэй, байршлыг тодорхой заасан аймгийн эрүүл мэндийн нэгдсэн нэг дэд хөтөлбөр боловсруулах
- Бүх нийтийн эрүүл мэндийн хамралтыг сайжруулах, аймаг орон нутгийн эрүүл мэндийн салбарыг өвчлөл, байгууллагад суурилсан загвараас хүн хүү чиглэсэн хүн төвтэй эрүүл мэндийн үйлчилгээний загвар руу шилжүүлэх
- Аймгуудын эрүүл мэндийн тогтолцооны үр ашгийг үнэлэхийн тулд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгод эрүүл мэндийн чиглэлээр тусгасан зорилттой уялдуулсан эрүүл мэндийн даатгал, урьдчилан сэргийлэлт, илрүүлэг, тандалтын талаарх буюу ХДХВ, халдварт болон халдварт бус өвчин, хорт зуршил, архи, тамхи, орчны эрүүл мэнд (ус ариун цэвэр, агаарын чанар), осол гэмтлийн талаарх шалгууруудаас нэмж оруулах
- Аймгийн эрүүл мэндийн салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, нэгдсэн эмнэлгийг бүх талаар бэхжүүлэх, зонхилон тохиолдож буй зүрх судас, амьсгалын замын, хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг, хавдрын оношилгоо, эмчилгээг сайжруулах, удаан хугацааны эмчилгээ асаргаа сувилгаа шаардах архаг өвчний эмчилгээ, сэргээн засах эмчилгээ болон хөнгөвчлөх эмчилгээний байгууллагуудыг шинээр бий болгох
- Төр болон хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх замаар зарим нэг тусламж үйлчилгээг хувийн хэвшлийн байгууллагаар үзүүлэх зарчим баримтлах
- Хүн амын эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлага, дадал, халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг үнэлэх
- Ус ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл байдал, шинэ болон дахин сэргэж буй халдварт өвчний тандалт судалгааг хийх
- Ундны усны чанарыг сайжруулах, ариун цэврийн байгууламжийн чанар, хүртээмжид онцгой анхаарах
- Өмнөговь аймагт дотоод шүүрэл, бодисын солилцооны эмгэг, эпилепси, багтраа, шээс бэлгийн замын тогтолцооны эмгэгийн оношилгоо эмчилгээ, Говьсүмбэр,

Дорноговь аймагт цусны эргэлтийн тогтолцооны төрөлх гажгийн оношилгоо эмчилгээг сайжруулахад анхаарах

Ашигласан материалын жагсаалт

1. Measuring overall health system performance for 191 countries, WHO, GPE Discussion Paper Series: No.30, 2000
2. The efficiency of healthcare systems in Europe: a Data envelopment analysis approach, Laura Asandului, Monica Roman, Puiu Fatulescu. Procedia Economics and Finance 10 (2014)
3. Health systems around the world – a comparison of existing health system rankings, Journal of Global Health, 2018
4. Healthcare efficiency assessment using DEA analysis in the Slovak Republic, Research, Robert Stefko, Beata Gavurova and Kristina Kocisova, Health Economics Review 2018
5. Mongolia Health System Review, Health System in Transition, World Health Organization, Asia Pacific Observatory on Health System and Policies, Vol. 3, No.2, 2013
6. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн баримтын хуудас, ЭМЯ, НҮБ-ын ХАС, Баримтын цомог, 2018
7. Эх яагаад эндэв судалгаа, ЭМЯ, НҮБ-ын ХАС, 2016
8. Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгааны тайлан, Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага, 2016
9. Michael Borowitz et al. Mongolia: The Mongolian health system at a crossroads an incomplete transition to a Post-Semashko model Paper, No. 2007-1, 39014
10. World Health Organization: World Health Statistics 2018. Monitoring health for the SDGs WHO, 2018
11. Transforming our world: the 2030 Agenda for Sustainable Development, UN Resolution adopted by the General Assembly on 25 September 2015
12. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030, УИХ-ын 2016 оны 19-р тогтоол
13. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал
14. Эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2007-2017, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Улаанбаатар, 2007-2017 он
15. Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын гуравдугаар судалгаа – 2013, ЭМЯ, ДЭМБ, Монголын Мянганы сорилтын сан, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, 2013
16. Монгол улс дахь сүрьеэгийн тархалтын анхны судалгааны тайлан 2014-2015, 2016
17. Сүрьеэгийн тандалтын тайлан мэдээний эмхэтгэл 2012-2016, 2017
18. Нийгмийн эрүүл мэндийн төлөв байдал, Эрүүл мэндийн яам, 2000 – 2010, 2011
19. Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл 1996-2015, 2016

20. Сумын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ирээдүй, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн салбарын хөгжил-3 төсөл, 2009
21. Эмнэлгийн тусламж үйлчилгээний бодлогын дүн шинжилгээ, Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-3 төсөл, 2011
22. Эрүүл мэндийн салбар 2012, Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын жил, Эрүүл мэндийн яам, 2013
23. Өрхийн усны чанар, ариун цэвэр, эрүүл ахуйн талаарх хүн амын мэдлэг, дадал, хандлагыг үнэлэх судалгаа, 2009
24. Монгол улсын булгийн чанарын усны эрүүл ахуйн үнэлгээ, 2005
25. https://www.who.int/publications/almaata_declaration_en.pdf
26. <https://unstats.un.org/sdgs/report/2016/leaving-no-one-behind>

Хавсралтын жагсаалт

1. Аймгуудын эрүүл мэндийн үзүүлэлтийн матриц
2. Говьсүмбэр аймгийн эрүүл мэндийн үзүүлэлтийн матриц
3. Дорноговь аймгийн эрүүл мэндийн үзүүлэлтийн матриц
4. Дундговь аймгийн эрүүл мэндийн үзүүлэлтийн матриц
5. Өмнөговь аймгийн эрүүл мэндийн үзүүлэлтийн матриц
6. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн тогтвортой хөгжлийн зорилтын эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтүүд, 2017 оны байдлаар
7. Эрүүл мэндийн салбарын бодлогын баримт бичгийн жагсаалт
8. Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн баримт бичгийн жагсаалт, батлагдсан он, баталсан субъект
9. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бодлогын баримт бичгийн нэгтгэл - үндэсний, бүсийн, аймгийн, сумын түвшинд
10. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн эрүүл мэндийн салбарын бодлогын баримт бичгийн дүн шинжилгээ
11. Говьсүмбэр аймагт хэрэгжиж буй эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн уялдаа холбоо
12. Дорноговь аймагт хэрэгжиж буй эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн уялдаа холбоо
13. Дундговь аймагт хэрэгжиж буй эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн уялдаа холбоо
14. Өмнөговь аймагт хэрэгжиж буй эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн уялдаа холбоо

Хэвсрэлт 1. Аймгуудын эрүүл мэндийн үзүүлэлтийн матриц

Аймаг	Үндсэн үзүүлэлт			Хүний нөөц, 10 000 хүн амд /3 жилийн дундаж/			Эрүүл мэндийн үзүүлэлт /3 жилийн дундаж/								Санхүүжилтийн үзүүлэлт			
	ЭМ-ийн индекс	Хүн амын тоо	Дундаж нааслалт	Их эмчийн тоо	Сувилгатчийн тоо	Эмч, сувилгатчийн харьцаа	Эхний энгэлдэл, 100 000 амьд	Нялхсын энгэлдэл, 100 000 амьд	Төрөлгөдөг 1000 хүнд ногдох нас баралт	Хүн амын өвчлөл, 10 000 хүн амд	Хорт хавдар	Зүрх судасны өвчлөл	Осол гэмтэл	Орны фонд ашиглалтын хувь	Орны тоо, 10 000 хүн амд	Нэг хүнд ногдох санхүүжилт		
Архангай	0.7052	94,216	70.81	18.3	29	1:1.6	0	16.8	5.7	10178	12.92	19.20	7.59	81.4	55	153,203		
Баян Өлгий	0.6857	100,469	73.12	20.2	31.5	1:1.6	35.1	13.3	4.4	5408.8	9.83	21.74	3.85	74.9	77.1	137,530		
Баянхонгор	0.7312	86,288	69.27	21.7	34	1:1.6	0	15.5	5.6	10745.8	13.15	20.20	7.94	76.8	63.4	183,350		
Булган	0.6606	61,588	73.4	19.8	31.5	1:1.6	0	10.8	6.2	10707.1	16.42	23.38	8.13	68.5	60.4	185,879		
Говь-Алтай	0.7447	57,067	69.43	32.8	44.5	1:1.4	0	16.4	5.6	7442.8	15.18	21.48	6.47	71.8	78.7	226,416		
Говьсүмбэр	0.8555	17,167	73.01	33.2	39	1:1.2	0	7.2	5.9	6338.3	12.95	16.72	7.52	82.7	72.2	201,161		
Дархан Уул	0.6691	100,838	68.67	27.2	35.6	1:1.3	0	10.6	5.6	8945.2	16.55	20.26	8.23	86.8	73.6	139,924		
Дорноговь	0.7221	67,399	70.6	32.9	37.7	1:1.1	0	12.8	5.4	13795.3	12.64	13.09	12.33	74.7	68.8	193,120		
Дорнод	0.7082	78,640	68.76	23.3	35.2	1:1.5	0	13.4	6.1	7837.1	17.50	20.10	9.21	79.2	69.9	179,928		
Дундговь	0.7612	45,949	73.58	30.7	32.4	1:1	0	9.1	5.5	5926.6	15.87	21.15	8.38	80.1	65.5	209,570		
Завхан	0.7261	71,478	70.11	25.3	38.1	1:1.5	150.5	16.6	5.8	8723.5	15.60	21.99	5.10	65.3	82.1	217,804		
Орхон	0.6860	101,772	71.33	31.9	41.3	1:1.3	0	5	5.5	5959.4	14.62	18.98	6.87	78.7	63.4	142,852		
Өвөрхангай	0.6762	114,798	69.85	22.5	28.6	1:1.3	0	16.1	6.3	7804.1	10.45	23.91	7.91	64.8	72.7	146,501		
Өмнөговь	0.7644	64,653	71.85	29.2	27.1	1:0.9	76.9	16.1	5.5	10970.7	10.74	17.72	8.42	41.9	102.5	161,777		
Сүхбаатар	0.7061	60,678	72.07	25.2	35.4	1:1.4	78.4	17.3	5.6	7478	16.38	15.47	6.17	78.7	66.7	177,409		
Сэлэнгэ	0.6402	107,723	72.08	22.8	30.6	1:1.3	0	11	5.5	5046.2	12.09	19.98	6.26	74.9	65.7	157,032		
Төв	0.6847	93,647	72.85	23.3	31.5	1:1.4	0	10	6.2	9041.8	11.75	21.13	5.00	69.6	53.8	157,782		
Увс	0.7363	81,991	68.84	20.6	31.6	1:1.5	49.1	18.7	5.8	8278.3	17.68	18.20	6.56	77.4	67.2	179,827		
Ховд	0.6819	86,344	72.63	26.8	34.6	1:1.3	45.2	16.7	5.6	7297.1	14.00	16.61	5.91	88.1	66.8	195,229		
Хөвсгөл	0.6248	131,052	66.18	19	28.2	1:1.5	0	22	6.5	8001	15.21	26.71	7.97	72.1	59.7	146,039		
Хэнтий	0.7531	74,814	71.75	24.1	31	1:1.3	69.2	19.4	6.2	7298.4	11.39	17.22	5.59	77	63	251,251		
Улаанбаатар		1,399,094	71.51	46	45.1	1:1	31.2	12.7	5.2	10770.4	12.48	14.88	9.65	81.7	88.1	73,545		

	Эмнэлгийн тусламж үйлчилгээний үзүүлэлт								Өвчлөлийн үзүүлэлт						
	Стационарт хэвтэн эмчлүүлэгчид, 10 000 хүн амд	Амбулатори бүртгэгдсэн хүний амьдрал, 10 000 хүн амд	Эмнэлгийн тусламжийг төрсөн хүний тоо /5 жил нийлбэр/	Үндсэн онооны зөрүү /5 жилгийн дундаж/	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзэглэлийн хувь	Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан эмэгтэйдүүдийн хувь	Бирүст геватитын өвчлөл (10000 хүн амд)	Сүрьеэгийн тохиолдол (10000 хүн амд)	Амьсгалын өвчин	Хоол бооворуулах өвчин	Шээс бэлгийн тогтолцооны эмгэг	Зүрх-сүлсний тогтолцооны өвчин	Өвчлөл ба нас шалтгаан		
1	Архангай	2145	9120	2	5.72	53.4	88.9	1,1	5,5	2,029.01	1,505.69	1,345.73	1,558.60	224.25	19
2	Баян Өлгий	2811	4898	4	0	29	64.6	1,1	3,9	960.82	679.33	691.40	707.90	106.89	11
3	Баянхонгор	2344	10063	4	8.76	67.1	71.2	2,3	5,1	1,860.61	1,597.09	1,236.08	1,435.63	182.11	16
4	Булган	1963	9032	0	0	52.3	80.4	0,7	7,0	1,956.46	1,726.11	1,138.07	1,559.69	169.13	17
5	Говь Алтай	2555	6636	5	7.48	41.1	63.5	1,2	3,7	1,162.29	1,177.91	858.96	928.82	326.85	11
6	Говьсүмбэр	2878	6364	1	4	27.4	91.8	0	16,3	2,175.39	743.25	574.96	634.12	589.43	7
7	Дархан Уул	2935	8426	22	4.34	52.2	83.7	1,7	19,0	1,804.96	1,437.04	711.19	1,122.64	354.51	13
8	Дорноговь	2301	10306	7	7.44	54.3	80.7	1,4	14,2	2,399.27	1,800.27	1,114.51	1,017.75	461.96	15
9	Дорнод	2394	7756	1	3.72	67.1	86.6	1,8	16,1	1,549.33	2,038.76	610.14	622.28	284.73	10
10	Дундговь	2408	5891	10	11.96	70.0	84.5	1,8	8,8	1,419.29	1,102.12	630.00	795.27	172.58	7
11	Завхан	2359	6943	1	6.1	43.9	78	0,9	4,4	1,238.92	1,622.53	893.90	836.11	144.28	11
12	Орхон	2173	6110	21	4.68	25.6	69.9	1,5	8,4	1,968.06	727.55	571.69	615.30	215.89	10
13	Өвөрхангай	2143	7208	9	7.26	68.4	93.5	0,4	5,9	1,178.36	1,406.72	1,003.47	958.32	284.70	14
14	Өмнөговь	2096	10617	7	6.32	35.2	95.4	2,8	4,2	2,655.47	2,075.38	856.51	1,251.94	272.34	17
15	Сүхбаатар	2193	7729	3	0	62.6	94.5	1,4	11,2	2,042.53	1,313.37	608.18	933.80	300.23	7
16	Сэлэнгэ	2079	4751	7	3.5	43.5	72.5	0	18,5	1,130.20	555.83	657.50	777.63	180.21	9
17	Төв	1702	8798	5	10.74	45.3	62.3	0,1	11,7	2,034.30	1,874.32	959.11	1,289.46	147.89	15
18	Увс	2543	7857	30	5.88	52.8	76.6	2,6	6,8	1,791.12	1,366.90	933.36	1,072.36	191.82	14
19	Ховд	2727	6259	10	3.06	45.1	45.7	1,2	4,7	1,055.44	1,104.11	763.41	1,000.82	116.40	8
20	Хөвсгөл	2190	6681	11	6.02	57.5	95	1,4	7,7	1,410.36	1,051.93	729.80	1,163.91	172.50	16
21	Хэнтий	2177	6785	4	6.04	53.8	77.3	1	10,7	1,613.69	1,062.47	621.42	1,051.12	263.65	10
22	Улаанбаатар	3157	9555	382	5.72	23.5	94.3	2,3	16,2	1,545.61	1,349.71	855.24	1,026.41	837.50	16

Хэсвэлт 2. Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн үзүүлэлтийн матриц

Говьсүмбэр	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	Дундаж үзүүлэлт		
1																							0.855	0.9	
2	12.833	12.665	12.520	12.230	12.264	12.843	12.327	12.069	12.065	11,984	12,015	12,224	12,511	12,886	13,323	13,859	14,308	14,801	16,058	16,522	16,926	17,383	13459	13459	
3		62.59	67.62		66.03	66.21	66.36	66.48	66.76	67.39	67.84	68.32	69.01	69.83	69.89	71.06	71.83	72.26	72.86	73.42	73.01	73.01	73.01	69.1	69.1
4	22.9	21.6	20.2	22.5	22.8	20.2	18.6	19.1	19.1	18.1	20.6	21.7	23.9	27.6	28	26	31.5	32.9	31.8	27.4	26.9	24.3	24.3	24.0	24.0
5	16.5	15.4	15.4	16	14.6	13.5	12.4	14.2	14	12.2	13.8	17.3	19.6	22.5	23.3	20.3	24.5	28.7	26.4	22.4	22.5	19	19	18.4	18.4
6	23	25.5	26	27.3	30.6	28.3	24.9	27.5	28.6	26.9	30.7	31.9	33.8	31.3	28.8	33.1	34.1	38.5	37.6	34.4	31.1	33.2	33.2	30.3	30.3
7	40.3	42.1	37.9	35.9	36.2	40	38.6	35.6	34.3	34.3	35.8	38.6	45.6	40.5	37.8	39	41.2	38.5	42.1	37.4	37.1	39	39	38.5	38.5
8	1:1,8	1: 1.7	1: 1,5	1:1,3	1:1,2	1:1,4	1:1,6	1:1,3	1:1,2	1:1,3	1:1,2	1:1,2	1:1,3	1:1,3	1:1,3	1:1,2	1:1,2	1:1,0	1:1,1	1:1,1	1:1,2	1:1,2	1:1,2	1:1,3	1:1,3
9								0	0	448.4	384.6	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	55.5	55.5
10	38.5	29.4	0	27.3	43.6	20.2	57.5	16.3	25.5	9	23.1	3.5	29.6	22.2	2.7	8.5	11.3	14.6	6.1	13.5	15.6	7.2	7.2	19.3	19.3
11	49	51.5	18.9	41	76.4	20.2	62	20.4	34	17.9	23.1	17.5	32.9	27.8	5.3	8.5	11.3	14.6	6.1	15.7	20	14.4	14.4	26.8	26.8
12	6.4	6.2	4.8	6.5	8.2	6.7	6.2	5.1	5.1	6	6.8	4.4	4.3	5	4.7	5.7	7	4.3	5.4	5	4.4	5.3	5.3	5.6	5.6
13	81.1	97.4	88.1	87.2	76.4	78.1	82.5	74.7	81.5	87.9	88.8	82.6	75.5	86.4	97.3	94.2	88.7	82.4	142.7	99.6	93.7	82.7	82.7	88.6	88.6
14	127	108.2	104.6	102.5	113.4	110.7	111.7	107.7	100.4	100.4	96.8	93.4	96.8	81	78.3	77.3	74.6	85.9	55.7	64.5	706	72.2	72.2	121.3	121.3
15																						20116	20116	201161	201161

16	Стационарт хэвгэн эмчлүүлэгчид, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	3356.1	3116.4	2795.6	2757.2	2559.6	2578.9	2795.6	2856.2	2979.9	3321.2	3320.2	3143.2	3263.1	3251.1	3434.7	3336.8	3213.7	3050.6	3399.9	2804.1	3003.5	2826.4	3052.9
17	Амбулаторт бүртгэгдсэн хүн амын өвчлөл, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	7284.5	5707	4815.9	4594.1	5370.6	7159.3	6618.7	5331.7	6166.3	7214.7	8313.8	7369.5	8755.5	9228.1	13085	12232	9023.3	6396.6	6743.6	6415	6337.6	6338.5	7295.6
18	Нийт төрөлгөд эмнэлгийн тусламжгүй төрсөн хүний эзлэх хувь	0	0	0	0.3	0	0	0.4	0	0	0.1	0.4	0	0.3	0.3	0	0	0	0.2	0	0	0.2	0.2	0.1
19	Үндсэн оношийн зөрүү /20 жилийн дундаж/	0	0	0	0	0	0	0	0	0	0	8.3	42.8	10	25	36.4	0	0	20	0	0	3.1	0	6.6
20	Хүн амын өвчлөл, 10 000 хүн амд												7369.5	8755.5	9228.1	13085	12232	9023.3	6396.6	6743.4	6415	6337.6	6338.3	8356.8
21	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгийн хувь, 2017 он																						27.4	27.4
22	Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан эмэгтэйчүүдийн хувь, 2017 он									84.2	84.2	80.5	94.4	97	97.5	99.2	98.9	98.6	96.4	98.4	99.5	99.8	91.8	94.3
23	Жирэмсний эхний 3 саргайд хяналтад авсан жирэмсэн эмэгтэйчүүд, 1000-д /22 жилийн дундаж/	53.2	20.5	45	51.5	52.9	37.5	53.3	73.9	83.1	76.9	77.5	87.3	82.3	84.2	81.1	91.1	89.6	89.5	83.7	87.7	83.3	88.1	71.5
24	Вируст талатгын өвчлөл, 10000 хүн амд*								20.8	17.8	21.5	24.6	72.8	47.4	12.6	79	74.8	10.9	7.7	3.4	5.8	2.4	0	26.8
25	Сүрьеэгийн тогнолдол, 10000 хүн амд*								16.2	14.6	22.3					15	13.1	18.2	14.1	16.9	10.4	15.1	16.3	15.7
26	Амьсгалын тогтолцооны өвчин, 10 000 хүн амд	3098.9	1857	1491	955.3	1596.3	1971.3	1909.5	1688.9	1589.9	1725.1	1629.7	1976.5	2040.6	2330.9	3528.5	2758.4	2744.3	1953.3	2783.6	2202.6	2194.4	2129.1	2098.0
27	Хоол боловруулах тогтолцооны өвчин, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	1827.3	972.6	805.8	1078.3	818.7	1292.7	1072.5	577.6	1240.6	1139.7	1907.1	1148.4	1209.9	1351.9	2239.8	1832.8	1275.3	872.6	807.5	877.2	673.88	678.5	1168.2

28	Шэс бэлгийн тогтоцооны эмгэг, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	662	908.4	851.7	936.3	833.7	1189.1	1140.7	992.3	1172.1	1163.4	1140.5	1149.9	1338.9	1208.3	1630.1	1673.9	1033.1	621.1	528.9	570.9	541.74	612.2	995.4
29	Хорт хавдар, 10 000 хүн амд*	12.7	18.6	10.7	6.8	16.6	8.2	12.9	6.5	0.8	13.9	8.6	15.2	5.5	7.6	12.6	24.3	7.8	11	12.3	17.2	19.7	24.5	12.5
30	Зурх судасны өвчлөл, 10 000 хүн амд*	446.1	520.3	311.6	382	470.5	693.3	760.8	587.3	790.9	863.8	990.9	1008.8	1019.5	1291.6	1667.1	1813.7	1142.5	730.4	747.3	779	574.03	824.6	
31	Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан, 10 000 хүн амд								195.22	195.89	189.41	196.33	229.23	542.79	693.16	588.95	590.1	542.48	576.45	534.02	507.67	655.94	604.67	456.2
32	Халдварт шимсэгчт зарим өвчин, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	98.4	115.2	152	135.9	234.5	393.1	236.2	140.9	84.1	97.2	190.9	244.4	225	113.9	206.2	213.4	140.6	135.4	101.8	70.6		166.5	
33	Үр хөндлөгт /1000 амьд төрөгчдөд/ /22 жилийн дундаж/	136.6	124.1	206.5	386.9	227.1	166.7	110.7	66.2	59.7	37.2	90.9	98.7	93.2	63.7	141.2	307.9	261.9	144.1	81.5	74	28.9	136.3	
34	Мэс заслын хүндрэлийн хувь /22 жилийн дундаж/	0	1	0	0.6	0	0	0	0	0	0	0	0	0	0.4	0	0	0	0	0	0	0	0.5	0.1

Хавсгалт 3. Дорноговь аймгийн Эрүүл мэндийн үзүүлэлтийн матриц

	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	Дундаж үзүүлэлт Т
1	ЭМ-ийн индекс /3 жилийн дундаж/																						0.7
2	Хүн аман тоо /22 жилийн дундаж/	47,148	47,979	48,844	50,575	50,977	51,783	51,827	52,151	52,913	54,105	55,128	56,695	57,693	58,859	60,206	61,302	62,537	63,808	65,267	66,450	68,147	56169.5
3	Дундаж наслалт* /21 жилийн дундаж/		65.65	63.9	62.68	62.86	63.01	63.13	63.91	64.54	65.16	65.8	66.5	67.25	67.31	68.44	69.18	69.59	70.17	70.71	70.4	70.6	66.5
4	1000 хүнд ногдох төрөлт /22 жилийн дундаж/	22.3	20.1	19.9	20.2	20.3	17.8	17.3	17.3	17	17.9	20.8	22	23.1	21.9	22.8	23.3	24.4	23.6	24	21.8	19.7	20.9
5	1000 хүнд ногдох цэвэр өсөлт /22 жилийн дундаж/	15.5	14.7	14	14.6	13.7	11.9	11	11.7	10.6	11.5	15.7	16	18.2	16.1	16.4	17.6	18.5	17.9	18.7	16	14.6	15.0
6	Их эмчийн тоо, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	22.3	21	22.6	21.5	25.4	26.7	27.7	23	27.2	28.6	28.4	33.7	30.8	31.2	30.1	30.1	33.1	31	32.5	33.9	32.9	28.2
7	Сувилагчийн тоо, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	33.6	35.3	35.5	29.4	29.1	28.4	29.2	30.4	30.6	18	30.1	31.2	30.1	31.1	30.1	29.3	31.7	31.3	32.2	34.3	37.7	30.8
8	Эмч сувилагчийн харьцаа /22 жилийн дундаж/	1:1.5	1:1.7	1:1.6	1:1.4	1:1.1	1:1.0	1:1.1	1:1.3	1:1.1	1:0.6	1:1.0	1:0.9	1:0.9	1:1.0	1:1.0	1:1.0	1:0.9	1:1.0	1:1.0	1:1.0	1:1.1	1:1.1
9	Эхийн эндэгдэл, 100 000 амьд төрөлтөд*							81.37	0	0	104.5	0	80.5	0	0	0	0	66.3	0	0	0	0	22.2
10	1 хүргэх насны хүүхдийн эндэгдэл, 1 000 амьд төрөлтөд*	49.5	33.5	33.6	29.9	30.4	29.6	21.7	19.9	19.9	26.1	23	30.6	21.8	24.7	13.3	16.3	15.2	13.4	12.3	14.6	12.8	23.7
11	5 хүргэх насны хүүхдийн эндэгдэл, 1 000 амьд төрөлтөд*	67.2	45.7	46.8	40.8	42.7	38.3	34.3	29.8	25.4	30.3	25.6	33.8	24	28.5	19.2	18.4	21.9	19.5	12.3	16.7	13.6	31.0
12	1000 хүнд ногдох нас баралт /22 жилийн дундаж/	6.8	5.5	5.9	5.6	5.8	5.9	5.7	5.7	6.4	6.3	5.1	6	4.9	5.8	6.3	5.7	5.9	5.7	5.3	5.8	5	5.8
13	Орны фонд ашиглалтын хувь /22 жилийн дундаж/	73.7	88.4	105	77	75.7	87.7	73.9	74.1	75	75.6	79.6	80.7	77.6	78.3	76.4	74.2	75.9	74.6	72.1	79.1	74.7	78.8
14	Орны тоо, 10 000 хүн амд	149.2	111.1	86.8	83.8	78.4	72.7	74.2	74.8	74.9	73.5	66.7	64.3	61.6	62.1	61.5	60.2	59.1	62.8	62.6	66.5	68.8	75.0
15	Нэг хүнд ногдох санхүүжилт, 2017 он /аймгийн тайлан/																						193120. 0

16	Стационарт хэвгэн эмчлүүлэгчид, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	3293.1	3055.95	2588.94	2099.43	2015.56	2138.35	2109.04	2180.54	2218.92	2250.81	2222	2379.03	2381.62	2236.8	2345.55	2279.41	2184.22	2074.14	2219.95	2103.89	2415.8	2381.9	2326.1
17	Амбулаторт бүртгэгдсэн хүн амын өвчлөл, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	3593.9	5967.6	4265.5	3686.6	3692.1	5097.1	5117.9	5389.2	5664	5640.6	5749.7	4999.1	5311.6	5534	6078.2	6131.2	6236.6	6374.9	7332	7821	9302.9	13795.3	6035.5
18	Нийт төрөлгөд эмнэлгийн тусламжгүй төрсөн хүний элэх хувь	0	0.6	0.3	0.3	0.1	0.7	0.4	0.6	0	0.3	0.2	0.2	0.4	0.3	0.2	0	0	0.2	0.1	0.2	0.1	0.2	0.2
19	Үндсэн оношийн зөрүү /20 жилийн дундаж/	0	0	12.5	21.8	1.9	1.9	12.1	5.9	0	7.1	10	8.8	3.8	10.4	11.4	9.4	10.3	5.6	8.8	3.1	5.6	0	6.8
20	Хүн амын өвчлөл, 10 000 хүн амд												4999.1	5311.6	5534	6078.2	6131.2	6239.6	6374.9	7232.2	7821	9302.9	13795.3	7165.5
21	Умайн хүүхдүүний өмөнгийн эрт илрүүдлийн үзлэгийн хувь, 2017 он																						54.3	54.3
22	Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдсан эмэгтэйдүүдийн хувь, 2017 он																							
23	Жирэмсний эхний 3 сартайд хяналтанд авсан жирэмсэн эмэгтэйдүүд, 1000-д /22 жилийн дундаж/	45.6	47.9	89	92.9	75.9	78.4	85.7	88.5	86.9	89.6	88.5	85.7	98.1	98	98.6	98.6	98.9	99.9	94.1	84.8	68.7	80.7	93.7
24	Вируст талитын өвчлөл, 10000 хүн амд*																							
25	Сурьсэгийн тохиолдол, 10000 хүн амд*																							
26	Амьсгалын тогтоцооны өвчин, 10 000 хүн амд	1192.1	1422.4	1025.7	895.1	787.1	1085.7	1094.6	1399.2	1205.1	1286.5	1165.9	1020.2	1136.6	1224.1	1420.2	1302.3	1414.6	1207.5	1878.8	1753.4	1973.15	3471.27	1380.1
27	Хоол боловруулах тогтоцооны өвчин, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	718.8	1534.9	720.4	575.8	554.5	833.3	994.3	1022.5	1070.2	1064.9	972.3	814.3	886.4	785.6	815.9	873.8	893.1	988.9	1058.4	1310.7	1524.92	2565.17	1026.3

28	Шээс бэлгийн тогтоцооны эмгэг, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	466.3	780.4	593	561	593.2	787.6	816.7	821.3	909.4	894.1	957.3	764.8	785.8	833	877.3	886.1	880.4	939	995.1	187	969.34	1217.9 7	796.2
29	Хорт хавдлар, 10 000 хүн амд*	19.6	8.8	12.1	15.9	13.6	20.8	20.3	14	21.8	15.9	22.2	11.7	12.8	10.6	14.3	18.8	21.6	23.7	24.5	24.6	19.6	19.9	17.6
30	Зурх судасны өвчлөл, 10 000 хүн амд*	293.2	602.1	442.4	351	394.9	513.6	509.4	515.8	535	562.8	582.7	524.5	569.4	603.8	725.8	764.1	674.4	800.2	853.1	846.1	834.51	1372.5 7	630.5
31	Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан, 10 000 хүн амд								160.27	241.02	258.33	228.87	257.6	232.23	258.36	358.91	376.93	429.27	468.67	457.48	466.09	443.37	476.42	340.9
32	Халдварт ба шимэгчигт зарим өвчин, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/		97.4	159.9	90	64.6	174.9	172.8	98.6	104.1	122.9	173.3	271.5	205	190.7	238.6	209.3	166.9	168.4	133.3	136.8			156.9
33	Үр хөндлөлт /1000 амьд төрөлтөд/ /22 жилийн дундаж/	115.5	148.4	80.3	163	216.8	227.6	233	258.8	310.4	245.7	278.9	214.3	236.9	303.8	302.5	347.6	248.2	235.9	224.5	291.2	416.4	304.9	245.7
34	Мэс заслын хүндрэлийн хувь /22 жилийн дундаж/	1.5	1.2	0	2.2	0.6	0.6	0.6	0.5	0.8	0.3	0.4	0	0.1	0	0.1	0	0	0	0	0	0.2	0	0.4

Хавсралт 4. Дундговь аймгийн Эрүүл мэндийн үзүүлэлтийн матриц

	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	Дундаж үзүүлэлт
1																							0.8
2	52,985	53,078	52,898	51,517	50,602	49,910	49,094	47,780	46,473	45,465	44,353	43,240	42,027	40,776	38,728	37,726	37,773	37,364	44,351	44,429	44,762	45,755	45,503.9
3		69.98	69.44		66.59	66.77	66.92	67.04	67.18	67.81	68.22	68.66	69.41	70.17	70.23	71.41	72.18	72.61	73.22	73.78	73.46	73.58	69.9
4	23.6	22.3	21.9	21.4	19.8	18.5	19.6	16.2	16.2	16.7	16	18.2	20.2	22.6	18.4	20	21.6	23.2	22.6	21.4	21.4	19.2	20.2
5	16.5	17.5	16.9	15.8	13.7	13.2	14.6	13.3	11.2	11.6	11.2	13	15.1	17.7	12.2	13.8	15.5	17.7	17.5	16.7	15.4	14.1	14.7
6	18.7	16.4	17	16.9	19.6	19.7	18.7	19.3	17.7	16.3	16	17.9	19.2	19	18.7	22	26.2	28.2	27.2	27.7	28.7	30.7	21.0
7	28.5	27.7	25.9	26.2	26.3	28.6	27.7	29.1	30.5	30.7	27.4	29.4	29.3	30.7	32	36.1	38.1	39.7	37	35.6	34.1	32.4	31.0
8	1:1.5	1:1.7	1:1.5	1:1.6	1:1.3	1:1.5	1:1.5	1:1.5	1:1.7	1:1.9	1:1.7	1:1.6	1:1.5	1:1.6	1:1.7	1:1.6	1:1.5	1:1.4	1:1.4	1:1.3	1:1.2	1:1.1	1:1.5
9								0	122.55	147.8	0	111.5	101.5	91.5	0	0	0	0	0	0	0	0	38.3
10	39.3	30.1	27.8	24.1	28.4	17.9	26.9	20.7	29.3	19.2	15.2	14.5	14.2	20.1	21.9	13.1	11	10.1	16.9	7	16.8	9.1	19.7
11	61	36	35.4	31	42.2	27.3	28.9	26.1	36.6	32.4	19	15.6	16.2	22.9	30	15.7	12.2	14.6	20	10	21	15.9	25.9
12	7.1	4.8	5.1	5.6	6.1	5.3	5.1	5	5	5.1	4.8	5.1	5.1	4.9	6.2	6.2	6.1	6	5.7	5.9	15.4	5	5.9
13	70.4	91.4	91.7	69	71.7	63.2	61.8	54.6	61.9	72.2	71.1	70.8	71.3	80.9	79.5	76.8	80.2	78.5	109.2	95.2	80.8	80.1	76.5
14	92.4	65.2	64.6	62.1	66.3	69.2	69.7	69.8	69.7	70.3	70.9	71.1	72.2	62.1	63.4	78	78.9	79.3	55.6	51.1	67.5	65.5	68.9
15																							209570.0

16	Стационарт хэвгэн эмчлүүлэгчид, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	1961.8 6	1871.7 7	18460 5	1428. 78	1526.5 1	1654.9 7	1497	1514.5 9	1755.7 1	2032.0 9	2051.7 9	2120.9 8	2260.8 7	2232.6 5	2269.5 1	2234.5 3	2879.7 7	2736.0 7	2662.6 7	2271.0 1	2457.3	2279.4	2070.3
17	Амбулаторт бүртгэгдсэн хүн амын өвчлөл, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	1173.9	2724.4	2882.7	2260. 1	2590.1	2927.6	2965.7	3532	4041.2	3807.8	3567.3	3605	3638.1	3656.6	3991.7	5200	5397.4	5974.4	6064.2	5392.2	6353.6	5926.6	3985.1
18	Нийт төрөлгөд эмнэлгийн тусламжгүй төрсөн хүний элэх хувь	0	0	0.5	0.9	0.9	0.7	0	0	0	0.1	0	0.1	0	0.1	0	0	0.1	0.2	0.2	0.5	0.2	0.2	0.2
19	Үндсэн оношийн зөрүү /20 жилийн дундаж/	0	0	0	2.4	0	0	4.3	0	0	0	0	7.7	0	0	0	0	30	17.6	5.9	11.1	16.7	4.6	
20	Хүн амын өвчлөл, 10 000 хүн амд												3605	3638.1	3656.6	3991.7	5200	5397.4	6064.3	5392.2	6353.6	5926.6	5018.2	
21	Умайн хууруний өмөнгийн эрт илрүүдлийн үзлэгийн хувь, 2017 он																					70	70.0	
22	Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдсан эмэгтэйтчүүдийн хувь, 2017 он										85.4	96	98.5	97.9	94	95.7	98.2	93	99.9	97.6	66.6	84.5	91.7	
23	Жирэмсний эхний 3 сартайд хяналтанд авсан жирэмсэн эмэгтэйтчүүд, 1000-д /22 жилийн дундаж/	60.2	73.4	74.9	68.2	74	81.5	80.7	87.9	92.1	90.9	92	91.6	91.7	88.4	86.3	84.8	85.5	87.6	86.3	84.7	88.5	83.3	
24	Вируст гепатитын өвчлөл, 10000 хүн амд*								20.1	27.1	43.5	58.7	36.4	22.2	4.3	19.9	75.1	38.4	4.9	1.6	1.1	1.8	23.8	
25	Сүрьеэгийн тохиолдол, 10000 хүн амд*								2.9	4.7	5.4				6.1	4.5	4.5	3.2	4.9	7.2	6.8	8.8	5.3	
26	Амьсгалын тогтолцооны өвчин, 10 000 хүн амд	354.5	626.4	666.3	550.9	646.3	605.2	651.8	705.8	806.1	694.7	565.3	587.2	668.7	651.5	859.1	920.3	895.6	913	1251.9	1631.1 2	1423.3 2	812.7	
27	Хоол боловсруулах тогтолцооны өвчин, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	187.3	392.5	440.9	370.9	392	524.2	565.9	862.3	708	805.4	590.9	825.2	678.4	610.4	622.4	907	993.1	1228.2	1193.4	1250.5 9	1067.2 7	736.6	

28	Швэс бэлгийн тогтоцооны эмгэг, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	162.6	487.6	515.3	356.2	396.7	511.7	438.8	607.1	774.6	728.9	742.7	636.8	633.1	639.2	715	915.8	825.4	815.6	753.1	1035.1	647.16	680.1	637.2
29	Хорт хавдлар, 10 000 хүн амд*	18.9	14.2	17.5	14.7	21.4	14.2	13.9	18.7	17.9	11.5	14.3	15.9	14	12.3	11.3	19.9	19.3	17.8	21.5	24.1	24	24.8	17.4
30	Зурх судасны өвчлөл, 10 000 хүн амд*	84.1	203.7	201.3	168.1	221.1	244.7	317.2	346.1	500.9	447.1	443.3	427.7	474.3	518	568.6	793.4	930.6	1074.3	921.5	757.4	837.99	790.44	512.4
31	Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан, 10 000 хүн амд								111.89	112.88	140.07	134.74	124.8	99.81	96.97	113.64	136.81	120.53	141.34	143.18	124.8	176.7	216.33	133.0
32	Халдварт ба шимэгчиг зарим өвчин, 10 000 хүн амд	83.4	96	141.4	62.3	186.7	143	117.7	83	54	69.1	108.7	103.9	54.2	44.4	75.8	171.3	116	96.6	83.2	115.3			100.3
33	Үр хөндлөлт /1000 амьд төрөлтөд/	70.6	72.5	113.7	94.6	46	40.4	51.9	47.4	48.8	63.9	90.7	50.6	64.4	49.1	49.5	51	50.2	58.4	61.2	104.9	127	64.7	66.9
34	Мэс заслын хүндрэлийн хувь /22 жилийн дундаж/	0.7	0.2	0.5	0.8	0.7	0.4	0.4	0	1.1	0.4	0	0.6	1.3	0.2	0.8	0	0.3	0.5	2.7	0.5	0.3	0.1	0.6

Хавсралт 5. Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн үзүүлэлтийн матриц

	Өмнөговь	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	Дундаж үзүүлэлт
1	ЭМ-ийн индекс /3 жилийн дундаж/																							0.8
2	Хүн аман тоо /22 жилийн дундаж/	45,950	46,353	46,698	46,858	47,852	49,207	50,070	50,552	51,576	51,852	53,215	54,594	56,355	58,949	61,591	63,426	65,373	67,149	69,694	71,655	73,307	75,314	55345.0
3	Дундаж наслалт* /21 жилийн дундаж/		67.56	68.98		65.03	65.21	65.36	65.48	65.62	66.19	66.58	67.	67.61	68.47	68.53	69.68	70.44	70.85	71.44	72.	71.68	71.85	68.3
4	1000 хүнд ногдох төрөлт /22 жилийн дундаж/	26.7	26.2	25.3	24.6	25.3	23.1	20.1	20	20	17.7	17.1	19.4	24.9	26.4	23.3	19.5	20.2	23.3	22.7	24.8	22.6	20.1	22.4
5	1000 хүнд ногдох цэвэр өсөлт /22 жилийн дундаж/	20	19.3	19.4	16.6	18.3	16.8	13.9	11.6	14.3	10.7	11.3	13.8	19.1	20.4	17	14.4	15.1	18.7	17.8	19.4	17.4	15.4	16.4
6	Их эмчийн тоо, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	16.4	17.3	16.8	17.5	19.4	20	19.1	19	16	17	19.2	20.3	23	21.8	23.3	19	21	22.2	25.1	28	29.1	29.2	20.9
7	Сувилагчийн тоо, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	27.7	24	24.4	25.5	22.5	25.2	26.5	28.1	25.7	26.7	23.1	26.2	28.3	25.8	24.1	22.1	24.4	23.1	26.8	27.9	29	27.1	25.6
8	Эмч сувилагчийн харьцаа /22 жилийн дундаж/	1:1.7	1:1.4	1:1.5	1:1.5	1:1.2	1:1.3	1:1.4	1:1.5	1:1.6	1:1.6	1:1.2	1:1.3	1:1.2	1:1.2	1:1.0	1:1.2	1:1.2	1:1.0	1:1.0	1:1.0	1:1.0	1:0.9	1:1.3
9	Эхийн эндэгэл, 100 000 амьд төрөлтөд*								0	0	245.1	0	329.3	0	78	169.8	0	0	0	69.4	66.4	212.9	76.9	83.2
10	1 хүртэлх насны хүүхдийн эндэгэл, 1 000 амьд төрөлтөд*	33.2	41.1	32.7	50.5	44.3	29.1	48.5	28.8	20.4	29.4	27.7	22	23.7	21.1	22.1	19.7	16.9	16.8	16.6	19.2	16.1	27.3	27.3
11	5 хүртэлх насны хүүхдийн эндэгэл, 1 000 амьд төрөлтөд*	44.9	53.7	37.8	63.8	55.6	39.4	59.1	38.4	23.6	35.5	30.2	27.4	28.8	23.4	26.3	29.9	23.1	19.4	26.4	19.9	24.1	20	34.1
12	1000 хүнд ногдох нас баралт /22 жилийн дундаж/	6.7	6.8	5.9	7.9	7	6.3	6.2	5.6	5.6	6.9	5.8	5.6	5.8	6	6.3	5.2	5.1	4.6	5	5.4	5.1	4.7	5.9
13	Орны фонд ашиглалтын хувь /22 жилийн дундаж/	70	81.1	88.3	70.9	69.1	65.7	73.4	57.6	63.6	60.9	63.7	70	72.3	74.7	67.5	65.7	68.4	75.6	54.6	55.6	63.6	41.9	67.0
14	Орны тоо, 10 000 хүн амд	89.1	67.2	67.7	62.9	64.1	65.4	65.2	66.5	67.8	64.2	64.4	63.6	63	55.9	56	46.6	45.2	43.9	69.1	73.5	71.4	102.5	65.2
15	Нэг хүнд ногдох санхүүжилт, 2017 он /аймгийн тайлан/																							161777.0

16	Стационарт хэвгэн эмчлүүлэгчид, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	2364.1 4	2114. 24	2189.8 5	1749.7 3	1833.7 7	1799.2	1956.9	1846.7 4	2147.9	1949.3 1	1996.4 3	2177.6 8	2285.3 6	2143.5 8	1941.6 8	1593.0 5	1615.3 9	1620.7 1	1877.2 8	2008.9 2	2174.1	2105.9	1976.9
17	Амбулаторт бүртгэгдсэн хүн амын өвчлөл, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	3007.6	4314. 3	4206.7	3528	4277	4170.3	4425.9	4644.3	5093.6	5022.3	4956.3	5910.4	6233.3	6845.6	8427.2	7143.1	7251.9	7597.4	8094.4	9652.8	11227. 6	10970. 7	6227.3
18	Нийт төрөлгөд эмнэлгийн тусламжгүй төрсөн хүний эзлэх хувь	0	0	0.6	0.7	0.3	0.3	0.4	0	0.1	0	0	0	0.1	0.1	0	0	0.1	0.2	0.1	0.1	0.1	0.1	0.2
19	Үндсэн оношийн зөрүү /20 жилийн дундаж/	0	0	4	8.1	10	10	2.9	5	12.5	4	0	16.4	12.1	9.1	2.9	2.4	3	7.7	7.7	14.7	9.7	7.0	
20	Хүн амын өвчлөл, 10 000 хүн амд												5910.4	6233.3	6845.6	8427.2	7143.1	7251.9	7597.4	8094.4	11227. 6	10970. 7	8123.1	
21	Умайн хувууний өмөнгийн эрт илрүүдлийн үзлэгийн хувь, 2017 он																					35.2	35.2	
22	Жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа хяналтанд хамрагдсан эмэгтэйтүүдийн хувь, 2017 он																							
23	Жирэмсний эхний 3 сартайд хяналтанд авсан жирэмсэн эмэгтэйтүүд, 1000-д /22 жилийн дундаж/	33.9	51.4	61.6	54.6	51.7	67.9	71.4	82.6	81.8	82.8	82.8	82.4	85.3	85	86	88	85.7	89.2	86.8	83.2	87.2	75.7	
24	Вируст талитын өвчлөл, 10000 хүн амд*								10.6	9.4	7.5	11.5	136.1	73.3	11.4	8.3	51	57.4	18.9	3.9	2.8	2.8	27.3	
25	Сурьсэгийн тохиолдол, 10000 хүн амд*								4.9	5.8	5.2				6.7	3.9	5.1	3.8	3.8	3.3	4.5	4.2	4.7	
26	Амьсгалын тогтолцооны өвчин, 10 000 хүн амд	861.1	1255. 4	1270.4	1008.4	1157.7	1017.6	1239.3	1356.4	1416.8	1336.5	1196.3	1513.4	1582.4	2033.3	2531.8	2157.6	1974.1	1788.1	2247.8	2775.8 8	2907.3 7	1677.8	
27	Хоол боловруулах тогтолцооны өвчин, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	571.6	633.5	546	512	741.6	573.2	658.2	709.5	798.7	936.5	999.3	953.2	952.8	991.8	1311.1	970.6	1242.2	1426.3	1430.9	2345.6 7	2029.6	1053.9	

Төвийн бүсийн говийн дэд бүсийн эрүүл мэндийн салбарын хөгжил, байршлын судалгаа

28	Шээс бэлгийн тогтоцооны эмгэг, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	331	505.6	674.2	659.4	546.5	608.1	543.6	600.5	656.4	659.8	561.9	683.7	644.6	746.7	823.9	670.8	729.5	752.9	760	830.2	849.7	889.67	669.5
29	Хорт хавдар, 10 000 хүн амд*	12	16.2	19.2	7.6	10	20.3	10.8	10.2	10.1	8.7	26.7	37.6	21.8	25.1	21.9	20	32.6	27.4	25.5	18.2	12.2	18.8	
30	Зурх судасны өвчлөл, 10 000 хүн амд*	287.1	354.2	403.5	229.1	404.6	356	475.9	532.7	589.3	565.6	726.6	722.8	837.2	953.9	812	824.5	878.5	932.6	1199.2	1323.1	1233.5	690.6	
31	Өвчлөл ба нас баралтын гадны шалтгаан, 10 000 хүн амд								163.16	232.19	246.56	364.8	315.64	380.28	430.91	397.38	301.4	396.31	308.57	316.94	225.99	274.08	306.3	
32	Халдварт ба шимэгчиг зарим өвчин, 10 000 хүн амд /22 жилийн дундаж/	106.2	70.7	81.8	72.2	84.4	146.5	116.9	46.2	34.5	59.4	184.7	119.4	64.5	60.6	166.7	84.3	74.4	87.5	166.3			95.0	
33	Үр хөндлөлт /1000 амьд төрөлтөд/ /22 жилийн дундаж/	184.4	188	183.9	138.9	235.4	198.6	310.7	354.1	398.8	210.5	202.9	154.5	130.9	86.9	212.9	323.6	216.3	370.6	340.9	301.6	469.6	254.4	
34	Мэс заслын хүндрэлийн хувь /22 жилийн дундаж/	0.7	0.6	0.3	0.7	0.5	0.3	0.3	0.35	0.8	0	0.5	0.4	1.1	0.7	0.3	0.3	0.5	0.1	0.3	0.2	0.1	0.4	

Хавсралт 6. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн тогтвортой хөгжлийн зорилтын эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтүүд, 2017 оны байдлаар

	2016-2020 онд хүрэх түвшин	Говьсүмбэр	Дорноговь	Дундговь	Өмнөговь
Дундаж наслалт	71	73,01	70,6	73,6	71,8
Эхийн эндэгдэл, 100000 амьд төрөлтөд	25	0	0	0	76,9
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, 1000 амьд төрөлтөд	15	7,2	12,8	9,1	16,1
Нялхсын эндэгдлийн түвшин, 1000 амьд төрөлтөд	13	14,4	13,6	15,9	20,0
Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт, 10000 хүн амд	17,4	18,6	13,8	21,7	18,6
Хорт хавдраас шалтгаалсан нас баралт, 10000 хүн амд	10,5	15,1	12,3	14,4	8,5
Товлолт дөрхлөх хамралтын хамралтын хувь	98,5	99,5	99,6	99,3	98,6
Вируст гепатитын өвчлөл, 10000 хүн амд	3	0	1,4	1,8	2,8
Сүрьеэгийн тохиолдол, 10000 хүн амд	14,4	16,3	14,2	8,8	4,2

Эрүүл мэндийн салбарт дараах бодлогын баримт бичгүүд мөрдөгдөж байна. Үүнд:

Хавсралт 7. Эрүүл мэндийн салбарын хөгжлийн бодлогын баримт бичгийн жагсаалт

Хөгжлийн бодлогын баримт бичиг	Батлагдсан он	Баталсан субъект	Хүчин төгөлдөр эсэх
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	2016 оны 45-р тогтоол	УИХ	хүчин төгөлдөр
Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр багтах тухай			
Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал	2016 оны 19-р тогтоол	УИХ	хүчин төгөлдөр
Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 багтах тухай			
Төрөөс баримтлах бодлого	2017 оны 24-р тогтоол	Засгийн газар	хүчин төгөлдөр
Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого			
Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр	2018 оны 140-р тогтоол	Засгийн газар	хүчин төгөлдөр
Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр			
Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	2018 оны 37-р тогтоол	УИХ	хүчин төгөлдөр
“Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай”			
Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги (2015 – 2025 он)	2015 оны 353-р тогтоол	Засгийн газар	хүчин төгөлдөр
Үндэсний хөтөлбөр			
7.1 Эрүүл насжилт, настны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр /i үе шаг 2014-2017 он, ii үе шаг 2018-2020 он/	2013.12.14-ний тогтоол 416-р	Засгийн газар	хүчин төгөлдөр
7.2 Элэг бүтэн монгол үндэсний хөтөлбөр (2017-2020 он)	2017.04-12-ны 112-р тогтоол	Засгийн газар	хүчин төгөлдөр
7.3 Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр /2016-2025 он/	2015.11.16-ны 447-р тогтоол	Засгийн газар	хүчин төгөлдөр
7.4 Хотжилт ба эрүүл мэнд үндэсний хөтөлбөр (2016 – 2020 он)	2016.01.04-ний 4-р тогтоол	Засгийн газар	хүчин төгөлдөр
7.5 Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр (2017 – 2021 он)	2017.09.27-ны 289-р тогтоол	Засгийн газар	хүчин төгөлдөр
7.6 Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр (2017-2021 он)	2017.01.11-ны 11-р тогтоол	Засгийн газар	хүчин төгөлдөр

7.7	Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр (2017-2020)	2017.08.09-ний тогтоол	225-р	Засгийн газар	хүчин төгөлдөр
7.8	Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр (2018 – 2022 он)	2018.05.30-ны	163-р тогтоол	Засгийн газар	хүчин төгөлдөр
7.9	Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр (2017-2021 он)	2017.03.07-ны	78-р тогтоол	Засгийн газар	хүчин төгөлдөр
7.10	Эрүүл шүд, эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөр (2019-2023 он)	2018.08.15-ны	255-р тогтоол	Засгийн газар	хүчин төгөлдөр
7.11	Эрүүл мэнд үндэсний хөтөлбөр (2010-2021 он)	2010.10.13 –ны тогтоол	268-р	Засгийн газар	хүчин төгөлдөр
7.12	Сэтгэцийн эрүүл мэнд үндэсний 2 дахь хөтөлбөр (2010-2019 он)	2009.09.30-ны	303-р тогтоол	Засгийн газар	хүчин төгөлдөр

Хавсралт 8. Эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн баримт бичгийн жагсаалт, батлагдсан он, баталсан субъект

Д/Д	Хууль, тогтоомжийн нэр	Батлагдсан/ш инэчилсэн найруулгын огноо	Баталсан субъект	Хүчингэй эсэх
Хууль				
1	Эрүүл мэндийн тухай хууль	2016.04.22	УИХ	хүчин төгөлдөр
2	Эрүүл мэндийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль	2016.04.22	УИХ	хүчин төгөлдөр
3	Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль	2016.04.22	УИХ	хүчин төгөлдөр
4	Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль	2016.04.22	УИХ	хүчин төгөлдөр
5	Эрүүл ахуйн тухай хууль	2016.02.14	УИХ	хүчин төгөлдөр
6	Эрүүл мэндийн даатгалын тухай хууль	2015.01.29	УИХ	хүчин төгөлдөр
7	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль	2015.01.29	УИХ	хүчин төгөлдөр
8	ХДХВ, ДОХ-оос сэргийлэх тухай хууль	2012.12.13	УИХ	хүчин төгөлдөр
9	Тамхины хяналтын тухай хууль	2012.10.27	УИХ	хүчин төгөлдөр
10	Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль	2013.01.03	УИХ	хүчин төгөлдөр
11	Тамхины бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай протоколыг соёрхон батлах тухай	2014.04.24	УИХ	хүчин төгөлдөр
12	Донорын тухай хууль	2018.01.19	УИХ	хүчин төгөлдөр
13	Нялх балчир насны хүүхдийн хоол тэжээлийн тухай хууль		УИХ	хүчин төгөлдөр

14	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай			УИХ	хүчин төгөлдөр
15	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль		2003.05.30	УИХ	хүчин төгөлдөр
16	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль		2006.12.15	УИХ	хүчин төгөлдөр
Бодлогын баримт бичиг					
1	Төрөөс эмийн талаар баримтлах бодлого		2014.10.09	УИХ-ын 57-р тогтоол	хүчин төгөлдөр
2	Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030		2016.02.05	УИХ-ын 19-р тогтоол	хүчин төгөлдөр
3	Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал		2001.06.14	УИХ-ын 57-р тогтоол	хүчин төгөлдөр
4	Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого		2004.04.23	УИХ-ын 21-р тогтоол	хүчин төгөлдөр
5	Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр багтах тухай		2016.09.09	УИХ-ын тогтоол 45-р тогтоол	хүчин төгөлдөр
6	Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги (2015 – 2025 он)		2015.08.31	Засгийн газрын 353-р тогтоол	хүчин төгөлдөр
Засгийн газрын тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөрүүд					
1	Эрүүл насжилт, настны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр /i үе шат 2014-2017 он, ii үе шат 2018-2020 он/		2013.12.14	ЗГ-ын 416-р тогтоол	хүчин төгөлдөр
2	Элэг бүтэн монгол үндэсний хөтөлбөр (2017-2020 он)		2017.04.12	ЗГ-ын 112-р тогтоол	хүчин төгөлдөр
3	Хүн амын хоол гэжээл үндэсний хөтөлбөр /2016-2025 он/		2015.11.16	ЗГ-ын 447-р тогтоол	хүчин төгөлдөр
4	Хөгжилт ба эрүүл мэнд үндэсний хөтөлбөр (2016 – 2020 он)		2016.01.04	ЗГ-ын 4-р тогтоол	хүчин төгөлдөр
5	Халдварт бус өвчингэй гэмцэх үндэсний хөтөлбөр (2017 – 2021 он)		2017.09.27	ЗГ-ын 289-р тогтоол	хүчин төгөлдөр
6	Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр (2017-2021 он)		2017.01.11	ЗГ-ын 11-р тогтоол	хүчин төгөлдөр
7	Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр (2017-2020)		2017.08.09	ЗГ-ын 225-р тогтоол	хүчин төгөлдөр
8	Осол, гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр (2018 – 2022 он)		2018.05.30	ЗГ-ын 163-р тогтоол	хүчин төгөлдөр
9	Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр (2017-2021 он)		2017.03.07	ЗГ-ын 78-р тогтоол	хүчин төгөлдөр
10	Эрүүл шүд, эрүүл хүүхэд үндэсний хөтөлбөр (2019-2023 он)		2018.08.15	ЗГ-ын 255-р тогтоол	хүчин төгөлдөр
11	Эрүүл мэнд үндэсний хөтөлбөр (2010-2021 он)		2010.10.13	ЗГ-ын 268-р тогтоол	хүчин төгөлдөр

12	Сэтгэцийн эрүүл мэнд үндэсний 2 дахь хөтөлбөр (2010-2019 он)	2009.09.30	ЗГ-ын 303-р тогтоол	хүчин төгөлдөр
----	--	------------	---------------------	----------------

Хавсралт 9. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бодлогын баримт бичгийн нэгтгэл - үндэсний, бүсийн, аймгийн, сумын түвшинд

Боловсрол	Урт 15-20 жил	Дунд хугацааны			Богино		Нийт
		8-10 жил	3-5 жил	1 жил	1 жил		
<i>Нийт хүчинтэй /Улс, аймаг/</i>	2	6	32	8	48		
Үндэсний /улс/ түвшний	2	3	13	2	20		
Бүсийн түвшний	0	1	0	0	1		
Аймгийн түвшинд	0	2	19	6	27		
<i>Говьсүмбэр</i>	1	1	3	1	5		
<i>Дорноговь</i>	1	1	7	1	9		
<i>Дундговь</i>			5	1	6		
<i>Өмнөговь</i>			4	3	7		
Нийт хүчинтэй /Сумын ИТХ багалсан/	0	2	0	47	49		
Говьсүмбэр	0	0	0	3	0		
Баянтал				1			
Сүмбэр				1			
Шивээговь				1			
Дорноговь	0	0	0	14	0		
Их хэт				1			
Хөвсгөл				1			
Сайншанд				1			
Айраг				1			
Алтанширээ				1			
Даланжаргалан				1			
Дэлгэрэх				1			
Замын Үүд				1			

Мандах						1	
Өргөн						1	
Сайхандулаан						1	
Улаанбадрах						1	
Хаганбулаг						1	
Эрдэнэ						1	
Дундговь	0	0	0	0	0	15	0
Баянжаргал						1	
Говь-Угтаал						1	
Дэлгэрцогт						1	
Өндөршил						1	
Эрдэнэдалай						1	
Дэлгэрхангай						1	
Дөрөн						1	
Луус						1	
Өлзийт						1	
Сайхан-Овоо						1	
Хулд						1	
Цагаандэлгэр						1	
Сайнцагаан						1	
Адаацаг						1	
Гурвансайхан						1	
Өмнөговь	0	2	0	0	0	15	0
Даланзадгад						1	
Манлай						1	
Сэврэй						1	
Цогтцэций						1	
Баяндалай						1	
Баян-Овоо						1	
Булган						1	
Гурвантэс						1	

Мандал-Овоо							1	
Ноён							1	
Номгон			1				1	
Ханбогд							1	
Ханхонгор							1	
Хүрмэн							1	
Цогт-Овоо			1				1	

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН

Хавсралт 10. Төвийн бүсийн говийн дэд бүсийн 4 аймгийн эрүүл мэндийн салбарын бодлогын баримт бичгийн дүн шинжилгээ

Үндэсний хөтөлбөрүүд										
1	Баримт бичгийн нэр	Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр	Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр	Эх хүүхэд, Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр	Элэг бүтэн монгол үндэсний хөтөлбөр	Сэтгэцийн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр	Эрүүл насжигт, настны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр	Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр	Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр	Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого
2	Хэрэгжих хугацаа	2017-2021	2017-2021	2017-2021	2017-2020	2010-2019	2014-2020	2016-2025	2017-2020	2017-2026
3	Шийдвэр	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын тогтоол
Говь-Сүмбэр аймаг										
1	Бодлогын баримт бичиг байгаа эсэх	Бие даасан хөтөлбөр байхгүй.	Бие даасан хөтөлбөр байхгүй.	Бие даасан хөтөлбөр байхгүй.	Бие даасан хөтөлбөр байхгүй.	Бие даасан хөтөлбөр байхгүй.	Бие даасан хөтөлбөр байхгүй.	Бие даасан хөтөлбөр байхгүй.	Бие даасан хөтөлбөр байхгүй.	Засаг даргын мөрийн хөтөлбөр, Аймгийн эрүүл мэндийн салбарыг хөгжүүлэх хөтөлбөрт заалтууд туссан
2	Он цагийн нийцэл, хөгжлийн бодлогын тухай хуульд нийцүүлэх.	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓
3	Байршил заагдсан эсэх, бодлого ба байршил	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй
4	Батлагдсан газар									
4.1	Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр Аймгийн ИТХ-ын 2016 оны 11 сарын 30-ны өдрийн 04 тоот тогтоол	Заалт 5	Заалт 5	Заалт 4	Заалт 5	-	-	-	-	Заалт 1,2,3
4.2	Аймгийн эрүүл мэндийг хөгжүүлэх дэд хөтөлбөр	Заалт 2	Заалт 1	-	-	-	-	-	-	Заалт 3, 4, 5

Аймгийн Засаг даргын 2018 оны А/85-р захирамж																
Мэдээллийн эх сурвалж																
Захиргааны вэб хуудас	✓		✓													
Яамнаас авсан мэдээлэл	✓		✓													
6	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус			
7	Хөгжүүлэх нийлүүлэлтийн сүлжээ															
Дундговь аймаг																
1	Бодлогын баримт бичиг байгаа эсэх	<p>Дундговь аймаг дахь Төрийн аудитын газраас 2017 онд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудитын хийсэн байна.</p> <p>ДУГНЭЛТ: Тус тайланд УАГ-НАГ/2017/07-НА/ “Аймгийн хэмжээнд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.” Гэсэн байна.</p> <ol style="list-style-type: none"> Хөгжлийн бодлогын баримт бичгийн төсөл боловруулах үйл ажиллагааг зохион байгуулах төлөвлөгөөгүй ажиллажээ. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр боловруулахдаа нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, зорилго зорилгын уялдааг тодорхойлох, бодлогын хувилбаруудыг боловруулах ажил хийгдээгүй байна. Бодлогын баримт бичгийн төслийн хувилбарууд боловруулагдаагүй тул нөлөөллийн урьдчилсан үнэлгээ хийгдээгүй, төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн гэж тайлагнасан боловч нотлох баримтгүй байна. Бодлогын баримт бичигт зорилго, зорилт, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, санхүүгийн тооцооллыг тусгасан боловч хууль журамд бүрэн нийцэхгүй байна. “Шинээр боловруулах дэд хөтөлбөр”-ийн жагсаалтыг боловруулж багтуулаагүй байна. Үндэсний хэмжээнд хэрэгжих бодлогын баримт бичгийн тайланг хугацаанд нь ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийгээгүй, ЗГХЭГ-г хүргүүлээгүй байна. Хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг нэгтгэх, үнэлж дүгнэх ажлыг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих, мэдээлэх үүрэг бүхий байгууллага болон албан тушаалтан үүрэг хангалтгүй хэрэгжүүлж байна. Сумдад хөгжлийн бодлогын баримт бичгийг олон нийгэд мэдээлэх, сурталчилах ажил хангалтгүй байна. 														Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр

2	Он цагийн нийцэл, хөгжлийн бодлогын тухай хуульд нийцүүлэх. Байршил заагдсан эсэх, бодлого ба байршил	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓	✓			Эрдэнэдалай суманд шинэ эмнэлэг Говьутгаал, гурвансайхан, Өлзийт сумын эмнэлгийг засварын ажил хийнэ.	✓	
3		үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй					
4	Баглагдсан газар																
4.1	Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр	Заалт 1,3	Заалт 1,10,12	Заалт 2												Заалт 4-10	
5	Мэдээллийн эх сурвалж	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас				Захиргааны вэб хуудас	
6	тогтвортой хөгжлийн зорилт 2030 нийцэл	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус				Яамны мэдээлэл	
7	Хөгжүүлэх нийлүүлэлтийн сүлжээ	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Шалгуур үзүүлэлт тодорхой бус				Шалгуур үзүүлэлт тодорхой бус	
Дорноговь аймаг																	
1	Бодлогын баримт бичиг байгаа эсэх	Аймгийн дэд хөтөлбөр батлагдсан	Бие даасан хөтөлбөр байхгүй	Аймгийн дэд хөтөлбөр батлагдсан	Аймгийн дэд хөтөлбөр батлагдсан	Аймгийн дэд хөтөлбөр батлагдсан	Бие даасан хөтөлбөр байхгүй	Аймгийн дэд хөтөлбөр батлагдсан	Бие даасан хөтөлбөр байхгүй	Аймгийн дэд хөтөлбөр батлагдсан	Бие даасан хөтөлбөр байхгүй	Аймгийн дэд хөтөлбөр батлагдсан	Бие даасан хөтөлбөр байхгүй	Бие даасан хөтөлбөр байхгүй	Бие даасан хөтөлбөр байхгүй	“Эрүүл ирээдүй – Дорноговь” аймгийн дэд хөтөлбөр	“Дорноговь аймгийн эрүүл мэндийн салбарын

													Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах” аймгийн дэд хөтөлбөр
2	Он цагийн нийцэл, хөгжлийн бодлогын тухай хуульд нийцүүлэх.	Нийцэж байна.	Нийцэж байна.	Нийцэж байна.	-	Нийцэж байна.	-	Нийцэж байна.	-	-	-	-	
3	Байршил заагдсан эсэх, бодлого ба байршил	Үгүй	Үгүй	Үгүй	-	Үгүй	-	Үгүй	-	-	-	-	Үгүй
4	Багтаагдсан газар	ИТХ-ын 2017 оны 05-р сарын 10-ны өдрийн 45-р тогтоол	ИТХ-ын 2017 оны 05-р сарын 30-ны өдрийн 55-р тогтоол	ИТХ-ын 2017 оны 05-р сарын 10-ны өдрийн 44-р тогтоол	-	ИТХ-ын 2017 оны 05-р сарын 10-ны өдрийн 44-р тогтоол	-	ИТХ-ын 2015 оны 10-р сарын 06-ны өдрийн 37-р тогтоол	-	-	-	-	ИТХ-ын 2017 оны 05-р сарын 30-ны өдрийн 55-р тогтоол ИТХ-ын 2018 оны 04-р сарын 20-ны өдрийн 34-р тогтоол
4.1	Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр												
5	Мэдээллийн эх сурвалж	Захиргааны вэб хуудас Яамны мэдээлэл	Захиргааны вэб хуудас Яамны мэдээлэл	Захиргааны вэб хуудас Яамны мэдээлэл	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас Яамны мэдээлэл	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас Яамны мэдээлэл
6	Тогтвортой хөгжлийн зорилт 2030 нийцэл	Нийцэж байна.	Нийцэж байна.	Нийцэж байна.									
7	Хөгжүүлэх нийлүүлэлтийн сүлжээ												
Өмнөговь аймаг													
1	Бодлогын баримт бичиг байгаа эсэх	Бие даасан хөтөлбөр байхгүй	Аймгийн дэд хөтөлбөр багтаагдсан	Аймгийн дэд хөтөлбөр багтаагдсан	Аймгийн дэд хөтөлбөр багтаагдсан	Аймгийн дэд хөтөлбөр багтаагдсан	Аймгийн дэд хөтөлбөр багтаагдсан	Аймгийн дэд хөтөлбөр багтаагдсан	Бие даасан хөтөлбөр байхгүй	Бие даасан хөтөлбөр байхгүй	Бие даасан хөтөлбөр байхгүй	Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл	

2	Он цагийн нийцэл, хөгжлийн бодлогын тухай хуульд нийцүүлэх.	-	Оновчтой бус	Нийцэж байна.	-	-	-	Оновчтой бус	ажиллагааны төлөвлөгөө
3	Байршил заагдсан эсэх, бодлого ба байршил	-	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй	үгүй
4	Баглагдсан газар	-	ИТХ-ын 2015 оны 04-р сарын 23-ны өдрийн 58-р тогтоол	ИТХ-ын 2016 оны 11-р сарын 28-ны өдрийн 53-р тогтоол	ИТХ-ын 2016 оны 11-р сарын 28-ны өдрийн 52-р тогтоол	-	-	-	Аймгийн Засаг даргаар батлуулсан
4.1	Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр								
5	Мэдээллийн эх сурвалж	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас	Захиргааны вэб хуудас Яамны мэдээлэл
6	тогтвортой хөгжлийн зорилт 2030 нийцэл	Яамны мэдээлэл Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Яамны мэдээлэл Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Яамны мэдээлэл Нийцэж байна.	Яамны мэдээлэл Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Яамны мэдээлэл Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Яамны мэдээлэл Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Яамны мэдээлэл Шалгуур үзүүлэлт тодорхой бус	Яамны мэдээлэл Шалгуур үзүүлэлт тодорхой бус
7	Хөгжүүлэх нийлүүлэлтийн сүлжээ								

Хавсралт 11. Говьсүмбэр аймагт хэрэгжиж буй эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн уялдаа холбоо

	Нэр	Эрүүл мэндийн чиглэлээрх заалтууд	ТХУБ-ын зорилт
1	Аймгийн эрүүл мэндийг хөгжүүлэх дэд хөтөлбөр	<ol style="list-style-type: none"> Хүн амд эрүүл ахуйн мэдлэг, дадал олгох модуль, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг тооцож үнэлгээ хийх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх идэвхи санаачилгыг өрнүүлэх, ухуулга нөлөөллийн ажлыг бүх шатанд хийх Зонхилон тохиолдох гепатитийн В, С вирус, сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, хорт хавдрыг эрт илрүүлж, өвчлөл нас баралтыг бууруулна. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцааны сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна. Нэн шаардлагатай үндсэн болон нарийн мэргэжлийн болон төрөлжсөн мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтаар эмч мэргэжилтнүүдийг сургаж чадавхижуулах Эмч мэргэжилтнүүдийг өндөр хөгжилтэй улс орны төрөлжсөн төв эмнэлгүүдэд сургах, туршлага судлуулах, сэлгэн ажиллуулах үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулах 	<p>Бүлэг 2.2.2. Зорилт 1</p> <p>Бүлэг 2.2.2. Зорилт 4</p> <p>Бүлэг 2.2.2. Зорилт 1</p>
2	Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр	<ol style="list-style-type: none"> Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог сайжруулан, оношилгоо үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. Аймгийн нэгдсэн эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. Сумдын эрүүл мэндийн төвүүдийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, нялхсын эндэгдлийг бууруулна. Зонхилон тохиолдох В, С вирус, сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, хорт хавдрыг эрт илрүүлж, өвчлөл нас баралтыг бууруулна. 	<p>Бүлэг 2.2.2. Зорилт 1</p> <p>Бүлэг 2.2.2. Зорилт 1</p> <p>Бүлэг 2.2.2. Зорилт 1</p> <p>Бүлэг 2.2.2. Зорилт 2</p> <p>Бүлэг 2.2.2. Зорилт 1</p> <p>Зорилт 1</p> <p>Зорилт 3</p> <p>Зорилт 4</p>

Хавсралт 12. Дорноговь аймагт хэрэгжиж буй эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн уялдаа холбоо

	Нэр	Эрүүл мэндийн чиглэлээрх заалтууд	ТХУБ-ын зорилт
1	Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах дэд хөтөлбөр	Бие даасан дэд хөтөлбөр тул үндэсний хөтөлбөртэй нийцэж байна.	Бүлэг 2.2.2. Зорилт 4
2	“Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” аймгийн дэд хөтөлбөр	Бие даасан дэд хөтөлбөр тул үндэсний хөтөлбөртэй нийцэж байна.	Бүлэг 2.2.2. Зорилт 2
3	“Элэг бүтэн Дорноговь” аймгийн дэд хөтөлбөр	Бие даасан дэд хөтөлбөр тул үндэсний хөтөлбөртэй нийцэж байна.	Бүлэг 2.2.2. Зорилт 1
4	“Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” аймгийн дэд хөтөлбөр	Бие даасан дэд хөтөлбөр тул үндэсний хөтөлбөртэй нийцэж байна.	Бүлэг 2.2.2. Зорилт 1 Зорилт 3
5	“Дорноговь аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах” аймгийн дэд хөтөлбөр	Бие даасан дэд хөтөлбөр тул Эрүүл мэндийн талаар төрөөс баримглах бодлогын “Хүний нөөц”-ийн талаарх зорилттой нийцэж байна.	Бүлэг 2.2.2. Зорилт 1

Хавсралт 13. Дундговь аймагт хэрэгжиж буй эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн уялдаа холбоо

	Нэр	Эрүүл мэндийн чиглэлээрх заалтууд	ТХУБ-ын зорилт
1	Аймгийн Засаг даргын 2016-2020 оны ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга	<ol style="list-style-type: none"> Иргэдийг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгт жилд нэг удаа хамруулж, В,С вирусийн илрүүлэлт, эмчилгээг сайжруулж, зонхилон тохиолдох хавдрын өвчлөлийг бууруулна. Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр “Нөхөн үржихүйн эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлэн хүүхдийн эндэгдлийн шалтгааныг судлан, оношилгоо эмчилгээг сайжруулж, нялхсын эндэгдлийг бууруулах, чиглэлээр зарим суманд КТГ-ын аппаратаар хангах 	Бүлэг 2.2.2. Зорилт 2 Зорилт 3 Бүлэг 2.2.2. Зорилт 2

Хэмжээний төлөвлөгөө	<p>3. Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гамшиг осол, онцгой байдал, шинэ сэргэж буй халдварын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангуулж, нөөцийг бүрдүүлнэ.</p> <p>4. Эрүүл мэндийн байгууллагуудад цахим эрүүл мэнд төслийг хэрэгжүүлж, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн үйлчилгээ авах шаг дамжлага, чирэгдлийг бууруулж, мэдээлэл технологийн програм хангамжийг сайжруулна.</p> <p>5. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, нэгдсэн эмнэлгийн эмчилгээ оношилгооны чадавхийг сайжруулахад нэн шаардлагагай орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангана.</p> <p>6. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд зөөврийн зүрхний цахилгаан бичлэг, ЭХО аппарат бүхий мобайл технологийг нэвтрүүлж, хоёрдогч шатлалын эмнэлгээс цаг алдалгүй зөвлөгөө авах боломжийг бүрдүүлнэ.</p> <p>7. Нэгдсэн эмнэлгийг зориулалтын тоноглогдсон түргэн тусламжийн автомашинтай болгож, аймгийн хэмжээнд яаралтай тусламжийн чанар хүргээмжийг сайжруулна.</p> <p>8. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд автомашины парк шинэчлэлийг хийж, багийн эмчийн унааны асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.</p> <p>9. Төрөөс эмийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэн иргэдэд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, жороор олгож хэвшүүлэх, зайлшгүй шаардлагагай эмийн хангалтыг нэмэгдүүлэн, эмийн санд тавих хяналтыг сайжруулна.</p> <p>10. Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн идэвхи оролцоог нэмэгдүүлэн салбар дундын хамтын ажиллагааг сайжруулж, “Эрүүл хог, сум, баг, байгууллага, өрх, иргэн” -ийг бий болгох “Эрүүл иргэнтэй Дундговь” аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</p> <p>11. Явуулын тусламж үйлчилгээгээр алслагдсан сум баг, малчин иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.</p> <p>12. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, эрүүл зан үйл, хандлага, дадлыг төлөвшүүлэх, энэ чиглэлээр гаргасан шинэ санаа санаачилгыг дэмжинэ</p> <p>13. Шаардлагагай сумдын эрүүл мэндийн төвийн барилга засварлах буюу шинээр барьж, нэгдсэн эмнэлгийн барилгын сантехникчийн засвар, угаалга, мооргийн барилгын их засвар, амбулагорын барилгын хүүзүүвч, хүлээлгийн танхимыг шинээр барина.</p>	<p>Бүлэг 2.2.2. Зорилт 4</p> <p>Бүлэг 2.2.2. Зорилт 1</p> <p>Бүлэг 2.2.2. Зорилт 1</p> <p>Бүлэг 2.2.2. Зорилт 1</p> <p>Бүлэг 2.2.2. Зорилт 4</p> <p>Бүлэг 2.2.2. Зорилт 1</p> <p>Бүлэг 2.2.2. Зорилт 1</p> <p>Бүлэг 2.2.2. Зорилт 1</p> <p>Бүлэг 2.2.2. Зорилт 1</p> <p>Бүлэг 2.2.2. Зорилт 1</p>
----------------------	---	---

2	Аймгийн Засаг даргын А/506 дугаар захирамж	“Эрүүл иргэнтэй Дундговь” дэд хөтөлбөр	Бүлэг 2.2.2. Зорилт 1
---	--	--	--------------------------

Хавсралт 14. Өмнөговь аймагт хэрэгжих бүй эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн уялдаа холбоо

	Нэр	Эрүүл мэндийн чиглэлээрх заалтууд	ТХУБ-ын зорилт
1	Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх Аймгийн засаг даргын үйл ажиллагааны “Бид хамтдаа” хөтөлбөр	<p>Нийт 17 зорилттой. Эрүүл чийрэг - Өмнөговьчууд</p> <p>39. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, урьдчилан сэргийлэх үзлэгийн тоо, хамрах хүрээг нэмэгдүүлнэ.</p> <p>40. Эх хүүхдийн эрүүл мэнд хөтөлбөр хэрэгжүүлнэ.</p> <p>41. Эрүүл шүд хөдөлгөөнийг өрнүүлж, иргэн бүрийг хамруулна.</p> <p>42. Элэгний хагуурал, хорт хавдраас сэргийлэх “Элэг бүтэн Өмнөговь” хөтөлбөр хэрэгжүүлнэ.</p> <p>43. Хүүхэд, өсвөр үеийнхэнд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг өргөжүүлнэ.</p> <p>44. Халдварт өвчний гаралтыг бууруулж, БЗДХ/ХДХВ-ээс сэргийлж, “Сайн дурын зөвлөгөө шинжилгээний төв”-ийн тоог нэмэгдүүлнэ.</p> <p>45. Төв суурин газрын хүн амын ундны усны эрүүл ахуй аюулгүй байдлыг сайжруулж, орчны бохирдлыг бууруулна.</p>	<p>Бүлэг 2.2.2. Зорилт 1-4</p> <p>Бүлэг 2.3.1. Зорилт 2.</p>



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН



ТӨВИЙН БҮСИЙН ГОВИЙН ДЭД БҮСИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР
БОЛОВСРУУЛАХ СУДАЛГАА

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ
БАЙДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

ЭЦСИЙН ТАЙЛАН

2019 он

Зөвлөх:

Ч.Нарантуяа (PhD)

МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль

Эдийн засгийн тэнхим

МУИС-ийн хичээлийн 5-р байр, 603 тоот

Судлаач:

А.Заяадэлгэр

Интринсик ХХК

Төслийн захирал

Энэхүү тайлан нь захиалагч болон санхүүжүүлэгчийн байр суурь бус, судлаачдын байр суурийг илэрхийлнэ.

Агуулга

Хүснэгт	iii
Зураг	v
Талархал.....	vi
Товчилсон үгийн жагсаалт.....	vii
Тайлангийн хураангуй.....	1
1. Судалгааны хүрээ, зорилго, зорилт, арга аргачлал.....	6
2. Боловсрол	9
2.1 Боловсролын салбарын бодлогын уялдаа холбоо.....	9
2.1.1 Говьсүмбэр	10
2.1.2 Дорноговь.....	11
2.1.3 Дундговь.....	11
2.1.4 Өмнөговь	12
2.1.5 Боловсролын салбарын бодлогын талаарх дүгнэлт.....	12
2.2 Боловсролын салбарын өнөөгийн нөхцөл байдал	14
2.3 Боловсролын салбарын шалгуур үзүүлэлтүүд.....	17
2.4 Боловсролын салбарын өнөөгийн байдал: үнэлгээ ба үр дүн.....	19
2.4.1 Говьсүмбэр	19
2.4.2 Дорноговь.....	20
2.4.3 Дундговь.....	21
2.4.4 Өмнөговь	22
2.5 Боловсролын салбарын бодлогын хэрэгжилтийн үнэлгээ	23
2.6 Боловсролын салбарын бодлогод өгөх санал ба зөвлөмж	25
3. Соёл.....	29
3.1 Соёлын салбарын бодлогын уялдаа холбоо	30
3.1.1 Говьсүмбэр	31
3.1.2 Дорноговь.....	31
3.1.3 Дундговь.....	32
3.1.4 Өмнөговь	32
3.1.5 Соёлын салбарын бодлогын талаарх дүгнэлт	33
3.2 Соёлын салбарын өнөөгийн нөхцөл байдал.....	33
3.2.1 Хөгжлийг хэмжих соёлын үзүүлэлтүүд.....	35
3.2.2 Төрөөс үзүүлэх соёлын үйлчилгээ: үнэлгээ ба үр дүн	35
3.2.3 Соёлын өвийн ашиглалт: үнэлгээ ба үр дүн.....	39
3.3 Соёлын салбарын бодлогод өгөх санал ба зөвлөмж.....	45
4. Шинжлэх ухаан, технологи, инновац	48
4.1 ШУТ-ийн салбарын бодлогын уялдаа холбоо	50
4.1.1 Говьсүмбэр	51
4.1.2 Дорноговь.....	51
4.1.3 Дундговь.....	51
4.1.4 Өмнөговь	51
4.1.5 ШУТ-ийн салбарын бодлогын талаарх дүгнэлт	52
4.2 ШУТ-ийн салбарын өнөөгийн нөхцөл байдал	52
4.2.1 Шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийг хэмжих үзүүлэлтүүд	52
4.2.2 Уламжлалт мэдлэг ба шинжлэх ухаан	55
4.2.3 Монгол улсын шинжлэх ухаан, технологийн үзүүлэлтүүд	56
4.3 ШУТ-ийн салбарын бодлогод өгөх санал ба зөвлөмж.....	60

Номзүй	63
ХАВСРАЛТ	65
<i>ХАВСРАЛТ 1.</i> Боловсролын бодлогын жагсаалт, уялдаа.....	65
<i>ХАВСРАЛТ 2.</i> Боловсролын үр нөлөөний тооцоонд багтах үзүүлэлтүүд	65
<i>ХАВСРАЛТ 3.</i> Аймгуудын үзүүлэлтүүд	67
<i>ХАВСРАЛТ 4.</i> Хөгжлийн үзүүлэлтүүд дэх соёлын хэсгийг тооцох аргазүй	67
<i>ХАВСРАЛТ 5.</i> Төрийн үйлчилгээ	67
<i>ХАВСРАЛТ 6.</i> Соёлын өв	67
<i>ХАВСРАЛТ 7.</i> Шинжлэх ухаан, технологи.....	67

Хүснэгт

Хүснэгт 2.1 Боловсролын бодлогын баримт бичиг	10
Хүснэгт 2.2 Боловсролын БББ-ийн уялдаа	10
Хүснэгт 2.3 Говьсүмбэр аймгийн боловсролын салбарын бодлогын уялдаа.....	11
Хүснэгт 2.4 Дорноговь аймгийн боловсролын салбарын бодлогын уялдаа.....	11
Хүснэгт 2.5 Дундговь аймгийн боловсролын салбарын бодлогын уялдаа.....	12
Хүснэгт 2.6 Өмнөговь аймгийн боловсролын салбарын бодлогын уялдаа.....	12
Хүснэгт 2.7 Ерөнхий боловсролын үр нөлөөг харуулах үзүүлэлтүүд	14
Хүснэгт 2.8 Сургуулийн өмнөх боловсролын үр нөлөөг харуулах үзүүлэлтүүд.....	15
Хүснэгт 2.9 Ерөнхий боловсролын үзүүлэлтүүдийн нэгтгэл	15
Хүснэгт 2.10 Сургуулийн өмнөх боловсролын үзүүлэлтүүдийн нэгтгэл.....	16
Хүснэгт 2.11 Ерөнхий боловсролын шалгуур, өнөөгийн үнэлгээ.....	17
Хүснэгт 2.12 Сургуулийн өмнөх боловсролын шалгуур, өнөөгийн үнэлгээ	18
Хүснэгт 2.13 Говьсүмбэр аймгийн ерөнхий боловсролын үнэлгээ.....	19
Хүснэгт 2.14 Говьсүмбэр аймгийн сургуулийн өмнөх боловсролын үнэлгээ	20
Хүснэгт 2.15 Дорноговь аймгийн ерөнхий боловсролын үнэлгээ.....	20
Хүснэгт 2.16 Дорноговь аймгийн сургуулийн өмнөх боловсролын үнэлгээ	20
Хүснэгт 2.17 Дундговь аймгийн ерөнхий боловсролын үнэлгээ.....	21
Хүснэгт 2.18 Дундговь аймгийн сургуулийн өмнөх боловсролын үнэлгээ	22
Хүснэгт 2.19 Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын үнэлгээ.....	22
Хүснэгт 2.20 Өмнөговь аймгийн сургуулийн өмнөх боловсролын үнэлгээ.....	23
Хүснэгт 2.21 Боловсролын салбарын хууль, бодлогын хэрэгжилтийг хэмжих үзүүлэлтүүд.....	23
Хүснэгт 2.22 Говийн дэд бүсийн хүрээн дэх боловсролын салбарын бодлогын хэрэгжилт	24
Хүснэгт 2.23 Дундговь аймгийн боловсролын салбарын бодлогын хэрэгжилт	24
Хүснэгт 2.24 Дорноговь аймгийн боловсролын салбарын бодлогын хэрэгжилт	24
Хүснэгт 2.25 Говьсүмбэр аймгийн боловсролын салбарын бодлогын хэрэгжилт	25
Хүснэгт 2.26 Өмнөговь аймгийн боловсролын салбарын бодлогын хэрэгжилт.....	25
Хүснэгт 3.1 Соёлын бодлогын бичиг баримт.....	30
Хүснэгт 3.2 Соёлын бодлогын баримт бичгийн уялдаа	31
Хүснэгт 3.3 Говьсүмбэр аймгийн соёлын салбарын бодлогын уялдаа.....	31
Хүснэгт 3.4 Дорноговь аймгийн соёлын салбарын бодлогын уялдаа.....	32
Хүснэгт 3.5 Дундговь аймгийн соёлын салбарын бодлогын уялдаа.....	32
Хүснэгт 3.6 Өмнөговь аймгийн соёлын салбарын бодлогын уялдаа	32
Хүснэгт 3.7 Хөгжлийг хэмжих соёлын үзүүлэлтүүд	35
Хүснэгт 3.8 Соёлын эдийн засгийн үзүүлэлтүүд	35
Хүснэгт 3.9 Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллагын үйлчилгээний шалгуур.....	36
Хүснэгт 3.10 Музейн үйлчилгээний шалгуур	36
Хүснэгт 3.11 Аймгийн төвүүдийн театр, чуулгын үзүүлэлтүүд.....	36
Хүснэгт 3.12 Аймгийн төвүүдийн музейн үйлчилгээ.....	36
Хүснэгт 3.13 Аймгийн урлагийн мэргэжлийн байгууллагын үнэлгээ.....	37
Хүснэгт 3.14 Аймгийн музейн үнэлгээ	37
Хүснэгт 3.15 Сумдын соёлын үйлчилгээний шалгуур	37
Хүснэгт 3.16 Дорноговь аймгийн сумдын соёлын үйлчилгээний үнэлгээ	37
Хүснэгт 3.17 Дундговь аймгийн сумдын соёлын үйлчилгээний үнэлгээ.....	38
Хүснэгт 3.18 Өмнөговь аймгийн сумдын соёлын үйлчилгээний үнэлгээ	38
Хүснэгт 3.19 Говьсүмбэр аймгийн сумдын соёлын үйлчилгээний үнэлгээ	38
Хүснэгт 3.20 Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн шалгуур	38
Хүснэгт 3.21 Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын хэрэгжилт	39
Хүснэгт 3.22 Аймгийн үл хөдлөх соёлын дурсгалын нэгтгэл	42

Хүснэгт 3.23 Аймгийн үл хөдлөх дурсгалын нэгтгэл, төрлөөр.....	42
Хүснэгт 3.24 Аймгийн биет бус соёлын өвийн нэгтгэл, төрлөөр.....	43
Хүснэгт 3.25 Өмнөговь аймгийн соёлын өвийн нөөц, сумдаар.....	43
Хүснэгт 3.26 Дундговь аймгийн соёлын өвийн нөөц, сумдаар	43
Хүснэгт 3.27 Дорноговь аймгийн соёлын өвийн нөөц, сумдаар	44
Хүснэгт 3.28 Говьсүмбэр аймгийн соёлын өвийн нөөц, сумдаар	44
Хүснэгт 4.1 Шинжлэх ухаан, технологитой холбоотой бодлогын баримт бичиг.....	49
Хүснэгт 4.2 Шинжлэх ухаан, технологийн баримт бичгийн уялдаа	50
Хүснэгт 4.3 Нийт мэдүүлсэн патентын тоо	56
Хүснэгт 4.4 Нийт олгосон патентын тоо	57
Хүснэгт 4.5 Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарт ажиллагсадын тоо (аймаг, бүсээр).....	57
Хүснэгт 4.6 Шинжлэх ухааны салбарын байгууллагын тоо, ажиллагсадын тоо.....	58
Хүснэгт 4.7 Судалгаа боловсруулалтын чиглэлийн ажиллагсадын тоо	58
Хүснэгт 4.8 Судалгаа боловсруулалт чиглэлийн ажиллагсадын харьцуулсан тоо, 2016 оны байдлаар	58
Хүснэгт 4.9 Улсын төсвийн ШУТ-ийн салбарын зарцуулалт	58
Хүснэгт 4.10 Судалгаа боловсруулалтын чиглэлийн дотоодын нийт зарцуулалт.....	59

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭГЭЛЭН

Зураг

Зураг 1.1 Бодлогын үр нөлөө	8
Зураг 3.1 ЮНЕСКО-гийн мэдээллийн сан дахь Монгол улсын соёлын мэдээлэл	29
Зураг 4.1 Нэг сая оршин суугчдад оногдох судлаачдын тоо, дэлхийн бүс нутгаар	53
Зураг 4.2 Дунд болон бага орлоготой орнуудын инновац нэвтрүүлж буй пүүсийн хувь (боловсруулах салбарын нийт пүүсэд эзлэх хувийн жин).....	54
Зураг 4.3 Web of Science санд бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн Монгол улсын шинжлэх ухааны бүтээлийн тоо	56
Зураг 4.4 Судалгаа боловсруулалтын дотоодын нийт зардлын ДНБ-д эзлэх хувийн жин, дэлхийн бүс нутгаар 2016 онд	59

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭГ

Талархал

Энэхүү судалгааг хийхэд шаардлагатай мэдээллээр хангаж, зөвлөгөө өгсөн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Үндэсний статистикийн хороо, Үндэсний хөгжлийн газар, Соёл, урлагийн газрын албаны хүмүүст талархал илэрхийлье.

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН

Товчилсон үгийн жагсаалт

БББ	Бодлогын баримт бичиг
БМС	Боловсролын мэдээллийн систем
БСШУСЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БТХ	Барилгын тухай хууль
ЕБ	Ерөнхий боловсрол
ЕШ	Ерөнхий шалгалт
ЗД	Засаг дарга
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
МУЗГ	Монгол улсын Засгийн газар
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СТХ	Соёлын тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ХСҮ	Хөгжлийг хэмжих соёлын үзүүлэлтүүд /Хөгжлийн үзүүлэлтүүд дэх соёлын хэсэг/
ШУА	Шинжлэх ухааны академи
ШУТ	Шинжлэх ухаан, технологи

Тайлангийн хураангуй

Энэхүү тайланд Төвийн бүсийн Говийн дэд бүсийн дөрвөн аймаг болох Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгийн боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын талаар хэрэгжүүлж буй бодлого, тэдгээрийн төрийн бодлоготой нийцж буй эсэхэд дүгнэлт хийлээ. Мөн тус салбарын хөгжлийн өнөөгийн байдал, ялангуяа олон улсын хөгжлийн хандлага, Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-ийн хүрээнд тавьсан зорилт болон тэдгээртэй харьцуулахад бидний судалж буй дөрвөн аймгийн хувьд өнөөгийн хүрсэн түвшин ямар байгаа талаар тоон болон чанарын мэдээлэлд суурилан шинжилгээ хийж, дүгнэлт гаргав. Бодлогын нийцэл болон өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ, дүгнэлтэд суурилан цаашид бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, энэ чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, салбарын хөгжлийн бодлого, цаашилбал, энэ дөрвөн аймгийн урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогыг (шинэчлэн) боловсруулахад юуг анхаарах талаар санал ба зөвлөмжийг өгсөн болно.

Говийн дэд бүсийн дөрвөн аймгийн хувьд **боловсролын** салбарын болон аймаг, сумын түвшний нийт 164 бодлогын баримт бичигт шинжилгээ хийхэд энэ салбарт бодлогын баримт бичиг хэт олон батлагдаж, тэдгээр нь хоорондоо давхцал ихтэй, ерөнхий заалт ихтэй, агуулга явцуу, орчин үеийн боловсролын чиг хандлагыг бүрэн тусгаагүй, байнга давтагддаг “улиг болсон” албан хэллэгтэй байна гэж дүгнэлээ. Цаашилбал, бодлогын бичиг баримтыг зүгээр л батлаад орхидог, хэрэгжих хугацаа нь дууссан боловч хүчинтэй хэвээр, мөн тэр бодлогыг хэрэгжүүлээд ямар үр дүнд хүрсэн, цаашид хэрхэх нь тодорхойгүй байдал ажиглагдаж байна. Ихэнх бодлогын баримт бичигт орон нутгийн зүгээс хүлээх хариуцлагыг бага тусгажээ.

Тухайлбал, “Боловсролын тухай хууль”, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”, боловсролын салбарын үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг нутгийн өөрөө удирдах байгууллагын баталдаг бодлогод тусгадаггүй юм байна. Боловсролын тухай хуулийн “боловсролын тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх” тухай заалтыг аймгууд бодлогод тусгахгүй байгаа нь урт хугацаанд хүний хөгжил, эдийн засаг, нийгмийн дэвшилд ихээхэн сөрөг нөлөөтэй гэж үзлээ. Хийх ажлын хариуцлага доороосоо дээш чиглэсэн боловч, эдийн засгийн эрх мэдэл нь дээрээсээ доош чиглэсэн хэлбэртэй байгааг дурдах нь зүйтэй. Говийн дэд бүсийн дөрвөн аймгуудаас Өмнөговь, Говьсүмбэр аймгийн хувьд бодлогын нийцэл харьцангуй бага хувьтай байгаа бол Дорноговь аймагт боловсролын бодлогын уялдаа бусад аймгаас илүү өндөр байна.

Манай улсад орчин үеийн боловсролын үйлчилгээний зорилтууд ямар нэг хэмжээгээр хэрэгжиж байна гэж дүгнэлээ. Сумдын түвшинд хуулийн хэрэгжилт харилцан адилгүй байгаа ч огт хэрэгжээгүй гэдэг үзүүлэлт гарахгүй байна. Хэрэгжилтэд өгсөн үнэлгээг нэгтгэж харвал бүс дотроо Өмнөговь, Говьсүмбэр аймаг харьцангуй өндөр, Дорноговь мөн боломжийн түвшинд, харин Дундговь аймагт хэрэгжилт тааруу байгаа нь хамран сургалттай шууд холбоотой байна. Аймгуудийн үзүүлэлт 0.35-0.42 хооронд байгаа нь зорилтот 1 гэсэн түвшнээс доогуур юм.

Боловсролын салбар дахь өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэхдээ НҮБ-ын “бүх хүнд чанартай боловсролыг насан туршдаа олж авах тэгш боломж олгох” зорилтыг гол болгож, орон нутагт боловсрол (1) хүртээмжтэй байгаа, (2) тэгш байдал хангагдаж байгаа, тэгш боломж олгогдож байгаа, (3) чанартай байгаа болон (4) үр дүнтэй байж чадаж байгаа эсэхийг тодорхойлохыг эрмэлзлээ. Ингэхдээ боловсролын чухал үзүүлэлтүүдийг эдгээр 4 бүлэгт хуваарилан, үнэлгээ хийв. Эдгээрийг ерөнхий болон сургуулийн өмнөх боловсролын түвшинд тус тусад нь үнэлж үзлээ.

Дэд бүсийн аймгуудыг авч үзвэл, Говьсүмбэр аймгийн хувьд хүртээмж, оролцоо сайн гарчээ. Харин боловсролын орцын чанар тааруу гарсан байна. Энэ нь барилга байгууламж, хүчин чадлын хувьд шийдэх ёстой асуудал байна гэсэн үг юм. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, оролцоо муу байгаа нь ихэнхдээ хүчин чадалтай холбоотой байна. Тухайлбал, Сүмбэр сумын төрийн өмчийн 4 цэцэрлэгийн бүлэг дүүргэлт бүгд 35-аас их, гэтэл цэцэрлэгийн насны хүн амын 69 хувийг хамруулж байгаа нь “хүчин чадлаа нэмэх ёстой” гэсэн дохиог өгч байна.

Дорноговь аймгийн хувьд үйлчилгээ авч буй хүн ам олон, нягтрал, хүрээ их учраас үзүүлэлтүүд сум бүрийн хувьд харилцан адилгүй байна. Сайншанд, Замын-Үүд, Айраг сумдын хувьд ихэнх үзүүлэлт нь сайн байна. Хүртээмж, оролцоо бусад сумдад муу байгаа ч аймгийн нийт дүн харьцангуй сайн гарчээ. Сургуулийн өмнөх боловсролын орцын үнэлгээ сайн гарсан ч хүртээмж, тэгш байдал муу байна.

Дундговь аймаг харьцангуй цөөн хүн амд боловсролын үйлчилгээг тааруу хүргэж байна гэж дүгнэлээ. Энэ аймгийн хувьд хүртээмж, оролцоо муу, тэгш боломж, боловсролын орчны чанар мөн тааруу гарчээ. Хүртээмж оролцоо маш сайн байгаа 3 сум нь Сайнцагаан, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумдууд юм. Дундговь аймгийн боловсролын үр дүн энэ дэд бүс нутагтаа хамгийн өндөр гарсан. Сургуулийн өмнөх боловсролын хувьд ч хүртээмж, оролцоо тааруу байна. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт ердөө 79 хувь байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт юм.

Өмнөговь аймгийн дүнгээр хүртээмж, оролцоо сайн байна. Сумдын суурь боловсролын хүртээмж Цогтцэцийд маш сайн, Гурвантэт дунд, бусад сумдад тааруу эсвэл муу байна. Бусад аймагтай харьцуулахад боловсролын орцын чанар харьцангуй сайн байгаа ч боловсролын үр дүн тааруу байгаа бололтой. Нэг хүүхдийг сургах өртгөөр тэгш байдлыг хэмжвэл хамгийн их хэлбэлзэлтэй аймаг байлаа. Жишээ нь, зарим суманд нэг хүүхдийг 2.6 сая төгрөгөөр сургаж байгаа нь аймгийн дунджаас даруй 2.6 дахин их юм. Тус аймгийн ихэнх сумдад цэцэрлэгийн бүлэг дүүргэлт өндөр, хүн амдаа үйлчилгээ үзүүлж хүрэхгүй байна гэж дүгнэв. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж нийт хүн амын ердөө 80 хувийг л хангаж байгаа нь доогуур үзүүлэлт юм.

Боловсролын салбарын хувьд боловсролыг бүхлээр нь харсан бодлого, заалт байх хэрэгтэй. Өмнөх бодлогууд эсвэл хэт ерөнхий асуудал руу орох, тэр нь хэмжих боломжгүй, эсвэл хэт жижиг, нарийн асуудал руу орсон логик уялдаа холбоос муутай байна. Иймд боловсролыг эсвэл аль нэг асуудлыг бүхлээр нь, боловсролын шатыг дуустал бүхлээр нь (cohort) харж зорилт, түүнийг дагаад авах арга хэмжээ, түүний биелэлтийг хэмжих шалгуураа тодорхойлох хэрэгтэй байна. Ялангуяа дунд сургууль төгссөн хүүхдүүд цааш ахлах сургууль болон МСҮТ гэж салж боловсрол үргэлжлүүлэн ээмшиж буй тохиолдолд мөшгих боломжгүй болж, бодлогын уялдаа алдагдаж, мэдээлэл тасрахад хүрч байна.

Манай улсын боловсролын салбарын хамгийн хүнд, бас амин чухал ажлыг баг, хорооны засаг дарга хийхээр заажээ. Гэтэл Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудад баг, хорооны засаг даргын “эдийн засгийн эрх чөлөө” хязгаарлагдмал байна. Иймээс цаашид бодлогын хэрэгжилтийг илүү хангахын тулд энэ түвшний эрх мэдлийг нэмэгдүүлэх, ажлын үр дүнг нь цалин тэтгэмжтэй нь уялдуулах, чадавхыг бэхжүүлэх, хариуцлагыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Орон нутгийн түвшинд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт, суралцах орчин, дэд бүтцийн нөхцөл байдал, ахлах сургуулийн сурагцагч цөөн байгаа, анги дүүргэлт бага байгаа нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлж буйг анхаарч ажиллах шаардлагатай байна.

Соёлын салбарын нийт 141 бодлогын баримт бичигт шинжилгээ хийсэн. Боловсролын салбартай харьцуулахад соёлын бодлогын баримт бичиг үндэсний болон салбарын түвшинд илүү цэгцтэй, бас заалтууд нь давхардал багатай, ойлгомжтой байна. Аймаг орон нутгийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт ч мөн харьцангуй сайн тусчээ. Соёлын талаар хангалттай бодлогын баримт бичиг байдаг боловч хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэж байна. Үүний шалтгаан нь эсвэл хэрэгжүүлээд хүрэх үр дүнгийн үзүүлэлт хэт бүрхэг байдаг, эсвэл хөрөнгө мөнгөний асуудлаас шалтгаалан хойшлуулах хандлагатай байдаг байх магадлалтай юм. Иймд соёлын салбарын эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг тооцож төсөв, хөрөнгө батлуулах байр сууриа илэрхийлэхдээ тэрхүү үзүүлэлтээ суурь болгон ашиглаж хэвших хэрэгтэй байна.

Аймгуудын бодлогын хувьд Говьсүмбэр аймаг “Соёл, урлагийг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр” хэрэгжүүлж байгаа бөгөөд түүний бусад бодлогын баримт бичигтэй нийцэх нийцэл өндөр байв. Дорноговь аймагт мөрдөгдөж байгаа 33 бодлого болон үндэсний хэмжээний, салбарын бодлогын

нийцэл дунд зэрэг байна. Дундговь аймгийн соёлын бодлогын чанар харьцангуй чамбай байсны зэрэгцээ бодлогын баримт бичигт соёлын хөгжлийн асуудал сайтар тусгагджээ. Өмнөговь аймгийн соёлын үйл ажиллагааны зорилт, төлөвлөгөө үндэсний болон салбарын бичиг баримттай хамгийн бага нийцэлтэй байна.

Манай улсын соёлын салбарын хувьд үйлдвэр, үйлчилгээний индекс, ажил, мэргэжлийн лавлагаа гаргах асуудлаас шалтгаалан соёл, урлагийн үйлдвэрлэл, үйлчилгээ, ажил мэргэжлийн талаар бүрхэг ойлголттой буюу “соёл” гэхээр театр, музей, соёлын төвийн үйл ажиллагаагаар хязгаарлаж, явцуу утгаар ойлгож ирсэн нь бодлогын баримт бичгээс тодорхой байна. Харин олон улсын бичиг баримтаас харахад үнэт эдлэл хийхээс авахуулаад програм хангамж зохиох хүртэлх бүхий л бүтээлч үйл ажиллагааг соёлын үйл ажиллагаа гэж үздэг.

Салбарыг бүхлээр нь харвал “эмхэрч цэгцрээгүй байгаа” мэт сэтгэгдэл төрж байна. Энэ салбарыг бүхлээр, илүү өргөн утгаар нь харсан философи хэрэгтэй байна. Иймээс цаашид соёлын тухай ойлголтыг өргөжүүлэн, олон улсын жишгээр тодорхойлж, ангилал зэрэг холбогдох асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Энэ салбарын “эдийн засгийн хүч” эрхзүйн орчинд тэр чигтээ сул байна. Үндсэн хуулийн 7 дугаар заалтад “соёлын өв төрийн хамгаалтад байх тухай” заалт байгаа учраас зөвхөн тоолж бүртгэх биш, сэргээн засварлах, хамгаалах бүхий л зардлыг төрөөс аливаа хүндрэлгүйгээр шийдвэрлэж байх ёстой. Эрсдэлд байгаа хөдлөх болон үл хөдлөх өвийг хамгаалах талаар Төсвийн тухай хуульд тусгай зүйл заалт байх хэрэгтэй.

Соёлын салбарын өнөөгийн байдлын үнэлгээг хийхдээ юуны түрүүнд НҮБ-аас 2014 онд боловсруулсан “хөгжлийг хэмжих соёлын үзүүлэлтүүд” (Culture for development indicators)-ийг авч үзлээ. Энэ хүрээнд 7 бүлгийн нийт 22 үзүүлэлтийг салбарын ерөнхий түвшин болон аймгийн түвшинд тооцоолсон. Ихэнх үзүүлэлт нь соёлын үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих, бүтээлч сэтгэлгээ явагдах институцийн тогтолцоо байна уу гэдгийг харуулах үзүүлэлт юм. Үнэлгээнээс харахад манай улсын салбарын түвшинд эдгээр нь 48 орчим хувьтай, харин бидний судалж буй аймгуудын хувьд 32-37 орчим хувь байсан бөгөөд аймгуудын хувьд ялгаа бага байна. Соёлын үйлдвэрлэл, үйлчилгээнээс ДНБ-д оруулж буй хувь нэмэр аймгуудад 1-2 хувь, харин улсын хэмжээнд 3 хувь, нийт ажил эрхлэгчдийн 3 орчим хувийг соёлын салбарт бизнес, хөдөлмөр эрхлэгчид эзэлж байгаа нь харьцангуй доогуур үзүүлэлт юм.

Цаашилбал, бид соёлын салбарын хүрсэн түвшинд тодорхойлохдоо (1) соёлын үйлчилгээ болон (2) соёлын өв гэж салгаж үзсэн. Төрөөс соёлын үйлчилгээний хүртээмж, оролцоо, тэгш байдлыг хангах үүрэгтэй. Үүнд орон нутагт театр, чуулга, музей, номын сан, соёлын төв зэргийн үйл ажиллагааг хамруулав. Энэ үзүүлэлтээр аймгуудыг авч үзвэл Говьсүмбэр аймгийн театр чуулгын үйлчилгээний хүртээмж маш сайн, Дорноговь аймгийнх тааруу гэсэн дүн гарчээ. Харин музейн хувьд Дундговь, Дорноговь хүртээмжтэй байсан бол Өмнөговь хамгийн тааруу үзүүлэлттэй ажиллаж байна.

Соёлын төв, номын сангийн үйлчилгээний хувьд Дорноговь аймгийн сумдын номын сан, соёлын төвийн барилгын дэд бүтэц буюу байшин барилгын засвар, шинэчлэл дээр шийдэх асуудал олон байна. Энэ аймагт номын сангийн үйлчилгээний хүртээмж сайн, соёлын төвийн үйлчилгээний хүртээмж тааруу байжээ. Дундговь аймгийн сумдын номын сан, соёлын төвийн барилга, дэд бүтцэд мөн шийдэх асуудал олон байна. Эдгээр сумдын соёлын төвийн үйлчилгээний хүртээмж харьцангуй сайн байгаа ч, номын сангийн үзүүлэлт тааруу байжээ. Өмнөговь аймгийн сумдын номын сангийн хүртээмж сайн байсан, соёлын төв, номын сангийн барилга, түүний дэд бүтэц дээр шийдэх асуудал Дорноговь, Дундговь аймгуудтай харьцуулахад цөөн байна. Харин Говьсүмбэр аймаг соёлын төвийн үйлчилгээний хүртээмжээ сайжруулвал төрийн соёлын үйлчилгээний зорилгоо сайн биелүүлж чадахаар байна.

Соёлын биет болон биет бус өв үнэ цэнийг бүтээдэг. Соёлын өвийн аялал жуулчлал түүхийн, археологийн дурсгалт газар, үзмэрт илүү анхаарал хандуулсан байдаг бол соёлын аялал жуулчлал нь тухайн нутгийн хүмүүсийн амьдрах хэв маяг, дуу, хөгжим, бүжгийг сонирхож, фестиваль,

тэмдэглэлт арга хэмжээ, баяр ёслол зэрэг соёлын үйл ажиллагаанд өөрийн биеэр оролцож үзэх сонирхолтой байдгаараа ялгаатай.

Говийн дэд бүсэд ЮНЕСКО-гийн соёлын өвд бүртгүүлсэн дурсгал одоогоор байхгүй тул “Соёлын өвийн тухай” хуулиар “улсын хамгаалалтад байх”, “аймгийн хамгаалалтад байх” болон бусад гэж ангилж харвал Өмнөговь аймагт улсын хамгаалалтад байдаг дурсгалт газар 22 буюу хамгийн олон байна. Эдгээр дөрвөн аймагт булш оршуулгын дурсгал хамгийн олон байна. Мөн барилга архитектурын нөөц 207 гэж тоологдсон ч дэлхийн дурсгалт газартай өрсөлдөхүйц “хүний нүдэнд харагдах” бэлэн нөөц байх хэрэгтэй. Иймээс соёлын өвийн аялал жуулчлал хөгжүүлэхэд энэхүү нөөцөд их хэмжээний хөгжүүлэлт хийх шаардлага гарна.

Харин соёлын аялал жуулчлал хөгжүүлэхэд бэлэн байгаа өв, түүнийг дагаж гарах үйлчилгээ, тоглолт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, жуулчныг оролцуулах арга хэмжээг судалж үзэхэд Говийн дэд бүсэд ардын язгуур урлагийн нөөц элбэг байна. Ялангуяа Дундговь, Өмнөговь аймагт ЮНЕСКО-д бүртгэлтэй морин хуур, ардын уртын дуу, хөөмэй, ботго авахуулах зан үйл зэрэг төрлүүд түгээмэл байдаг нь давуу тал юм. 2018 онд зохион байгуулсан соёлын биет бус өвийн их наадамд Өмнөговь аймаг тэргүүн байр, Дундговь аймаг 3-р байр эзэлсэн нь ингэ хөөслөх, лимбийн битүү амьсгаа зэрэг ЮНЕСКО-д бүртгэлтэй соёлын өвийн уламжлалтай холбоотой юм. Дорноговь аймаг шашны зан үйлээр арвин уламжлалтай. Энэ чиглэлээр аялал жуулчлал хөгжүүлээд олон жил болж байгаа. Дорноговь аймагт биет өвийн нөөц илүү харагдаж байна. Соёлын биет болон ялангуяа биет бус өвд суурилан аялал жуулчлалын жижиг “ниш” зах зээл (niche market) хөгжүүлэх боломж энэ бүс нутагт байгаа гэж дүгнэж байна.

Цаашид соёлын салбарт төр удирдан хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, төлөвлөгөөг хэмжих шалгуур үзүүлэлттэй холбож, эдгээр нь хүн рүү чиглэсэн байхад анхаарах хэрэгтэй байна. Шалгуур үзүүлэлтгүй байсан учраас хариуцлага хүлээх, хяналт шинжилгээ хийх боломжгүй явсаар иржээ. Мөн заавал соёлын хөтөлбөр бүр шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн шийдэлтэй байх ёстой. Ер нь соёлын салбар өнөөг хүртэл соёлын мэдээллийн цуглуулах, шинжилгээ хийх систем бүрдүүлж чадаагүй байна гэж дүгнэж байна.

Шинжлэх ухаан, технологийн салбарын хувьд нийт 40 бодлогын баримт бичиг байгаад дүн шинжилгээ хийж судлав. “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д зааснаар шинжлэх ухаан технологийн хувьд үйлдвэрлэлтэй нягт уялдааг бий болгож, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлэх томоохон зорилтын хүрээнд санхүүжилтийг тасралтгүй нэмэгдүүлж, ДНБ-ий 3 хувьд хүргэх зорилтыг тавьжээ. Энэ асуудлаар бидний судалж буй 4 аймаг болон тус аймгуудын сумдын бодлогод ямар нэг зорилт тусгагдаагүй байна. Аймгуудын хөгжлийн бодлогын баримт бичигт шинжлэх ухаан, технологитой холбоотой зорилтууд ховор байна.

Шинжлэх ухаан, технологийн салбар нь хууль эрхзүй талаасаа харьцангуй сүүлд зохицуулалт хийгдсэн салбар юм. Энэ салбарт бодлогоор хангах, дэд бүтэц бүрдүүлэх, тэргүүлэх чиглэл тогтоох, хөшүүрэг бий болгох зэрэг төрийн үүргийг нилээд тодорхой заасан бөгөөд ингэхдээ Засгийн газар буюу төрийн захиргааны төв байгууллагуудын чиг үүрэгт түлхүү анхаарчээ. Цэвэр шинжлэх ухаантай холбоотой орон нутгийн үүрэг үндсэндээ байхгүй байна. Дүгнэж хэлэхэд, ШУТ-ийн бодлого нь улсын хэмжээнд ерөнхий байдлаар цаасан дээр буусан төдий байна. Иймээс орон нутгийн түвшинд битгий хэл үндэсний түвшинд ч хэрэгжилт үндсэндээ эхлээгүй учир дүгнэх боломжгүй юм.

ШУТ-ийн салбарын хөгжлийн өнөөгийн түвшнийг авч үзвэл шинжлэх ухааны бүтээл, өгүүлэл болон патентын тоо сүүлийн жилүүдэд өсч байгаа ч чамлалттай хэвээр байна. Хүний нөөцийн хувьд энэ салбарт ажиллагсадын тоо нийт ажиллагсадын дунд эзлэх хувийн жин нь 1.0-1.2 хувьд хэлбэлзэж буй нь бага үзүүлэлт. Энэ салбарын боловсон хүчин Улаанбаатар хотод төвлөрч байгаа, өнгөрсөн 10 жилийн хугацаанд энэ төвлөрөл нэмэгдэх хандлагатай байгаа нь нэг талаас хүний нөөцийн бөөгнөрөл үүсэх давуу талтай боловч орон нутгийн хөгжилд сөрөг нөлөөтэй байх

магадлалтай. Бидний судалж буй 4 аймгийн хувьд ШУТ-ийн салбарын ажиллагсадын тоо буурах хандлагатай байна.

Судалгаа боловсруулалтын талаарх нарийвчилсэн тоог авч үзвэл энэ чиглэлээр ажиллаж буй хүний нөөц болон зарцуулж буй хөрөнгө нь хөрш зэргэлдээ орнуудтай харьцуулахад үлэмж доогуур байна. Тодруулбал, ажил эрхлэгч 1000 хүнд ногдох судалгаа боловсруулалтын ажиллагсадын тоо БНХАУ-аас 4 дахин, ОХУ-ын үзүүлэлтээс даруй 5.3 дахин доогуур байна. Судалгаа боловсруулалтын нийт зардал дэлхийд тэргүүлэх орнуудад ДНБ-ий 2.5 хувийг эзэлж байна. Монгол улсын үзүүлэлт ДНБ-ий 0.2 хувь хүрэхгүй байгаа нь энэ чиглэлээр хамгийн бага хөрөнгө зарцуулдаг орнуудын тоонд ороход хүргэжээ. Энэ хөрөнгийн дийлэнх хэсгийг төрөөс санхүүжүүлж байна. Хувийн сектор болон их дээд сургуулиудын хувь нэмэр бага байна. ШУТ-ийн салбарт тэргүүлэх үүргийг өнөөгийн нөхцөлд төр гүйцэтгэх шаардлага хэвээр үлдэхээр байна. Энэ нөхцөлд төсвийн санхүүжилтийг үлэмж нэмэгдүүлэх хэрэгтэй.

ШУТ нь шинэ тутам хөгжих гэж буй салбар бөгөөд ихээхэн хэмжээний санхүү, дэд бүтэц, хүн хүчний нөөц шаарддаг учир шинжлэх ухааны бодлогыг төвлөрсөн байдлаар хэрэгжүүлэх нь дунд хугацаандаа оновчтой байх магадлалтай. Орон нутгийн оролцоо цаашид ч харьцангуй хязгаарагдмал байх болов уу. Говийн дэд бүсийн хүрээнд хүний нөөц, дэд бүтэц зэрэг шалтгааны улмаас ШУТ-ийн парк нь бие даасан хэлбэрээр байх нь боломж муутай. Иймээс шинжлэх ухаан, шинэ технологи нь бие даасан байдлаар биш харин аж үйлдвэрийн цогцолбор (парк эсвэл кластер)-ын хүрээнд хөгжих боломж байж болно. Орон нутгийн хувьд өөрийн байгаль цаг уур, уламжлалт мэдлэг, байгаа нөөцийн онцлогт тохирсон бүтээгдэхүүнийг шинжлэх ухааны аргаар боловсруулан зах зээлд нэвтэрч чадах шинэ бүтээгдэхүүнийг боловсруулах ажлыг уламжлалт мэдлэгийг тээж буй хүмүүс, холбогдох чиглэлээр шинжлэх ухааны мэдлэг, чадварыг эзэмшсэн байгууллага, судлаач нартай хамтын ажиллагаа өрнүүлэх, судалгаа шинжилгээ хийх, зах зээлд нэвтрэх бүтээгдэхүүн болгон хувиргах (product commercialization) ажил дээр хамтрах нь орон нутагт инновацийг нэвтрүүлэх нэг боломжит арга зам байж болно. Өмнөговь аймгийн зорилтоо болгон тавьсан ингэний сүүнээс гадна бусад аймгуудын хувьд ч ийм боломж байгаа. Мөн уул уурхайн салбарыг дагасан инновац байх боломжтой бөгөөд энэ чиглэлд хувийн сектор тэргүүлэх үүрэг гүйцэтгэх боломжтой юм.

1. Судалгааны хүрээ, зорилго, зорилт, арга аргачлал

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал боловсруулах ажлын хүрээнд Говьсүмбэр, Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгийн боловсрол, соёл, шинжлэх ухааны хөгжлийн өнөөгийн байдлыг судалсны үндсэн дээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль хийгээд хэрэгжиж буй бодлогын үр нөлөө, тулгамдаж буй асуудал, цаашдын боломжийг тодорхойлж, улмаар хөгжлийн төлөвлөгөө, зураглалд тусгах зорилгоор энэхүү судалгааг хийж байна. Судалгаанаас хүлээгдэж буй үр дүн нь:

- Хууль, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, уялдаж буй байдалд шинжилгээ хийсэн санал дүгнэлт зөвлөмж,
- Салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээний тайлан,
- Салбарын хөгжлийн бодлогын нөлөөллийн урьдчилсан үнэлгээний тайлан,
- Хөгжил, байршлын зураглал юм.

Ихэнх өгөгдлийг мэдээллийн систем, төрийн байгууллагаар дамжуулан цуглуулж, дүн шинжилгээ хийлээ. Судалгааны аргын хувьд салбарын онцлог, мэдээллийн олдоцоос хамааран тоон шинжилгээний (quantitative) дүрсэлсэн (descriptive) дүр зураг гарч байна. Хамаарлын аргагүй (correlative) ашиглах шаардлага бага байлаа.

Ажлын даалгаварт зааснаар судалгааг хоорондоо харилцан уялдаатай бодлогын судалгаа, бодлогын шинжилгээ гэсэн хоёр үе шатаар боловсруулах бөгөөд бодлогын судалгаа нь “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын дөрөвт заасан “нөхцөл байдлын дүн шинжилгээ”-г, бодлогын шинжилгээ нь журмын тавд заасан “нөлөөллийн урьдчилсан үнэлгээ”-г хийхэд тус тус чиглэгдэнэ.¹ Иймд энэ судалгааны ерөнхий аргачлал нь аливаа интервенц эсвэл бодлогын үр нөлөөг хэмжих “Бодлогын үр нөлөөний үнэлгээ” [Policy Impact Evaluation (PIE)] арга хэрэглэхийг санал болгосон.

Бодлогын үр нөлөөний үнэлгээний дараах 3 төрлөөс² эхний хоёрыг хэрэглэхийг хичээсэн авч, мэдээллийн олдоцоос шалтгаалан гол төлөв “явцын үнэлгээ”-ний аргыг сонгоход хүрлээ. Үүнд:

- Явцын үнэлгээ: Тухайн бодлого төлөвлөсөн зорилгодоо хүрч байна уу?
- Нөлөөллийн үнэлгээ: Энэ хугацаанд гарсан өөрчлөлт гарсан эсэх, тэрхүү өөрчлөлт нь хэрэгжүүлсэн бодлогоос хэр хамаарсан бэ?
- Эдийн засгийн үнэлгээ: Бодлого хэрэгжүүлснээр хүртэж буй үр өгөөж нь өртөг зардлаа нөхөж чадаж байна уу? зэрэг асуултад хариулах юм.

Бид тайлангийн хэсэг бүрийн хувьд дараах судалгааны аргыг хэрэглэсэн. Тухайлбал:

- Бодлогын уялдаанд бодлогын үр нөлөөг үнэлэх “явцын үнэлгээний тоон болон чанарын арга”,
- Бодлогын хэрэгжилтэд “явцын үнэлгээний тоон болон чанарын арга”,
- Өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээнд “нөөцөд суурилсан стратегийн арга” (Resource-based View (RBV) Strategic Approach),
- Нөлөөллийн үнэлгээнд “явцын” болон “нөлөөллийн үнэлгээ”,
- Хөгжил байршлын зураглалд оруулах мэдээлэлд “индексийн арга” хэрэглэв.

Бодлогын уялдааг харахдаа эхлээд тухайн салбарт хэрэгжүүлж буй хууль болон бодлогыг түүвэрлэж, баталсан субъект, тавьсан гол зорилт, тэдгээрээс орон нутагт хамааралтай хэсгийг нь ялгасан. Тухайлбал: “Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн дараах 2 зорилтоос 3.2.2 нь орон нутагт өнөөдөр шууд хэрэгжүүлэх боломжтой гэх мэт.

¹ ҮХГ (2018) “Өмнийн говийн хөгжлийн бүсийн хөтөлбөр боловсруулах судалгааны ажлын даалгавар”

² HM Treasury (2012) “Quality in Policy Impact Evaluation: Understanding the Effects of Policy from Other Influences”, London, UK Gov.

3.2.1. Малчны хүүхдийг 6-8 насны сонголттойгоор сургуульд элсэн суралцах боломжийг бүрдүүлнэ.

3.2.2. “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлж [хаана амьдарч байгаагаас үл хамааран хүүхэд бүр] цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно.

Ийнхүү боловсролд хамааралтай 28 зорилтоос 12 нь орон нутагт шууд хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж, эдгээр 12 заалтын хэдийг нь аймаг болон сумын хөгжлийн төлөвлөгөөнд тусгаснаар уялдааг гаргалаа.

Бодлогын хэрэгжилтийг гаргахдаа өнөөгийн нөхцөл байдлын тоон үзүүлэлтүүдийг нэгтгэж, утгыг нь холбон “чанарын шинжилгээний арга” хэрэглэв. Тухайлбал: Монгол улсын Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн

5.1.4. иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана;

хэмээх заалт хэрэгжиж байгаа эсэхийг өнөөгийн байдлыг харуулах үзүүлэлтүүд дээр үндэслэн дүгнэж, яагаад “хэрэгжиж байгаа” эсвэл “хэрэгжилт муу” гэж дүгнэснээ тайлбарлана.

Өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээний “нөөцөд суурилсан стратегийн аргаар” тухайн аймаг, сум, сургууль, цэцэрлэг, соёл, шинжлэх ухааны байгууллага нь 2018 оны байдлаар (зарим статистик мэдээ 2016 эсвэл 2017 оных байгаа) биет болон биет бус ямар нөөц боломж байгаа, түүнийгээ хэрхэн ашиглаж байгааг гаргаж, цаашид ямар хүндрэл бэрхшээл тулгарч болзошгүй талаас нь харна.

Бодлогын нөлөөллийг үнэлэхийн тулд эхлээд бодлого хэрэгжиж эхлэхэд байдал ямар байсныг харуулж чадах суурь үзүүлэлтүүд байх ёстой. Харин бидний хувьд тухайн салбарт хэрэгжиж буй бүхий л бодлогын хүрээг авч үзэж буй учраас тэр үед нь байдал ямар байсныг гаргах асуудал хүндрэлтэй байна. Тухайн салбарын хууль хийгээд олон төрлийн бодлогын баримт бичгээс түүвэрлэн авч үзэж болох авч, ингэхийн ач холбогдол өнөөдөр бага юм. Тухайлбал, Монгол улсын Үндсэн хуулийн боловсролтой холбоотой заалтыг 1992 онд байдал ямар байсан түүнээс хойш өнөөдрийг хүртэл хэрэгжсэнээр ямар үр нөлөө гарсныг дүгнэснээс илүү цаашид яах вэ гэдэгт анхаарлаа хандуулах нь чухал гэж үзлээ.


Актын нэр	Зүйл заалт	Заалт
Монгол улсын Үндсэн хууль Батлагдсан: 1992/01/13 Дагаж мөрдөх: 1992/02/12	Арван зургадугаар зүйл	2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй; 7/ сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;

Өнөөгийн хууль, бодлогын баримт бичгүүд нь “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн

4.1.12. “хөгжлийн бодлогын баримт бичиг” гэж үндэсний, салбарын, салбар хоорондын болон бүс нутаг, аймаг, нийслэлийн түвшинд, урт, дунд, богино хугацааны зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга зам, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тусгасан, эрх бүхий этгээдээс баталсан энэ хуулийн 4.1.1-4.1.11-д заасан баримт бичгийг хэлнэ

хэмээх заалтын шаардлагыг хангахгүй буюу чиглэсэн бүлэг, хүрэх зорилтын шалгуур үзүүлэлтийг тогтоох хүрээ бүрхэг байна. Иймд ихэнх тохиолдолд “бодлогын үр нөлөөний үнэлгээ” (PIE)-ний явцын арга хэрэглэхэд хүрч байна.

Зураг 1.1 Бодлогын үр нөлөө



Бид чухал бодлогоос боловсролыг аль болох бүхлээр нь авч үзэж болох зорилтуудыг сонгож тэдгээр бодлого үр дүнтэй байгаа эсэх, бодлогын улмаас ямар нэг өөрчлөлт гарсан бол **хүнд, хүний сайн сайхан байдал**³ хэр зэрэг үр нөлөө үзүүлсэн бэ⁴ гэдэг талаас нь харах суурийг тавьж өгөх болно. Өнөөгийн байдлыг харснаар 2030 он гэхэд авах арга хэмжээ, түүнийг явцад нь үнэлэх шалгуур үзүүлэлттэй болох юм. Тухайлбал, 2018 оны байдлаар соёлын үйлдвэрлэл, үйлчилгээний хувь хэмжээг гаргаснаар 2030 он хүртэл хэрхэн өсгөх, эдийн засагт үзүүлэх хувь нэмрийг нь хэрхэн нэмэгдүүлэх баримжаатай болж, түүнийгээ хөгжлийн зураглалд тусгах боломжтой.

³ Эцсийн дүнд нийгмийн, эдийн засгийн хөгжил хүнд л үр нөлөөтэй байх ёстой учраас

⁴ "Did the policy work?", "by how much?"

2. Боловсрол

Боловсролын өнөөгийн нөхцөл байдал, хэрэгжиж буй бодлогын үр нөлөөг гаргахдаа Монгол улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, үндэсний хөтөлбөрүүд зэрэг бодлогын баримт бичиг, мөн НҮБ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд баталсан “Боловсрол 2030 – Инчоны тунхаглал”-д үндэслэнэ.

Хүн амын боловсролын асуудлыг бүхлээр нь, гаднах бүх орчинтой харилцан хамааралтай харах нь хөгжлийн бодлого тодорхойлох зорилтын хувьд чухал бөгөөд боловсролыг бүхлээр нь харах аргад дараах зүйлс багтана. Үүнд:

- Бүх хүнээ цаг хугацааны дагуу мөшгих (Longitudinal cohort analysis)
- Боловсролын бүх хүчин зүйлийг хамарсан зорилтууыг дэвшүүлж, түүний биелэлтийг хангаж байгаа эсэхийг дүгнэх зэрэг багтана.

Цаг хугацааны дагуу мөшгих аргаар боловсролын үйлчилгээг бүхлээр нь харахдаа ч “бүх хүнд чанартай боловсролыг насан туршдаа олж авах тэгш боломж олгох”⁵ зорилтыг хангаж чадаж байгаа эсэхийг авч үзэх ба үүний тулд боловсролын үйлчилгээний хүртээмж, оролцоо, орцын чанар, тэгш байдал, тэгш боломж, үр дүнг үнэлнэ.

Олон улсын хандлагыг харвал цаг хугацаагаар нь мөшгих судалгааг (true cohort)⁶ түлхүү санал болгож байна.⁷ Харин манай улсын боловсрол эрэлт хэрэгцээ, өгөөж, хэрэглээнд биш, институтэд суурилсан хэлбэртэй, бүх нийтийн боловсролын үйлчилгээг институтээр дамжуулан хүргэхээр хичээж ирсэн тул гарцыг хэмжих өгөгдөл бага байдаг. Иймд бид одоогоор эхний аргыг хэрэглэх боломжгүй байна. Гэхдээ боловсролын салбарын өгөгдөл, мэдээлэл нь салбарын мэргэжилтнүүдийн хичээл зүтгэл, мэдээллийн технологийн үр нөлөөгөөр ихээхэн ахисан түвшинд хүрч байгааг энд тэмдэглэх нь зүйтэй.

2.1 Боловсролын салбарын бодлогын уялдаа холбоо

Боловсролын салбарт бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилт хийгээд өнөөгийн нөхцөл байдлыг судлахдаа мөрдөгдөж байгаа хууль, бодлогын бичиг баримтаас төлөөлүүлэн авч үзлээ. Мөрдөгдөж буй бүхий л хууль, тогтоомж, дүрэм журмыг биш харин орон нутгийн өөрөө удирдах байгууллагын зүгээс боловсруулж, хэрэгжүүлэх хэсэгт анхаарлаа хандуулсан болно. Салбарын зохицуулалт бүхий дараах хуулиуд үйлчилж байна:

1. Боловсролын тухай хууль (2002.05.03)
2. Бага, дунд боловсролын тухай хууль (2002.05.03)
3. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
4. Хүүхэд хамгааллын тухай хууль
5. Хүүхдийн эрхийн тухай хууль
6. Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль (2018.06.27)

Мөн хүчин төгөлдөр бодлогын баримт бичиг (БББ)-ээс “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай” хуулийн 6 дугаар зүйлд заасан жагсаалтын дагуу түүвэрлэн нийт 164 (зарим нь хүчинтэй эсэх нь тодорхойгүй) бодлогын баримт бичигт тойм шинжилгээ хийж үзэхэд тус хуулийн 4-р зүйлд заасан

⁵ НҮБ-ын зорилт

⁶ Гурван арга байдаг. Үүний нэг нь цаг хугацааны турш мөшгих судалгаа бөгөөд үүнийг “жинхэнэ мөшгилт” (true cohort) гэж нэрлэдэг.

⁷ Жишээ нь: Австрали улсын дээд боловсролын хорооны хийсэн мөшгих судалгаа

<https://app.powerbi.com/view?r=eyJrIjoiM2MwMWQ2ZDMtNGViNy00Mjc5LTk0OTgtNzJhMmM5ZDQwYWUxIiwidCI6ImRkMGNmZDE1LTQ1NTgtNGIxMi04YmFkLWVhMjY5ODRmYzQxNyJ9>

шаардлага тэр бүр бүрэн гүйцэд биш байна. Үүний шалтгаан нь тэдгээр баримт бичиг нь тус хууль батлагдахаас өмнө гарсантай холбоотой болов уу. Жагсаалтыг Хавсралт 1-ээс харна уу.

Хүснэгт 2.1 Боловсролын бодлогын баримт бичиг

Ангилал	Урт	Дунд хугацааны		Богино	Нийт
	15-20 жил	8-10 жил	3-5 жил	1 жил	
Нийт	2	12	95	55	164
<i>Улс, бус</i>	2	6	27	4	39
Үндэсний түвшний	2	5	27	4	38
Бүсийн түвшний	0	1	0	0	1
Аймгийн түвшинд	0	2	23	4	29
<i>Говьсүмбэр</i>		1	5	1	7
<i>Дорноговь</i>		1	6	1	8
<i>Дундговь</i>			3	1	4
<i>Өмнөговь</i>			9	1	10
Сумын түвшний /Зарим нь батлагдсан эсэх нь тодорхойгүй	0	4	45	47	96

Бидний судалсан 164 бодлогын баримт бичгээс 39 нь үндэсний болон салбарын хэмжээний буюу орон нутагт мөрдөж ажиллах, 125 нь аймаг, сумдын өөрөө удирдах байгууллагын баталсан баримт бичиг байна.

Урт хугацааны буюу 15-20 жил	Дунд хугацааны буюу 8-10 жил	Дунд хугацааны буюу 3-5 жил	Богино хугацааны буюу нэг жил	Нийт
2	6	27	4	39

Говьсүмбэр, Дорноговь аймгийн хүчин төгөлдөр “хөгжлийн хэтийн зорилт”-ыг олох боломжтой, харин Дундговь, Өмнөговь аймгийн батлагдсан материалыг олж авч чадсангүй.

Боловсролын тухай хуулийн “5.1.1 боловсролыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төрийн ивээл, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад байлгана;” хэмээх заалт, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” /2014-2020/-ын зорилтууд, Боловсролын талаарх үндэсний хөтөлбөрүүд, Монгол Улсын “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн “2.2.3. Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн”, “Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр”-ийн “3.2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ” зэргийг аймгуудын бодлогын бичиг баримтад хэрхэн туссанаар уялдааг гаргалаа /Хавсралт 1-ээс харна уу/.

Хүснэгт 2.2 Боловсролын БББ-ийн уялдаа

Үндэсний болон салбарын БББ	<i>Дундговь</i>	<i>Дорноговь</i>	<i>Өмнөговь</i>	<i>Говьсүмбэр</i>
Боловсролын тухай хуулийн 5.1.1	0.00	0.00	0.00	0.00
Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого	0.00	0.13	0.07	0.00
Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	0.15	0.14	0.03	0.07
МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр	0.30	0.38	0.20	0.26

2.1.1 Говьсүмбэр

Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газрын цахим хуудаст бүх чухал баримт бичиг тавигдсан байсан нь мэдээллийн ил тод байдлын хувьд их чухал үзүүлэлт байлаа. Гэхдээ боловсролын салбарын ойрын болон дунд хугацааны зорилтууд тэр бүр бодлогод нь суугаагүй байна. Тус аймаг “Боловсролыг дэмжих дэд хөтөлбөр” батлан хэрэгжүүлж, тэрхүү хөтөлбөрт МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн цөөн хэдэн заалт багтжээ.

Урт хугацааны буюу 15-20 жил	Дунд хугацааны буюу 8-10 жил	Дунд хугацааны буюу 3-5 жил	Богино хугацааны буюу нэг жил	Нийт
0	1	8	4	13

Хүснэгт 2.3 Говьсүмбэр аймгийн боловсролын салбарын бодлогын уялдаа

Хууль, бодлогын уялдаа, хэрэгжилт	Сүмбэр	Баянтал	Шивээговь	Говьсүмбэр
Боловсролын салбарын бодлогын уялдаа	0.06	0.06	0.02	0.08
Аймгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн уялдаа				0.08

2.1.2 Дорноговь

Дорноговь аймагт аймгийн ИТХ-ын баталсан 7, сумын баталсан 30 баримт бичиг байна. Эдгээрийн 3 нь 8-10 жилийн дунд хугацааны бодлого байлаа.

Тус аймагт боловсролын бодлогын уялдаа бусад аймгаас өндөр байна. Тухайлбал, МУЗГ-ын мөрийн хөтөлбөрт суусан зорилтуудыг сайтар тусгаж ажиллаж байгаа юм байна. Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө /2011-2021/ -нд боловсролын салбарт хэрэгжүүлэх ёстой чухал бодлогын заалтууд харьцангуй сайн багтсан нь сумдын үйл ажиллагаан мөрийн хөтөлбөрийн нийцэлд нөлөөлсөн байна. Гэхдээ мөн л бусад бодлогын адил хэмжих үзүүлэлт бага оруулжээ. Тоон илэрхийлэл муутай учраас үр дүнг нь хэмжих боломж хэрэгжиж байх явцад ч, хэрэгжиж дууссаны дараа ч бага байх болов уу.

Сайхандулаан сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрт ямар БББ-ийн ямар заалттай уялдуулснаа харуулсан нь их ойлгомжтой болсон байна.

Урт хугацааны буюу 15-20 жил	Дунд хугацааны буюу 8-10 жил	Дунд хугацааны буюу 3-5 жил	Богино хугацааны буюу нэг жил	Нийт
0	3	19	15	37

Хүснэгт 2.4 Дорноговь аймгийн боловсролын салбарын бодлогын уялдаа

Хууль, бодлогын уялдаа, хэрэгжилт	Сайншанд	Замын-Үүд	Далайжаргал	Айраг	Алтанширээ	Дэлгэрэх	Иххэт	Мандах	Сайхандулаан	Улаанбадрах	Хатанбулаг	Хөвсгөл	Эрдэнэ	Өргөн	Дорноговь
Боловсролын салбарын бодлогын уялдаа	0.17	0.21	0.10	0.29	0.08	0.13	0.11	0.06	0.27	0.19	0.0	0.10	0.33	0.19	0.18
Аймгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн уялдаа															0.25

Тус аймгийн Эрдэнэ, Айраг, Сайхандулаан сумдад бодлогын уялдаа өндөр гарсан буюу үндэсний хэмжээний бодлогыг орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгажээ.

2.1.3 Дундговь

Дундговь аймгийн нийт 33 БББ-ээс ИТХ-ын баталсан 3, Засаг даргын захирамжаар 1, сумын ИТХ-ын баталсан 29 баримт бичиг байна.

Урт хугацааны буюу 15-20 жил	Дунд хугацааны буюу 8-10 жил	Дунд хугацааны буюу 3-5 жил	Богино хугацааны буюу нэг жил	Нийт
0	0	17	16	33

Сумын ИТХ-ын баталсан Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр 2016-2020 болон бусад бодлого, Аймгийн ИТХ-ын баталсан бодлогын баримт бичгүүд үндэсний хэмжээний хийгээд Засгийн газрын хэрэгжүүлэх бодлоготой хэрхэн нийцтэй байгааг судлахад дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

- Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-д туссан 2 зорилтын хувьд Дундговь аймагт хэрэгжиж буй бодлоготой 15 орчим хувийн нийцэлтэй байна.
- МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт багтсан боловсролын тухай зорилтуудын 12 нь орон нутагт шууд хэрэгжүүлэх боломжтой бөгөөд тус аймагт дунджаар 30 орчим хувийн нийцэлтэй байна.

Дундговь аймгийн Өлзийт, Луус суманд бодлогын уялдаа хамгийн өндөр байна. Гэхдээ эдгээр үзүүлэлт 1 байх ёстой.

Хүснэгт 2.5 Дундговь аймгийн боловсролын салбарын бодлогын уялдаа

Хууль, бодлогын уялдаа, хэрэгжилт	Сайнцаан	Алашаг	Баянжаргалан	Говь-Угтаал	Гурвансайхан	Дэлгэрхангай	Дэлгэрцогт	Дэрэн	Луус	Сайхан-Овоо	Хулд	Цагаандэлгэр	Эрдэнэдалай	Өлзийт	Өндөршил	Дундговь
Боловсролын салбарын бодлогын уялдаа	0.06	0.08	0.04	0.19	0.06	0.02	0.17	0.27	0.25	0.08	0.10	0.04	0.04	0.23	0.06	0.11
Аймгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн уялдаа																0.10

2.1.4 Өмнөговь

Тус аймгийн хувьд нийцэл хамгийн бага хувьтай гарч байна. Өөрөөр хэлбэл боловсролын талаар үндэсний болон салбарын бодлогыг үйл ажиллагаандаа тусгах сонирхол бага байдаг бололтой.

Урт хугацааны буюу 15-20 жил	Дунд хугацааны буюу 8-10 жил	Дунд хугацааны буюу 3-5 жил	Богино хугацааны буюу нэг жил	Нийт
0	2	24	16	42

Өмнөговь аймагт аймгийн ИТХ-ын баталсан хамгийн олон дэд хөтөлбөр хэрэгжиж байна.

Хүснэгт 2.6 Өмнөговь аймгийн боловсролын салбарын бодлогын уялдаа

Хууль, бодлогын уялдаа, хэрэгжилт	Даланзадгад	Цогтцэий	Баяндалай	Баянвоо	Булган	Гурвантэс	Мандаловоо	Манлай	Ноён	Номгон	Сэврэй	Ханбогд	Ханхонгор	Хүрмэн	Цогтговоо	Өмнөговь
Боловсролын салбарын бодлогын уялдаа	0.08	0.02	0.04	0.02	0.13	0.04	0.10	0.08	0.10	0.15	0.10	0.04	0.04	0.06	0.08	0.08
Аймгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн уялдаа																0.08

2.1.5 Боловсролын салбарын бодлогын талаарх дүгнэлт

Бодлогын баримт бичигт дараах нийтлэг асуудлууд байна. Үүнд:

1. Боловсролын салбарт хэт олон БББ батлагдаж, тэдгээр нь хоорондоо давхцал ихтэй, эмх замбараа муутай, ерөнхий заалт ихтэй, агуулга явцуу, орчин үеийн боловсролын чиг хандлага бүрэн тусгагдаагүй байна. Тухайлбал, “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ын заалтууд хэмжих боломжгүй, уриа лоозонгийн шинжтэй байх бол, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал дахь боловсролын хэсэгт ЮНЕСКО-гийн дэвшүүлсэн зорилтоос зөвхөн 1 үзүүлэлт тодорхой, 1 үзүүлэлт бүрхэг утгаар багтсан байна.
2. Бодлогын бичиг баримтыг зүгээр л батлаад орхидог. Хэрэгжих хугацаа нь дууссан боловч хүчинтэй хэвээр, мөн тэр бодлогыг хэрэгжүүлээд ямар үр дүнд хүрсэн, цаашид хэрхэх нь

тодорхойгүй олон БББ байна. Тухайлбал, Засгийн газрын 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 151 дүгээр тогтоолоор баталж 2012-2016 онд хэрэгжүүлсэн “Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар олон нийтэд нээлттэй мэдээлэл олж авах боломж бага. Хэрэв энэ хөтөлбөр амжилттай хэрэгжсэн бол тус бүс нутагт “Их, дээд сургуулийн салбар, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн инженерийн дэд бүтэц” бий болсон байх ёстой байжээ.

3. Аймаг, сумын түвшинд боловсролын талаар тусгагдсан зорилтууд байнга давтагддаг (улиг болсон) албан хэллэг байна. Тухайлбал, Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөөнд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт тэрхүү мастер төлөвлөгөөг боловсруулж байхад хэд байсан, түүнийг энэ хугацаанд тийм болгоно гэсэн зорилт байгаагүй, харин тус төлөвлөгөөний 3.5 дахь хэсэгт “Цэцэрлэгийн хамран сургалтыг өргөжүүлнэ” гэсэн байна.
4. Ихэнх бодлогын баримт бичигт орон нутгийн зүгээс хүлээх хариуцлагыг бага тусгажээ. Ялангуяа үндэсний хөтөлбөрүүдийг Засгийн газар, салбарын яам хэрэгжүүлэхээр, харин орон нутагт эрх үүргээ хуваалцах зам нь тэдний хооронд гэрээ байгуулах арга⁸ байгаа нь бодлогын хэрэгжилтийг удаашруулж байна.

Салбарын хууль, бодлогын бичиг баримт болон орон нутгийн баталж хэрэгжүүлж буй бодлогын нийцэлд дараах зөрчил байна. Үүнд:

1. Боловсролын тухай хууль, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, боловсролын салбарын үндэсний болон дэд хөтөлбөрүүдийг нутгийн өөрөө удирдах байгууллагын баталдаг бодлогод тусгадаггүй юм байна. Боловсролын тухай хуулийн “боловсролын тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх” тухай заалтыг аймгууд бодлогодоо тусгахгүй байгаа нь урт хугацаанд хүний хөгжил, эдийн засаг, нийгмийн дэвшилд ихээхэн сөрөг нөлөөтэй.
2. Салбарын сайд бодлого батлах эсэх нь тодорхой биш байна. Гэтэл шууд бодлого гэж нэрлэхгүй ч бодлогын зохицуулалттай шийдвэрийг салбарын сайд тогтмол гаргадаг. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 6-р зүйлд салбарын сайд хөтөлбөр, дэд хөтөлбөр баталж болох юм. Тус хуулийн “8.4.Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төрөөс баримтлах бодлогын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулна.” гэжээ. Гэтэл бусад хуульд зөвшөөрөгдсөн байна. Тухайлбал, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлд:

28.1.2. боловсролын салбарын хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэл, төлөвлөгөө, үзэл баримтлал, үндсэн чиглэл, дүрэм, журам, хөтөлбөр, төсөл, заавар, аргачлалыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг тооцох;

гэж заажээ. Энэ заалтад “батлах” гэж байгаа тул Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 20 тоот тушаалаар баталсан “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого” хүчинтэй гэж үзэх юм. Учир нь, энэ бодлогыг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль батлагдахаас өмнө баталсан.

3. Хийх ажлын хариуцлага доороосоо дээш чиглэсэн боловч, эдийн засгийн эрх мэдэл нь дээрээсээ доош чиглэсэн хэлбэртэй байна. Тухайлбал, манай улсын боловсролын салбарын хамгийн хүнд, бас амин чухал ажлыг баг, хорооны засаг дарга хийхээр заажээ. Боловсролын тухай хуулийн “32 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх”:

32.1.1. сургуулийн өмнөх болон суурь боловсрол эзэмшүүлэх сургалтад харьяа айл өрхийн хүүхдийг хамруулах;

32.1.2. иргэдийн боловсрол эзэмшсэн байдалд судалгаа хийж, шаардлагатай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

32.1.3. суурь боловсрол эзэмшээгүй иргэнд нөхөн эзэмшүүлэх ажил зохион байгуулах.

⁸ Хуулийн дагуу хэрэгжүүлэх ёстой гэдэг “хүчлэх боломж” муутай (Legitimacy).

Гэтэл Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудад баг, хорооны засаг даргын “эдийн засгийн эрх чөлөө” хязгаарлагдмал байна.

2.2 Боловсролын салбарын өнөөгийн нөхцөл байдал

Өнөөгийн нөхцөл байдлыг үнэлэхдээ “бүх хүнд чанартай боловсролыг насан туршдаа олж авах тэгш боломж олгох”⁹ зорилгоо үндэс болгож, орон нутагт боловсрол хүртээмжтэй байгаа, тэгш байдал хангагдаж байгаа, тэгш боломж олгогдож байгаа, үр дүнтэй байж чадаж байгаа эсэхийг харахдаа дараах үзүүлэлтүүдийг тооцохоор багтаалаа.

Хүснэгт 2.7 Ерөнхий боловсролын үр нөлөөг харуулах үзүүлэлтүүд

Д	Үр нөлөө	Үзүүлэлтүүд	
1	Хүртээмж, оролцоо	<ul style="list-style-type: none"> Боловсролын үйлчилгээний байрлал болон хүн амын нягтрал Бага боловсролын хамран сургалтын бохир жин Дунд сургуульд хамрагдалтын жин Суурь боловсролын хамран сургалтын бохир жин 	4
2	Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал	<ul style="list-style-type: none"> Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ хамруулсан эсэх Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гарц байгаа эсэх Дотуур байрны ачаалал Дотуур байрны хангамж 	4
3	Боловсролын чанар	<p>3.1 Орц</p> <ul style="list-style-type: none"> Багш, сурагчийн харьцаа /бага/ Багш, сурагчийн харьцаа /дунд, ахлах/ Магистр болон түүнээс дээш зэрэгтэй багшийн жин Дундаж бүлэг дүүргэлт Сургалтын зориулалттай интернэт холболт Ээлжийн коэффициент <p>3.2 Дэд бүтэц /Шийдэх асуудал/</p> <ul style="list-style-type: none"> Дулаан хангамж Цэвэр усны хангамж Ариутгах татуурга БТХ-ын 9.1.1. барилга байгууламж шинээр барих; 9.1.2. барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх; 9.1.3. барилга байгууламжийг засварлах, тоноглох; 9.1.5. гадна талбайн тохижилт. 	13
4	Боловсролын үр дүн	<ul style="list-style-type: none"> Нэг суралцагчид /өдрөөр/ зарцуулж буй урсгал төсөв Бага боловсролын төгсөх монгол хэлний шалгалтын "хангалттай" үнэлгээний жин /Онц, сайн, хангалттай/ Дунд боловсролын төгсөх математикийн шалгалтын хангалттай үнэлгээний жин /А-D/ Ахлах сургуульд хамрагсдын жин Ерөнхий шалгалтын математикийн дундаж оноо Ерөнхий шалгалтын монгол хэлний дундаж оноо 	6

Цаашид оруулах боломжтой үзүүлэлтүүд:

- Сургалтын нэг компьютерт ногдох суралцагчдын тоо
- Боловсролын адил түвшний зэрэг эзэмшсэний дараа багшийн дундаж цалин бусад мэргэжилтэй харьцуулахад
- Төгсөх болон ЕШ-ын бусад хичээлийн үр дүнгээр өргөтгөх

Хүүхдийн хөгжлийн суурь шат (синапсис 0-5 насанд) амжилттай тавигдвал цааш цаашдын хөгжилд тулгуур болох учраас олон улсын хандлага эрт эхлэх, зөн совинг нь дагуулан сургахад анхаарлаа

⁹ НҮБ-ын зорилт

хандуулах болсон.¹⁰ Иймд бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах асуудал чухал юм. Манай улсын хүн ам хурдтай өсч байгаа учраас хамран сургалт төдийлөн дорвитой нэмэгдэхгүй байна. Иймд дараах гурван үр нөлөөг чухалчилж үзлээ. Хавсралт 4-өөс тайлбарыг харна уу.

Хүснэгт 2.8 Сургуулийн өмнөх боловсролын үр нөлөөг харуулах үзүүлэлтүүд

Д	Үр нөлөө	Үзүүлэлтүүд	
1	Хүртээмж, оролцоо	<ul style="list-style-type: none"> Цэцэрлэгийн байрлал болон хүн амын нягтрал Цэцэрлэгийн хамран сургалтын бохир жин СӨБ-ын хамран сургалтын бохир жин Зохион байгуулалттай сургалтад хамрагдалтын жин (сургуульд элсэн орохын өмнөх 1 жил) Өдрийн сургалтын бүлэг дүүргэлт 	4
2	Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал	<ul style="list-style-type: none"> Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ хамруулсан эсэх Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн орчин бүрдсэн эсэх 	2
3	Боловсролын чанар	3.1 Орц <ul style="list-style-type: none"> Нэг багшийн ачаалал Нэг суралцагчид /өдрөөр/ зарцуулж буй урсгал төсөв 3.2 Дэд бүтэц /Шийдэх асуудал/ <ul style="list-style-type: none"> Дулаан хангамж Цэвэр усны хангамж Ариутгах татуурга БТХ-ын 9.1.1.барилга байгууламж шинээр барих; 9.1.2. барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх; 9.1.3. барилга байгууламжийг засварлах, тоноглох; 9.1.5. гадна талбайн тохижилт 	9

Асуудал:

Өнөөгийн нөхцөл байдлын үзүүлэлтүүдийг тооцоолоход өгөгдлийн цаг хугацааны болон бэлэн байдлын асуудал гарсан. Үүнд:

1. Нэг суралцагчид зарцуулж буй урсгал төсвийг тооцоолохдоо 2017 оны төсвийн гүйцэтгэл, 2018-2019 оны хичээлийн жилийн хүүхдийн тоонд хуваасан байгаа. Энэ үзүүлэлт буруу. Гэхдээ зөвхөн хандлагыг харах зорилгоор түр ашигласан болно. Зүй нь 2017 оны төсвийг гүйцэтгэлд хамаарах санхүүжих дундаж хүүхдийг тооцох ёстой. Санхүүжих хүүхдийг тооцох томъёог аймаг бүрийн файлын “2017 оны ТГ” гэсэн ажлын хүснэгтэд харуулсан байгаа. Иймд хэмжээнд биш зөвхөн хандлагад анхаарлаа хандуулна уу.
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоог аймгаас авахад насны бүлгээр байсан. Дорноговь аймгийн хувьд 0-14 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо “Ерөнхий боловсрол” хэмээх өгөгдлийн ажлын хүснэгтэд оруулсан байгаа. Харин бусад аймгийн хувьд 5-14 насны хүүхдийн тоог ерөнхий боловсрол дээр, 0-4 насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсрол дээр түр тавьсан.
3. Боловсролын үр дүнг тооцох хэсэгт 2017 оны улсын шалгалтын дүн, мөн ерөнхий шалгалтын дүн тавьсан байгаа.

Өнөөгийн нөхцөл байдлын үзүүлэлтүүдийг өгөгдөл, мэдээллээ холбогдох ажлын хүснэгтэд шивэхэд эцсийн үр дүнд очиж нөлөөлөхөөр бүх тооцооллыг загварчлал үүсгэн томъёогоор татсан болно. Бүх өгөгдөл, мэдээллийг цуглуулан өнөөгийн нөхцөл байдлыг сум нэг бүрээр гаргасныг Хавсралт 5-д оруулав. Нэгтгэлийг дараах хүснэгтэд харуулья.

Хүснэгт 2.9 Ерөнхий боловсролын үзүүлэлтүүдийн нэгтгэл

Д	Боловсролын үзүүлэлтүүд	Дорноговь	Өмнөговь	Дундговь	Говьсүмбэр
---	-------------------------	-----------	----------	----------	------------

¹⁰ Michael J. Haslip, Dominic F. Gullo (2017) The Changing Landscape of Early Childhood Education: Implications for Policy and Practice, Springer Science+Business Media New York 2017.

1	Хүртээмж, оролцоо				
1	Боловсролын үйлчилгээний байрлал болон хүн амын нягтралшилт				
2	Бага боловсролын хамран сургалтын бохир жин	0.97	0.98	0.92	0.95
3	Дунд сургуульд хамрагдалтын хувь	0.94	0.97	0.92	0.98
4	Суурь боловсролын хамран сургалтын бохир жин	0.96	0.98	0.92	0.96
2	Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал				
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ хамруулсан эсэх	0.42	0.73	0.90	0.49
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гарц байгаа эсэх	11	15	9	0
3	Дотуур байрны ачаалал	0.66	0.56	0.65	1.14
4	Дотуур байрны хангамж	0.97	0.93	0.93	1
3	Боловсролын чанар				
3.1	Орц				
1	Багш, сурагчийн харьцаа /бага/	32:1	32:1	25:1	30:1
2	Багш, сурагчийн харьцаа /дунд, ахлах/	14:1	13:1	9:1	13:1
3	Магистр болон түүнээс дээш зэрэгтэй багшийн хувь	0.07	0.08	0.10	0.22
4	Дундаж бүлэг дүүргэлт	25.69	28.27	24.56	26.92
5	Сургалтын зориулалттай интернэт холболт	10	15	14	2
6	Ээлжийн коэффициент	1.46	1.00	1.06	1.39
3.2	Дэд бүтэц /Шийдэх асуудал/	57	45	54	7
1	Дулаан хангамж	2	-	-	-
2	Цэвэр усны хангамж	12	10	12	-
3	Ариутгах татуурга	10	6	10	-
4	9.1.1. барилга байгууламж шинээр барих;	6	-	2	2
5	9.1.2. барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх;	2	3	1	1
6	9.1.3. барилга байгууламжийг засварлах, тоноглох;	11	11	14	1
7	9.1.5. гадна талбайн тохижилт.	14	15	15	3
4	Боловсролын үр дүн				
1	Нэг суралцагчид /өдрөөр/ зарцуулж буй урсгал төсөв	1,053	1,012	1,352	1,039
2	Бага боловсролын төгсөх монгол хэлний шалгалтын "хангалттай" үнэлгээний эзлэх хувь /Онц, сайн, хангалттай/	0.92	0.91	0.88	
3	Дунд боловсролын төгсөх математикийн шалгалтын хангалттай үнэлэгдсэн хувь /A-D/	0.85	0.79	0.86	
4	Ахлах сургуульд хамрагсдын хувь	0.51	0.51	0.48	0.61
5	Ерөнхий шалгалтын математикийн дундаж оноо	489.5	483.46	499.69	489.50
6	Ерөнхий шалгалтын монгол хэлний дундаж оноо	524.20	510.70	510.10	524.20

Хүснэгт 2.10 Сургуулийн өмнөх боловсролын үзүүлэлтүүдийн нэгтгэл

Д	Сургуулийн өмнөх боловсролын үзүүлэлтүүд	Дорноговь	Өмнөговь	Дундговь	Говьсүмбэр
1	Хүртээмж, оролцоо				
1	Цэцэрлэгийн байрлал болон хүн амын нягтралшилт				
2	Цэцэрлэгийн хамран сургалтын бохир жин	0.70	0.77	0.70	0.69
3	СӨБ-ын хамран сургалтын бохир жин	0.79	0.80	0.78	0.89
4	Зохион байгуулалттай сургалтад хамрагдалтын хувь (сургуульд элсэн орохын өмнөх 1 жил)	0.76	0.86	0.84	0.80
5	Өдрийн сургалтын бүлэг дүүргэлт	33.77	33.58	31.78	28.53
2	Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал				
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ хамруулсан эсэх	Хичээж байгаа	-	Хичээж байгаа	Хичээж байгаа

2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн орчин	0.00	-	15.00	байгаа
3	Боловсролын чанар				
3.1	Орц				
1	Нэг багшийн ачаалал	28	30	28	29
2	Нэг суралцагчид /өдрөөр/ зарцуулж буй урсгал төсөв	1374	1312	1594	1158
3.2	Дэд бүтэц /Судлах асуудлын тоо/	21.00	24.00	22.00	1.00
1	Дулаан хангамж	0.00	-	0.00	0.00
2	Цэвэр усны хангамж	7.00	8.00	11.00	0.00
3	Ариутгах татуурга	5.00	5.00	3.00	0.00
4	9.1.1. барилга байгууламж шинээр барих;	2.00	1.00	1.00	1.00
5	9.1.2. барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх;	4.00	5.00	4.00	0.00
6	9.1.3. барилга байгууламжийг засварлах, тоноглох;	3.00	5.00	3.00	0.00
7	9.1.5. гадна талбайн тохижилт.	0.00	-	0.00	0.00

Дэлгэрэнгүй тооцооллыг Хавсралт 6-аас харна уу.

2.3 Боловсролын салбарын шалгуур үзүүлэлтүүд

Бүсийн хөгжлийн өнөөгийн байдлыг зураглалаар харуулахад үнэлгээний индекс ашиглахыг ҮХГ-аас санал болгосон. Бүсийн хөгжлийн талаарх судалгаа, холбогдох материалыг¹¹ судалсны үндсэн дээр дараах аргачлалыг хэрэглэлээ. Учир нь боловсролын үзүүлэлт нэг бүрийн эцсийн үр нөлөөг тооцоход оролцох оролцоог зохицуулж болохуйц уян хатан байв.

Хөгжлийн индекс	
Маш сайн	5
Сайн	4
Дунд	3
Тааруу	2
Муу	1
Асуудал	0

Интервал ойрхон байх нь тухайн үзүүлэлтийн оролцоог бууруулах давуу талтай. Жишээ нь бага, дунд боловсролын төгсөх шалгалтын оноогоор боловсролын эцсийн үр дүнг хэмжих нь өрөөсгөл тул оролцоог бууруулах хэрэгтэй. Харин бүхнийг багтаасан боловсролын хувьд хөгжлийн бэрхшээлтэй 0-14 насны хүн амаа сургууль, цэцэрлэгт бүрэн хамруулахгүй байх нь хүлээн зөвшөөрөх боломжгүй ойлголт болсон учраас үнэлгээ хатуу буюу интервал хол байх ёстой. Үзүүлэлт бүрийн хувьд ийм маягаар шалгуур, хэмжүүрийг зохицуулах боломжтой.

Хүснэгт 2.11 Ерөнхий боловсролын шалгуур, өнөөгийн үнэлгээ

Д	Боловсролын үзүүлэлтүүд	Шалгуур /2030 он гэхэд хүрэх зорилт/	2019 оны үнэлгээ					
			5	4	3	2	1	0
1	Хүртээмж, оролцоо		5	4	3	2	1	0
1	Боловсролын үйлчилгээний байрлал болон хүн амын нягтралшилт							
2	Бага боловсролын хамран сургалтын бохир жин	k=0.99	0.98	0.96	0.95	0.92	0.9	k<=0.91
3	Дунд сургуульд хамрагдалтын жин	k=0.99	0.97	0.95	0.94	0.91	0.89	k<=0.89
4	Суурь боловсролын хамран сургалтын бохир жин	k=0.99	0.97	0.95	0.94	0.91	0.89	k<=0.89
2	Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал							

¹¹ Номзүйгээс харна уу.

1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ хамруулсан эсэх	k=1 бол бүхнийг багтаасан	0.9	0.7	0.5	0.4	0.3	k<=0.3
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гарц байгаа эсэх	байгаа=1 байхгүй=0	1					0
3	Дотуур байрны ачаалал	k>=1	1	0.99	0.8	0.7	0.6	k<=0.6
4	Дотуур байрны хангамж	k>=1	1	0.98	0.95	0.9	0.88	k<=0.87
3	Боловсролын чанар							
3.1	Орц							
1	Багш, сурагчийн харьцаа /бага/	30:1	30:1					35:1 k<=19:1
2	Багш, сурагчийн харьцаа /дунд, ахлах/	15:1	13:1					k<=9:1
3	Магистр болон түүнээс дээш зэрэгтэй багшийн жин	Их тусмаа сайн	0.5	0.4	0.3	0.2	0.1	k<=0.09
4	Дундаж бүлэг дүүргэлт	25<k<30 бол хэвийн	25					k>=35 k<=20
5	Сургалтын зориулалттай интернэт холболт	Бүгд 1 байх	1					0
6	Ээлжийн коэффициент	k=1.1	1					
3.2	Дэд бүтэц /Шийдэх асуудал/		0					k>=6
1	Дулаан хангамж	k=0 бол одоогоор асуудалгүй	0					
2	Цэвэр усны хангамж	k=0						
3	Ариутгах татуурга	k=0						
4	9.1.1. барилга байгууламж шинээр барих; /Судлах асуудлын тоо/	k=0						
5	9.1.2. барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх; /Судлах асуудлын тоо/	k=0						
6	9.1.3. барилга байгууламжийг засварлах, тоноглох;/Судлах асуудлын тоо/	k=0						
7	9.1.5. гадна талбайн тохижилт	k=1 бол хүүхдэд ээлтэй орчин бүрдсэн						
4	Боловсролын үр дүн							
1	Нэг суралцагчид /өдрөөр/ зарцуулж урсгал төсөв	Жигд тархалттай бол сайн	k<Дундаж					k>=1.5* Дундаж
2	Бага боловсролын төгсөх монгол хэлний шалгалтын "хангалттай" үнэлгээний жин /Онц, сайн, хангалттай/	k=1	1	0.8	0.7			k<=6
3	Дунд боловсролын төгсөх математикийн шалгалтын хангалттай үнэлгээний жин /A-D/	k=1	1	0.8	0.7			k<=6
4	Ахлах сургуульд хамрагсдын жин	Их тусмаа сайн						
5	Ерөнхий шалгалтын математикийн дундаж оноо	k=800						
6	Ерөнхий шалгалтын монгол хэлний дундаж оноо	k=800						

Хүснэгт 2.12 Сургуулийн өмнөх боловсролын шалгуур, өнөөгийн үнэлгээ

Д	Сургуулийн өмнөх боловсролын үзүүлэлтүүд	Шалгуур /2030 он гэхэд хүрэх зорилт/	2019 оны үнэлгээ					
			5	4	3	2	1	0
1	Хүртээмж, оролцоо		5	4	3	2	1	0
1	Цэцэрлэгийн байрлал болон хүн амын нягтралшилт							

2	Цэцэрлэгийн хамран сургалтын бохир жин	$k=0.99$	0.98	0.96	0.95	0.9	0.88	$k \leq 0.88$
3	СӨБ-ын хамран сургалтын бохир жин	$k=0.99$	0.97	0.95	0.94	0.91	0.89	$k \leq 0.89$
4	Зохион байгуулалттай сургалтад хамрагдалтын хувь (сургуульд элсэн орохын өмнөх 1 жил)	$k=0.99$	1	0.98	0.96	0.94	0.92	$k \leq 0.92$
5	Өдрийн сургалтын бүлэг дүүргэлт	$20 < k < 25$ бол хэвийн	20-30					$k \geq 30$ $k \leq 19$
2	Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал							
1	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ хамруулсан эсэх	$k=0$ бол бүхнийг багтаасан	Бүгдийг багтаасан			Хичээж байгаа		Үгүй
2	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн орчин	Байгаа=1	1					0
3	Боловсролын чанар							
3.1	Орц							
1	Нэг багшийн ачаалал	$15 < k < 25$ бол хэвийн	15-25					$25 < k \leq 15$
2	Нэг суралцагчид /өдрөөр/ зарцуулж буй урсгал төсөв	Жигд тархалттай бол сайн	$k < \text{Дундаж}$					$k \geq 1.5^*$ Дундаж
3.2	Дэд бүтэц /Судлах асуудлын тоо/		0					$k \geq 3$
1	Дулаан хангамж	$k=0$						
2	Цэвэр усны хангамж	$k=0$						
3	Ариутгах татуурга	$k=0$						
4	9.1.1. барилга байгууламж шинээр барих;	$k=0$						
5	9.1.2. барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх;	$k=0$						
6	9.1.3. барилга байгууламжийг засварлах, тоноглох;	$k=0$						
7	9.1.5. гадна талбайн тохижилт.	$k=1$						

2.4 Боловсролын салбарын өнөөгийн байдал: үнэлгээ ба үр дүн

Энэхүү ерөнхий боловсролын 27, сургуулийн өмнөх боловсролын 15 үзүүлэлтээр үнэлгээ хийж харья.

2.4.1 Говьсүмбэр

2017 оны суурин хүн ам: 17399

2018-2019 оны хичээлийн жилд:

- ЕБ-ын сургууль: 5
- Суралцагчид: 3446
- Цэцэрлэг: 11
- Суралцагчид: 1728

Говьсүмбэр аймгийн хувьд хүртээмж, оролцоо сайн гарчээ. Харин боловсролын орцын чанар тааруу гарсан байна. Энэ нь барилга байгууламж, хүчин чадлын хувьд шийдэх ёстой асуудал байна гэсэн үг юм.

Хүснэгт 2.13 Говьсүмбэр аймгийн ерөнхий боловсролын үнэлгээ

Ерөнхий боловсролын үзүүлэлтүүд	Сүмбэр	Баянтал	Шивээговь	Говьсүмбэр
Хүртээмж, оролцоо	5	0	5	4
Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал	4	4	3	3
Боловсролын чанар	3	2	3	1

Боловсролын үр дүн	4	1	2	2
--------------------	---	---	---	---

Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж оролцоо муу байгаа нь ихэнхдээ хүчин чадалтай холбоотой байна. Тухайлбал, Сүмбэр сумын төрийн өмчийн 4 цэцэрлэгийн бүлэг дүүргэлт бүгд 35-аас их, гэтэл цэцэрлэгийн насны хүн амын 69 хувийг хамруулж байгаа нь “хүчин чадлаа нэмэх ёстой” гэсэн үг.

Хүснэгт 2.14 Говьсүмбэр аймгийн сургуулийн өмнөх боловсролын үнэлгээ

Сургуулийн өмнөх боловсролын үзүүлэлтүүд	Сүмбэр	Баянтал	Шивээговь	Говьсүмбэр
Хүртээмж, оролцоо	1	1	1	1
Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал	2	2	2	2
Боловсролын чанар	3	3	4	3

2.4.2 Дорноговь

Тус аймгийн хувьд боловсролын үйлчилгээ маш өргөн хүрээтэй.

2017 оны суурин хүн ам: 68192

2018-2019 оны хичээлийн жилд:

- ЕБ-ын сургууль: 22
- Суралцагчид: 13046
- Цэцэрлэг: 33
- Суралцагчид: 5321 байна.

Үйлчилгээ авч буй хүн ам олон, нягтрал, хүрээ их учраас үзүүлэлтүүд сум бүрийн хувьд харилцан адилгүй байна. Хүртээмж оролцоо сумдад муу байгаа ч аймгийн нийт дүн харьцангуй сайн гарчээ.

Хүснэгт 2.15 Дорноговь аймгийн ерөнхий боловсролын үнэлгээ

ЕБ-ын үзүүлэлтүүд	Сайншанд	Замын-Үүд	Даланжаргал	Айраг	Алтанширээ	Дэлгэрэх	Иххэг	Мандах	Сайхандулаан	Улаанбадрах	Хатанбулаг	Ховсгол	Эрдэнэ	Өргөн	Дорноговь
Хүртээмж, оролцоо	5	4	0	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	4
Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал	4	3	3	3	2	3	4	2	3	2	0	4	3	3	2
Боловсролын чанар	3	2	4	4	3	3	3	2	3	3	3	2	2	4	1
Боловсролын үр дүн	5	2	2	3	1	2	2	1	2	1	2	2	2	1	3

Сургуулийн хэмжээ боловсролын үр дүнд сайнаар нөлөөлдөг (big is better) эсэх тухай судалгаа 2000-аад оны эхээр олноороо хийгдсэн. Энэ зарчим манай улсын хувьд ерөнхийдөө үнэн байсаар ирсэн. Олон хүүхэдтэй том сургуулийн үзүүлэлтүүд жигдхэн сайн байдаг, боловсролын үр дүн ч мөн сайн байх хандлагатай.¹² Учир нь олон хүүхэдтэй, багштай сургуульд төрөл бүрийн нөөц их, хүүхдүүд хамтдаа суралцаж, “мэргэжлийн” багш нар хамтдаа ажиллах боломжтой. Тухайлбал, Дорноговь Замын-Үүд, Сайншанд, Айраг сумын сургуулиудын үзүүлэлт сайн байна.

Хүснэгт 2.16 Дорноговь аймгийн сургуулийн өмнөх боловсролын үнэлгээ

¹²Санал, дүгнэлтийн хэсгээс судалгааг харах

Сургуулийн өмнөх боловсролын үзүүлэлтүүд	Сайншанд	Замын-Үүд	Даланжаргал	Айраг	Алтанширээ	Дэлгэрэх	Иххэг	Мандах	Сайхандулаан	Улаанбадрах	Хатанбулаг	Хөвсгөл	Эрдэнэ	Өргөн	Дорноговь
Хүртээмж, оролцоо	1	0	1	1	1	1	0	0	1	1	1	0	0	0	1
Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал	1	1	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	0	1
Боловсролын чанар	3	2	3	4	2	2	4	1	2	1	1	2	4	4	3

Сургуулийн өмнөх боловсролын орцын үнэлгээ сайн гарсан ч хүртээмж, тэгш байдал муу байна.

2.4.3 Дундговь

2017 оны суурин хүн ам: 46383

2018-2019 оны хичээлийн жилд:

- ЕБ-ын сургууль: 19
- Суралцагчид: 8050
- Цэцэрлэг: 21
- Суралцагчид: 3328

Дундговь аймаг харьцангуй цөөн хүн амд боловсролын үйлчилгээг тааруу хүргэж байна. Аймгийн нийт дүнг сумдын дунджаар биш харин бие даасан хэлбэрээр гаргасан. Хүртээмж, оролцоо муу, тэгш боломж, боловсролын орчны чанар тааруу гарчээ. Хүртээмж, оролцоо маш сайн байгаа 3 сум байна.

Харин боловсролын үр дүн энэ дэд бүс нутагтаа хамгийн өндөр гарсан. Өмнөх бүлгээс энэ үр нөлөөг тооцоход ямар үзүүлэлтүүд авсныг харах хэрэгтэй. Ерөнхий шалгалтын дундаж оноо улсын дунджаас өндөр байсан нь хамгийн их нөлөөлсөн байх. Гэхдээ сумд харьцангуй жигд байх нь бүхнээс чухал.

Хүснэгт 2.17 Дундговь аймгийн ерөнхий боловсролын үнэлгээ

ЕБ-ын үзүүлэлтүүд	Сайнцагаан	Адаацаг	Баянжаргалан	Говь-Угтаал	Гурвансайхан	Дэлгэрхангай	Дэлгэрцогт	Дэрэн	Луус	Сайхан-Овоо	Хулд	Цагаандэлгэр	Эрдэнэдалай	Өлзийт	Өндөршил	Дундговь
Хүртээмж, оролцоо	5	0	0	0	0	5	0	0	0	0	3	0	5	0	0	1
Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал	4	4	3	2	4	3	2	2	3	4	2	1	3	3	3	2
Боловсролын чанар	3	3	2	3	4	3	3	3	3	4	3	2	3	3	4	2
Боловсролын үр дүн	4	4	1	1	2	2	0	4	3	4	3	0	5	1	1	3

Сургуулийн өмнөх боловсролын хувьд ч хүртээмж, оролцоо муу гарсан байна. Дэлхийн улс орнууд сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 98 хувьд хүргэсэн тухай мэдээлж байхад тус аймагт ердөө 79 хувь байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт байна.¹³ Сургуульд элсэхийн өмнөх 1 жилд бүх хүүхдийг зохион байгуулалттай сургалтад 100 хувь хамруулахаар БСШУЯ олон жил хичээж ирсэн. Тус аймагт энэ үзүүлэлт 76 хувь байгаа нь хүүхдийн эрх зөрчигдөж, боловсролын үйлчилгээний хүртээмж муу байгааг мөн илтгэнэ. Сум бүрийн хувьд шилжилт хөдөлгөөн, хүн амын тооны асуудлаас шалтгаалан хамран сургалт харилцан адилгүй байж болох ч аймгийн дүнгээр бага байгаа нь анхаарах ёстой асуудал болж байна. Сайнцагаан, Эрдэнэдалай сумдаас бусад нь

¹³ Куба, Герман, Чех, Дани зэрэг олон оронд 100%, <https://data.worldbank.org/indicator/SE.PRE.ENRR?view=chart>

цэцэрлэгийн барилгын хүчин чадал хүрэлцэхгүй байгаагаас шалтгаалаагүй байна. Иймд онцгой анхаарал хандуулж суурин хүн амын тоог нягтлан хүртээмж, оролцоог улсын дундаж түвшинд “яаралтай” авчрах хэрэгтэй.

Хүснэгт 2.18 Дундговь аймгийн сургуулийн өмнөх боловсролын үнэлгээ

Сургуулийн өмнөх боловсролын үзүүлэлтүүд	Сайнцаган	Адаацаг	Баянжаргалан	Говь-Угтаал	Гурвансайхан	Дэлгэрхангай	Дэлгэрцогт	Дэрэн	Луус	Сайхан-Овоо	Хулд	Цагаандэлгэр	Эрдэнэдалай	Өлзийт	Өндөршил	Дундговь
Хүртээмж, оролцоо	3	0	2	1	1	1	1	1	1	1	4	0	4	1	1	1
Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал	1	0	1	0	0	0	0	1	0	1	1	0	1	1	0	1
Боловсролын чанар	2	3	3	3	3	3	3	3	3	3	3	2	2	3	1	3

2.4.4 Өмнөговь

2017 оны суурин хүн ам: 65645

2018-2019 оны хичээлийн жилд:

- ЕБ-ын сургууль: 21
- Суралцагчид: 12185
- Цэцэрлэг: 28
- Суралцагчид: 5421

Аймгийн дүнгээр хүртээмж, оролцоо сайн байна. Сумдын суурь боловсролын хүртээмж Цогтцэцийд маш сайн, Гурвантэст дунд, бусад сумдад тааруу эсвэл муу байна. Бусад аймагтай харьцуулахад боловсролын орцын чанар харьцангуй сайн байгаа ч боловсролын үр дүн тааруу байгаа бололтой. Нэг хүүхдийг сургах өртгөөр тэгш байдлыг хэмжвэл хамгийн их хэлбэлзэлтэй аймаг байлаа. Жишээ нь, зарим суманд нэг хүүхдийг 2.6 сая төгрөгөөр сургаж байгаа нь аймгийн дунджаас даруй 2.6 дахин их юм.

Хүснэгт 2.19 Өмнөговь аймгийн ерөнхий боловсролын үнэлгээ

ЕБ-ын үзүүлэлтүүд	Даланзадгад	Цогтцэций	Баяндалай	Баяновоо	Булган	Гурвантэс	Мандаловоо	Манлай	Ноён	Номгон	Сэврэй	Ханбогд	Ханхонгор	Хүрмэн	Цогтовоо	Өмнөговь
Хүртээмж, оролцоо	5	5	0	0	0	3	0	0	0	0	0	1	0	0	0	5
Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал	3	3	4	4	4	4	3	3	3	2	4	3	4	3	2	2
Боловсролын чанар	3	3	3	3	3	4	3	3	3	3	3	3	3	2	4	2
Боловсролын үр дүн	5	4	2	1	2	2	2	2	2	1	2	2	2	2	0	2

Тус аймгийн ихэнх сумдад бүлэг дүүргэлт өндөр байв. Эндээс цэцэрлэгийн хүчин чадал хүн амдаа үйлчилгээ үзүүлж хүрэхгүй байна гэж дүгнэж болохоор байна. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж нийт хүн амын ердөө 80 хувийг л хангаж чадаж байна. Сумдын үзүүлэлт харьцангуй жигд байв. Сургуульд элсэхийн өмнөх нэг жилд хүүхдүүдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулахад анаахарч байгаа юм байна. “Зохион байгуулалттай сургалтад хамрагдалтын хувь (сургуульд элсэн орохын өмнөх 1 жил)” 86 хувь байлаа. Гэхдээ нэмэгдүүлэх хэрэгтэй. Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал “маш муу” гарчээ. Энэ нь (inclusiveness) орчин үеийн боловсрол судлалд хамгийн чухал ойлголт болсон.

Хүснэгт 2.20 Өмнөговь аймгийн сургуулийн өмнөх боловсролын үнэлгээ

Сургуулийн өмнөх боловсролын үзүүлэлтүүд	Даланзадгад	Цогтлэций	Баяндалай	Баяновоо	Булган	Гурвангэс	Мандаловоо	Манлай	Ноён	Номгон	Сэврэй	Ханбогд	Ханхонгор	Хүрмэн	Цогтговоо	Өмнөговь
Хүртгээмж, оролцоо	3	2	1	1	0	0	1	0	1	1	1	0	1	1	0	1
Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал	1	1	0	0	0	0	0	0	0	0	1	1	1	0	0	0
Боловсролын чанар	2	4	4	3	3	3	3	2	4	3	3	4	4	4	1	3

2.5 Боловсролын салбарын бодлогын хэрэгжилтийн үнэлгээ

Бодлогын хэрэгжилтийг гаргахдаа тухайн хууль болон бодлогын баримт бичгээр дэвшүүлсэн зорилтыг хангахад хамааралтай хамгийн ойр үзүүлэлтийг эсвэл бүлэг үзүүлэлтийг сонгохыг хичээлээ.

Хүснэгт 2.21 Боловсролын салбарын хууль, бодлогын хэрэгжилтийг хэмжих үзүүлэлтүүд

Хууль, бодлогын зорилт	Түвшин	Үзүүлэлт
Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйл		
2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;	Ерөнхий боловсрол	Дэд бүтэц /Шийдэх асуудал/
	Сургуулийн өмнөх боловсрол	Дэд бүтэц /Шийдэх асуудал/
7/ сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;	Ерөнхий боловсрол	Суурь боловсролын хамран сургалтын бохир жин
Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн		
5.1.4. иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана;	Ерөнхий боловсрол	Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал
	Сургуулийн өмнөх боловсрол	Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал
Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого /2014-2020/		
7.9. Ерөнхий боловсролын сургуульд заах арга зүй, сургалтын технологиор мэргэшсэн магистр зэрэгтэй багшийн эзлэх хувийг 70 хувьд хүргэнэ.	Ерөнхий боловсрол	Магистр болон түүнээс дээш зэрэгтэй багшийн хувь
7.10. Ерөнхий боловсролын сургууль нэг ээлжээр хичээллэх боломж бүрдсэн байна.	Ерөнхий боловсрол	II ээлжинд нийт хүүхдийн хэдэн хувь хичээллэж байгаа
		Ээлжийн коэффициент
7.6. Монгол хүүхэд бүр үндсэн, цагийн, улирлын, ээлжийн, явуулын багшийн, нүүдлийн зэрэг хэлбэрээр сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдсан байна.	Сургуулийн өмнөх боловсрол	СӨБ-ын хамран сургалтын бохир жин
Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030		
I үе шат (2016-2020): Сургуулийн өмнөх боловсролын тогтолцооны төрөл хэлбэрийг өргөтгөж, хүртгээмж, чанарыг сайжруулан	Сургуулийн өмнөх боловсрол	СӨБ-ын хамран сургалтын бохир жин

сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд сургуулийн өмнөх насны нийт хүүхдийн 70 хувийг хамруулах нөхцөл бүрдүүлэх.		
I үе шат (2016-2020): Боловсролын олон улсын чанарын үнэлгээнд /PISA/ хамрагдах бэлтгэлийг хангаж, нийт ерөнхий боловсролын сургуулийг хоёроос ихгүй ээлжээр хичээллэх боломжийг бүрдүүлэх, уламжлалт нүүдлийн ахуйд зохицсон боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, нэвтрүүлэх. Бүрэн дунд боловсрол эзэмшсэн хүүхэд бүр мэргэжлийн чиг баримжаатай болсон байх	Ерөнхий боловсрол /4 зорилтот үзүүлэлтээс/	Ээлжийн коэффициент

Өмнөх бүлэгт харуулсан хууль, тогтоомж, бодлогын хэрэгжилтээс харахад манай улсад орчин үеийн боловсролын үйлчилгээний зорилтууд тодорхой хэмжээгээр хэрэгжиж байна гэж дүгнэж болохоор байна. Сумын түвшинд хуулийн хэрэгжилт харилцан адилгүй байгаа ч огт хэрэгжээгүй гэдэг үзүүлэлт гарахгүй байна. Хэрэгжилтэд өгсөн үнэлгээг нэгтгэж харвал бүс дотроо Өмнөговь, Говьсүмбэр аймаг бага зэрэг өндөр гарчээ. Гэхдээ энэ үзүүлэлтийн шалгуур 1 байх ёстой. Иймд 2030 он хүртэл хийх ажил их байгааг нотолж байна.

Хүснэгт 2.22 Говийн дэд бүсийн хүрэн дэх боловсролын салбарын бодлогын хэрэгжилт

Аймгууд	Дундговь	Дорноговь	Өмнөговь	Говьсүмбэр
Бодлогын хэрэгжилт	0.35	0.41	0.42	0.42

Хэрэгжилтэд өгсөн үнэлгээг нэгтгэж харвал Дундговь аймагт хэрэгжилт тааруу гарч байгаа нь хамран сургалттай шууд холбоотой байна. Сумдын үзүүлэлтэд хэлбэлзэл их байна. Дундговь аймгийн Өлзийт, Гурвансайхан суманд хэрэгжилт хамгийн өндөр байна.

Хүснэгт 2.23 Дундговь аймгийн боловсролын салбарын бодлогын хэрэгжилт

Хууль, бодлогын уялдаа, хэрэгжилт	Сайнцагаан	Адаацаг	Баянжаргалан	Говь-Угтаал	Гурвансайхан	Дэлгэрхангай	Дэлгэрцогт	Дөрөн	Луус	Сайхан-Овоо	Хулд	Цагаандэлгэр	Эрдэнэдалай	Өлзийт	Өндөршил	Дундговь
Боловсролын салбарын бодлогын хэрэгжилт	0.46	0.33	0.50	0.45	0.58	0.34	0.33	0.29	0.42	0.46	0.56	0.17	0.53	0.59	0.42	0.35

Дорноговь аймгийн Алтанширээ, Айраг, Иххэт, Хатанбулаг сумдад хэрэгжилт илүү өндөр гарсан байна. Гэхдээ энэ хоёр үзүүлэлтийг нэг болгох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, үндэсний хэмжээний бодлогыг орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд бүрэн тусгаж, Монгол улсын хэмжээнд хууль болон бодлогын бичиг баримтаар дэвшүүлсэн зорилт бүрэн хэрэгждэг болсон тэр үед бид хөгжлийн тухай ярих боломжтой юм.

Хүснэгт 2.24 Дорноговь аймгийн боловсролын салбарын бодлогын хэрэгжилт

Хууль, бодлогын уялдаа, хэрэгжилт	Сайншанд	Замын-Үүд	Даланжаргал	Айраг	Алтанширээ	Дэлгэрэх	Иххэт	Мандах	Сайхандулаан	Улаанбадрах	Хатанбулаг	Хөвсгөл	Эрдэнэ	Өргөн	Дорноговь
Боловсролын салбарын бодлогын хэрэгжилт	0.50	0.38	0.44	0.46	0.37	0.42	0.56	0.45	0.25	0.20	0.29	0.54	0.34	0.59	0.41

Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд хэрэгжилт илүү өндөр гарчээ.

Хүснэгт 2.25 Говьсүмбэр аймгийн боловсролын салбарын бодлогын хэрэгжилт

Хууль, бодлогын уялдаа, хэрэгжилт	Сүмбэр	Баянтал	Шивээговь	Говьсүмбэр
Боловсролын салбарын бодлогын хэрэгжилт	0.50	0.54	0.58	0.42

Өмнөговь аймгийн Баян-Овоо, Булган сумдад уялдаа, хэрэгжилт жигд өндөр байна. Ханбогд, Хүрмэн сумдад хэрэгжилт өндөр байгаа ч бодлогын уялдаа тааруу байжээ.

Хүснэгт 2.26 Өмнөговь аймгийн боловсролын салбарын бодлогын хэрэгжилт

Хууль, бодлогын уялдаа, хэрэгжилт	Даланзадгад	Цогтцэций	Баяндалай	Баянвоо	Булган	Гурвантэс	Мандаловоо	Манлай	Ноён	Номгон	Сэврэй	Ханбогд	Ханхонгор	Хүрмэн	Цогтовоо	Өмнөговь
Боловсролын салбарын бодлогын хэрэгжилт	0.50	0.38	0.44	0.46	0.37	0.42	0.56	0.45	0.25	0.20	0.29	0.54	0.34	0.59	0.29	0.42

2.6 Боловсролын салбарын бодлогод өгөх санал ба зөвлөмж

Монгол улсын хөгжлийн үзэл баримтлалд өгөх санал

1. Боловсролыг бүхлээр бодлого боловсруулж байх. Өмнөх бодлогууд нэг бол хэт ерөнхий асуудал руу орж, тэр нь хэмжих боломжгүй, нэг бол бүр 1.1.1.1 байхаар хэт жижиг асуудал руу орсон логик уялдаа холбоос муутай байна.¹⁴ Иймд боловсролыг эсвэл аль нэг асуудлыг бүхлээр нь, боловсролын шатыг дуустал (cohort) харж зорилт, түүнийг дагаад авах арга хэмжээ, түүний биелэлтийг хэмжих шалгуураа тодорхойлох хэрэгтэй байна.
2. Орчин үеийн боловсрол судлалын концепцийн өөрчлөлт, бодит хэрэгцээг харах. Албан боловсрол буюу заавал эзэмших суурь боловсролоос бусад төрлийн “сургалтыг” албан бус боловсрол гэж бид нэрлэдэг. Орчин үед концепцийн хувьд ийм хэлбэрээр үргэлжлүүлэх боломжгүй болсон. Хүн насан туршдаа, насан эцэслэх хүртлээ боловсордог (Жон Дью 1916, Ардчилал ба боловсрол, 1-р бүлэг). Сургуульд суух, тодорхой ажлын чиг баримжаа олох сургалтад хамрагдах зэрэг нь боловсролын зөвхөн маш бага хэсэг. Учир нь хүн цаг мөч бүрт, бас хаана байхаас үл хамааран боловсорч байдаг. Боловсрол эзэмшихийг ахиж дэвших чадвар олж авах үйл явц гэж тодорхойлвол насан туршийн боловсролыг өөрчлөгдөж буй нийгэмд дасан зохицон үр дүнтэй амьдрах чадвартай болох үйл явц гэж тодорхойлно. Насан туршийн боловсролын талаар, насанд хүрсэн хүн амын боловсролын талаарх бодлогоо эргэн харах хэрэгтэй болжээ. Тухайлбал, насанд хүрсэн хүн ам урсгалаараа буюу нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээлэл төдийхнөөр эмх цэгцгүй мэдээлэл хүлээн авдаг. Гэтэл зарим нэг албан байгууллагын мэргэжлийн сургалт, хүмүүс өөрийн хүсэлтээр хамрагдах сургалт, мэргэжлийн бүлгүүдийн хамтдаа бүтээх хуваалцах бага зэргийн мэдлэгээс өөр Монгол улс насанд хүрсэн хүн амаа боловсруулах тал дээр бараг юу ч хийхгүй байна. Насанд хүрсэн хүн амын зарим хэсэгт зориудын сургалт хэрэгтэй байдаг, яагаад бодлого боловсруулагчид хүн амын насан туршийн боловсролын үйл явцад нөлөөлөхийг хичээх хэрэгтэй байдаг тухай сүүлийн үед философийн болон эмпирикийн судалгаа, эргэцүүлэл олноор хэвлэгдэж

¹⁴ “Турван тулгуурт бодлого” макро асуудал төлөвлөж байснаа хэт микро асуудал руу орсон байх бол “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” нэг бүхэл зүйлийг зөвхөн нэгээхэн жижигхэн хэсгүүдийг онцолж авч үзсэн шинжтэй.

байна.¹⁵ Мөн Хятад улс хэрхэн ажилгүй, ажил эрхлэхийг хүсэхгүй байгаа залуусаа нөхөн сэргээх төв (“rehabilitation center”)-д амьдруулан төлөвлөгөөт сургалт явуулж байгаа тухай бичих боллоо.

3. Боловсролд хүнлэг энэрэнгүй, бүхнийг багтаасан зарчмыг бүх шатанд хангах. Хүүхэд байтугай насанд хүрсэн хүн бүрт амьдралын тодорхой үед тусламж дэмжлэг хэрэгтэй байдаг. Гэхдээ орчин үеийн хандлага хүүхдийг эрт үед нь оношилж, эртнээс ямар тусламж хэрэгтэй байна түүнийг нь хүргэхийг хичээдэг болсон. Сургуулиудад тусгай мэргэжилтэн ажиллуулж, хүүхэд нэг бүрийг тусгайлан авч үздэг болсон байна¹⁶. Хүүхдэд маш олон төрлийн тусгай тусламж (хөгжлийн бэрхшээлтэй, хоцрогдолтой, удаан, хөгжлийн тодорхой үе шат удааширсан, ар гэрт нь асуудал байгаа гэх мэт) хэрэгтэй байж болно. Зөв цаг үед хэрэгтэй тусламж үзүүлснээр нийгмийн олон асуудлыг хамтдаа даван туулах боломжтой. Тухайлбал, ахлах ангийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох, нэмэлт санхүүжилт шаардлагатай бол төрөөс бүрэн хариуцах эрхзүйн орчинг нь илүү тодорхой болговол сургуулиуд, орон нутаг үүнд анхаарлаа хандуулж эхлэх байх.
4. Орон нутгийн хүлээх хариуцлагыг заавал ил тод тусгах. Ихэнх бодлогын баримт бичигт орон нутгийн зүгээс хүлээх хариуцлагыг орхигдуулжээ. Ялангуяа үндэсний хөтөлбөрүүдийг Засгийн газар, салбарын яам хэрэгжүүлэхээр, харин орон нутагт эрх үүргээ хуваалцах зам нь тэдний хооронд гэрээ байгуулах арга байгаа нь бодлогын хэрэгжилтийг удаашруулж байна. Боловсролын зорилтуудыг аймгийн удирдлага гэрээгээр биш илүү хүчтэй эрхзүйн зохицуулалтаар гүйцэтгэх хэрэгтэй санагдсан. Энд хуулийн хүчлэлт (legitimacy) дутагдаж байна.
5. Боловсролын тухай хуулийн “32 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх” хэсэгт
 - 32.1.1. Сургуулийн өмнөх болон суурь боловсрол эзэмшүүлэх сургалтад харьяа айл өрхийн хүүхдийг хамруулах;
 - 32.1.2. Иргэдийн боловсрол эзэмшсэн байдалд судалгаа хийж, шаардлагатай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;
 - 32.1.3. Суурь боловсрол эзэмшээгүй иргэнд нөхөн эзэмшүүлэх ажил зохион байгуулах.

хэмээн зааж, хамгийн гол ажил үүрэг нь нэгэнт баг, хорооны Засаг даргад ногдож байгаа учраас тэдэнд онцгой анхаарал хандуулж, боловсролын мэдээллийн системд нэвтрэх эрх олгох, боловсрол судлалын бүхий л төрлийн сургалтад хамруулах зэргээр хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, ажлын үр дүнг үнэлэх үнэлгээнд хамгийн гол ажил болгон оруулж, хөдөлмөрийн хөлс урамшуулал нь дээрх үүргээ хэрхэн биелүүлж байгаагаас хамаардаг болгох хэрэгтэй байна.

Бүсийн хөгжлийн хөтөлбөрт

Олон жил боловсрол судлаачдын дунд сургуулийн хэмжээ боловсролын үр дүнд хамаатай эсэх тухай мэтгэлцээн явсан. Энд хоёр өөр ойлголт байгаа. Олон бүлэгтэй “том” сургууль байх, бүлэг дүүргэлт өндөр байхыг “том” сургууль гэж хэлэх нь өөр ойлголтууд.

Бүлэг дүүргэлтийн тухайд, ерөнхийдөө багш нарт цөөн байх тусмаа амар, мөн нэг хүүхдэд тавих анхаарал, халамж нэмэгдэнэ. Ялангуяа бага ангид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чухал болох нь судалгаагаар харагддаг.¹⁷ Харин дунд болон ахлах ангид бүлэг дүүргэлт бага байвал сайн гэж

¹⁵ Boeren Ellen 2016, Lifelong Learning Participation in a Changing Policy Context, Panitsides, Eugenia A, 2016, Lifelong Learning: Concepts, Benefits and Challenges.

¹⁶ Sahlberg, 2016 Finnish lesson

¹⁷ Бүлэгт дүүргэлтийн нөлөөллийг тооцох зорилгоор 1979-2014 онуудад хийсэн судалгаануудын үр дүнг нэгтгэсэн тойм судалгаагаар “Australian Association for Research in Education”, Prof. David Zyngier

I have just completed a comprehensive review of 112 research papers on class sizes written between 1979 and 2014. I found that reducing class size in the first four years of school can have an important and lasting effect on student achievement.

баталж чадаагүй.¹⁸ Гэхдээ олон хүүхэдтэй ангид шинжлэх ухааны хичээлүүдийг уламжлалт лекцийн аргаар /хүүрнэх хэлбэрээр/, ширээ, сандалыг уламжлалт хэлбэрээр байрлуулан заагаад нэмэргүй гэдэг нь тодорхой. “Ангид хүүхдүүд араар дүрсгүйтэж, ярьж, тоглож цагийг өнгөрөөх нь элбэг” хэмээн бүлэг дүүргэлт болон сургуулийн хэмжээ боловсролын үр дүнд хамаатай эсэхийг судалсан боловсролын түүхэнд хийгдсэн хамгийн том судалгааны нэг болох “STAR”-ийн тайланд бичжээ.¹⁹

He saw the change himself visiting classrooms in Buffalo.

“In a big class, everybody in the back of the room is talking and giggling, and the little kids are throwing things at each other,” Finn said. “But in a small class, the first thing a teacher says is ‘Let’s all bring our chairs around me here in a circle.’”

Харин манай улсад олон бүлэгтэй төрийн өмчийн “том” сургуулийн сурлагын амжилт аймгуудад сайн байсаар ирсэн. Бидний хийж буй энэ судалгааны өнөөгийн нөхцөл байдлын үзүүлэлтээс ч мөн ингэж харагдаж байна.²⁰ Эсрэгээрээ, анги дээшлэх тусам “том” нь дээр юм байна гэдэг дүгнэлт ч²¹ орон нутагт үнэн байдаг. Энэ нь, тухайлбал, нэг сургуульд 6-р ангийн хоёроос дээш бүлэг хичээллэх тухай ойлголт. Сумдад цөөхөн хүүхэдтэй анги хичээллэх нь хүүхдийн эрх ашигт нийцэж байна гэж бодлого боловсруулагчид тайлбарладаг боловч харин ч эсрэгээрээ хүүхдийн эрхийг зөрчиж хүүхдэд тэгш боломж олгох үүргээ биелүүлж чадахгүй байгаа хэрэг. Гэрээсээ сургуульд явж байгаа нь түүнд тэгш боломж олгож байгаа мэт боловч тухайн сургуульд 6-р ангийн нэг бүлэг байдаг, тэр нь 8 хүүхэдтэй (зарим сургуульд түүнээс ч цөөн хүүхэд байх нь элбэг) бол тэр институц зарчмын дагуу ажлаа хийх, мөн хийж байгааг нь хянах (institutional legitimacy) тогтолцоо алдагдах эрсдэл өндөр.²² Нэг хичээлийг заадаг хоёр багш байвал бие биедээ туслахаас гадна хяналт тавьж чадна.

Иймд бид бага ангид аль болох бүлэг дүүргэлтийг багасгаж, дунд болон ахлах ангид бүлэг дүүргэлтийг нэмэгдүүлэх, бага сургууль бол тэр хэмжээндээ олон бүлэгтэй, дунд сургууль мөн нэг анги нь хоёроос дээш бүлэгтэй байхаар тухайн сургуулийн хэв шинжид тохирсон “том” байх нь боловсролын үр дүнд нөлөөлж байна гэж үзлээ. Хүүхэд цөөн байхад заавал 9 жилийн сургууль байх гэж, 12 жилийн сургууль байх гэж хичээх нь эдийн засгийн хувьд ч үр ашиг муутай, хамгийн гол нь хүүхдийн эрх ашиг хохирно. Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн дагуу хил зааг хамааруулахгүйгээр кластер хэлбэрээр сургуулийг зохион байгуулах эрхзүйн үндэс байдаггүй байх. Гэхдээ хамгийн чухал нь хүүхдийн эрх ашиг тул хүүхдэд ээлтэй байдлаар шийдэх эрх нь орон нутгийн удирдлагад нээлттэй.

Ахлах сургуулийн хамран сургалт бидний судалсан 4 аймагт бага байна. Ялангуяа Дундговь аймагт 48 хувь нь 10-р ангид элсчээ. Мөн хүн амын тоо эрс нэмэгдэж байгаатай холбоотой Дорноговь аймаг, хамран сургалт тааруу болох шинж байгаа тул эдгээр аймагт зарим сургуулийг өргөтгөж 12 жилийн сургууль болгон элсэлтийг нь нэмэгдүүлэх хэрэгтэй болжээ. Олон улсад хүүхдүүдийг 12 жилийн сургуулиар бүрэн дунд боловсрол эзэмшүүлж, мөн мэргэжлийн чиг баримжаатай болгож төгсгөх бодлого баримталж байгаа. Бүрэн дунд боловсрол бол маргаангүй хүнийг маш сайн төлөвшүүлдэг хамгийн чухал шат гэдэг нь тодорхой. Өмнө нь манай улс 10-р ангид элсэгчдийг 75 хувьд хүргэхээр төлөвлөдөг байсан гэтэл одоо 50 орчим хувьтай, аймгуудын хувьд үлдсэн 50 хувийн хэд нь МСҮТ-д элсэж байгаа нь тодорхойгүй. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны МСҮТ-ийн статистикийн мэдээ хангалтгүй байдаг учраас элсэлтийг аймгаар гаргаж харах өгөгдөл

¹⁸“STAR” төслийн зохиогч ингэж бичжээ:

“Despite the many studies that show positive effects, research has yet to come up with a consistent, integrated explanation for the gains attributable to reduced class size,” according to the paper, published in the journal [Review of Educational Research](#).

¹⁹ Finn, Jeremy D.; Pannozzo, Gina M.; Achilles, Charles M. The "Why's" of Class Size: Student Behavior in Small Classes *Review of Educational Research*, v73 n3 p321-368 2003.

²⁰ Гэхдээ нийслэлд энэ дүгнэлт батлагдахаа больдог.

²¹ <https://www.gatesnotes.com/Education/UCF-Digital-Learning>

²² Suchman, M. (1995). Managing legitimacy: Strategic and institutional approaches. *Academy of Management Review*, 20(3), 571-610.

байхгүй байна. Иймд боловсролын мөшгих (Cohort) шинжилгээ энд ирээд алдагддаг. МСҮТ-ийн ерөнхий боловсролын сургалтын чанар маш муугаас гадна БСШУС-ын Сайдын 2018 оны А/453 тоот тушаалаар 1225 цаг жилд тавигдсан байдаг бол мэргэжлийн боловсролд ерөнхий эрдмийн энэ цагийн ердөө 20 орчим хувийг судлаад мэргэжлийн боловсролоос гадна ерөнхий боловсрол эзэмшсэн гэрчилгээ авдаг нь хэтэрхий гажуудуулсан хэрэг болдог. Иймд аль болох олон хүүхдийг ахлах сургуулиар бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхгүй бол хожим засахад хэцүү алдаа эндээс гарна.

Аймгийн хөгжлийн хөтөлбөрт

1. Хуулиудын боловсролын талаарх заалт, үндэсний хэмжээний БББ-ыг хэмжиж болохуйцаар зорилтот бүлэг, шалгууртайгаар аймгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгах боломжтой.
 - Орон нутагт адил хэрэгжиж байж л үндэсний хэмжээнд хэрэгжинэ.
2. Өнөөг хүртэл хүртээмж, оролцоо олон улсын түвшинд хүрэхгүй байна.
 - 98-аас бууж болохгүй. Монгол улс 2015 онд хэрэгжүүлж дууссан “Боловсролын мастер төлөвлөгөө”-нд дэвшүүлсэн зарим зорилтоо 2018-2019-оны хичээлийн жилд ч бүрэн хангаагүй байна.
3. Сургуулийн өмнөх боловсролд онцгой анхаарал хандуулах шаардлагатай байна.
 - Ялангуяа Дундговь аймгийн үзүүлэлтүүд улсын дунджаас бага байна. 2015 оны мастер төлөвлөгөөний зорилтод хүртэл хүрээгүй байна. Малчдын хүүхдийн хувьд зуны сургалтаас гадна, байнгын эцэг эхэд нь сургалт хийх тогтолцоо хэрэгтэй. Хүүхдийн тархийг багаас нь хөгжүүлэх арга техникүүд (whole brain development), синапсис явагдах үед нь тархийг хөгжүүлэх аргуудыг заавал эцэг эхэд нь зааж өгөх хэрэгтэй байдаг.
4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ бүрэн хамруулах, анхаарал халамж тавьж мэргэжлийн чиг баримжаатай болгох²³
 - ОХУ-ын туршлага: Код бичигч (Java, python программын хэл), зохиолч, хөгжимчин, анимейшн график дизайнер, эм зүйч зэрэг биеийн хөдөлгөөн бага ажил мэргэжил эзэмшүүлэхэд анхаарсан – үр дүн нь их сайн байгаа.
5. Боловсролын орцын чанарын асуудлуудыг шийдвэрлэж дуусах шаардлагатай.
 - Шийдэх ёстой асуудал гэдэг нь Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан хөрөнгө оруулалтууд хэрэгтэй байгаа, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан эрхийг хангаж чадахгүй байгаа тухай юм. 21-р зуунд хүний амьдралын хамгийн суурь хэрэгцээг хангаж чалахгүй байх нь утгагүй юм. Иймд барилга шинээр барина гэхээсээ илүү сургалтын орчны, эрүүл ахуйн асуудлыг эхний ээлжинд яаралтай шийдвэрлэмээр байна. Ялангуяа Дундговь /сургуулиудад 54 асуудал, цэцэрлэгүүдэд 22 асуудал/, Дорноговь аймагт /сургуулиудад 57 асуудал, цэцэрлэгүүдэд 21 асуудал/ дулаан хангамж, усан хангамж, ариутгах татуурга нь инженерийн болон инженерийн бус төвлөрсөн шугамд холбогдоогүй, барилга байгууламжийн засвар үйлчилгээ, орчны тохижилтын асуудалтай сургууль, цэцэрлэг олон байна.
6. Боловсролын үр дүнг сайжруулахад удирдлагын зүгээс багахан анхаарал тавихад л хангалттай байдаг.
 - Манай улсын боловсрол бага багаар сайжирч байгаа. Багахан хичээл зүтгэл их хэмжээний өөрчлөлт авчирч чаддаг онцлогтой. Иймд илүү хүүхэд рүү, судлагдахуун руу нарийн орсон эсвэл багшийн мэргэшил рүү хандсан, хүүхдийн хоцрогдолтод, мөн илүү хурдтай хүүхдийг уйдаахгүй байхад, нөгөө талд хэнийг ч хөтөлбөрөөс хоцроохгүй байхад анхаарсан зорилт дэвшүүлэх хэрэгтэй. Жишээ нь, газарзүйн нийт 56 багшийг програм хангамж ашиглан заах аргазүйд сургана, бүх сургуулийг


²³ Soresi, Nota, Ferrari, & Solberg, (2008) Career Guidance for Persons with Disabilities, International Handbook of Career Guidance (pp.405-417).

хөгжмийн хичээл заах акустик шаардлага хангасан хөгжмийн хичээл хийх танхим, хөгжмийн зэмсгээр хангана гэх мэт.²⁴

3. Соёл

Олон улсын байгууллагад нэгтгэдэг мэдээллийн хоёр сан болох “Соёлын статистик”, “Хөгжлийн үзүүлэлт дэх соёлын хэсэг”-ийн аль алиныг бид одоогоор илгээж чадахгүй байна. ЮНЕСКО-гийн соёлын статистик 2009 оноос хойш нэгтгэгдэж байгаа боловч манай улсын мэдээлэл дараах зурагт харуулсан байдалтай байв.

Зураг 3.1 ЮНЕСКО-гийн мэдээллийн сан дахь Монгол улсын соёлын мэдээлэл



Эх сурвалж: <http://uis.unesco.org/en/country/mn?theme=culture>

Олон улсад нэгтгэдэг мэдээлэлд ач холбогдол өгснөөр олон давуу тал бий болно. Тухайлбал:

- Соёл, урлагийн үзүүлэлтүүдийг нэгтгэж харж чадвал асуудлын мөн чанарыг бүхлээр нь²⁵ тодорхойлж, авах арга хэмжээгээ зөв гаргаж ирнэ.
- Хөрөнгө оруулагчдыг бодитой, судалгаатай тоон мэдээлэлд үндэслэсэн өнөөгийн нөхцөл байдал, цаашдын хэрэгцээний талаарх мэдээллээр хангана. Улмаар асуудлаа шийдэх үндэслэл сайтай тайлбартай²⁶ болно. Гарах үр дүн нь тодорхой харагдаж байгаа нөхцөлд л хөрөнгө оруулалт хийгддэг.

Статистикийн зорилгоор соёлыг тодорхойлох нь соёлын үндсэн салбаруудад тушиглэсэн прагматик ойлголт юм.²⁷ Үнэ цэнийн гинжин холбоо загвараар (value chain) авч үзвэл, загвар, санаа гаргахаас эхлэн бүтээх, үйлдвэрлэх, түгээх, үзүүлэх, дамжуулах, хэрэглэх үе шатыг багтаасан соёлын бүхий л үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг хамарна. Соёлын өргөн хүрээний тодорхойлолтод аялал, жуулчлал, чөлөөт цагийн үйл ажиллагаа ч багтжээ.

Соёлын үндсэн салбар:

- А: Соёлын болон байгалийн өв (Cultural and Natural Heritage)
- В: Урлагийн тоглолт, баяр наадам (Performance and Celebration)

²⁴ Аймгийн удирдлага энэ дээр “Teach like Finland” by Timothy D. Walker (2017)-г жишээ нь уншиж санаа авч болно.

²⁵ As a whole nationwide

²⁶ Justification

²⁷ 2009 FCS (UNESCO-UIS, 2009)

- C: Дүрслэх урлаг, гар урлал (Visual Arts and Crafts)
- D: Ном, хэвлэл (Books and Press)
- E: Аудио, видео, интерактив медиа (Audio-visual and Interactive Media)
- F: Загвар, бүтээлч үйлчилгээ (Design and Creative Services)
- Биет бус соёлын өв (Intangible Cultural Heritage)

Холбоотой салбар:

- G: Аялал жуулчлал (Tourism)
- H: Спорт, чөлөөт цагийн үйл ажиллагаа (Sports and Recreation)

Дараах гурван салбар мөн соёлын үйлдвэрлэл, тархалтад гол хувь нэмэр оруулдаг. Эдгээр нь:

- Боловсрол, сургалт (Education and Training)
- Архив, хадгалалт (Archiving and Conservation)
- Тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл (Equipment and Supporting Materials)

3.1 Соёлын салбарын бодлогын уялдаа холбоо

Соёлын одоо мөрдөгдөж буй хуулийн уялдааг судлахдаа дараах 6 хуулиар хязгаарлалаа. Үүнд:

1. Соёлын тухай хууль (1996.04.11)
2. Соёлын өвийн тухай хууль
3. Боловсролын тухай хууль (2002.05.03)
4. Монгол хэлний тухай хууль
5. Номын сангийн тухай хууль.

Эдгээр хууль дээр Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан жагсаалтын дагуу түүвэрлэн нийт 141 /зарим нь хүчинтэй эсэх нь тодорхойгүй/ бодлогын баримт бичигт тойм шинжилгээ хийв.

Хүснэгт 3.1 Соёлын бодлогын бичиг баримт

Бодлогын бичиг баримтын төрөл	Урт	Дунд хугацааны		Богино	Нийт
	15-20 жил	8-10 жил	3-5 жил	1 жил	
Нийт	3	12	73	53	141
Улс, бус	3	6	18	2	29
Үндэсний түвшний	3	5	18	2	28
Бүсийн түвшний	0	1	0	0	1
Аймгийн түвшинд	0	2	10	4	16
Говьсүмбэр		1	5	1	7
Дорноговь		1	2	1	4
Дундговь			2	1	3
Өмнөговь			2	1	3
Сумын түвшний /Зарим нь батлагдсан эсэх нь тодорхойгүй	0	4	45	47	96

Нийт 141 бодлогоос 29 нь үндэсний болон салбарын хэмжээний буюу орон нутагт мөрдөж ажиллах, 112 нь аймаг, сумдын өөрөө удирдах байгууллагын баталсан баримт бичиг байна.

Урт хугацааны буюу 15-20 жил	Дунд хугацааны буюу 8-10 жил	Дунд хугацааны буюу 3-5 жил	Богино хугацааны буюу нэг жил	Нийт
3	6	18	2	29

Соёл, урлагийн талаар үндэсний хөтөлбөр, дэд хөтөлбөр олон байх боловч цаг хугацааны хувьд хугацаа нь өнгөрсөн нь олон байлаа. Гэтэл тэдгээр нь өнөөг хүртэл хүчинтэй гэсэн ангилалтай байв. Тухайлбал “Морин хуур, уртын дуу үндэсний хөтөлбөр” гэхэд 2004-2014 онд хэрэгжсэн боловч

одоо ч эрхзүйн хувьд хүчинтэй байх тул бид жагсаалтад багтаасан байгаа. Мөн хэрэгжээд ямар үр дүнд хүрсэн талаарх мэдээлэл олдохгүй байна.

Боловсролын салбартай харьцуулахад соёлын БББ үндэсний болон салбарын түвшинд цэгцтэй, бас заалтууд нь давхардал багатай, ойлгомжтой байлаа. Аймаг орон нутгийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт ч мөн харьцангуй сайн тусчээ.

Хүснэгт 3.2 Соёлын бодлогын баримт бичгийн уялдаа

Бодлогын нэр	Дундговь	Дорноговь	Өмнөговь	Говьсүмбэр
Соёлын өвийн тухай хуулийн зорилт	0.26	0.28	0.19	0.18
Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал	0.44	0.09	0.07	0.14
Төрөөс соёлын талаар баримтлах бодлого	0.30	0.16	0.08	0.21
МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр	0.20	0.31	0.28	0.39
Дундаж	0.30	0.21	0.16	0.23

Нийтлэг байгаа асуудал бол орчин үед “соёл”-ыг харах, ойлгох, хэрэглэх өнцөг өөрчлөгдсөн нь орон нутагт хүрээгүй байгаа бололтой. Тухайлбал, Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө /2011-2021/-нд:

“ДНБ-ийг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 34.7 хувийг хөдөө аж ахуй, 4.2 хувийг олборлох болон боловсруулах үйлдвэр, 13.5 хувийг тээвэр агуулахын үйл ажиллагаа, 0.8 хувийг барилга, 9.6 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн, барааны засварлах үйл ажиллагаа, 10.3 хувийг боловсрол, 9.4 хувийг төрийн удирдлага батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын үйл ажиллагаа, 17.5 хувийг бусад салбар тус тус эзэлжээ.”

гэжээ. Энд соёлын үйлдвэрлэлээс хэд гэдэг нь байхгүй байна.

3.1.1 Говьсүмбэр

Говьсүмбэр аймаг “Соёл, урлагийг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр” хэрэгжүүлж байгаа бөгөөд түүний бусад бодлогын баримт бичигтэй нийцэх нийцэл 50 хувь байв. Мөн МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг үйл ажиллагаандаа сайтар тусгажээ.

Урт хугацааны буюу 15-20 жил	Дунд хугацааны буюу 8-10 жил	Дунд хугацааны буюу 3-5 жил	Богино хугацааны буюу нэг жил	Нийт
	1	7	4	12

Хүснэгт 3.3 Говьсүмбэр аймгийн соёлын салбарын бодлогын уялдаа

Хууль, бодлогын уялдаа, хэрэгжилт	Сүмбэр	Баянтал	Шивээговь	Говьсүмбэр
Соёлын салбарын бодлогын уялдаа	0.19	0.19	0.13	0.23
Аймгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн уялдаа				0.29

3.1.2 Дорноговь

Дорноговь аймагт мөрдөгдөж байгаа 33 бодлого болон үндэсний хэмжээний, салбарын бодлогын нийцэл дунджаар 21 хувь гарлаа. Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн уялдаа муу байсан нь үүнд нөлөөлсөн. Учир нь сумын засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр ихэвчлэн аймгийн Засаг даргын зорилтуудыг биелүүлэхэд чиглэсэн байдаг.

Урт хугацааны буюу 15-20 жил	Дунд хугацааны буюу 8-10 жил	Дунд хугацааны буюу 3-5 жил	Богино хугацааны буюу нэг жил	Нийт
	3	15	15	33

Хүснэгт 3.4 Дорноговь аймгийн соёлын салбарын бодлогын уялдаа

Хууль, бодлогын уялдаа, хэрэгжилт	Сайншанд	Замын-Үүд	Даланжаргал	Айраг	Алтанширээ	Дэлгэрэх	Иххэт	Мандах	Сайхандулаан	Улаанбадрах	Хаганбулаг	Хөвсгөл	Эрдэнэ	Өргөн	Дорноговь
Соёлын салбарын бодлогын уялдаа	0.19	0.06	0.13	0.31	0.19	0.19	0.13	0.13	0.31	0.06	0.00	0.19	0.25	0.38	0.21
Аймгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн уялдаа															0.26

3.1.3 Дундговь

Дундговь аймгийн соёлын бодлогын чанар харьцангуй чамбай байлаа. Хэдийгээр аймгийн хэтийн зорилтыг төлөвлөсөн дараах бодлогын баримт бичгийн хүчин төгөлдөр хувийг олж авч үнэлгээнд оруулж чадаагүй ч, бусад БББ-г соёлын хөгжлийн асуудал сайтар тусгагджээ.

Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр /2018-2028/	Батлагдсан хувийг олоогүй
Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр /2012-2031/	Батлагдсан хувийг олоогүй

Тус аймгийн БББ-ын нийцэл хамгийн өндөр буюу 30 хувь гарлаа.

Урт хугацааны буюу 15-20 жил	Дунд хугацааны буюу 8-10 жил	Дунд хугацааны буюу 3-5 жил	Богино хугацааны буюу нэг жил	Нийт
	0	15	16	31

Хүснэгт 3.5 Дундговь аймгийн соёлын салбарын бодлогын уялдаа

Төрөөс соёлын талаар баримтлах бодлого	Сайнцагаан	Адаацаг	Баянжаргалан	Говь-Угтаал	Гурвансайхан	Дэлгэрхангай	Дэлгэрцогт	Дэрэн	Луус	Сайхан-Овоо	Хулд	Цагаандэлгэр	Эрдэнэдалай	Өлзийт	Өндөршил	Дундговь
Бодлогын уялдаа	0.28	0.24	0.36	0.30	0.25	0.18	0.31	0.19	0.30	0.30	0.31	0.30	0.13	0.40	0.25	0.30
Аймгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийн уялдаа																0.42

3.1.4 Өмнөговь

Өмнөговь аймгийн соёлын үйл ажиллагааны зорилт, төлөвлөгөө үндэсний болон салбарын бичиг баримттай хамгийн бага (16 хувь) нийцэлтэй байна.

Урт хугацааны буюу 15-20 жил	Дунд хугацааны буюу 8-10 жил	Дунд хугацааны буюу 3-5 жил	Богино хугацааны буюу нэг жил	Нийт
	2	17	16	35

Хүснэгт 3.6 Өмнөговь аймгийн соёлын салбарын бодлогын уялдаа

Хууль, бодлогын уялдаа, хэрэгжилт	Даланзадгад	Цогцэний	Баяндалай	Баянвоо	Булган	Гурвантэс	Мандагвоо	Манлай	Ноён	Номгон	Сэврэй	Ханбогд	Ханхонгор	Хүрмэн	Цогтووо	Өмнөговь
Соёлын салбарын бодлогын уялдаа	0.13	0.06	0.25	0.06	0.06	0.06	0.06	0.44	0.13	0.19	0.19	0.06	0.25	0.25	0.19	0.16

3.1.5 Соёлын салбарын бодлогын талаарх дүгнэлт

Соёлын бодлогын баримт бичигт дараах нийтлэг асуудлууд байна. Үүнд:

1. Соёлын талаар хангалттай БББ байдаг боловч хэрэгждэггүй. Эсвэл хэрэгжүүлээд хүрэх үр дүнгийн үзүүлэлт хэт бүрхэг байдаг эсвэл хөрөнгө мөнгөний асуудлаас шалтгаалан хойшлуулах хандлагатай байдаг байх магадлалтай юм байна. Иймд соёлын салбарын эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг тооцож төсөв, хөрөнгө батлуулах байр сууриа илэрхийлэхдээ тэрхүү үзүүлэлтээ суурь болгон ашиглаж сурах хэрэгтэй байна. Үйлдвэр, үйлчилгээний индекс, ажил, мэргэжлийн лавлагаа гаргах асуудлаас шалтгаалан соёл, урлагийн үйлдвэрлэл, үйлчилгээ, ажил мэргэжлийн талаар бүрхэг ойлголттой буюу “соёл” гэхээр театр, музей, соёлын төвийн үйл ажиллагаагаар хязгаарлаж ирсэн. Харин олон улсын бичиг баримтаас харахад ээмэг бөгж зэрэг үнэт эдлэл хийхээс програм хангамж зохиох хүртэлх бүхий л бүтээлч үйл ажиллагааг соёлын үйл ажиллагаа гэж үздэг юм байна.²⁸ Хавсралт 8-аас харна уу.
2. Бусад орны эрхзүйн орчинтой харьцуулахад дүрслэх урлаг (art) талаа эрхзүйн бичиг баримтад хэт ерөнхий оруулдаг, орхидог юм болов уу гэж санагдаж байна.²⁹
3. Энэ салбарын эдийн засгийн хүч (power) эрхзүйн орчинд тэр чигтээ сул байна. Үндсэн Хуулийн 7 дугаар заалтад “соёлын өв төрийн хамгаалтад байх тухай” заалт байгаа учраас зөвхөн тоолж бүртгэх биш, сэргээн засварлах, хамгаалах бүхий л зардлыг төрөөс асуудалгүйгээр шийдвэрлэж байх ёстой. Эрсдэлд байгаа хөдлөх болон үл хөдлөх өвийг хамгаалах талаар Төсвийн тухай хуульд тусгай зүйл анги байх хэрэгтэй.
4. Соёлын салбарыг бүхлээр нь харсан философи хэрэгтэй байна. Салбарыг бүхлээр нь харвал “эмхэрч цэгцрээгүй байгаа мэт” сэтгэгдэл төрлөө.
5. Салбарын хуулийн философи болон хүч нөлөөг (Spirit of law) бодолгүйгээр бусад хуулийн загвараар боловсруулах нь тухайн салбарын онцлог бүхий орчинд үйлчилж чадахгүй байх эрсдэлтэй. Бүтээлч сэтгэлгээ хязгааргүй урсаж байхыг дэмжих тал дээр Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулга ч дутуу болжээ. Уран бүтээлчдийг хөгжүүлэх, хамгаалах талаар дэвшилттэй агуулга багтсан байна. Тус хуулийг яаралтай гаргах нь энэ салбарын асуудлуудыг шийдэхэд тус дөхөмтэй юм.
6. Соёл, урлагийн газарт статистикийн чиг үүрэг шилжсэн нь буруу өөрчлөлт болжээ. Бодлогын хэрэгжилт, цаашдын хэрэгцээг эмпирик байдлаар харуулахад өнөөгийн нөхцөл байдлын дэлгэрэнгүй статистик чухал үүрэгтэй.

3.2 Соёлын салбарын өнөөгийн нөхцөл байдал

Монгол улс өнөөг хүртэл соёлын салбарыг хэт явцуу хүрээнд ойлгож ирсэн. Соёлыг хүн төрөлхтний амьдрах хэв маяг, арга ухаан гэдэг утгаар ойлгох нь чухал. Хүн төрөлхтөн өнөөдрийг хүртэл хэрхэн амьдарч ирсэн нь соёл юм.

Соёлын хуулийн шинэчилсэн найруулгын 3 дугаар зүйлд зааснаар:

3.1.1. “соёл” гэж хүн төрөлхтний язгуур үнэт зүйлс, аливаа ард түмний тогтвортой хөгжлийн үндэс, улс үндэстэн оршин тогтнохын баталгаа, харилцан ойлголцох түлхүүр, хүний сайн

²⁸ Culture for development indicators

²⁹ Жишээ нь (http://www.academia.edu/37169711/Santander_Art_and_Culture_Law_Review_-_Interview_with_Cecile_Duvelle_by_H._Schreiber_and_L._Lixinski “Art, culture and heritage law review”).

сайхан амьдралын эх сурвалж, унаган байгаль, эх дэлхийтэйгээ идээшин зохицож ирсэн амьдрах ухааныг;

гэж ойлгоно. Соёлын үйл ажиллагаанд оролцож, үйлчилгээ авах нь хүний суурь эрх. Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлд зааснаар “Монгол улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

8/ соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;”

гэсэн байдаг.

Соёл бол аливаа өөрийн гэсэн онцлог бүхий үндэстэн оршин тогтнох үндсийн нэг. Монгол улсын “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ийн 3.1.4 дугаар зүйл заалт тэр чигээрээ соёлыг хамгаалах тухай юм.

Институцийн талаасаа соёлын аливаа бодлогыг хэрэгжүүлэхэд санхүүжилтийн эх үүсвэрийг шийдэх, төр, орон нутгийн засаг захиргаа туслах тал дээр илүү хүчтэй институц бий болгох заалт хэрэгтэй байж болохоор байна. Тиймгүйсэн бол улс үндэстэн дотроо үйл ажиллагаа явуулахад олон улсын конвенцийг тогтмол иш татах³⁰ шаардлага үүсэхгүй байх байсан болов уу. Мэдээж олон улсын конвенцээр хүлээсэн үүргээ биелүүлэх нь чухал ч соёлоо хамгаалах нь үндэстний заавал хүлээх ёстой хариуцлага юм.

Дүгнэж хэлбэл, соёл хүний суурь эрх, соёл үндэстний оршин тогтнох үндэс гэдэг утгаараа төрөлхийн үнэ цэнэтэй³¹ (intrinsic value) буюу зардал, үр өгөөж болон үр ашгийг тооцож харьцуулсны үндсэн дээр санхүүжилтийг шийдэх албагүй юм.

Харин соёлын өвийн талаарх хууль эрхзүйн тогтолцоо харьцангуй сайн тавигджээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Долдугаар зүйлд

1. Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.
2. Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн

гэж заасан нь соёлын өв, түүнтэй холбоотой үйл ажиллагааг төр хариуцна гэсэн үг.

ЮНЕСКО-гийн “Соёлын бодлогын дахин тодорхойлох нь” хэмээх 2015 оны тайлангаас харахад соёлын бодлогодоо дараах зорилт дэвшүүлэхийг санал болгосон. Үүнд:

1. Соёлын засаглалын тогтвортой системийг дэмжих,
2. Соёлын бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээний тэнцвэртэй урсгалыг бий болгох хийгээд уран бүтээлч болон соёлын мэргэжилтнүүдийн хөдөлгөөнийг нэмэгдүүлэх,
3. Соёлыг тогтвортой хөгжлийн хамрах хүрээнд багтаах,
4. Хүний эрх болоод суурь эрх чөлөөг хөхүүлэн дэмжих.

Шинэ хууль батлагдсанаар эдгээр асуудлыг хамгийн гол нь орон нутгийн соёлын байгууллагуудын санхүүжилтийн асуудлыг баталгаатай болгоход чухал ач холбогдолтой юм.

Улс орны соёлын салбарын өнөөгийн нөхцөл байдлыг бүхлээр нь харах үүднээс бидний судалгааны зорилготой нийцтэй байгаа дараах 3 чиглэлийг сонголоо. Үүнд:

- Хөгжлийг хэмжих соёлын үзүүлэлтүүд (Culture for development indicators)
- Төрөөс үзүүлж буй соёлын үйлчилгээ
- Соёлын өвийн ашиглалт (Economics of Heritage)

³⁰ Үндэслэл болгох өөр хууль, эрхзүй дутмаг гэсэн үг.

³¹ Жон Дью (1906) Ардчилал ба боловсрол, 18-р бүлэг

3.2.1 Хөгжлийг хэмжих соёлын үзүүлэлтүүд

Хөгжлийг хэмжих соёлын үзүүлэлтүүд (Culture for development indicators)-ийг НҮБ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд эдийн засаг, нийгмийн хөгжилд соёлын бодлого хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх зорилгоор ЮНЕСКО-оос 2014 онд боловсруулсан. Харин улс орнууд эдгээр үзүүлэлтийг ажлын хэсэг байгуулан тусгайлан судалж гаргадаг юм байна. Үүний ач холбогдол нь тогтвортой хөгжил, эдийн засгийн өсөлт, нийгмийн ахиц дэвшилд соёл хэрхэн хувь нэмэр оруулж байгааг эмпирик байдлаар баталгаажуулж, хөгжлийн стратегид соёлыг багтаах асуудлыг чухалчилж харуулдаг.³²

Хүснэгт 3.7 Хөгжлийг хэмжих соёлын үзүүлэлтүүд

Д	Үзүүлэлтүүд	Салбар	Дорноговь	Дундговь	Говьсүмбэр	Өмнөговь
1	Соёлын эдийн засаг	0.06	0.03	0.03	0.03	0.03
2	Соёлын боловсрол	0.5	0.5	0.5	0.5	0.5
3	Соёлын засаглал	0.5	0.2	0.2	0.2	0.2
4	Нийгмийн оролцоо	0.8	0.7	0.8	0.9	0.7
5	Хүйсийн тэгш байдал	0.4	0.3	0.6	0.3	0.4
6	Харилцаа холбоо	0.2	0.2	0.2	0.2	0.2
7	Соёлын өв	0.9	0.3	0.3	0.2	0.2
Дүн		3.37	2.23	2.57	2.39	2.23
Институцийн бэлэн байдал, оролцоо		48.2%	31.9%	36.8%	34.2%	31.9%

Дээрх 7 бүлгийн нийт 22 үзүүлэлтийг аймгийн түвшинд тооцоолсон. Ихэнх үзүүлэлт нь соёлын үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих, бүтээлч сэтгэлгээ явагдах институцийн тогтолцоо байна уу гэдгийг харуулах үзүүлэлт юм. Дээрх хүснэгтээс орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд соёлын оролцоо 30 орчим хувь байна гэж дүгнэж болохоор байв. Хавсралт 4-өөс дэлгэрэнгүй харна уу.

Хүснэгт 3.8 Соёлын эдийн засгийн үзүүлэлтүүд

Соёлын үзүүлэлтүүд	Улс/Салбар	Дорноговь	Дундговь	Говьсүмбэр	Өмнөговь
Эдийн засаг	0.06	0.03	0.03	0.03	0.03
Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх соёлын үйлдвэрлэл, үйлчилгээний жин	0.03	0.02	0.01	0.01	0.02
Соёлын салбарт хөдөлмөр эрхлэгчид	0.03	0.03	0.03	0.04	0.01
Соёлын үйл ажиллагаанд зарцуулж буй өрхийн зардлын жин*	0.10	0.05	0.05	0.05	0.05

*Тайлбар: ҮСГ-гийн өрхийн амьжиргааны судалганаас соёлын үйл ажиллагаанд зарцуулж буй өрхийн зардлын жинг улсын дунджаар аймгуудад ижил тавилаа.

Соёлын үйлдвэрлэл, үйлчилгээнээс ДНБ-д оруулж буй хувь нэмэр аймгуудад 1-2 хувь, харин улсын хэмжээнд 3 хувь, нийт ажил эрхлэгчдийн 3 орчим хувийг соёлын салбарт бизнес, хөдөлмөр эрхлэгчид эзэлж байна. Харин Украин улсад ДНБ-д оруулах хувь нэмэр 5.72, хөдөлмөр эрхлэгчдийн 4.75, хэрэглээний 2.43 хувь байна.

3.2.2 Төрөөс үзүүлэх соёлын үйлчилгээ: үнэлгээ ба үр дүн

Монгол улсын Үндсэн хууль, Соёлын тухай хууль, Засгийн газрын тухай хуулиар төрөөс соёлын үйлчилгээний хүртээмж, оролцоо, тэгш байдлыг хангах үүрэгтэй. Төр энэ үүргээ институцээр дамжуулан хийдэг. Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлд зааснаар:

³² The CDIS thus facilitates the operationalization of the 2005 Convention and the United Nations 2030 Sustainable Development Agenda

2. Ашгийн төлөө бус улсын болон орон нутгийн байгууллага үйл ажиллагаагаа улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлнэ.

Орон нутагт театр, чуулга, музей, номын сан, соёлын төв нь төсвийн санхүүжилтээр үйл ажиллагаа явуулдаг.

3.2.2.1 Аймгийн урлагийн мэргэжлийн байгууллагын үйлчилгээ

Аймгийн төвд орших мэргэжлийн урлагийн байгууллагын үйлчилгээг дараах шалгуураар үнэлж өнөөгийн нөхцөл байдлыг 2016 оны байдлаар³³ харуулав.

Хүснэгт 3.9 Аймгийн мэргэжлийн урлагийн байгууллагын үйлчилгээний шалгуур

Үзүүлэлт	Хэмжүүр	2030 оны зорилт	Өнөөгийн үнэлгээ		
			Сайн=1	Дунд=0.5	Муу=0
Хүртгээмж	6-аас дээш насны хүн амд үйлчилсэн хувь /нэг тоглолтоор/	5%	$k \geq 0.03$	0.01	$k \leq 0.01$
Суудал ашиглалт	Нэг тоглолтын суудал ашиглалт	90%	$k \geq 0.9$	0.6	$k \leq 0.5$
Шинэ уран бүтээл	Тоо	20	$k \geq 11$	10	$k \leq 9$
Дэд бүтэц	Шийдвэрлэх шаардлагатай асуудлын тоо	0	0	1	$k \leq 1$

Хүснэгт 3.10 Музейн үйлчилгээний шалгуур

Үзүүлэлт	Хэмжүүр	2030 оны зорилт	Өнөөгийн үнэлгээ		
			Сайн=1	Дунд=0.5	Муу=0
Үзэгчдийн сонирхол	Нэмэгдсэн жин	$d=0.2$	$d=0.1$	$d=0.05$	$d < 0.04$
Үзмэрийн баяжилт	Нэмэгдсэн тоо	$d=20$	$d=10$	$d=5$	$d < 5$
Дэд бүтэц	Шийдвэрлэх шаардлагатай асуудлын тоо	0	0	1	$k \leq 1$

Аймгуудын театр, чуулгын тоглолтыг давхардсан тоогоор нийт 6-аас дээш насны хүн амын 80 орчим хувь үзэж сонирхжээ. Энэ үзүүлэлт Говьсүмбэр аймагт хамгийн өндөр байна.

Хүснэгт 3.11 Аймгийн төвүүдийн театр, чуулгын үзүүлэлтүүд

Аймгийн төв	6-аас дээш насны хүн ам	Шинэ уран бүтээл	Нийт тоглолт	Нийт үзэгчид	Суудлын тоо	Нэг тоглолтыг үзсэн	Хүртгээмж	Суудал ашиглалт
Сүмбэр	15064	2	43	21226	246	494	0.033	2.01
Сайншанд	60142	3	147	35700	360	243	0.004	0.67
Сайнцагаан	41123	33	193	54600	396	283	0.007	0.71
Даланзадгад	57403	5	73	26105	350	358	0.006	1.02

Музейн үйлчилгээг аймгийн үзүүлэлт дээр нэгтгэж харуулсан. Дундговь аймагт музейн үзмэр хамгийн олон тоогоор нэмэгдэж, үзэгчдийн тоо мөн 14 хувиар өссөн байна.

Хүснэгт 3.12 Аймгийн төвүүдийн музейн үйлчилгээ

Аймгийн төв	6-аас дээш насны хүн ам	Үзэгчдийн тоо			Үзмэрийн тоо		
		2016	2017	Нэмэгдсэн жин	2016	2017	Нэмэгдсэн тоо
Сүмбэр	15064	3154	7800	1.47	929	821	-108
Сайншанд	60142	9005	10100	0.12	8343	8456	113

³³ 2017, 2018 оны статистик мэдээлэл байхгүй.

Сайнцагаан	41123	9388	10700	0.14	5695	5878	183
Даланзадгад	57403	19403	19300	-0.01	4495	4322	-173

Аймгийн мэргэжлийн байгууллагуудын өнөөгийн байдалд хийсэн үнэлгээгээр Говьсүмбэр аймгийн театр чуулгын үйлчилгээний хүртээмж маш сайн, Дорноговь аймгийнх тааруу гэсэн дүн гарчээ.

Хүснэгт 3.13 Аймгийн урлагийн мэргэжлийн байгууллагын үнэлгээ

Д	Аймаг	2016 оны байдал			Дундаж үнэлгээ
		Театр, чуулгын хүртээмж	Суудал ашиглалт	Дэд бүтэц	
1	Говьсүмбэр	1	1	0.5	0.83
2	Дорноговь	0	0.5	0.5	0.33
3	Дундговь	0	0.5	1.0	0.50
4	Өмнөговь	0	1	0.5	0.50

Харин музейн хувьд Дундговь, Дорноговь аймаг хүртээмжтэй байсан бол Өмнөговь аймаг хамгийн тааруу үзүүлэлттэй ажиллаж байна.

Хүснэгт 3.14 Аймгийн музейн үнэлгээ

Д	Аймаг	2016-2017 оны байдал			Дундаж үнэлгээ
		Үзэгчдийн сонирхол	Үзмэрийн баяжилт	Дэд бүтэц	
1	Говьсүмбэр	1	0	1.0	0.67
2	Дорноговь	1	1	1.0	0.83
3	Дундговь	1	1	1.0	0.83
4	Өмнөговь	0	0	0.5	0.17

3.2.2.2 Сумдын соёлын төв, номын сангийн үйлчилгээ

Сумдад номын сан, музей (ихэнх сумдад орон нутаг судлах танхим нэртэй), соёлын төвөөр дамжуулан урлаг, соёлын үйлчилгээ хүргэдэг.

Хүснэгт 3.15 Сумдын соёлын үйлчилгээний шалгуур

Үзүүлэлт	Хэмжүүр	2030 оны зорилт	Өнөөгийн үнэлгээ		
			Сайн=1	Дунд=0.5	Муу=0
Номын сангийн хүртээмж, оролцоо	6-аас дээш насны хүн амд үйлчилсэн жин	0.8	$k \geq 0.8$	0.6	$k \leq 0.5$
Соёлын төвийн хүртээмж	Нэг арга хэмжээнд оролцсон хүний тоо нийт 6-аас дээш насны хүн амд эзлэх жин	0.2	$k \geq 0.08$	0.04	$k \leq 0.02$
Дэд бүтэц	Шийдвэрлэх шаардлагатай асуудлын тоо	0	0	3	$k \leq 5$

Хүснэгт 3.16 Дорноговь аймгийн сумдын соёлын үйлчилгээний үнэлгээ

Үзүүлэлт	Айраг	Алганширээ	Даланжаргалан	Дэлгэрэх	Замын үүд	Иххэт	мандах	Өргөн	Сайхандулаан	Улаанбадрах	Хаганбулаг	Хөвсгөл	Эрдс	Дорноговь

Дорноговь аймгийн сумдын номын сан, соёлын төвийн барилгын дэд бүтэц буюу байшин барилгын засвар, шинэчлэл /Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлээр ангилагдах асуудал, мөн 4 дүгээр

зүйлээр ангилагдах төвлөрсөн болон төвлөрсөн бус шугам/ дээр шийдэх асуудал олон байна. Номын сангийн үйлчилгээний хүртээмж сайн, соёлын төвийн үйлчилгээний хүртээмж тааруу байжээ.

Хүснэгт 3.17 Дундговь аймгийн сумдын соёлын үйлчилгээний үнэлгээ

Үзүүлэлт	Адаацаг	Баянжаргалан	Говь-Угтаал	Гурвансайхан	Дэлгэрхангай	Дэлгэрцогт	Дэрэн	Луус	Өлзийт	Сайхан-Овоо	Хулд	Цагаандэлгэр	Өндөршил	Эрдэнэдалай	Дундговь
Сумдын номын сан, соёлын төвийн үйлчилгээний үнэлгээ	0.3	0.3	0.3	0.3	0.2	0.3	0.2	0.2	0.3	0.7	0.7	0.2	0.3	0.2	0.3

Дундговь аймгийн сумдын номын сан, соёлын төвийн барилга, түүний дэд бүтэц буюу байшин барилгын засвар, шинэчлэл, шугам сүлжээ /Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлээр ангилагдах асуудал, мөн 4 дүгээр зүйлээр ангилагдах төвлөрсөн болон төвлөрсөн бус шугам/ дээр шийдэх асуудал олон байна. Соёлын төвийн үйлчилгээний хүртээмж харьцангуй сайн байгаа ч, номын сангийн үзүүлэлт тааруу байжээ.

Хүснэгт 3.18 Өмнөговь аймгийн сумдын соёлын үйлчилгээний үнэлгээ

Үзүүлэлт	Баяндалай	Баян Овоо	Булган	Гурван гэс	Манлай	Мандал Овоо	Номгон	Ноён	Сэврэй	Ханбогд	Ханхонгор	Хүрмэн	Цогт Овоо	Цогт Цэций	Өмнөговь
Сумдын номын сан, соёлын төвийн үйлчилгээний үнэлгээ	0.2	0.8	0.2	0.5	0.8	0.2	0.8	0.7	0.7	0.3	0.2	0.5	0.5	0.2	0.5

Өмнөговь аймгийн сумдын номын сангийн хүртээмж сайн байсан, соёлын төв, номын сангийн барилга, түүний дэд бүтэц дээр шийдэх асуудал Дорноговь, Дундговь аймгуудтай харьцуулахад цөөн байна.

Хүснэгт 3.19 Говьсүмбэр аймгийн сумдын соёлын үйлчилгээний үнэлгээ

Үзүүлэлт	Баянтал	Шивээговь	Говьсүмбэр
Сумдын номын сан, соёлын төвийн үйлчилгээний үнэлгээ	0.3	0.8	0.5

Харин Говьсүмбэр аймаг соёлын төвийн үйлчилгээний хүртээмжээ сайжруулвал төрийн соёлын үйлчилгээ зорилгоо сайн биелүүлж чадахаар байна.

Бодлогын хэрэгжилтийн тухайд соёлын салбарын бараг бүх баримт бичигт шалгуур үзүүлэлт байдаггүй учраас хүндрэлтэй байна. Жишээ болгож Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын /ТСТББ/ хэрэгжилтийг гаргаж болох үзүүлэлтийг харлаа.

Хүснэгт 3.20 Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн шалгуур

Төрөөс соёлын талаар баримтлах бодлого	Тооцох түвшин	Үзүүлэлт
Хоёр. Соёлын талаар баримтлах бодлогын зорилт		
	<i>Аймаг</i>	Аймгийн үйлчилгээний хүртээмж

2.1.1. үндэсний хөгжилд соёл, урлагийн эзлэх байр суурь, оруулах хувь нэмэр, үр ашгийг нэмэгдүүлэх;	Сум	Сумдын үйлчилгээний хүртээмж, дэд бүтэц
2.1.2. соёлын үнэт зүйлийг иргэд бүтээн бий болгох, хүртэх, эзэмших, орчин, нөхцөл бүрдүүлэх;	Аймаг	Соёлын үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт хамааралтай ажил эрхэлдэг хүний тоо /жин/
2.1.3. соёлын өвийг хадгалж, хамгаалах, өвлөн уламжлах, баяжуулан хөгжүүлэх;	Аймаг	Бүртгэгдсэн өвийн хулгайн гэмт хэргийн тоо
	Сум	Зарцуулсан урсгал төсөв
2.1.4. үндэсний соёл, урлагийг дэлхий нийтэд сурталчлан таниулах, монгол соёлын нөлөөллийг өргөжүүлэх, давтагдашгүй чанарыг баталгаажуулах.	Аймаг	Мэргэжлийн урлагийн тоглолтод
	Сум	Соёлын нэг арга хэмжээнд оролцогчдын жин /6-аас дээш насны хүн амд/

Зарим үзүүлэлт нь бидний судалгааны богино хугацаанд олоход хүндрэлтэй байсан. Ер нь соёлын салбар өнөөг хүртэл соёлын мэдээллийн цуглуулах, шинжилгээ хийх систем бүрдүүлж чадаагүй байна.

Хүснэгт 3.21 Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын хэрэгжилт

БББ-ын нэр	Дорноговь	Дундговь	Говьсүмбэр	Өмнөговь
Төрөөс соёлын талаар баримтлах бодлогын хэрэгжилтийн өнөөгийн үнэлгээ	0.42	0.27	0.36	0.34

Дундговь аймгийн хувьд соёлын үйлчилгээ үзүүлдэг барилга байгууламжийн чанар, орчин үеийн үйлчилгээ, хүний тав тух, соёлтой орчинд тавигдах наад захын шаардлагыг хангах асуудал хүндрэлтэй байгаа нь эндээс ч мөн харагдаж байна.

3.2.3 Соёлын өвийн ашиглалт: үнэлгээ ба үр дүн

Соёлын өв үнэ цэнэ бүтээдэг. Тэр нь хэрэглээний, хэрэглээний бус байна. Хэрэглээний үнэ цэнэ өвийг шууд болон шууд бус замаар хэрэглэсэнээр³⁴ тухайлбал:

- санхүүгийн үр ашиг
- гоо зүйн таашаал
- тухайн орон нутаг, үндэстэн, хүй нэгдлийн дүр төрх (имиж) бүрдүүлэх, сайнаар харуулах
- орон нутгийн оршин суугчид аялал, жуулчлал, худалдаа арилжаа, чөлөөт цаг өнгөрөөх эсвэл нийгмийн зорилгоор ашиглах боломж үүснэ.

Хэрэглээний бус үнэ цэнэ нь соёлын өвийг хадгалж хамгаалснаар үүсэх биет бус давуу талууд, тухайлбал:

- оршин байгаагийн үнэ цэнэ: яг одоо очиж үзэх гээгүй ч соёлын өвийг хамгаалж үлдэж байгаа гэдэг ойлголтоос,
- сонголт байгаагийн үнэ цэнэ: ирээдүйд аялаж болох юм гэдэг хувилбар байгаагаас,
- өв залгамжлах үнэ цэнэ: соёлын өв хойч үед дамжин өвлөгдөнө гэдэг ойлголтоос үүснэ.

Соёлын өвийн аялал жуулчлал түүхийн, археологийн дурсгалт газар, үзмэрт илүү анхаарал хандуулсан байдаг бол соёлын аялал жуулчлал нь тухайн нутгийн хүмүүсийн амьдрах хэв маяг, дуу, хөгжим, бүжгийг сонирхож, фестиваль, тэмдэглэлт арга хэмжээ, баяр ёслол зэрэг соёлын үйл ажиллагаанд өөрийн биеэр оролцож үзэх сонирхолтой байдгаараа бага зэрэг ялгаатай.³⁵ Соёлын туршлагыг биеэрээ мэдрэх хүсэлтэй хүмүүс биет өвөөс гадна, биет бус өв, түүнийг дагаж гарах

³⁴ <http://www.environment.gov.au>

³⁵ Remaoldo et.al (2016)

үйлчилгээнд татагддаг.³⁶ Соёлын үйл ажиллагаанд оролцох нь сүүлийн үед жуулчлалын гол сэдэл (мотивац) болж байна.³⁷

Жуулчдыг шийдвэр гаргахад юу нөлөөлж байгааг судалдаг хэд хэдэн арга байдгийн нэг нь “түлхэх, татах” (push and pull) хүчин зүйлийг судлах арга юм. Түлхэх гэдэг нь жуулчин хаашаа явахаа шийдэхэд түүний хувийн болон нийгмийн статус нөлөөлдөг тухай бол татах гэдэг нь гадны хүчин зүйлүүд болох тодорхой нэг газрын сэтгэл татам байдал, дүр төрх, бусад жуулчдын зөвлөгөө, тухайн ард түмний талаарх төсөөлөл зэрэг юм. Санал асуулгын судалгаануудад тойм хийж 7 түлхэх, 4 татах түгээмэл хүчин зүйл гаргаж ирсэн байна.³⁸ Энэ мэтчилэн соёлын аялал жуулчлал хөгжүүлэх сонирхолтой орон нутаг маш их судалгаа хийж, хамгийн гол нь ирүүлэхдээ биш сэтгэл хангалуун явуулахад анхаарлаа хандуулах нь тогтвортой аялал жуулчлал оршин тогтнох үндэс юм гэж орчин үеийн аялал жуулчлалын талаар туурьвисан бүтээлүүдэд зөвлөжээ.

Жуулчлалын сэдэл (мотивац)-ийг судалсан судалгаанаас дараах хэсгийг тоймлон харлаа.

Сэдэл (мотивац)	Гадаадын жуулчны ирсэн шалтгаанаа тодорхойлсноор нь эрэмбэлвэл
Хотоор аялах, тур хийх /Өөр соёлыг сонирхох, сониуч зандаа хөглөгдөн ирсэн/	I /65.0%/
Барилга, архитектурын дурсгал үзэх /Дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн газрыг үзэх зорилгоор ирсэн/	II /42.2%/
Орон нутгаас зохион байгуулдаг соёлын арга хэмжээг сонирхож оролцох зорилгоор ирсэн	III /39.7%/
Арга хэмжээнд оролцох /"Европын соёлын нийслэл" хэмээх арга хэмжээ зохион байгуулсан учраас ирсэн/	IV /33.5%/
Нутгийн хоол хүнс, дарс амтлахаар ирсэн	V /33.2%/

Эх сурвалж: Remoaldo, P., Cadima Ribeiro, J., Vareiro, L., Freitas Santos, J. (2014), "Tourists' perceptions of world heritage destinations: The case of Guimarães (Portugal)", Tourism and Hospitality Research, 14(4), 206-218.

Ирсэн жуулчид ЮНЕСКО-д бүртгэлтэй архитектурын дурсгалт газарт сэтгэл хангалуун байсан бөгөөд түүнийг арчилж, сэргээж хамгаалж байгаа нь их таалагдсан гэсэн байна. Дэлхийн хэмжээнд бүртгэгдсэн өв нь сэтгэл ханамжийг өндөр байлгаж чадсан гэж 94 хувь нь үзсэн бол 93.1 хувь нь найз нөхдөдөө санал болгоно, 38.9 хувь нь эргэж ирмээр байна гэжээ.

Сэдэл	АНУ-ын нийт жуулчны
Соёлын болон дурсгалт газар үзэх, аялах сэдэлтэй	2/3
Аризона зэрэг соёлын дурсгалаараа алдартай газруудад соёлын хүчин зүйлд татагдаж ирдэг	50%

Эх сурвалж: Nyaupane, Gyan P. PhD and Andereck, Kathleen L (2016) An Expansion of Typology of Cultural Heritage Visitors, Arizona State University

Дээрх судалгаа ирсэн бүх хүнийг соёлын жуулчид гэж үзэхгүй. Тэднийг жинхэнэ соёлын жуулчид, өөр зорилгоор ирээд тэдгээрийг үздэг гэсэн хэсэгт хувааж, жинхэнэ соёлын жуулчдыг дурсгалт газар сонирхогч, соёлын үйл ажиллагаанд оролцогч хэмээн хуваасан байна. Дурсгалт газар сонирхогчдыг нэг төрлийн бүтээгдэхүүн хэрэглэгч зах зээл гэж үзэж болох талтай гэжээ (homogenous market).

³⁶ Richards & Munsters (2010)

³⁷ Remaaldo et.al (2016)

³⁸ Remaaldo et.al (2016)

	Жуулчдын хийдэг зүйлс
Түүхийн болон археологийн дурсгалт газар үзэх	66%
Соёлын арга хэмжээнд оролцох	64%
Уран зургийн галерей, музейгээр аялах	54%
Урлагийн тоглолт, фестивальд оролцох	45%
Мэргэжлийн бүжгийн тоглолт үзэх	44%
Алдартай цэцэрлэгт хүрээлэнгээр зугаалах	41%
Музейн дэлгүүр орох	22%
Хөрш орноороо аялах, тэдний амьдралыг сонирхох	30%

Эх сурвалж: <https://www.georgia.org/sites/default/files/wp-uploads/2013/09/GA-Heritage-Tourism-Handbook.pdf>

Дээрх судалгааны үр дүн болон бусад уншиж судалсан бүтээлээс дараах дүгнэлтийг хийж болохоор байна.

- Дэлхийн соёлын өвд багтсан газар хүмүүсийн сэтгэлийг татаж бас хүчээлтийг нэмэгдүүлдэг тул “татах” гол хүчин зүйлийн нэг юм байна.
- Жуулчдын 65 орчим хувь нь түүхийн болон археологийн дурсгалт газар үзэхийг хүсч ирдэг байх магадлалтай.
- Соёлын өвийн аялал жуулчлалд ниш (niche) зах зээл үүсгэх нь оновчтой байх магадлалтай.
- Нийт жуулчдын 35 орчим хувь нь соёлын арга хэмжээнд оролцох, биеэрээ мэдрэх зорилгоор ирдэг байх магадлалтай. Сүүлийн жилүүдэд энэ сонирхол давамгайлах болсон гэж үзэж болохоор байна. Соёлын аялал жуулчлалд (арга хэмжээнд оролцох, соёлыг мэдрэх, далайн эрэгт амрах гэх мэт) масс зах зээлийн стратеги хэрэглэсээр ирсэн, гэхдээ байгаль орчинд хор хохирол ихтэй байдаг тул мөн л “ниш” зах зээл үүсгэхийг санал болгожээ.

Ниш (niche) зах зээл нь тусгай сонирхолтой цөөн жуулчин авна гэсэн үг. Газар нутгийн онцлог, соёлын онцлогоо давуу тал гэж үзэж байгаа үед ниш зах зээл үүсгэнэ. Энэ төрлийн жуулчид боловсрол, мэдээлэл сайтай, аяллын төсөвт төдийлөн санаа зөвдөггүй, шаардлага өндөртэй байдаг. Манай улс болон Говийн бүс нутгийн хувьд олон төрлийн жижиг ниш зах зээл үүсгэж боломж байна. Тухайлбал:

- Адал явдалт аялал хийлгэх (Говиор 30 хэмийн халуунд аялах, хамгийн олон км явсан нь ялагч болно гэх мэт),
- Хүрэх бартаа ихтэй газрын онцлогоос шалтгаалан цөөн хүн амьдардаг газар очиж үзэх,
- Гэрэл зураг авах,
- Амьтан, ургамал ажиглах,
- Мэргэжлийн түүхчид эсвэл палеонтологи сонирхогчдын аялал,³⁹
- Айлд амьдарч, мал хариулж, үнээ сааж өдөр тутмын амьдралд оролцох

зэрэг олон жижиг ниш зах зээл үүсгэж түүнийгээ чанартай сайн хийвэл тогтвортой, байгаль орчинд ээлтэй аялал жуулчлал болж чадах юм.

Ниш зах зээлийн мөн сул тал олон бий. Цөөн жуулчин ирнэ, өргөтгөх боломж бага, ямар нэг гэнэтийн тааламжгүй үйл явдал тэр нутагт болсон гэж дуулдвал маш мэдрэг, өрсөлдөгчөөс шалтгаалан үйлчлүүлэгчдээ амархан алдах эрсдэл өндөр, маш олон ниш зах зээл гэдэг нь маш олон хүн адилхан бизнес хийнэ гэсэн үг. Тэгэхээр ийм зах зээл дээр олуулаа ажиллах нь өрсөлдөгчдөд муу үр дагавар авчраад зогсохгүй, эцэст нь бүгд эрсдэлд ордог. Нэг төрлийн үйлчилгээг тодорхой бүлэг хүнд санал болгоход гэр бүлээрээ явж буй бусад өөр сонирхолтой хүмүүсийг яах вэ гэдэг асуудал хамгийн чухал. Иймд өөр хаанаас ч хайгаад олохооргүй онцгой ниш байх хэрэгтэй.

³⁹ Говийн аймгууд Палеонтологийн дурсгалт газар ихтэй хэмээн хэвлэмэл бүтээлүүдэд олонтаа бичсэн байна.

Соёлын өвийг дагасан аялал жуулчлалд ниш зах зээл үүсгэх нь оновчтой гэдэг санааг дэмжиж Говийн дэд бүсийн 4 аймагт ямар өв байгааг харья.

Соёлын өвийн тухай хуулийн 4 дүгээр зүйл. Соёлын өвийн ангилал

4.1 Соёлын өвийг биет ба биет бус гэж ангилна.

4.2 Соёлын биет өвийг түүх, соёлын үл хөдлөх дурсгал болон хөдлөх дурсгалт зүйл гэж ангилна.

4.3 Түүх, соёлын үл хөдлөх дурсгал нь дангаар болон цогцолбор байдлаар оршино.

Үл хөдлөх дурсгалыг Соёлын өвийн үндэсний төвийн “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын лавлах”-д ангилсаны дагуу, хөдлөх дурсгалыг “Соёлын өвийн тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т зааснаар хосгүй үнэт, үнэт гэж, биет бус өвийг ур чадварын үнэлгээгээр⁴⁰ ангилан судалгааг нэгтгэлээ.

Хүснэгт 3.22 Аймгийн үл хөдлөх соёлын дурсгалын нэгтгэл

Аймгууд	Улсын хамгаалалтад байх	Аймгийн хамгаалалтад байх	Бусад	Нийт
Говьсүмбэр	0	2	53	55
Дорноговь	6	7	418	431
Дундговь	6	13	287	306
Өмнөговь	22	11	179	212

Энэ дэд бүсэд ЮНЕСКО-гийн соёлын өвд бүртгүүлсэн дурсгал одоогоор байхгүй тул Соёлын өвийн тухай хуулиар “улсын хамгаалалтад байх”, “аймгийн хамгаалалтад байх” болон бусад гэж ангилж харвал Өмнөговь аймагт улсын хамгаалалтад байдаг дурсгалт газар /22/ хамгийн олон байна.

Эдгээр 4 аймагт булш оршуулгын дурсгал хамгийн олон байна. Дээр дурдсан аялал жуулчлалын мотивацаас харахад жуулчин шууд очоод бэлэн харах зүйлд татагддаг гэж үзвэл аялал жуулчлал хөгжүүлэхэд бидэнд байгаа нөөц их хэмжээний хөгжүүлэлт шаардахаар харагдаж байна. Хэдийгээр барилга архитектурын нөөц 207 гэж байгаа ч Португал улсын судалгаанд гарсан дээрх дурсгалт газартай өрсөлдөхүйц “хүний нүдэнд харагдах” бэлэн нөөц байх хэрэгтэй.

Хүснэгт 3.23 Аймгийн үл хөдлөх дурсгалын нэгтгэл, төрлөөр

Аймгууд	Чулуун зэвсгийн үеийн дурсгалт газар	Хадны зураг, бичгийн дурсгал	Булш оршуулгын дурсгал	Тахил тайлгын байгууламж	Барилга, архитектурын дурсгал	Хөшөө дурсгал	Үйлдвэрлэлийн үл мөр хадгалсан дурсгалт газар	Палеонтологийн дурсгалт газар
Говьсүмбэр	0	1	33	8	5	8	0	0
Дорноговь	1	35	166	99	96	13	3	18
Дундговь	2	36	151	63	44	6	1	3
Өмнөговь	0	51	43	24	62	13	3	16
Дүн	3	123	393	194	207	40	7	37

Харин соёлын аялал жуулчлал хөгжүүлэхэд бэлэн байгаа өв, түүнийг дагаж гарах үйлчилгээ, тоглолт, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, жуулчныг оролцуулах арга хэмжээ чухал гэж үзэн бид судалсан. Энэ утгаар авч үзвэл ардын язгуур урлагийн нөөц их байгаа нь сайн хэрэг. Ялангуяа Дундговь, Өмнөговь аймагт ЮНЕСКО-д бүртгэлтэй дараах төрлүүд түгээмэл байдаг нь давуу тал болж байна.

Төрөл

Бүртгэгдсэн огноо

Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг	2008
Монгол ардын уртын дуу	2008
Монгол тууль	2009
Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг	2009

⁴⁰ Улсын билэг авьяастны жагсаалт болон аймгийн комиссын үнэлгээ

Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлаг	2009
Монгол наадам	2010
Монгол ардын хөөмэйн урлаг	2010
Шувуучлаухуй буюу бүргэдээр ан хийх зан үйл	2010
Монгол Лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга барил –битүү амьсгаа	2011
Алтан товч	2011
Монгол Данжуур	2011
Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл	2014
Монгол уран бичлэг	2014
Шагайн харваа	2015
Ботго авахуулах зан үйл	2015

Гэхдээ ниш зах зээл үүсгэж жуулчин хүлээн авах газар /tourist destination/ болгон “хөгжүүлэлт” хийхэд ардын язгуур урлагийн тоглолтыг аймгийн театр, чуулга зохион байгуулах уу, жуулчны бааз зохион байгуулах уу гэдгээс эхлэн хөрөнгө оруулалт, тогтсон бизнес загварчлал хэрэгтэй болно.

Хүснэгт 3.24 Аймгийн биет бус соёлын өвийн нэгтгэл, төрлөөр

Аймгууд	Эх хэл аман уламжлал	Ардын язгуур урлаг	Үндэсний уламжлалт баяр, зан үйл	Байгалийн болон сав ертөнцийн тухай мэдлэг, заншил, арга технологи	Ардын уламжлалт гар урлал
Говьсүмбэр	9	64	2	6	35
Дорноговь	6	24	10	5	9
Дундговь	5	124	29	14	59
Өмнөговь	15	97	8	3	76
Дүн	35	309	49	28	179

Өмнөговь аймаг 2018 онд зохион байгуулсан соёлын биет бус өвийн их наадамд 1-р байр эзэлсэн. Ингэ хөөслөх зан үйл, лимбийн битүү амьсгаа зэрэг ЮНЕСКО-д бүртгэлтэй яаралтай хамгаалах шаардлагатай өвийн их уламжлалтай (Г.Энхбат, 2018 Соёлын биет бус өвийн их наадам).

Хүснэгт 3.25 Өмнөговь аймгийн соёлын өвийн нөөц, сумдаар

Үзүүлэлт	Баяндалай	Баяновоо	Булган	Гурвантэс	Даланзадгад	Мандаловоо	Манлай	Ноён	Номгон	Сэврэй	Ханбогд	Ханхонгор	Хүрмэн	Цогтовоо	Цогтцэций
Биет бус өв	6	6	16	8	24	10	25	7	17	7	12	18	10	21	12
Биет үл хөдлөв өв	18	12	14	17	5	11	12	13	18	16	29	9	20	9	9
Биет хөдлөх өв	163	37	27	176		79	181		138	125	583	36	56	100	31

Тус аймагт байгаа нөөцийг тоогоор авч үзвэл Ханбогд сум соёлын аялал жуулчлалын “бүтээгдэхүүн” хөгжүүлэлт хийж үзэх хамгийн боломжтой нь харагдаж байна. Гэвч байгаа дурсгалын төлөөлөх цаг хугацаа, хүний сонирхол татах байдал, бүрэн бүтэн байдал, түүх, археологийн чанараараа бодит байдал ихээхэн өөр.

Хүснэгт 3.26 Дундговь аймгийн соёлын өвийн нөөц, сумдаар

Үзүүлэлт	Баянжаргал	Говь-Угтаал	Дэлгэрцогт	Өндөршил	Эрдэнэдалай	Дэлгэрхангай	Дэрэн	Луус	Өлзийт	Сайхан-Овоо	Хулд	Цагаандэлгэр	Сайнцагаан	Адаацаг	Гурвансайхан
Биет бус өв	26	17	6	24	12	17	15	13	15	10	30	12	14	8	12
Биет үл хөдлөв өв	20	16	28	22	13	17	21	11	15	11	24	14	44	23	27
Биет хөдлөх өв	31	27	54	311	212	21		188	60		69			31	

Харин Дундговь аймгийн хувьд биет үл хөдлөх өвийн нөөцөөс гадна биет бус өвийн суурь сайтай бөгөөд өвлөн уламжлуулах дээр анхаарч ажиллаж байгаа давуу тал байна. 2018 онд зохион байгуулсан соёлын биет бус өвийн их наадамд 3-р байр эзэлсэн. Ингэ хөөслөх, уртын дуу, тэмээтэй холбоотой соёлын өвийн уламжлалтай.

Хүснэгт 3.27 Дорноговь аймгийн соёлын өвийн нөөц, сумдаар

Үзүүлэлт	Их хэт	Хөвсгөл	Сайншанд	Айраг	Алтанширээ	Даланжаргалан	Дэлгэрэх	Замын Үүд	Мандах	Өргөн	Сайхандулаан	Улаанбадрах	Хатанбулаг	Эрдэнэ
Биет бус өв	3	18	1	0	5	10	10	0	0	0	0	0	7	0
Биет үл хөдлөв өв	32	28	11	22	47	33	22	0	19	46	26	32	67	46
Биет хөдлөх өв	329	99		64	167	135	62		274	66	271	121	107	108

Дорноговь аймаг шашны зан үйлээр арвин уламжлалтай. Энэ чиглэлээр аялал жуулчлал хөгжүүлээд олон жил болж байгаа. Дорноговь аймагт биет өвийн нөөц илүү харагдаж байна. Хөвсгөл, Эрдэнэ, Хатанбулаг, Өргөн, Алтанширээ сумдад соёлын өвийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх боломжтой байж магадгүй юм.

Хүснэгт 3.28 Говьсүмбэр аймгийн соёлын өвийн нөөц, сумдаар

Үзүүлэлт	Баянтал	Сүмбэр	Шивээговь
Биет бус өв	6	92	18
Биет үл хөдлөв өв	4	45	6
Биет хөдлөх өв	51	948	

Соёлын өвийн мэргэжилтнүүдийн бүтээлээс дараах санал гарсан байна. Үүнд:

1. Г.Энхбат, Б.Даваацэрэн (2012) Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал VII, IX, XII дэвтэрт бичсэнээр:

Дундговь аймаг: “Их, Бага газрын чулуу” дурсгалын орчимд ландшафт хийх боломжтой. Мөн Өлзийт сумын нутагт орших Дэл уул орчмын дурсгалыг ЮНЕСКО-гийн хамгаалалтад оруулах урьдчилсан жагсаалтад багтсан байгаа.

Дорноговь: Бурхан шашны дурсгал, түүнийг тойрсон дурсгал олон бий. Аймгийн музейд Монгол улсын хосгүй үнэт үзмэрт багтдаг 3 дээл байдаг.

Өмнөговь: Хадны зураг, палеонтологийн олдвор ихтэй, Говийн бүс нутгийг харуулсан онцлог байгаль нь өөрөө нөөц болно.

Говьсүмбэр: Чойрын хийдийн туурь, Зараагийн зүүн өвөрт орших хүн чулууны хөшөөг Түрэгийн үеийн хөшөөдөөс хамгийн өндөр нь гэж үздэг.

2. БСШУСЯ-ны мэргэжилтэн Б.Даваацэрэнгийн санал:

Өнөөгийн байдал: Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа аялал жуулчлалын байгууллагууд Улаанбаатараас говийн чиглэлд хийх аялал жуулчлалыг үндсэн 2 маршрутаар зохион байгуулдаг. Тодруулбал, Төв аймгийн Сэргэлэн сумаар дамжин Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Бага газрын чулуу, Адаацаг сумын Сүм Хөх бүрдийн балгас, Дэлгэрхангай сумын Онгийн хийд, Өмнөговь аймгийн Булган сумын Баянзаг гэсэн нэгдүгээр маршрут, Налайхаар дамжин Дорноговь аймгийн Хамарын хийд Хөвсгөл сумын Цувираагийн хийд,

Өмнөговь аймгийн Манлай сумын Цар цав гэсэн хоёрдугаар маршрут байна. Үүнээс гадна Дундговь аймгийн Цагаан суврага, Дэл уулыг чиглэсэн маршрут бас бий. Эдгээр нь ерөнхийдөө шашны дурсгал, археологи, палеонтологийн дурсгалыг түшиглэн бий болсон маршрут юм.

Давуу тал: Говийн бүс нь палеонтологийн асар их нөөцтэй, дэлхийн шинжлэх ухаанд эхний байруудад ордог тул жуулчдын анхаарлыг онцгой татдаг. Үүнийг гэрчлэх эртний амьтан, ургамлын олдворт газрууд, эртний далайн ёроол байсан цав газрууд нь байгалийн унаган хэлбэрээ хадгалан үлдсэн байдаг. Түүнчлэн, говийн хадны зургууд нь Евразийн бүс нутагт аж төрж байсан эртний хүмүүсийн оюун санааны хөгжил, нийгмийн харилцаа, соёл, шашин, ахуйн талаарх гайхамшигтай түүхийг өгүүлдэг. Эдгээр нь Говийн бүс нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чухал давуу тал болно /байгалийг мартаж өсгүй шүү/.

Сул тал: Говийн бүс нутагт дэд бүтэц сул хөгжсөн, усны хангамж бага, аялал жуулчлалын зориулалтын бүтээгдэхүүн цөөн, үйлчилгээний чанар хүртээмж бага зэрэг нь аялал жуулчлалыг хөгжүүлэхэд бэрхшээл учруулж байна.

Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Дэл уул: Хүрэл болон төмрийн түрүү үеийн хадны зургийн гайхамшигт дурсгалтай, байгалийн өвөрмөц тогтоц, тэмээний уламжлалт ахуй соёлыг илэрхийлэх нутаг юм. Эргэн тойронд нь Цагаан суврага, Хонгорын элс гэх мэт байгалийн унаган тогтоцтой газар юм.

Дорноговь аймгийн Мандах сумын нутагт орших Сүйхэнтийн палеонтологийн дурсгалт газар: Сүйхэнт уулын орчмын хурдаст Юрийн цаг үеийн буюу одоогоос 170 гаруй сая жилийн тэртээд холбогдох *Araucariaceae* овгийн нүцгэн үрт, шилмүүстийн төрлийн чулуужсан модны баялаг олдвор хадгалагдаж байдаг. Эндээс дэлхийд ховорт тооцогдох 1 м өргөнтэй, уртаашаа 10 м урт цайвар цагаан, улаан ногоон өнгөтэйгөөс гадна магма, галт уулын чулуулаг, боржингийн хольцтой чулуужсан мод ихээр олддог. Сүйхэнтийн чулуужсан ойд үндэс, мөчир, холтос, өсөлтийн цагиргын хэлбэр төрх, шинжийг тод хадгалж үлдсэн мод ихээр байдаг нь энэ төрлийн дурсгал дотор ховорт тооцогддог юм байна. 8-9 км-ийн зайнд Өлгийн хийд бий.

Өмнөговь аймгийн Манлай сумын нутагт орших Шар цавын палеонтологийн дурсгалт газар: Шар цавын Хожуу Цэрдийн Нэмэгтийн цаг үед холбогдох хурдаст одоогоос 70-65 сая жилийн тэртээд амьдарч байсан үлэг гүрвэл, шувуу, яст мэлхий, матрын чулуужсан ясны баялаг олдвор хадгалагдан үлдсэн бол газрын гадрага дээр ил гарсан чулуулаг дээр тэдгээр амьтдын олон мянган мөр хадгалагдан үлдсэн байдаг. Эндээс теропод үлэг гүрвэл, аврага өвсөн идэшт үлэг гүрвэл, хойд хоёр хөл дээрээ хурдан гүйж явдаг теропод үлэг гүрвэлийн чулуужсан ясны үлдэгдэлүүд, үлэг гүрвэлийн өндөгний үүр зэрэг олдворууд олноор байжээ. Уг олдворт газраас олдсон дурсгалууд нь тухайн цаг үед амьдарч байсан амьтад, тэдгээрийн үйл хөдөлгөөн идэш тэжээлийн талаарх мэдээллийг бий болгодог бөгөөд дэлхийд ховорт тооцогддог байна.

3.3 Соёлын салбарын бодлогод өгөх санал ба зөвлөмж

Аймгийн хөгжлийн бодлогод тусгах санал

1. Соёлын салбарт төр удирдан хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, төлөвлөгөөг заавал шаардагдах санхүүгийн эх үүсвэрийн шийдэлтэй оруулах хэрэгтэй.
 - Дээр шалтгааныг нь тайлбарласан.

2. Хэмжих шалгуур үзүүлэлтийг бодлогодоо заавал багтаах, мөн хүн рүү чиглэсэн байх хэрэгтэй байна.
 - Аймгийн хөтөлбөр, төлөвлөгөөнд хэмжих шалгуур үзүүлэлт огт байгаагүй. Тухайлбал 6-аас дээш насны сумын хүн амын 80 хувьд соёлын төвийн үйлчилгээ хүрсэн байх ёстой, дор хаяж 60 хувь нь номын сангаар үйлчлүүлсэн байх ёстой, аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд соёлын үйлдвэрлэл үйлчилгээний эзлэх хувийг 10 хувьд хүргэнэ гэх мэт.
3. “Хөгжилд хувь нэмэр оруулах соёлын үзүүлэлтүүд”-ийг орон нутагт гаргах мэдээлэл хангалттай байна. Иймд соёлын институцийг бүхлээр нь харах, улмаар хаана сул тал байгааг тодорхойлох боломжтой, соёлын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, ажилгүйдэлтэй тэмцэх, хүний хөгжлийг хангах гээд олон талын бодлогоо сайжруулахад тустай байх болно.

Салбарын бодлогод тусгах санал

1. БББ-д хэмжих шалгуур үзүүлэлт байхгүй учраас хариуцлага хүлээх, хяналт шинжилгээ хийх боломжгүй явсаар иржээ. Үндэсний хэмжээний бодлогуудад хэмжих шалгуур үзүүлэлт байгаагүй. Тухайлбал “Төрөөс соёлын талаарх баримтлах бодлого”-ын
 - 5.2. Соёлын талаар баримтлах бодлогыг Засгийн газар, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын чиг үүрэгт хамааруулан, урт, дунд, богино хугацааны стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.
 - 5.4. Энэ бодлогын 5.2-т заасан урт, дунд, богино хугацааны стратегийн хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон иргэний нийгмийн холбогдох байгууллагууд хамтран хяналт, шинжилгээ-үнэлгээ хийж, цаашдын хөгжлийн зорилтыг тодорхойлж байх болно.гэсэн авч бид энэ талаар ямар нэг мэдээлэл олж авч чадсангүй. Тиймээс өнөөдөр хэрэгжилт ямар байгааг гаргах боломжгүй байв.
2. Соёлын бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагааг “Хөгжилд хувь нэмэр оруулах соёлын үзүүлэлтүүд” (CDIS) багтсан үзүүлэлтүүдээр хэмждэг болохын тулд эхлээд соёлын үйлдвэр, соёлын ажил мэргэжлийн лавлагаа гаргах хэрэгтэй байна.
3. Өвийг хамгаалахад ч стандарт, аргачлал батлуулах шаардлага үүссэн. Тухайлбал, *S. Lagomarsino, N. Abbas, C. Calderini, S. Cattari, M. Rossi, R. Ginanni Corradini, G. Marghella, F. Mattolin & V. Piovanello* нарын бүтээлүүдээс түүхийн дурсгалт барилга байгууламжийн одоогийн байдлыг үнэлэх, гэмтлийн зэргийг тогтоох, ангилах аргачлал боловсруулах хэрэгтэй юм. Түүхийн барилгын буулгаж дахин барих биш харин гэмтлийг нь оношилж байнгын хяналтад байлгаж, цаг тухайд нь завсар үйлчилгээ хийж чадвал олон жил ашиглах боломжтой гэжээ⁴¹.

Бүсийн хөгжлийн хөтөлбөрт

- Нөөцийн талаарх тоон мэдээг харвал Дорноговь, Өмнөговь, Дундговь аймгийн хувьд нэгдсэн маршрут бүхий (кластер) аялал жуулчлалын бүтээгдэхүүн хөгжүүлэх боломжтой харагдаж байна. Үүнд соёлын биет өв дээр хөгжүүлэлт хийгээд, палеонтологийн нөөцийн газрын доорх зураглалыг технологийн тусламжтай музей болгон харуулж, Өмнөговь, Дундговь аймагт соёлын биет бус өвийн үзүүлбэр, тоглолт үзүүлэх цогц бүтээгдэхүүний хөгжүүлэлт бүхий ниш зах зээл үүсгэж болохоор байна.

⁴¹ Lagomarsino et al. (2011) Classification of cultural heritage assets and seismic damage variables for the identification of performance levels, WIT Transactions on the Built Environment, Vol 118, © 2011 WIT Press

ҮХГ-г өгөх зөвлөмж

1. ҮХГ-аас эхлээд бүх нөөцийн мөн чанарыг тодорхойлох нарийвчилсан судалгаа хийх хэрэгтэй байна. Дараа нь хаана, ямар төрлийн ниш эсвэл масс заах зээл үүсгэхээ шийдээд, эхлээд нэгийг сонгож, өөрсдөө удирдан аялал жуулчлал хүлээн авах газар (tourist destination), бүтээгдэхүүн хөгжүүлэлт хийж соёлын болон соёлын өвийн аялал жуулчлал хөгжүүлэх эхлэлийг тавих арга зам нь үр дүнтэй болов уу. Үүний дараа аймгуудад сургалт зохион байгуулж, нэр хүнд, сэтгэл ханамж өндөр байх нь дараагийн шатны аялал жуулчлалын сурталчилгаа гэдгийг ойлгуулах ёстой. Аялал жуулчлалын зах заал эмзэг, хэврэг бөгөөд тэр цэг нь соёлын талаарх төсөөлөл гэхээсээ илүү өмнөх жуулчны сэтгэл ханамж гэдгийг орон нутагт маш сайн ойлгуулах хэрэгтэй санагдсан. Аймаг, сум дур дураараа хийж эхэлвэл алдаа их гарч улмаар Тайланд шиг байдалд бид орно.
2. Соёлын өвийн болон соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд эхлээд “аялал жуулчлалын стратеги” (хэрэв байдаг бол)-тай уялдуулан маркетингийн загварчлал гаргах хэрэгтэй санагдлаа. Бид өмнө нийлүүлэх бүтээгдэхүүний боломжоо ярьж байсан ч зах зээлээ огт судалж ярьж байгаагүй. Маркетингийн загвар боловсруулахын тулд эхлээд орон нутагт тоологдсон нөөцийн “үнэ цэнэ”-ийг гаргах хэрэгтэй. Түүний дараа аялал жуулчлал эрхлэх боломжтой цэгүүдэд нарийвчилсан үнэлгээ (due diligence) хийж хэрэгжүүлэх боломжтой эсэхийг (feasibility) гаргаж шийдвэр гаргамаар байна. Энэ удаагийн судалгаагаар загвар боловсруулах мэдээлэл хомс байлаа.

4. Шинжлэх ухаан, технологи, инновац

Шинжлэх ухаан, технологи (ШУТ) болон инновацийн ажиллагаа нь шинэ мэдлэгийг бүтээх, шилжүүлэх, технологи худалдаж авах, дамжуулах, бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх (product commercialization) болон судалгаа болон туршилтын боловсруулалт (research and experimental development, R&D) хийх зэргийг багтаадаг. Шинжлэх ухааны шинэ мэдлэгийг бүтээх, түүний ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх нь орчин үеийн хөгжлийн хөдөлгүүр болж, ядуурлыг бууруулах гол арга зам хэмээн олон улсад үзэж байна. Инновац нь орчин цагт улс орнуудын өрсөлдөх чадвар болон хөгжлийн түвшнийг тодорхойлох болжээ. Иймээс олон орны хувьд эдгээр асуудал ихээхэн ач холбогдол өгч, төрийн болон хувийн сектор энэ чиглэлээр хүний нөөцийг бэхжүүлэх, хөрөнгө оруулалт хийх, дэд бүтцийг хөгжүүлэх, бусад зардал гаргах, бодлогыг оновчтой тодорхойлж, зохих хөшүүргийг бий болгоход онцгойлон анхаарч байна. Монгол улсын хувьд энэ асуудал сүүлийн жилүүдэд мөн бодлого боловсруулагчдын анхаарлыг татах болсон.

А. Хууль

Монгол улсад шинжлэх ухааны асуудлыг зохицуулсан цөөн тооны хууль үйлчилж байна. Үүнд:

1. Монгол улсын Үндсэн хууль (1992)
2. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль (2006)
3. Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль (2009)
4. Инновацийн тухай хууль (2012)

Монгол улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу Монгол улсын Засгийн газар нь

2/ шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх;

бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар зааснаар Засгийн газрын бүрэн эрхэд шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж батлуулах, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлон батлах, мастер төлөвлөгөө, үндэсний хөтөлбөрийг батлах, үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх зэрэг бүрэн эрх хамаарч байна. Үндсэндээ шинжлэх ухаан технологийн бодлогын ерөнхий чиглэлийг тодорхойлох үүрэг Засгийн газарт байна. Энд орон нутгийн оролцоо бага бөгөөд онц шаардлагагүй юм.

2012 оны Инновацийн тухай хуулийн дагуу шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд (7 дугаар зүйл) үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах; инновацийн тэргүүлэх чиглэл, үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрт шаардагдах төсвийн санхүүжилтийн талаар санал боловсруулах, төрөөс шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын талаар баримтлах бодлогыг инновацийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг хангах; шинжлэх ухаан, технологийн салбарт инновацийг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл боловсруулах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах; шинжлэх ухаан, технологийн салбарт инновацийн дэд бүтцийг байгуулах төлөвлөлтийг хийх, түүнийг хэрэгжүүлэх зэрэг бүрэн эрх хамаарч байна.

Орон нутгийн захиргааны байгууллагын хувьд инновацийг хөгжүүлэх талаар арга хэмжээ авах талаар 7 дугаар зүйлд зааснаас шууд бусаар ойлгогдож байгаа бөгөөд эдгээр арга хэмжээг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, оролцогч талуудын түншлэл, үйл ажиллагааны уялдааг хангах бодлогыг хэрэгжүүлэх үүрэг төрийн захиргааны төв байгууллагад байх талаар заажээ. Мөн хуулийн

18 дугаар зүйлд үйлдвэрлэл технологийн парк байгуулах талаар заасан ба үүний зорилгуудын нэг нь “инновацийн үйл ажиллагаанд тулгуурлан бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх, эдийн засгийн төрөлжилтийг бий болгох” явдал юм.

2009 онд батлагдсан Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль нь парктай холбоотой эрхзүйн асуудлыг илүү дэлгэрэнгүй тусгасан хууль юм. Хуулийн 4 дүгээр зүйлд парк байгуулах зорилгод шинэ, дэвшилтэт болон өндөр технологи дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах, экспортын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг болон импортыг орлох үйлдвэрлэлийг дэмжих, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих; жижиг, дунд үйлдвэр, өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ хөгжих орчныг бүрдүүлэх, ажлын байр бий болгох, байгаль орчинд халгүй үйлдвэрлэлийг хөгжүүлэх; хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйлдвэрлэлийг хөгжүүлэхээр заасан байна. Энэ нь бүс нутгийн засаг захиргааны тодорхой түвшний оролцоог хангах, тэдгээрт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх талаарх заалт юм.

Мөн хуулийн 9 дүгээр зүйлд нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг тодорхойлохдоо “тухайн нутаг дэвсгэрт паркийн үйл ажиллагааг дэмжих орон нутгийн хөтөлбөр батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих; паркийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөлөлд хяналт тавих” зэргийг тусгасан байгаа нь дээрх санааг тодотгож байна.

Дээр дурдсан 4 хууль нь Үндсэн хуулиас эхлээд ерөнхийгөөс нарийвчилсан зохицуулалт руу явж буй нь харагдаж байна. Шинжлэх ухаан, технологитой холбоотой салбарын хуулиуд нь манай улсын хувьд 2006 оноос буюу харьцангуй сүүлд батлагдан гарсан байна. Иймээс энэ салбарын эрхзүйн зохицуулалт нь шинэлэг үзэгдэл гэж дүгнэж болно. Нөгөө талаас шинжлэх ухаан, технологийн асуудлаар төрийн төв байгууллага голчлох үүрэгтэй байхаар хуульчилсан ба бүс нутаг ба орон нутгийн чиг үүрэг нь үйлдвэрлэл, технологийн парктай холбоотой цөөн заалтаар хязгаарлагдаж байна. Ингэхдээ үндэсний хэмжээнд нэгэнт байгуулахаар шийдвэрлэсэн паркийн үйл ажиллагааг дэмжих орон нутгийн хөтөлбөр батлаж хэрэгжүүлэх, паркийн үйл ажиллагаанд байгаль орчны сөрөг нөлөө байгаа эсэхэд хяналт тавихаар заасан нь орон нутаг нь “туслах, дэмжих” үүрэгтэй болохыг тодорхойлно.

Б. Бодлогын баримт бичиг

Шинжлэх ухаан, технологийн салбарын хувьд үндэсний түвшинд нийт 27, бүс нутгийн түвшинд 1, аймгийн түвшинд 10, сумын түвшинд 2, нийт 40 бодлогын баримт бичиг байгаад бид дүн шинжилгээ хийж судлав.

Хүснэгт 4.1 Шинжлэх ухаан, технологитой холбоотой бодлогын баримт бичиг

Ангилал	Урт	Дунд хугацааны		Богино	Нийт
	15-20 жил	8-10 жил	3-5 жил	1 жил	
Нийт	3	10	21	6	40
Үндэсний, бүсийн түвшин	3	6	17	2	28
Үндэсний түвшний	3	5	17	2	27
Бүсийн түвшний	0	1	0	0	1
Аймгийн түвшин	0	2	4	4	10
Говьсүмбэр		1	1	1	3
Дорноговь		1	1	1	3
Дундговь			1	1	2
Өмнөговь			1	1	2
Сумын түвшин /Зарим нь батлагдсан эсэх нь тодорхойгүй	0	2	0	0	2

“Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030”-д зааснаар шинжлэх ухаан технологийн хувьд үйлдвэрлэлтэй нягт уялдааг бий болгож, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлэх томоохон зорилтын хүрээнд санхүүжилтийг тасралтгүй нэмэгдүүлж, ДНБ-ий 3 хувьд хүргэх зорилтыг тавьжээ. Энэ асуудлаар бидний судалж буй 4 аймаг болон тус аймгуудын сумдын бодлогод ямар нэг зорилт тусгагдаагүй байна.

Энэ салбарт хэрэгжиж буй үндэсний хэмжээний чухал бодлогуудыг авч үзвээс:

1. Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого /2017-2025/
2. Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого батлах тухай
3. Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого

эдгээр хамарна.

Үндэсний түвшинд дараах хөтөлбөр болон дэд хөтөлбөрүүд хэрэгжиж иржээ. Үүнд:

1. ШУА-ийн дунд хугацааны (2018-2025) стратеги төлөвлөгөө
2. Монгол судлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр
3. Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хөгжүүлэх инновацийн хөтөлбөр
4. Монгол улсын үндэсний хиймэл дагуул хөтөлбөр
5. “Шинжлэх ухаан, технологийн салбарын менежментийн шинэчлэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө /2010-2013/
6. “Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалт /2010-2014/
7. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр
8. Монгол улсын үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр /2008-2015/
9. Монгол улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөг дэмжих тухай
10. Монгол улсын шинжлэх ухаан, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр
11. “Биотехнологи” дэд хөтөлбөр
12. Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр
13. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах үндсэн чиглэл /2008-2012/

4.1 ШУТ-ийн салбарын бодлогын уялдаа холбоо

Аймгуудын хөгжлийн бодлогын баримт бичигт шинжлэх ухаан, технологитой холбоотой зорилтууд ховор байгаа нь ажиглагдаж байна. Энэ чиглэлээр аймгуудын түвшинд батлагдсан баримт бичиг нь үндсэндээ Засаг заргын мөрийн хөтөлбөр байна. Дорноговь, Говьсүмбэр аймгийн хувьд 10 жилийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж баталсан нь нөгөө хоёр аймагтай харьцуулахад давуу талтай байна. Дундговь аймгийн хувьд цаг хугацааны хувьд давхардалтай хоёр ч дунд хугацааны баримт бичгийн төсөл байгаа хэр нь батлагдсан эсэх нь тодорхойгүй байна.

Бид хууль болон бодлогын баримт бичгийн уялдааг шинжлэх ухааны салбарт авч үзэхдээ холбогдох 4 хуулиас “Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль”-д орон нутагтай холбоотой заалт байгаа учир сонгож авах. Бусад хуулийн хувьд орон нутагтай холбоотой заалт байхгүй учир орхив. Бодлогын хувьд Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого /2017-2025/ болон өмнөхийн адил Монгол улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг авч үзэв. Баримт бичгийн нийцэл, уялдааг доорх хүснэгтэд нэгтгэн харуулав. Дэлгэрэнгүйг Хавсралт 7-оос харна уу.

Хүснэгт 4.2 Шинжлэх ухаан, технологийн баримт бичгийн уялдаа

	Дундговь	Дорноговь	Өмнөговь	Говьсүмбэр
Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль	0.00	0.67	0.00	0.33

<i>Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030</i>	0.00	0.00	0.00	0.00
<i>Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого /2017-2025/</i>	0.00	0.42	0.06	0.17
<i>МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр</i>	0.00	0.08	0.00	0.08

4.1.1 Говьсүмбэр

Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого /2010-2021/-ын хүрээнд “Баянтал суманд мал аж ахуй, үйлдвэрлэл технологийн, Алтанговь технологийн паркийн хүрээнд Чойрын технологийн их сургууль, Химийн аж үйлдвэрийн эрдэм шинжилгээний үндэсний хүрээлэн байгуулах” зорилтуудыг тавьсан байгаа нь Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хууль болон Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого /2017-2025/-той уялдаж байна. Харин Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт эдгээр зорилт нь цааш ажил болон тусгагдаагүйн улмаас бодлогын ерөнхий нийцэл доогуур байна.

4.1.2 Дорноговь

Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө /2011-2021/-ний 2.2.1.4, 2.2.1.2.5, 2.2.1.2.6 заалтуудад Сайншандын аж үйлдвэрийн парк байгуулах талаар зорилт тавьсан байгаа нь дээр заасан хууль болон Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого /2017-2025/-д заасан зорилтуудыг тодорхой хэмжээнд тусгажээ гэж дүгнэлээ. Харин Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн хувьд орон нутагтай холбоотой 4 заалт байгаагаас аймгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “4.2.2 Бизнес инкубатор төв байгуулах” гэсэн ганц заалт орсон нь нийцэл багатайг харуулж байна. Дорноговь аймгийн хувьд шинжлэх ухааны чиглэлээр цөөн ч болов зорилт тавьсан байгаа нь бусад гурван аймагтай харьцуулахад илүү өндөр үзүүлэлттэй байна. Гэвч Дорноговь аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “1.3.1 Паркаар дамжуулан “Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөр” хэрэгжүүлэх, 1.2.3 ШУА бусад байгууллагуудтай хамтрах” гэсэн зорилтууд орсон нь хэт ерөнхий бөгөөд шинжлэх ухаан гэхээс илүүтэй аж үйлдвэржилт талруу чиглэсэн зорилт учир үүнийг шууд утгаар нь өндөр гэж ойлгож болохгүй юм.

4.1.3 Дундговь

Дундговь аймгийн хувьд шинжлэх ухаан, технологийн салбарт үндэсэндээ ямар нэг зорилт тавигдаагүй нь харагдаж байна. Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр /2012-2031/ гэсэн баримт бичиг батлагдсан эсэх нь тодорхойгүйн улмаас тухайн хөтөлбөрт заасан “Дундговь” үйлдвэрлэл, технологийн паркийг өргөтгөн хөгжүүлэх гэсэн зорилтыг хүчингүй гэж үзэн тооцоогүй болохыг анхаарна уу.

4.1.4 Өмнөговь

Өмнөговь аймгийн хувьд шинжлэх ухааны салбарын бодлого чухал баримт бичигт тусгагдаагүй байгаа нь Дундговь аймгийн нэгэн адил уялдаа холбоо доогуур байхад хүргэж байна. Шинжлэх ухаантай ямар нэг байдлаар холбоотой зорилт гэвэл аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгалаа олсон “66. Ингэний сүү боловсруулах үйлдвэр байгуулж “дэлхийн брэнд”-тэй болох” зорилт юм. Үүнийг эс тооцвол энэ салбарын чиглэлээр ямар нэг өөр зорилт тавигдаагүй байна. Урт хугацааны бодлогын баримт бичгээ боловсруулсан Номгон, Цогт-Овоо сумдын хувьд эртний амьтан, ургамлын үлдвэр, хот балгасны суурь, түүх соёлын дурсгалт Сангийн далай хийд, Зүүн баруун бичигт, Чингисийн Хар улаан балгас, уртын сүг зураг гэх мэт газрыг палеонтологийн судалгаанд хамруулж тэмдэгжүүлэн хамгаалах чиглэлээр Шинжлэх

ухааны академийн эрдэмтэдтэй хамтран ажиллах зорилтыг дэвшүүлсэн байна. Энэ нь шинжлэх ухаан гэхээсээ илүү аялал жуулчлалын маршрут тогтоох зорилготой ажээ.

4.1.5 ШУТ-ийн салбарын бодлогын талаарх дүгнэлт

Дүгнэж хэлэхэд:

1. Шинжлэх ухаан, технологийн салбар нь хууль эрхзүй талаасаа харьцангуй сүүлд зохицуулалт хийгдсэн салбар юм. Энэ салбарт бодлогоор хангах, дэд бүтэц бүрдүүлэх, тэргүүлэх чиглэл тогтоох, хөшүүрэг бий болгох зэрэг төрийн үүргийг нилээд тодорхой заасан бөгөөд ингэхдээ Засгийн газар буюу төрийн захиргааны төв байгууллагуудын чиг үүрэгт түлхүү анхаарчээ. Цэвэр шинжлэх ухаантай холбоотой орон нутгийн үүрэг үндсэндээ байхгүй бөгөөд ямар нэг хэмжээгээр шинжлэх ухаан, технологитой холбогдох зорилтууд нь үйлдвэрлэл, технологийн парк, өндөр технологийн кластер байгуулах гэсэн чиглэлээр тавигдсан байна. Эдгээр нь цэвэр шинжлэх ухааны зорилт биш хэдий ч “шинэ, дэвшилтэт болон өндөр технологи дамжуулах, нэвтрүүлэх, нутагшуулах” зорилготой гэдэг утгаар нь энэхүү тайланд авч үзэв.
2. Орон нутгийн түвшинд үйлдвэрлэл, технологийн паркийн асуудлыг бодлогын 8-10 жилийн дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан хоёр аймаг байгаа нь Дорноговь болон Говьсүмбэр аймгууд юм. Говьсүмбэр аймгийн “Алтанговь технологийн паркийн хүрээнд Чойрын технологийн их сургууль, Химийн аж үйлдвэрийн эрдэм шинжилгээний үндэсний хүрээлэн байгуулах” зорилт нь илүү хэтийн бөгөөд өргөн хүрээтэй байна. Иймээс эдгээр нь хэрэгжих боломжтой эсэхийг нягтлах шаардлага харагдаж байна. Нөгөө хоёр аймгийн хувьд парк болон шинжлэх ухаантай холбоотой зорилт тусаагүй байна. Өмнөговь аймаг ингэний сүү боловсруулах үйлдвэр байгуулж, “дэлхийн брэнд” бүтээх зорилт нь тодорхой хэмжээний инновацийг шаардах зорилт гэж харагдаж байна.
3. Нэгтгэн дүгнэхэд, шинжлэх ухаан, технологийн бодлого нь өнөөгийн байдлаар улсын хэмжээнд ерөнхий байдлаар цаасан дээр буусан төдий байна. Иймээс орон нутгийн түвшинд битгий хэл үндэсний түвшинд ч хэрэгжилт үндсэндээ эхлээгүй, хэрэгжилтийг дүгнэх боломжгүй байна.

4.2 ШУТ-ийн салбарын өнөөгийн нөхцөл байдал

Өмнө нь дурдсанчлан, шинжлэх ухаан, технологи, инновацийн ажиллагаа нь шинэ мэдлэгийг бүтээх, шилжүүлэх, технологи худалдаж авах, дамжуулах, бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх, судалгаа боловсруулалт хийх зэрэг үйл ажиллагааг хамардаг.


4.2.1 Шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийг хэмжих үзүүлэлтүүд

Аливаа улсад шинжлэх ухаан, технологийн хөгжлийг тодорхойлоход ЮНЕСКО-оос боловсруулсан олон улсын хэмжээнд ашигладаг дараах үзүүлэлтүүд байна. Үүнд:

- Шинжлэх ухааны бүтээлийн тоо
- Салбарын ажиллагсадын тоо [Headcount, эсвэл Full-time equivalent (FTE)]
- Судалгаа боловсруулалтад зарцуулж буй дотоодын нийт зардал [Gross domestic expenditure on R&D (GERD)]

Шинжлэх ухаан, технологийн салбарын нэг чухал онцлог нь хүний нөөцөөс ихээхэн шалтгаалдаг байдал юм. Иймд энэ салбарт ажиллаж буй судлаачдын тооны үзүүлэлт нь тухайн улс орны шинэ мэдлэг бүтээх, технологи дамжуулах, инновац бүтээх чадварыг илтгэнэ. Холбогдох боловсон хүчнээр хангагдсан байдлыг авч үзвэл, дэлхийн улс орнууд дараах байдалтай байна:

Зураг 4.1 Нэг сая оршин суугчдад оногдох судлаачдын тоо, дэлхийн бүс нутгаар



Эх сурвалж: UIS Fact Sheet No. 49/June 2018 <http://uis.unesco.org/sites/default/files/documents/fs49-human-resources-rd-2018-en.pdf>

Судлаачдын дунд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин нь энэ салбарын хүний нөөцийн нэг чухал үзүүлэлт болдог. Шинжлэх ухааны салбар дахь жендерийн ялгаа Төв Ази, Латин Америк, Карибын тэнгисийн бүс нутаг, Төв болон Зүүн Европын орнуудад харьцангуй бага байхад, 2015 оны байдлаар Зүүн Ази болон Номхон далайн бүс нутаг нийт судлаачдын 23.4 хувь, Өмнөд болон Баруун Азид 18.5 хувь нь эмэгтэй судлаач нар эзэлж буй нь жендерийн ялгаа ихтэйг харуулж байна⁴².

ШУТ-ийн салбарын хүний нөөцийн тооцохдоо хүний ердийн тоо (headcount) болон бүтэн цагийн ажилтанд шилжүүлсэн тоо (full-time equivalent) гэсэн хоёр аргачлалаар тооцдог бөгөөд сүүлийнх нь тухайн салбарт ажиллаж буй хүн өөрийн цагийн хэдэн хувийг судалгаа боловсруулалтад зарцуулж буйг илтгэдэг илүү нарийн үзүүлэлт юм.

Судалгаа ба боловсруулалтын түвшинг хэмждэг өөр нэг чухал үзүүлэлт нь энэ чиглэлээр зарцуулж буй хөрөнгийн хэмжээ юм. 2015 оны байдлаар дэлхийн бүс нутгаар авч үзвэл, судалгаа боловсруулалтын зардлын ДНБ-д эзэлж буй хувийн жин дараах байдалтай байна⁴³:

- Дэлхийн дундаж – 1.7 хувь
- Арабын улсууд – 0.5 хувь
- Төв болон Зүүн Европ – 1.0 хувь
- Төв Ази – 0.2 хувь
- Латин Америк, Карибын тэнгисийн бүс нутаг – 0.7 хувь
- Хойд Америк ба Баруун Европ – 2.5 хувь
- Зүүн Ази болон Номхон далайн бүс нутаг – 2.1 хувь
- Өмнөд болон Баруун Ази – 0.6 хувь
- Сахарын өмнөх Африк – 0.4 хувь

⁴² UIS Fact Sheet No. 51/June 2018 <http://uis.unesco.org/sites/default/files/documents/fs51-women-in-science-2018-en.pdf>

⁴³ UIS Fact Sheet No. 50/June 2018 <http://uis.unesco.org/sites/default/files/documents/fs50-global-investments-rd-2018-en.pdf>

Өндөр хөгжилтэй орнуудын хувьд эдгээр зардлын дийлэнх хувийг хувийн сектор зарцуулдаг ба төрийн сектор, их сургуулиудын үүрэг харьцангуй бага хувийн жинтэй байна. Тухайлбал, 2016 оны байдлаар Япон, БНСУ, Арабын Нэгсэн Эмират зэрэг орнуудын нийт зардлын ¾-аас ихийг хувийн секторын зардал эзэлж байсан нь дэлхийд тэргүүлэх үзүүлэлт юм. Харин хөгжиж буй орнуудын судалгаа боловсруулалтын зардлын зонхилох хувийг төрөөс санхүүжүүлдэг онцлогтой байна. Эдгээр орноос ялгарч буй цөөн улсуудын нэг нь БНХАУ юм. Хятад улсын хувьд бизнесийн салбарын зардал нь дотоодын нийт зардлын 80 шахам хувийг эзэлж буй нь ихээхэн өндөр үзүүлэлт юм. Энэ салбарт хийж буй хувийн секторын хөрөнгө оруулалтаар Израиль, Япон, БНСУ, БНХАУ, АНЭ, Тайланд, Вьетнам, Сингапур нар дэлхийд тэргүүлж байна.


ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэн (UNESCO Institute for Statistics)-ээс инновацийн түвшнийг хэмжих үзүүлэлтүүдийг мөн боловсруулж, 2010 оноос мэдээллийг системтэйгээр цуглуулж эхэлсэн. Хамгийн сүүлийн судалгаа 2017 онд гарсан бөгөөд үүнд нийт 71 орон хамрагджээ.⁴⁴ Инновацийн түвшнийг хэмжихдээ:

- Бүтээгдэхүүний инновац
- Үйл явцын инновац
- Үйлдвэрлэлийн зохион байгуулалтын инновац
- Маркетингийн инновац

гэсэн 4 бүлэгт ангилсан байна.

Мөн боловсруулах салбар дахь инновац нэвтрүүлсэн пүүсийн тоо, нийт пүүсэд эзлэх хувийн жин зэрэг нийт 13 үндсэн үзүүлэлтээр мэдээлэл цуглуулж, боловсруулж байна. Аргачлалын хувьд 1992 оны Ослогийн гарын авлагыг (Oslo Manual) 2017 онд шинэчилсний дагуу мэдээлэл цуглуулж, холбогдох тайлбарыг хийж байна.

Зураг 4.2 Дунд болон бага орлоготой орнуудын инновац нэвтрүүлж буй пүүсийн хувь (боловсруулах салбарын нийт пүүсэд эзлэх хувийн жин)



Эх сурвалж: UNESCO Institute for Statistics (2017) Summary Report of the 2015 UIS Innovation Data Collection Information Paper No. 37 - <http://uis.unesco.org/sites/default/files/documents/ip37-summary-report-of-the-2015-uis-innovation-data-collection-2017-en.pdf>

⁴⁴ UNESCO Institute for Statistics (2017) Summary Report of the 2015 UIS Innovation Data Collection Information Paper No. 37 - <http://uis.unesco.org/sites/default/files/documents/ip37-summary-report-of-the-2015-uis-innovation-data-collection-2017-en.pdf>

ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэн (UNESCO Institute for Statistics) шинжлэх ухаан, технологи болон инновацийн мэдээллийг өөрийн аргачлалын дагуу цахим хуудсандаа нээлттэй байршуулж байна.⁴⁵

Мэдээллийн цуглуулахдаа тодорхой асуулгын дагуу түүвэр судалгаа хийх аргыг ашигладаг бөгөөд асуулгын дэлгэрэнгүй аргачлалыг мөн өөрийн цахим хуудсанд байршуулдаг.⁴⁶ ШУТ болон инновацийн түвшнийг хэмжих мэдээлэл нь зарим тохиолдолд түвэгтэй, ялангуяа хөгжиж буй орны хувьд нарийвчлан гаргахад хүндрэл үүсдэг, мэдээллийн чанар болон найдвартай байдал асуудал дагуулдаг талаар ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэн тайлбар хийсэн байна.⁴⁷

4.2.2 Уламжлалт мэдлэг ба шинжлэх ухаан

Хөгжиж буй орнуудын хувьд уламжлалт мэдлэгт (traditional knowledge) суурилсан инновац бусад орнуудтай харьцуулахад илүү өндөр ач холбогдолтой байх магадлалтай. Тодорхой нутаг орон, байгаль цар уурын онцлог, түүхэн нөхцөл болон соёлын онцлогт суурилсан мэдлэг нь системтэй ажиглалт, туршилтад суурилдаг, уян хатнаар өөрчлөгдөн зохицох, хувьсан өөрчлөгдөх чадвартай учир шинжлэх ухааны мэдлэгтэй ижил чанарыг агуулдаг гэсэн байр суурийг судлаачид илэрхийлж байна.⁴⁸ Харин сонгодог шинжлэх ухаанаас ялтаатай нь эдгээр мэдлэг нь албан ёсоор бүртгэгдээгүй, зарим тохиолдолд биет бус (аман) хэлбэрээр оршдог, хязгаарагдмал нутгийн онцлогт тохирсон байдаг юм.

Хөгжиж буй орнуудад эдгээр мэдлэг нь тогтсон практикийг эвдэх, асуудлын илүү оновчтой шийдлийг олох, улмаар эдийн засгийн эргэлтэд орж, ядуурлыг бууруулах ач холбогдолтой. Ялангуяа, уламжлалт мэдлэгийг орчин үеийн шинжлэх ухааны мэдлэг, арга хэрэгсэл, техник болон технологитой хослуулан орон нутгийн асуудлыг шийдвэрлэхэд дөхөмтэй болгож болно. Уламжлалт мэдлэгийг шинжлэх ухаантай холбох дараах аргууд байдаг:

- Этно шинжлэх ухаан (ethnoscience) болон түүний салбар болон этноботаник (ургамал судлал), мал эмнэлэг (ethno-veterinary medicine), этноэкологи (ethno-ecology) болон бусад асуудлыг шинжлэх ухааны үүднээс судлах
- Уламжлалт мэдлэгийг шинжлэх ухаанчаар судлан, албан ёсны шинжлэх ухааны мэдлэг болгон хувиргах, тухайлбал, ардын эмчилгээний аргууд, байгаль орчныг хамгаалах арга, уламжлалт хоол хүнс, хөдөө аж ахуйн (мал аж ахуй, ой мод, загасны аж ахуй, газар тариалан) бүтээгдэхүүний боловсруулалтыг дэмжих
- Орон нутгийн мэдлэгийг тээгч нар болон эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих (participatory R&D)

Үүний зэрэгцээ, судалгаа боловсруулалт нь зөвхөн байгалийн шинжлэх ухаан бус мөн нийгэм, хүмүүнлэгийн ухааныг хамрах ёстой. Тухайлбал, антропологи, соёл болон шашин судлалын хүрээнд тухайн нутаг орны ёс заншил, иргэдийн сэтгэлзүйн онцлог зэргийг судлана. Эдгээр мэдлэг нь нийгмийн инновацийн суурийг бүрдүүлэхээс гадна бусад инновац амжилттай хэрэгжих суурь нөхцөл нь болдог.

⁴⁵ <http://data.uis.unesco.org>

⁴⁶ Questionnaire on Research and Experimental Development (R&D) Statistics
http://uis.unesco.org/sites/default/files/documents/uis_rd_m_2016_en_0.pdf Guide to Conducting R&D Survey: for Countries Starting to Measure Research and Experimental Development UIS Technical Paper No. 11 (2014)
<http://uis.unesco.org/sites/default/files/documents/guide-to-conducting-an-rd-survey-for-countries-starting-to-measure-research-and-experimental-development-2014-en.pdf>


⁴⁷ UNESCO Institute for Statistics (2010) *Measuring R&D: Challenges Faced by Developing Countries* Technical Paper No. 5 - <http://uis.unesco.org/sites/default/files/documents/measuring-rd-challenges-faced-by-developing-countries-2010-en.pdf>

⁴⁸ Rahman (2000)

4.2.3 Монгол улсын шинжлэх ухаан, технологийн үзүүлэлтүүд

4.2.3.1 Шинжлэх ухааны бүтээлийн тоо

Зураг 4.3 Web of Science санд бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн Монгол улсын шинжлэх ухааны бүтээлийн тоо



Эх сурвалж: Web of Science

1980 оноос хойш Монголын эрдэм шинжилгээний байгууллагуудын судлаачдын нийт 4284 өгүүлэл Web of Science санд бүртгэлтэй сэтгүүлд хэвлэгдсэн байна. Скопус мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо өнөөгийн байдлаар 4239 хүрсэн байна.⁴⁹ Шинжлэх ухааны бүтээлийн тоо 2000 оноос хойш тасралтгүй өсч байгаа хэдий ч чамлалттай хэвээр байна. Хөгжиж буй зарим орнуудын судлаачдын бүтээлийн тоо сүүлийн жилүүдэд огцом өсч байгаа тухай олон улсад тэмдэглэж байна. Ялангуяа БНХАУ-ын эрдэм шинжилгээний бүтээлийн тоо 2000-2010 оны хооронд 100 хувь гаруй өссөн байна⁵⁰.

5.2.3.2 Патент болон зохиогчийн эрхийн тоо

Хүснэгт 4.3 Нийт мэдүүлсэн патентын тоо

	Шинэ бүтээлийн патентын мэдүүлэг		Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг	
	2018	2019/I	2018	2019/I
Бүгд	159	100	269	144
Дотоодын мэдүүлэг	82	60	140	104
Иргэн	54	49	65	56
Хуулийн этгээд	28	11	75	48
Гадаадын мэдүүлэг	10	1	38	3
Иргэн	1	0		3
Хуулийн этгээд	9	1	38	0

⁴⁹ <https://www.scimagojr.com/countrysearch.php?country=mn>

⁵⁰ Gaillard, J. (2010), Measuring R&D in Developing Countries: Main Characteristics and Implications for the Frascati Manual, Science, in Technology & Society, Vol. 15(1), pp. 77-111.

Патентын хамтын ажиллагааны гэрээний дагуу мэдүүлсэн олон улсын мэдүүлэг	67	39		
Иргэн	5	1		
Хуулийн этгээд	62	38		
Гаагийн хэлэлцээрийн дагуу мэдүүлсэн олон улсын мэдүүлэг			91	37
Хуулийн этгээд			91	37

Эх сурвалж: YCX www.1212.mn

Иргэд, аж ахуйн нэгжийн дунд патентын мэдүүлэг нэмэгдэх хандлагатай байна. Мөн үүнийгээ дагаад олгосон патентын тоо өсөх хандлага ажиглагдаж байна. Энэхүү мэдээлэл аймгийн түвшинд гарах боломжгүй байна.

Хүснэгт 4.4 Нийт олгосон патентын тоо

	2018	2019/Г улирал
Бүгд	347	146
Шинэ бүтээл	76	91
Бүтээгдэхүүний загвар	271	55

Эх сурвалж: YCX www.1212.mn

5.2.3.3 Салбарын ажиллагсадын тоо

Хүснэгт 4.5 Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарт ажиллагсадын тоо (аймаг, бүсээр)

Аймаг, бүс	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Улсын дүн	10,849	9,576	11,422	11,342	13,591	12,527	14,107	12,676	12,746	14,609
Баруун бүс	1,772	810	1,058	2,123	1,625	1,368	685	1,215	1,572	1,258
Зүүн бүс	608	577	1,082	539	731	802	700	931	342	561
Улаанбаатар	5,879	5,919	6,330	5,997	8,164	7,567	8,581	8,233	7,507	10,400
%	54.2%	61.8%	55.4%	52.9%	60.1%	60.4%	60.8%	64.9%	58.9%	71.2%
Хангайн бүс	915	1,310	1,455	983	1,308	1,019	1,712	798	1,244	959
Төвийн бүс	1,675	960	1,497	1,700	1,763	1,771	2,428	1,499	2,081	1,431
Өмнийн говийн дэд бүс	912	326	225	795	835	818	407	579	516	411
Говьсүмбэр	87	40	66	90	-	19	20		44	48
Дорноговь	356	167	-	158	194	309	174	142	154	125
Өмнөговь	250	70	114	247	477	263	134	235	198	113
Дундговь	219	49	45	300	164	227	79	202	120	125

Эх сурвалж: YCX www.1212.mn

ҮСХ-оос гаргасан тоогоор мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбарт ажиллагсадын тоо улсын хэмжээгээр өсч байгаа хэдий ч нийт эдийн засгийн салбарт ажиллагсадын дунд эзлэх хувийн жин нь 1.0-1.2 хувьд хэлбэлзэж буй нь бага үзүүлэлт бөгөөд харьцангуй өсөлтгүй байгааг харуулж байна.

ШУТ-ийн салбарын боловсон хүчин Улаанбаатар хотод төвлөрч байгаа, өнгөрсөн 10 жилийн хугацаанд энэ төвлөрөл нэмэгдэх хандлагатай байгаа нь нэг талаас хүний нөөцийн бөөгнөрөл үүсэх давуу талтай боловч орон нутгийн хөгжилд сөрөг нөлөөтэй байх магадлалтай. Бидний судалж буй 4 аймгийн хувьд ШУТ-ийн салбарын ажиллагсадын тоо буурах хандлагатай байна. Энэ нь салбарын хувьд нэн чухалд тооцогдох хүний нөөц орон нутгийн хувьд цөөрч байгаа нь цаашид ШУТ болон инновацийн бүсийн хөгжилд сөргөөр нөлөөлөхийг сануулж байна.

Цэвэр шинжлэх ухааны байгууллагуудыг авч үзвэл тоо нь сүүлийн жилүүдэд цөөрөх хандлагатай, мөн ажиллагсадын тоо бага зэрэг буурах хандлага ажиглагдаж байна. Эдгээр нь гол төлөв төрөөс

хэрэгжүүлсэн бүтцийн өөрчлөлттэй холбоотой юм. Эрдэм шинжилгээний ажилтнуудын хувьд манай улсад жендерийн тэгш байдал хангагддаг давуу талтай байна.

Хүснэгт 4.6 Шинжлэх ухааны салбарын байгууллагын тоо, ажиллагсадын тоо

Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Байгууллагын тоо	64	68	65	70	70	71	71	59	61
Ажиллагсад	3,656	3,750	4,045	4,120	4,071	4,411	4,374	4,125	3,502
Эмэгтэй	1,848	1,913	2,096	2,171	2,096	2,234	2,216	2,007	1,701

Эх сурвалж: YCX www.1212.mn

ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэнгээс гаргасан аргачлалын дагуу Монгол улсад хийсэн түүвэр судалгааны дагуу судалгаа боловсруулалтын үйл ажиллагаанд оролцдог ажиллагсадын тоог дараах байдлаар тооцжээ:

Хүснэгт 4.7 Судалгаа боловсруулалтын чиглэлийн ажиллагсадын тоо

	2011	2012	2013	2014	2015	2016
Нийт R&D ажиллагсадын тоо	2,583	2,672	2,694	2,724	2,515	2,211
Нийт R&D ажиллагсадын тоонд эмэгтэйчүүдийн эзлэх хувь (%)	53.0	52.7	51.5	51.8	50.8	51.2
Хөдөлмөрийн нөөцийн 1000 хүнд ногдох R&D ажиллагсадын тоо	2.14	2.20	2.17	2.16	1.97	1.74
Ажил эрхлэгч 1000 хүнд ногдох R&D ажиллагсадын тоо	2.25	2.29	2.27	2.27	2.07	1.88
1 сая оршин суугчдад ногдох R&D ажиллагсадын тоо	935.36	949.46	938.97	931.63	844.85	730.33

Эх сурвалж: <http://data.uis.unesco.org>

Дээрх үзүүлэлтийг зарим орнуудтай харьцуулж үзүүлбэл дараах дүр зураг харагдаж байна:

Хүснэгт 4.8 Судалгаа боловсруулалт чиглэлийн ажиллагсадын харьцуулсан тоо, 2016 оны байдлаар

Улс	Нийт R&D ажиллагсадын тоо	Нийт R&D ажиллагсадын тоонд эмэгтэйчүүдийн эзлэх хувь (%)	Ажил эрхлэгч 1000 хүнд ногдох R&D ажиллагсадын тоо	1 сая оршин суугчдад ногдох R&D ажиллагсадын тоо
БНХАУ	5,830,741	26.5	7.6	4,154.4
Монгол	2,211	51.2	1.9	730.3
ОХУ	722,291	..	10.1	5,017.1

Эх сурвалж: <http://data.uis.unesco.org>

Дээрх хүснэгтээс Монгол улсын судалгаа боловсруулалтын чиглэлээр ажиллаж буй хүний нөөц хөрш зэргэлдээ орнуудтай харьцуулахад үлэмж доогуур, тодруулбал ажил эрхлэгч 1000 хүнд ногдох судалгаа боловсруулалтын ажиллагсадын тоо БНХАУ-аас 4 дахин, ОХУ-ын үзүүлэлтээс даруй 5.3 дахин доогуур байгаа нь энэ чиглэлийн хүний нөөц нэн дутагдалтай нь харагдаж байна. Цаашилбал, 1 сая оршин суугчдад ногдох судалгаа боловсруулалтын ажиллагсадын тооны үзүүлэлтээр БНХАУ-аас 5.7 дахин, ОХУ-ын үзүүлэлтээс 6.9 дахин доогуур байгаа нь энэ байдлыг бататгаж байна.

5.2.3.4 Судалгаа боловсруулалтын чиглэлээр зарцуулж буй дотоодын нийт зардлын хэмжээ

Монгол улсын ШУТ чиглэлээр зарцуулж буй хөрөнгийн дийлэнх хэсгийг төрөөс санхүүжүүлж байна. Улсын төсвийн ШУТ-ийн салбарт зарцуулж буй санхүүжилтийг авч үзвэл:

Хүснэгт 4.9 Улсын төсвийн ШУТ-ийн салбарын зарцуулалт

	2000	2005	2016	2017	2018* (урьдчилсан гүйцэтгэл)
Улсын төсвийн нийт зардал (тэрбум төг)	434.2	764.6	9,519.9	9,017.3	9,222.9

ШУТ-ийн төсвийн зардал (тэрбум төг)	3.4	7.3	42.2	47.5	-
ШУТ-ийн төсвийн улсын нийт төсөвт эзлэх хувийн жин (%)	0.78%	0.95%	0.44%	0.53%	

Эх сурвалж: YCX тооцоолол

Манай улсын төсвийн 1 хүрэхгүй хувийг ШУТ-ийн салбарт зарцуулж буй нь хэт доогуур үзүүлэлт болно. Сүүлийн хэдэн жилийн хувьд энэ үзүүлэлт буурсан байна.

Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн нэгдмэл аргачлалын дагуу судалгаа боловсруулалтын чиглэлээр зарцуулж буй нийт зардлыг авч үзвэл Монгол улсын хувьд дараах үзүүлэлт гарч байна:

Хүснэгт 4.10 Судалгаа боловсруулалтын чиглэлийн дотоодын нийт зарцуулалт


	2011	2012	2013	2014	2015	2016
Дотоодын нийт зарцуулалт (тэрбум төг)	30.37	39.91	44.57	49.66	35.81	43.90
Дотоодын нийт зарцуулалт (сая \$ PPP)	56.54	67.09	73.99	78.09	56.06	68.17
Дотоодын нийт зарцуулалтын ДНБ-д эзлэх хувийн жин (%)	0.23	0.24	0.23	0.22	0.15	0.18
Дотоодын нийт зарцуулалтын засгийн газрын санхүүжилтийн хувийн жин (%)	65.5	..	74.0	75.8	80.1	86.3
Дотоодын нийт зарцуулалтын бизнесийн секторын санхүүжилтийн хувийн жин (%)	11.4	..	8.3	7.5	7.3	4.9
Дотоодын нийт зарцуулалтын дээд боловсролын байгууллагын санхүүжилтийн хувийн жин (%)	1.3	..	1.8	3.2	9.7	3.7

Эх сурвалж: <http://data.uis.unesco.org>

Судалгаа боловсруулалтын зориулалтаар зарцуулж буй нийт зардлын үзүүлэлтээр Хойд Америк ба Баруун Европ дэлхийд тэргүүлж (ДНБ-ий 2.5 хувь), Зүүн Азийн орнууд удаалж байна (ДНБ-ий 2.1 хувь). Монгол улсын үзүүлэлт ДНБ-ий 0.2 хувь хүрэхгүй байгаа нь энэ чиглэлээр хамгийн бага хэмжээний хөрөнгө зарцуулдаг орнуудын тоонд ороход хүрч байна.

Доорх зураг дэлхийн улс орнуудын судалгаа, боловсруулалтад зарцуулж буй зардлыг харуулж байна.

Зураг 4.4 Судалгаа боловсруулалтын дотоодын нийт зардлын ДНБ-д эзлэх хувийн жин, дэлхийн бүс нутгаар 2016 онд



Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д заасанчлан, технологи, инновацийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийг шат дараалалтай нэмэгдүүлж, 2016-2020 онд ДНБ-ий 2 хувь, 2021-2025 онд 2.5 хувь, 2026-2030 онд 3 хувь хүртэлх түвшинд хүргэх зорилтыг хүрээнд санхүүжилтийн болон бусад бодлого огт хэрэгжихгүй байна.

Энэ томоохон зорилгын хүрээнд ШУТ-ийн талаар баримтлах бодлогод “I үе шат: 2017-2020 онд шинжлэх ухаан, технологийн салбарын бодлого, хууль эрх зүйн орчин, бүтэц, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгож, дэд бүтцийг сайжруулан санхүүжилтийг үе шаттай нэмэгдүүлж, шинжлэх ухааны паркийн дэд бүтцийг байгуулах ажлыг эхлүүлж, эрдэм шинжилгээний ажлын нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ” гэсэн зорилтууд мөн биеэллээ олоогүйг тоон мэдээлэл нотолж байна. Эхний үе шат дуусах гэж буй өнөөгийн нөхцөлд энэ чиглэлээр гарсан ахиц дэвшил ховор байна.

Өнөөгийн байдлаар суурь нь ийнхүү сул байгаа тохиолдолд “II үе шат: 2021-2025 онд дотоодын нийт бүтээгдэхүүнд шинжлэх ухаан, технологийн салбарын төсвийн санхүүжилтийн эзлэх хувийг зорилтот түвшинд хүргэж, салбарын чадавх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, улсын эдийн засгийн хөгжлийн тулгуур хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлнэ” хэмээх зорилтод хүрэх боломж бага харагдаж байна.

ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэнгийн инновацийн түвшнийг хэмжих үзүүлэлтүүдийг боловсруулж, 2010 оноос хойш мэдээллийг системтэйгээр цуглуулж эхэлснийг дээр дурдсан. Монгол улс энэ судалгаанд хараахан хамрагдаагүй байна. Тиймээс инновацийн чиглэлийн тоон мэдээлэл хомс байна.

Орон нутгийн түвшний инновацийн асуудлаар Инновацийн тухай хуульд “инновацийн үйл ажиллагаанд тулгуурлан бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх, эдийн засгийн төрөлжилтийг бий болгох” зорилтыг дэвшүүлсэн билээ. Говийн дэд бүсийн хувьд зарим аймгийн хувьд орон нутгийн брэнд болох бүтээгдэхүүнийг өөрийн нөөц болон уламжлалт мэдлэгт суурилан, шинжлэх ухааны дэмжлэгтэйгээр зах зээлд гаргах боломж бүрэн бий. Тухайлбал, Өмнөговь аймаг ингэний сүү боловсруулах үйлдвэр байгуулж “дэлхийн брэнд”-тэй болох зорилт тавьсан нь үүний нэг жишээ юм.

4.3 ШУТ-ийн салбарын бодлогод өгөх санал ба зөвлөмж

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн бодлогод өгөх санал

1. ШУТ нь шинэ тутам хөгжих гэж буй салбар бөгөөд ихээхэн хэмжээний санхүү, дэд бүтэц, хүн хүчний нөөц шаарддаг учир шинжлэх ухааны бодлогыг төвлөрсөн байдлаар хэрэгжүүлэх нь дунд хугацаандаа оновчтой байх магадлалтай. Судалгаа шинжилгээтэй холбоотой орон нутгийн оролцоо цаашид ч харьцангуй хязгаарагдмал байх болов уу.
2. Урт хугацаандаа “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тусгасанчлан “шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлнэ” гэсэн зорилт тавигдаж байгаа нөхцөлд энэ зорилт нь бүс нутаг, аймаг, орон нутгийн түвшинд ямар хэлбэрээр хэрэгжихийг илүү дэлгэрэнгүй тодорхойлох шаардлага гарахаар харагдаж байна.
3. Бүс нутагт шинжлэх ухааны парк байгуулах асуудал хүндрэлтэй, биелэгдэх магадлал багатай харагдаж байна. Учир нь хүний нөөц болон дэд бүтэц нь нийслэл хотод төвлөрсөн, орон нутагт

энэ чиглэлээр ажиллах дэд бүтцийн орчин бүрдээгүй, ажилладаг хүмүүсийн тоо цөөрсөөр байгаа нь сөрөг суурийг бүрдүүлж байна. Ийм нөхцөл байдалд орон нутагт шинжлэх ухаан, технологийн паркийг байгуулах асуудал хэт өндөр зардалтай, үр өгөөж багатай байх магадлалтай юм.

4. Технологийн шийдэл нь орон нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх бөгөөд нутгийн болон соёлын онцлогийг тусгасан байх нь илүү оновчтой гэж үздэг. Иймээс бүсчилсэн хөгжлийн бодлогод орон нутгийн түвшинд тулгарч буй асуудлыг шийдэх технологийн шинэ шийдэл гаргах талаас дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгах шаардлагатай. Эдгээр нь заавал өөрийн бүс нутагт ШУТ-ийн парк байгуулах замаар шийдвэрлэгдэх албагүй юм. ШУТ-ийн дэд бүтэц болон холбогдох хүний нөөц төвлөрсөн газартай хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар шийдэх боломжтой юм.

Салбарын бодлогод өгөх санал

1. ШУТ-ийн чиглэрээр томоохон зорит тавьсан нь өнөөгийн байдлаар тунхаглалын шинж чанартай хэвээр байна. Энэ нь өөрөө шинэ тутам хөгжих гэж буй салбар учир бодлогын бодит арга хэмжээ авч эхлээгүй хэвээр байна. Цаашид тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д тавьсан мэдлэгт суурилсан эдийн засаг болон хөгжих зорилт хэвээр хадгалагдах тохиолдолд энэ чиглэлээр бодлогын дорвитой арга хэмжээ авах шаардлага байна.
2. 2017 онд батлагдсан төрөөс ШУТ-ийн талаар баримтлах бодлогод тусгагдсан арга хэмжээнүүд мөн биеэллээ олоогүй, цаасан дээр хэвээр байгааг анхаарах хэрэгтэй. Тухайлбал, энэхүү бодлогыг хэрэгжүүлснээр гарах үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдээр суурь он болох 2017 оноос хойш гарсан ахиц дэвшил хомс байгаа анхаарах.
3. ШУТ-ийн салбарт тэргүүлэх үүргийг өнөөгийн нөхцөлд төр гүйцэтгэх шаардлага хэвээр үлдэхээр байна. Энэ нөхцөлд төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлага байна. Дунд хугацаандаа төр энэ салбарт гоцлох тоглогч байх бөгөөд ШУТ болон инновацийг дэмжих дэд бүтэц, боловсон хүчин, санхүүжилтийн асуудлыг хариуцахаас өөр аргагүй юм. Гэтэл санхүүжилт нь сүүлийн жилүүдэд өсөөгүй төдийгүй, харьцангуй хувь нь буурах хандлага ажиглагдаж байгаа нь хэтдээ сөрөг үр дагавартай байх болно.
4. ШУТ болон инновацийн чиглэлээрх өнөөгийн санхүүжилтэд хувийн сектор болон их сургуулиудын хувийн жин бага байгаа нь бизнес эрхлэгчдийн дунд өрсөлдөх чадвар бүхий шинэ бүтээгдэхүүн боловсруулах чадвар болон сонирхол бага байгаагийн илрэл юм. Энэ нь гадаадын зах зээлд бага нэвтэрсэн, үүнээс үүдэн инновацийн хэрэгцээ шаардлага сул, өрсөлдөөний шахалт дарамт бага байгаатай холбоотой гэж үзэж болно. Иймээс цаашид Монголын пүүсүүд шинэ санаа, инновацийг өөрийн үйлдвэрлэлдээ нэвтрүүлэхэд дэмжлэг, хөшүүрэг бий болгох хэрэгцээ байна.
5. ШУТ-ийн мэдээллийг илүү өргөн хүрээнд цуглуулах, энэ салбарт гарч буй өөрчлөлт, ахиц дэвшлийг хянах, олон улсын жишигт нийцсэн мэдээлэлтэй байх нь бодлогыг илүү оновчтой тодорхойлох, бодлогын үр өгөөжийг тооцох, өөрийн давуу болон сул талыг тодорхойлох зэрэг олон талын ач холбогдолтой учир чанартай, тогтмол мэдээллийн санг бүрдүүлэхэд анхаарах шаардлага байна.
6. Инновац нь өнөөгийн байдлаар манай улсад цоо шинэ ойлголт бөгөөд энэ талаар мэдээлэл үндсэндээ байхгүйтэй адил байна. Цаашид ямар салбарт, ямар байгууллага, пүүсүүд шинэ санаа, шинэ бүтээгдэхүүн, шинэ процессийг нэвтрүүлж буй, хаана ямар боломж байгаа талаар судалгаа хийж мэдээлэл цуглуулах шаардлага байна. Улмаар ЮНЕСКО-гийн

Статистикийн хүрээлэнгийн инновацийн судалгаанд хамрагдаж, олон улсын жишигт нийцсэн мэдээллийг цуглуулж, боловсруулдаг болох хэрэгтэй. Энэ нь микро буюу пүүсийн түвшний түүвэр судалгаа хийхийг шаардах ба энэ нь өндөр ач холбогдолтой байх болно.

Аймгийн хөгжлийн бодлогод өгөх санал

1. Богино хугацаа буюу 2-3 жилийн хувьд аймгуудын түвшинд хийж болох ажил нь орон нутгийн онцлог нөөцөнд тулгуурлан (уул уурхай, ХАА, боловсруулах салбар, соёлын өв) инновацид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн боловсруулах чиглэлээр эрэл хайгуул хийж, шинжлэх ухааны мэдлэг илүү шингэсэн салбарыг тодорхойлох шаардлагатай.
2. Төвийн бүсийн Говийн дэд бүсийн хүрээнд ШУТ-ийн парк нь бие даасан хэлбэрээр байх нь боломж муутай харагдаж байна. Шинжлэх ухаан, шинэ технологи нь аж үйлдвэрийн цогцолбор (парк эсвэл кластер)-ын хүрээнд хөгжих боломж байж болно.
3. Орон нутгийн хувьд өөрийн байгаль цаг уур, уламжлалт мэдлэг, байгаа нөөцийн онцлогт тохирсон бүтээгдэхүүнийг шинжлэх ухааны аргаар боловсруулан зах зээлд, ялангуяа гадаад зах дээлд нэвтэрч чадах шинэ бүтээгдэхүүнийг боловсруулах ажлыг орон нутгийн уламжлалт мэдлэгийг тээж буй хүмүүс, холбогдох чиглэлээр шинжлэх ухааны мэдлэг, чадварыг эзэмшсэн байгууллага, судлаач нартай хамтын ажиллагаа өрнүүлэх, судалгаа шинжилгээ хийх, зах зээлд нэвтрэх бүтээгдэхүүн болгон хувиргах (product commercialization) ажил дээр хамтрах нь орон нутагт инновацийг нэвтрүүлэх нэг боломжит арга зам гэж харагдаж байна. Өмнөговь аймгийн ингэний сүүнээс гадна бусад аймгуудын хувьд ч ийм боломж байгаа.

Номзүй

Эх хэлээр:

Г.Энхбат, Б.Даваацэрэн (2012) Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал VII, IX, XII дэвтэр, Соёлын өвийн үндэсний төв.

Г.Энхбат, Б.Даваацэрэн (2012) Монгол нутаг дахь түүх, соёлын үл хөдлөх дурсгал VII дэвтэр, Соёлын өвийн төв.

Г.Энхбат (2018) Нүүдэлчин монгол, Соёлын биет бус өвийн их наадам, Соёлын өвийн үндэсний төв.

Г.Энхбат, Ц.Цогтбаатар (2017) Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын лавлах, Швейцарын хөгжлийн агентлаг.

Англи хэлээр:

Bennett, J. (2001) 'Natural Heritage Valuation Methods: Applications to Cultural Heritage' in *Heritage Economics: Challenges for Heritage Conservation and Sustainable Development in the 21st Century*, Australian Heritage Commission, Australia.

Finn, Jeremy D.; Pannozzo, Gina M.; Achilles, Charles M. The "Why's" of Class Size: Student Behavior in Small Classes *Review of Educational Research*, v73 n3 p321-368 2003.

Gaillard, J. (2010), Measuring R&D in Developing Countries: Main Characteristics and Implications for the Frascati Manual, *Science, in Technology & Society*, Vol. 15(1), pp. 77-111.

HM Treasury (2012) *Quality in policy impact evaluation: understanding the effects of policy from other influences*, London, UK Gov.

Inter-American Council for Integral Development (CIDI) (2016) *Study for Theme 1: "Culture as an Engine for Economic Growth, Employment and Development"*, USA.

Nyaupane, Gyan P. PhD and Andereck, Kathleen L. PhD, "A TYPOLOGY OF CULTURAL HERITAGE ATTRACTION VISITORS" (2016). Travel and Tourism Research Association: Advancing Tourism Research Globally. 63. https://scholarworks.umass.edu/ttra/2007/Presented_Papers/63

Lagomarsino et al. (2011) Classification of cultural heritage assets and seismic damage variables for the identification of performance levels, *WIT Transactions on the Built Environment*, Vol 118, © 2011 WIT Press.

Michael J. Haslip Dominic F. Gullo (2017) *The Changing Landscape of Early Childhood Education: Implications for Policy and Practice*, Springer Science+Business Media New York 2017.

The CDIS thus facilitates the operationalization of the 2005 Convention and the United Nations 2030 Sustainable Development Agenda

Rahman, A. (2000), *Development of an Integrated Traditional and Scientific Knowledge Base: A Mechanism for Accessing, Benefit-Sharing and Documenting Traditional Knowledge for Sustainable Socio-Economic Development and Poverty Alleviation*, United Nations Conference on Trade and Development (UNCTAD), http://r0.unctad.org/trade_env/docs/rahman.pdf

Remoaldo, P., Cadima Ribeiro, J., Vareiro, L., Freitas Santos, J. (2014), "Tourists' perceptions of world heritage destinations: The case of Guimarães (Portugal)", *Tourism and Hospitality Research*, 14(4), 206-218.

Richards, G., Munsters, W. (ed.), (2010), *Cultural Tourism Research Methods*, Wallingford, Cab International.

Suchman, M. (1995). Managing legitimacy: Strategic and institutional approaches. *Academy of Management Review*, 20(3), 571–610.

Soresi et al., (2008) Career Guidance for Persons with Disabilities, *International Handbook of Career Guidance* (pp.405-417).

Timothy, D. (2011), Cultural heritage and tourism: An introduction, *Aspects of Tourism Texts*, 4, Bristol, Channel View Publications.

UNESCO Institute for Statistics (2010) *Measuring R&D: Challenges Faced by Developing Countries* Technical Paper No. 5 - <http://uis.unesco.org/sites/default/files/documents/measuring-rd-challenges-faced-by-developing-countries-2010-en.pdf>

UNESCO Institute for Statistics (2014) *Guide to Conducting R&D Survey: for Countries Starting to Measure Research and Experimental Development* Technical Paper No. 11
<http://uis.unesco.org/sites/default/files/documents/guide-to-conducting-an-rd-survey-for-countries-starting-to-measure-research-and-experimental-development-2014-en.pdf>

UNESCO Institute for Statistics (2017) *Summary Report of the 2015 UIS Innovation Data Collection* Information Paper No. 37 - <http://uis.unesco.org/sites/default/files/documents/ip37-summary-report-of-the-2015-uis-innovation-data-collection-2017-en.pdf>

UIS Fact Sheet No. 49/June 2018 <http://uis.unesco.org/sites/default/files/documents/fs49-human-resources-rd-2018-en.pdf>

UIS Fact Sheet No. 50/June 2018 <http://uis.unesco.org/sites/default/files/documents/fs50-global-investments-rd-2018-en.pdf>

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1. Боловсролын бодлогын жагсаалт, уялдаа

Excel файл: Educ Culture and Science Laws and Policy Docs Jan 28

ХАВСРАЛТ 2. Боловсролын үр нөлөөний тооцоонд багтах үзүүлэлтүүд

Ерөнхий боловсрол

Хүртээмж, оролцоо (access and participation) хүнд үйлчилгээ хүрч очиж чадаж байна уу гэдгийг харахдаа:

- Хүн амын суурьшил болон сургуулийн байршил
- Бага боловсролд хамрагдах ёстой бүх хүн амыг жигд хамруулж чадаж байгаа эсэх
- Дунд сургуульд тухайн насны хүүхдүүд бүрэн хамрагдаж чадаж байгаа эсэх
- Суурь боловсролд хамрагдах ёстой бүх хүн амыг жигд хамруулж чадаж байгаа эсэх

Тэгш боломж, бүхнийг багтаасан байдал (Inclusiveness and Equal opportunity) үүсгэж чадаж байна уу гэдгийг харахдаа:

- Хөгжлийн бэрхшээлтэй сургуулийн насны хэдэн хүүхэд тухайн орон нутагт байгаа, тэдэнд боловсролын үйлчилгээ хүргэж чадаж байгаа эсэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах орчин нөхцөл бүрдсэн эсэх
- Дотуур байранд амаьдрах хүсэлт гаргасан хүүхдүүдийг бүрэн хамруулж чадах хүчин чадал байгаа эсэх,

Боловсролын чанарыг (Quality) харахдаа орц болон дэд бүтэц талаасаа чанартай, орчин үеийн шаардалага хангасан, хүний эрхийг дээдэлсэн үйлчилгээ үзүүлэх нөөц бүрдэж үү гэдэг утгаар:

Орц:

- Багш, сурагчийн харьцаа
- Багшийн мэргэшил
- Бүлэг дүүргэлт
- Сургалтын зориулалттай интернэт холболт
- Ээлжийн ачаалал

Дэд бүтэц /Шийдэх асуудал байгаа эсэхээр харуулах:

- 1) Инженерийн шугам сүлжээ
 - Дулаан хангамж
 - Цэвэр усны хангамж
 - Ариутгах татуурга
- 2) Барилгын нөхцөл байдал

Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.Барилгын ажил нь дараахь төрөлтэй байна. Үүнд:

- 9.1.1. барилга байгууламж шинээр барих;
- 9.1.2. барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх;
- 9.1.3. барилга байгууламжийг засварлах, тоноглох;
- 9.1.4. буулгалтын ажил;
- 9.1.5. гадна талбайн тохижилт.

Эдгээрээс шинээр барих шаардлагатай эсэхийг харахдаа тухайн барилга анх баригдсан оноос хойш 60 жил ашиглахаар тооцож, харин их засварыг 15 жилээр тооцлоо.⁵¹ Харин өргөтгөх шаардлагатай эсэхийг өнөөгийн ачааллыг харуулах үзүүлэлтүүд болох

- Хүчин чадал ашиглалт
- Нэг ээлжээр хичээллэх боломж
- 2-р ээлж хүндэрсэн эсэх

гэсэн үзүүлэлтүүдийг ашиглаж дата шинжилгээгээ хийнэ.

Боловсролын үр дүн (Outcome) харахдаа:

- Нэг суралцагчид ногдох боловсролын төсөв жигд байгаа эсэх (их, бага гэхээсээ илүү жигд байх)
- Бага боловсролын төгсөх монгол хэлний шалгалтын "хангалттай" үнэлгээний эзлэх хувь /Онц, сайн, хангалттай/
- Дунд боловсролын төгсөх математикийн шалгалтын хангалттай үнэлэгдсэн хувь /A-D/
- Ахлах сургуульд хамрагсдын хувь
- Ерөнхий шалгалтын математикийн дундаж оноо
- Ерөнхий шалгалтын монгол хэлний дундаж оноо

Сургуулийн өмнөх боловсрол

Хүртээмж, оролцоо (access and participation) хүнд үйлчилгээ хүрч очиж чадаж байна уу гэдгийг харахдаа

- Цэцэрлэгийн байрлал болон хүн амын суурьшил
- 2-5 насны хүн амыг өдрөөр цэцэрлэгт хамруулж чадаж байгаа эсэх
- 2-5 насны хүн амыг сургуулийн өмнөх боловсролд хамруулж чадаж байгаа эсэх
- 1-р ангид элсэх хүүхдийн сургуулийн өмнөх боловсрол бүрэн хамруулж байгаа эсэх

Тэгш боломж (Inclusiveness and Equal opportunity) олгож чадаж байна уу гэдгийг харахдаа

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцдаг эсэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах орчин нөхөл бүрдсэн эсэх

Боловсролын чанарыг (Quality) харахдаа орц болон дэд бүтэц талаасаа чанартай, орчин үеийн шаардалага хангасан, хүний эрхийг дээдэлсэн үйлчилгээ үзүүлэх нөөц бүрдэж үү гэдэг утгаар:

Орц:

- Нэг багшийн ачаалал
- Нэг суралцагчид ногдох боловсролын төсөв жигд байгаа эсэх (их, бага гэхээсээ илүү жигд байх)

Дэд бүтэц /Шийдэх асуудал байгаа эсэхээр харуулах:

- 3) Инженерийн шугам сүлжээ
 - Дулаан хангамж
 - Цэвэр усны хангамж
 - Ариутгах татуурга
- 4) Барилгын нөхцөл байдал

Барилгын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.Барилгын ажил нь дараахь төрөлтэй байна. Үүнд:

⁵¹ БСШУСЯ-ны норматив

- 9.1.1. барилга байгууламж шинээр барих;
- 9.1.2. барилга байгууламжийг өргөтгөх, шинэчлэх;
- 9.1.3. барилга байгууламжийг засварлах, тоноглох;
- 9.1.5. гадна талбайн тохижилт.

ХАВСРАЛТ 3. Аймгуудын үзүүлэлтүүд

Excel файл:

Uzuuleltuud-Dornogovi Zaya
 Uzuuleltuud-Dundgobi Zaya
 Uzuuleltuud-Gobisumber Zaya
 Uzuuleltuud-Umnugobi Zaya

ХАВСРАЛТ 4. Хөгжлийн үзүүлэлтүүд дэх соёлын хэсгийг тооцох аргазүй

Хөгжилд хувь нэмэр оруулах соёлын үзүүлэлтүүдийг тооцоходоо дараах линкээр ЮНЕСКО-гийн хэвлэсэн гарын авлагыг ашигласан.

<https://en.unesco.org/creativity/files/cdis-methodology-manual>

Соёлын эдийн засагт оруулах хувь нэмрийг судлахдаа

- Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллын олон улсын стандарт (International Standard Industrial Classification of Economic Activities (ISIC Rev .4)
- Олон улсн ажил мэргэжлийн ангилал (ISCO - 08)- Ажил, Мэргэжлийн Ангилал ба Тодорхойлолт YAMAT-08 Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам Улаанбаатар. 2010 он
- Хувь хүний хэрэглээний ангилал (Classification of Individual Consumption According to Purpose)-(COICOP) зэрэг олон улсын стандартаас өөрийн улсад мөрддөг болон дүйцүүлж болох ангиллг сонгосон.

Excel файл: Culture development indicators

ХАВСРАЛТ 5. Төрийн үйлчилгээ

Excel файл: Public cultural service

ХАВСРАЛТ 6. Соёлын өв

Excel файл: Үл хөдлөх

Хөдлөх

Negtgel Intangibe

Говьсүмбэр 2017

Дорноговь 2017

Дундговь 2017

Өмнөговь 2013

ХАВСРАЛТ 7. Шинжлэх ухаан, технологи

Excel файл: Science and technology



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН



ТӨВИЙН БҮСИЙН ГОВИЙН ДЭД БҮСИЙН АЙМГУУДЫН
ХӨДӨЛМӨРИЙН САЛБАРЫН ХӨГЖИЛ, БАЙРШЛЫН
БОДЛОГЫН СУДАЛГАА

ЭЦСИЙН ТАЙЛАН

УЛААНБААТАР 2019

Хөдөлмөрийн салбарын хөгжил, байршлын судалгааны баг

Зөвлөх:

Ц.Цэцэгмаа, МУИС-ийн Бизнесийн сургууль, Менежментийн тэнхимийн профессор, доктор
Монгол Улсын Их Сургууль, Хичээлийн IV байр, Их сургуулийн гудамж-1,
Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот

Судлаач:

С.Цолмон, Мандах Их сургуулийн эдийн засаг, бизнесийн тэнхимийн эрхлэгч, доктор
Амарсанаагийн гудамж 18/1, Баянгол дүүрэг, 16-р хороо, Улаанбаатар хот

Энэхүү тайланд тусгасан дүгнэлт болоод санал зөвлөмжүүд нь Захиалагч болон санхүүжүүлэгчийн байр суурь бус, судлаачдын байр суурийг илэрхийлэх болно.

ТАЛАРХАЛ

Энэхүү тайланг боловсруулах явцад арга зүйн болоод мэргэжлийн үнэтэй зөвлөгөө өгсөн, шаардлагатай мэдээлэл, тоо баримт гарган өгч хамтран ажилласан дараах байгууллага, хувь хүмүүст судалгааны багийн зүгээс талархал илэрхийлж байна. Үүнд:

1. МУИС ЭЗХ-ийн захирал, доктор, профессор Х.Цэвэлмаа тэргүүтэй зөвлөх багийнхан
2. ҮХГ-ын салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын дарга Д.Эрдэнэбаяр, ахлах мэргэжилтэн Д. Мөнхсайхан болон бусад гишүүд
3. ҮСХ-ны Үндэсний тооцоо, шинжилгээ судалгааны газрын дарга А.Дэмбэрэл, ахлах статистикч Б.Баярмаа, хүн ам, орон сууцны тооллогын товчооны статистикч И.Цэрэндулам, ажиллах хүчний судалгааны албаны статистикч Б.Уламбадрах
4. ХНХЯ-ны ХЭБЗГ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга С.Дамбий, мэргэжилтэн Г. Пүрэвсүрэн, салбарын статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн Э. Цэрэнбат
5. Говьсүмбэр аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга Д.Гансүх, хамт олон
6. Дорноговь аймгийн ажлын хэсгийн нарийн бичгийн дарга А.Амгаланзаяа
7. Дундговь аймгийн ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ХОХБТХ-ийн дарга Н.Эрдэнэ-Очир, ХХҮГ-ын дарга Г.Хишигдаваа
8. Өмнөговь аймгийн ХХҮГ-ын дарга Должинсүрэн, ХНХБ-ын мэргэжилтэн Г.Өлзийбүрэн, ОНХА-ын мэргэжилтэн н.Батням
9. МУИС-ийн Ахисан түвшний сургалтын бодлогын газрын дарга, доктор Б.Энх-Амгалан
10. МУИС БС-ийн зөвлөх профессор, доктор Х.Телеу.

АГУУЛГА

1. ХУРААНГУЙ.....	7
2. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО	9
2.1. Үндэслэл, шаардлага	9
2.2. Судалгааны зорилго.....	9
2.3. Судалгааны зорилт.....	9
2.4. Судалгааны арга зүй.....	10
3. ГОВИЙН ДЭД БҮСИЙН АЙМГУУДЫН ХӨДӨЛМӨРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ	11
3.1. Говийн бүсийн аймгуудын хүн амын өсөлтийн төлөв байдал	11
3.2. Говийн дэд бүсийн аймгуудын хөдөлмөрийн салбарын үндсэн үзүүлэлтүүд	13
3.3. Говийн дэд бүсийн аймгуудын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт ба нийлүүлэлт.....	17
3.3.1. Ажлын байрны захиалга болон ажилд зуучлагдсан иргэд.....	17
3.3.2. Гадаад ажиллагчид	18
3.4. Салбар хоорондын балансад суурилсан ажиллах хүчний өөрчлөлт, хэрэгцээ	18
3.5. Говийн дэд бүсийн аймагт баригдах ЖДҮ-д шаардагдах ажиллах хүчний хэрэгцээ	23
3.6. Говийн дэд бүсийн аймагт баригдах ЖДҮ-д шаардагдах ажиллах хүчний эрэлт ба нийлүүлэлтийн төлөв байдал.....	26
3.7. Хөдөлмөрийн салбарын хөгжлийн олон улсын чиг хандлага	26
3.7.1. Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлтийн чиг хандлага	27
3.7.2. Ажлын байрны өөрчлөлтийн чиг хандлага	27
3.7.3. Ажил мэргэжлийн өөрчлөлтийн чиг хандлага.....	28
3.7.4. Ажиллагчдын ур чадварын өөрчлөлтийн хандлага.....	28
4. ТӨВИЙН БҮСИЙН ГОВИЙН ДЭД БҮСИЙН ДӨРВӨН АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН УЯЛДАА, НИЙЦЛИЙН СУДАЛГАА.....	29
4.1. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа.....	29
4.2. Дорноговь аймгийн хөгжлийн бодлогын голлох баримт бичгүүдийн хөдөлмөрийн салбарынхтай уялдаж буй байдал	30
4.3. Говьсүмбэр аймгийн хөгжлийн бодлогын голлох баримт бичгүүдийн хөдөлмөрийн салбарынхтай уялдаж буй байдал	30
4.4. Дундговь аймгийн хөгжлийн бодлогын голлох баримт бичгүүдийн хөдөлмөрийн салбарынхтай уялдаж буй байдал	31
4.5. Өмнөговь аймгийн хөгжлийн бодлогын голлох баримт бичгүүдийн хөдөлмөрийн салбарынхтай уялдаж буй байдал	31
4.6. Бодлогын баримт бичгүүд дэх хөдөлмөрийн салбартай холбоотой шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийн байдал, цаашдын төлөв.....	32
4.7. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан шалгуур үзүүлэлтүүдийн төлөв байдал	34
5. СУДАЛГААНЫ ҮР ДҮН	35
6. НЭГДСЭН ДҮГНЭЛТ	37
7. НЭГДСЭН САНАЛ, ЗӨВЛӨМЖ	40
8. АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ЭХ СУРВАЛЖУУД.....	43
9. ХАВСРАЛТ	44
Хавсралт 1. Хөдөлмөрийн салбартай хамааралтай бодлогын үндсэн баримт бичгүүд.....	44
Хавсралт 2. Хөдөлмөрийн салбарт хамааралтай ОУ-ын конвенци, холбогдох хуулийн жагсаалт.....	46
Хавсралт 3. Хөдөлмөрийн салбартай хамаарал бүхий Хөгжлийн бодлогын үндсэн баримт бичгүүдэд байршилтай холбоотой заалтуудын товъёо.....	47

Хавсралт 4. Нийт 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоонд эзлэх хувь, эдийн засгийн салбараар	48
Хавсралт 5. 15-аас дээш насны ажиллагчдын тооны өөрчлөлт, ЭЗ-ийн салбараар, 2010-аас 2017 он.	49
Хавсралт 6. ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалингийн өсөлт, 2007-оос 2017 он, мянган төгрөг	49
Хавсралт 7. Монгол улсын нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоонд тухайн аймгийн эзлэх хувь	50
Хавсралт 8. Ажилгүйдлийн түвшин, хувиар, хүйсийн ангилалаар, 1997, 2007, 2017 он.	50
Хавсралт 9. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, хувиар, 1997-оос 2017 он.....	50
Хавсралт 10. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хүйсээр, хувиар, 1997-оос 2017 он.....	51
Хавсралт 11. Говийн бүсийн аймгуудын ажилгүй иргэдийн тоо, улсын дүнд эзлэх хувь, насны бүлгээр	51
Хавсралт 12. Говийн аймгуудын ажилгүй иргэдийн тооны өөрчлөлт, насны бүлгээр, 2009, 2013, 2017 он.....	51
Хавсралт 13. Ажилд зуучлагдсан иргэд, ажил мэргэжлийн ангиллаар (хүн), 2015-2017	52
Хавсралт 14. Ажилд зуучлагдсан иргэд, ажил мэргэжлийн үндсэн ангиллаар, 2015-2017	53
Хавсралт 15. Говийн дэд бүсийн аймагт баригдах ЖДҮ-д шаардагдах ажиллах хүчний хэрэгцээ, нийлүүлэлтийн төлөв байдлын матриц	54
Хавсралт 16. Говийн дэд бүсийн аймагт баригдах ЖДҮ-д шаардагдах ажиллах хүчний хэрэгцээ.....	59
Хавсралт 17. Хөдөлмөрийн салбартай холбоотой бодлогын баримт бичгийн судалгааны арга зүйн схем	62
Хавсралт 18. Аймгуудын хөгжлийн бодлого нь үндэсний хэмжээний бодлогуудтай уялдаж буй байдал	63
Хавсралт 19. Аймгийн хөгжлийн төлөвлөгөө МУЗГ болон хүн ам, хөдөлмөрийн салбарын бодлоготой уялдаж буй байдал.....	64
Хавсралт 19.1. Дорноговь аймгийн хөгжлийн бодлогын голлох баримт бичгүүд дэх хөдөлмөрийн салбартай холбоотой зорилтуудын уялдаа	65
Хавсралт 19.2. Дорноговь аймгийн хөгжлийн бодлогууд болон хөдөлмөрийн салбарт хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрүүдийн уялдаа	66
Хавсралт 19.3. Дорноговь аймгийн хөгжлийн бодлогууд нь үндэсний болоод бүсийн хэмжээний бодлогуудтай уялдаж буй байдал	68
Хавсралт 20. Хөдөлмөрийн салбарын орцууд.....	69
Хавсралт 21. Хөдөлмөрийн салбарын шалгуур үзүүлэлтүүд	70
Хавсралт 22. ТХЗ-той хамаарал бүхий зохистой хөдөлмөрийн үзүүлэлтүүдийн төлөв байдал.....	70

ЗУРАГ, ХҮСНЭГТ БОЛОН ТӨВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Говийн бүсийн аймгуудын хүн амын өсөлтийн 2030 он хүртэлх төсөөлөл, хувиар	11
Зураг 2. Монгол улсын нийт хүн амд говийн дэд бүсийн аймгуудын хүн амын эзлэх хувь	11
Зураг 3. Аймгуудын хүн амын шилжилт хөдөлгөөнд гарч буй өөрчлөлт, сүүлийн 10 жилээр.....	12
Зураг 4. Говийн аймгуудын хүн амын нягтрал болон ачаалал, хувиар	12
Зураг 5. 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын улсын нийт дүнд аймгуудын эзлэх хувь	13
Зураг 6. Говийн аймгуудын 15-аас дээш насны ажиллагчдын тооны 2010-2018 оны өөрчлөлт.....	13
Зураг 7. Өмнөговь аймгийн 15-аас дээш насны ажиллагчдын тооны 2010-2018 оны өөрчлөлт.....	14
Зураг 8. ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин, 2001, 2009, 2017 оноор, мян төгрөг	15
Зураг 9. Ажилгүйдлийн түвшин, хувиар, аймаг тус бүрийн 1992-оос 2017 оны үзүүлэлт.....	15
Зураг 10. Говийн дэд бүсийн аймгуудын бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр	16

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 15-аас дээш насны ажиллагчдын тоонд тухайн салбарт ажиллагчдын эзлэх хувь.....	14
Хүснэгт 2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн өөрчлөлт, 2007-оос 2017 он.	16
Хүснэгт 3. Зорилтот аймгуудын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, 2016-2018 он.	17
Хүснэгт 4. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд, хүнээр	18
Хүснэгт 5. Ажиллах хүчний өсөлтөд хөрөнгө оруулалтын үзүүлэх нөлөө /Үржүүлэгчээр/	19
Хүснэгт 6. Тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний дараах ажил эрхлэлтийн өөрчлөлт.....	20
Хүснэгт 7. Говьсүмбэр аймгийн салбарын тэнцэлд суурилсан ажил эрхлэлтийн үржүүлэгч.....	21
Хүснэгт 8. Дорноговь аймгийн салбарын тэнцэлд суурилсан ажил эрхлэлтийн үржүүлэгч.....	21
Хүснэгт 9. Дундговь аймгийн салбарын тэнцэлд суурилсан ажил эрхлэлтийн үржүүлэгч	22
Хүснэгт 10. Өмнөговь аймгийн салбарын тэнцэлд суурилсан ажил эрхлэлтийн үржүүлэгч.....	22
Хүснэгт 11. Говийн дэд бүсийн аймгуудад барих боломжтой сүүний цехийн тоо	23
Хүснэгт 12. Говийн дэд бүсийн аймгуудад барих боломжтой сүүний цехийн тоо	23
Хүснэгт 13. Сумын ҮТП-д жишээ авсан Архангай аймийн 5 сумын статистик, 2013 он	24
Хүснэгт 14. Архангай аймгийн 5 сумын дунд баригдах жишиг ҮТП-ийн тооцоолол, 2013 оноор.....	24
Хүснэгт 15. Говийн дэд бүсийн аймгуудад барих боломжтой ЖДҮ-д шаардагдах ажлын байр	25
Хүснэгт 16. Говийн дэд бүсийн аймгуудад барих боломжтой ЖДҮ-ийг барихад шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, сая төг	25
Хүснэгт 17. Ажилгүйдлийн түвшний зорилтот түвшин болон гүйцэтгэл, хувиар.....	32
Хүснэгт 18. Ажиллах хүчний оролцооны түвшний зорилтот түвшин болон гүйцэтгэл, хувиар.....	33
Хүснэгт 19. Хөдөлмөр эрхлэлтийн түвшний зорилтот түвшин ба гүйцэтгэл /албан/, хувиар	33

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ТХҮЗ - Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
ТХЗ – Тогтвортой хөгжлийн зорилго
БХҮЗ – Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал
ТХЭТББ – Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого
МУГЗ - Монгол улсын Засгийн газар
МХЗ – Мянганы хөгжлийн зорилтууд
МБСБ – Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МСҮТ –Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
ЗГҮАХ – Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ААНБ – Аж ахуйн нэгж, байгууллага
ХЗЗ – Хөдөлмөрийн зах зээл
ЖДҮ – Жижиг дунд үйлдвэр
ХЭТ – Хөдөлмөр эрхлэлтийн түвшин
ҮСХ – Үндэсний статистикийн хороо
ӨГ- Өмнөговь
ДоГ-Дорноговь
ГС-Говьсүмбэр;
ДуГ-Дундговь

1. ХУРААНГУЙ

Хөдөлмөрийн салбарын хөгжил, байршлын бодлогын судалгааны баг нь Төвийн бүсийн Говийн дэд бүсийн дөрвөн аймгийн хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, үндэсний болоод бүс, салбарт хамааралтай урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд нь аймгуудынхтай хэр уялдаж байгааг гарган, дүгнэлт, санал зөвлөмж гаргасан болно.

Аймгуудын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлохдоо хүн амын өсөлтийн ирээдүйн төлөв байдал; хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтүүд (15-аас дээш насны ажиллагчид, ЭЗИХА, ажиллагчид, ажилгүй иргэд, ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, ажилгүйдлийн түвшин, ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалингийн өөрчлөлтийг сүүлийн 10 жилээр); хөдөлмөрийн зах зээлийн эрэлт ба нийлүүлэлт; ажиллах хүчний өөрчлөлт ба хэрэгцээ; хөдөлмөрийн салбарын хөгжлийн олон улсын чиг хандлага зэргийг авч үзсэн.

Монгол улсын хүн ам сүүлийн 26 жилд 5.6 хувиар өссөн бол говийн дэд бүсийн аймгуудын хувьд 1 орчим хувиар өсчээ. Үүнээс Дорноговь аймгийн хүн амын тооны дундаж өөрчлөлт 1.7 хувь, Дундговь аймаг - 0.5 хувь, Өмнөговь аймаг 1.8 хувь, Говьсүмбэр аймаг 1.6 хувийн өөрчлөлттэй байна. Монгол улсын нийт хүн амд говийн аймгуудын хүн амын эзлэх хувь жилээс жилд буурсаар байна.

Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлыг 2007-2017 оноор харьцуулсан өөрчлөлт зорилтот аймгуудын хувьд харилцан адилгүй байна. **Говьсүмбэр** аймгийн хувьд ЭЗИХА болоод ажиллагчдын тооны өсөлтийн дундаж хурд өндөр, ажиллах хүчний оролцооны болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин өссөн, харин дундаж цалин улсын дунджаас 7.4 хувиар доогуур, 2017 оны байдлаар ажилгүйдлийн түвшин улсын дунджаас 1 пунктээр бага байна. **Дорноговь** аймгийн хувьд мөн ажиллах хүчний оролцоо болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин өссөн, дундаж цалин улсын дунджаас 11 хувиар бага байна.

Дундговь аймгийн хувьд говийн аймгууд дотроос сүүлийн 10 жилийн байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин болоод ажилгүйдлийн түвшний өөрчлөлт хамгийн бага, ажилгүйдлийн түвшин бага (4.4), харин сарын дундаж цалингийн хэмжээ улсын дунджаас эрс доогуур (32.2 хувь) байна. **Өмнөговь аймгийн хувьд** говийн аймгууд дотроос сарын дундаж цалингийн түвшин өндөр, орон нутгийн түвшинд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр олон дэд хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа зэрэг давуу талуудтай боловч ажиллах хүчний оролцооны болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин буурч, 2017 оны ажилгүйдлийн түвшин (16.4)-г улсынхтай харьцуулахад өндөр (1.86 дахин) байна.

Говийн дэд бүсийн хувьд хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдал алдагдаж, нийлүүлэлтийн хомсдол аймаг бүрт байгаагийн зэрэгцээ ажлын байр ашиглалтын түвшин буурч байна.

Ажиллах хүчний өөрчлөлт ба хэрэгцээг тооцохдоо ҮСХ-ноос гаргасан 2016 оны салбар хоорондын тэнцэл(20x20)-д тулгуурлан улсын хэмжээний салбар хоорондын баланс дахь ажил эрхлэлтийн үржүүлэгчийг тооцоолсон. Тооцооллын үр дүнгээс харахад, улсын хэмжээнд ажил эрхлэлтийн үржүүлэгч хамгийн өндөртэй салбарууд нь ХАА; бусад үйл ажиллагаа; үйлчилгээ зэрэг салбарууд байгаа бол уул уурхай, олборлолт; үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа; мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа зэрэг салбарууд нь хөдөлмөрийн үржүүлэгч хамгийн багатай гарсан байна. Харин өөр салбарт ажил эрхлэлтийг хамгийн ихээр бий болгож буй салбаруудад боловсруулах үйлдвэрлэл, байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа, барилга орж байна.

Улсын хэмжээнд эдийн засгийн 20 салбар тус бүрд 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхэд шуудаар байдлаар 1061, шууд бусаар 207, нийтдээ 1268 ажлын байр шинээр нэмэгдэхээр байна.

Мөн говийн дэд бүсийн аймгуудын салбар хоорондын тэнцэл (9х9)-ийг гаргах анхны оролдлого хийж, түүнд суурилсан ажил эрхлэлтийн үржүүлэгчийг аймаг бүрээр тооцсон.

2014 онд Эдийн засгийн хөгжлийн яам (ЭЗХЯ, хуучнаар)-наас боловсруулсан “Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөө”-ний жишиг ТЭЗҮ-д үндэслэн зорилтот аймаг бүрийн холбогдох нөөцийг тооцох байдлаар говийн дэд бүсэд ХАА, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр ирээдүйд баригдах ЖДҮ-ийн тоо, тэдгээрт шаардагдах ажиллах хүчний хэрэгцээг тооцоолсон. Эндээс харахад, говийн дэд бүсийн аймгуудад мал аж ахуй, газар тариалан, худалдаа, хүнс, оёдол, модон эдлэл зэрэг 17 чиглэлээр нийтдээ 127 бичил эсхүл ЖДҮ баригдах боломжтой, тэдгээрт ойролцоогоор 20,76 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдахаар байна. Энэ хөрөнгө оруулалтыг хийвэл, шууд байдлаар 1870 хүн ажлын байртай болохоос гадна шууд болон шууд бусаар 6200 гаруй хүн ирээдүйд баригдах үйлдвэрээс ямар нэг хэмжээгээр эдийн засгийн өгөөж хүртэхээр байна.

Ирээдүйд хэрэгцээтэй байгаа ажиллах хүчний 80 гаруй хувийг тухайн орон нутгийн хөдөлмөрийн зах зээл болон МСҮТ-ээр бэлтгэх боломжтой байгаа бөгөөд хөнгөн болон хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр инженер, технологичид болоод мэргэжлийн ажилчид бэлтгэхэд анхааран бодлогоор дэмжих шаардлагатай байна.

Бид үндэсний, бүс, аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоог гаргахдаа тэдгээрийн зорилго, зорилтууд агуулгын хувьд хөдөлмөрийн салбарт хэрэгжиж буй бодлоготой хэр нийцэж байгааг гурван түвшнээр гаргасан: Зорилтот аймгуудын хөгжлийн бодлогын баримт бичиг нь үндэсний болоод бүсийнхтэй; Аймгуудын хөгжлийн бодлого, төлөвлөгөө нь МУЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, хүн ам болоод хөдөлмөрийн салбарын бодлоготой; Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд хөдөлмөрийн салбарт хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд, дэд хөтөлбөрүүдтэй уялдаж буй байдал.

Аймгуудын хөгжлийн бодлогын баримт бичгүүд МХЗ-д суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгасан хөдөлмөрийн салбартай холбоотой зорилтуудын нийцлийн түвшин аймгуудын нэгтгэлээр авч үзэхэд, 81.2 хувь, ТХҮЗ-2030-ийг 72.2 хувь, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалынх 54.2 хувь байна. МУЗГ-ын мөрийн хөтөлбөр болоод төрөөс хүн ам болоод хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлоготой уялдаж байгаа нийцлийн ерөнхий хувь 68.5 хувь байна. Өмнөговь аймгийн хувьд Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлоготой нийцлийн хувь хамгийн өндөр 81.3%, харин хамгийн бага нийцлийн хувьтай нь Дундговь аймаг (56.3 %) байна. Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон хөдөлмөрийн салбарт хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүд хоорондын уялдаа Говьсүмбэрээс бусад аймагт харьцангуй сайн байна.

Үүнээс гадна хөгжлийн бодлогын баримт бичгүүд дэх хөдөлмөрийн салбартай хамаарал бүхий шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийн байдлыг гаргаж, цаашид 2020 оны зорилтот түвшинд хүрэхэд ажиллах хүчний оролцооны болон хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах, ажиллах хүчний оролцоо болоод хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр дүн, нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

2. СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО

2.1. Үндэслэл, шаардлага

Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон бүсүүдийн хөгжлийн хөтөлбөрийг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдуулан шинэчлэн боловсруулахад Төвийн бүсийн Говийн дэд бүсэд Хөдөлмөрийн салбарын хөгжил, байршлын өнөөгийн байдал, салбарын харилцааг зохицуулах эрх зүйн орчин, бодлого, хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийх, цаашдын төлөвлөлтийн үндэслэлийг гаргах шаардлага байна.

Хүн амын шилжилт хөдөлгөөн, хэт төвлөрлийг сааруулах, сумын төв, хөдөөгийн хүн амыг орон нутагтаа тогтвортой амьдрах нөхцөлийг бүрдүүлэн ажлын байраар тогтвортой хангах ажлыг зохион байгуулах шаардлагатай байна. Үүний тулд орон нутгийн нөөцөд түшиглэсэн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, түүнд хөрөнгө оруулалт хийх замаар шинээр ажлын байр бий болгох, ажилгүйдэл болон ядуурлыг бууруулах, тэдгээрт шаардлагатай ажиллах хүчний хэрэгцээг тооцон гаргах, хангах эс үүсвэрийг тодорхойлох болоод сургаж бэлтгэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар төлөвлөн зохион байгуулах шаардлагатай байна.

2.2. Судалгааны зорилго

Төвийн бүсийн говийн дэд бүсийн аймгуудын хөдөлмөрийн зах зээл болоод ажиллах хүчний ашиглалтын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх болоод хөдөлмөрийн салбарт хэрэгжиж буй хууль, бодлогын хэрэгжилтийг үндэсний, бүсийн, аймгийн түвшний хөгжлийн бодлогын баримт бичгүүд хоорондын уялдаа холбоо гарган зорилтот аймгуудын хувьд тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлж, нэгдсэн дүгнэлт, санал зөвлөмж боловсруулахад оршино.

2.3. Судалгааны зорилт

Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдал, хөгжлийн бодлогын баримт бичгүүд үндэсний, бүсчилсэн хөгжлийн болон хөдөлмөрийн салбарт одоо мөрдөгдөж буй хууль, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, уялдаа холбоо, зорилт зэрэгт дараах чиглэлээр шинжилгээ хийв. Үүнд:

- a) Үндэсний, говийн дэд бүсийн аймгуудын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийх;
- b) Салбар хоорондын балансыг ашиглан ажиллах хүчний өөрчлөлт, хэрэгцээг тооцох
- c) Орон нутгийн нөөцөд түшиглэсэн ХАА, хөнгөн үйлдвэрийн салбарт говийн аймгуудад ирээдүйд баригдах боломжит ЖДҮ-ийн тоо, түүнд шаардагдах ажиллах хүчний хэрэгцээг тооцон нийлүүлэлтийн төлөв байдлыг тодорхойлох
- d) Хөдөлмөрийн салбарын хөгжлийн олон улсын хандлагыг судлах
- e) Аймгуудын хөгжлийн мастер төлөвлөгөө/цогц бодлого үндэсний болоод бүсийн хэмжээний хууль, хөгжлийн бодлогын баримтууд хоорондын уялдаа, хэрэгжилтийг хөдөлмөрийн салбараар харьцуулан судлах;
- f) Аймгуудын хөгжлийн төлөвлөгөө МУЗГ болон хүн ам, хөдөлмөрийн салбарын бодлоготой уялдаж буй байдлыг бодлогуудын зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин/хүрэх үр дүнгийн хэрэгжилтийн байдалд шинжилгээ хийх;
- g) Говийн дэд бүсийн аймгуудын хөгжлийн бодлогын голлох баримт бичгүүдээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээнүүд нь хөдөлмөрийн салбарт хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүдтэй хэрхэн уялдаж байгааг харьцуулан судалж, дүн шинжилгээ хийх.
- h) Нэгдсэн дүгнэлт гаргах, санал зөвлөмж боловсруулах.

2.4. Судалгааны арга зүй

Ажлын даалгаврын хүрээнд өгөгдсөн нөхцөл байдлын дүн шинжилгээг хийхдээ “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 4-д заасан “Нөхцөл байдлын дүн шинжилгээ”-ний арга зүйд тулгуурлахаас гадна Германы Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас боловсруулсан “Хөдөлмөрийн зах зээл болон Хөдөлмөр эрхлэлтийн дүн шинжилгээ хийх” аргачлал¹ болоод тоон шинжилгээ, контент анализ, баримт бичиг судлах, түүхэн ба логик, харьцуулалтын аргуудыг ашигласан.

Үүнээс гадна орон нутагт баригдах үйлдвэрийн тоо, ажиллах хүчний хэрэгцээг тодорхойлохдоо Эдийн засгийн хөгжлийн яам (ЭЗХЯ, хуучнаар)-наас 2014 онд боловсруулсан “Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөө”-ний жишиг ТЭЗҮ-г ашигласан болно.


¹ Guidelines for an Employment and Labour Market Analysis (ELMA) published by GIZ, 2014.
http://www2.giz.de/wbf/4tDx9kw63gma/201403_Guidelines_Employment%20Analysis_ELMA_Final_web.pdf

3. ГОВИЙН ДЭД БҮСИЙН АЙМГУУДЫН ХӨДӨЛМӨРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

3.1. Говийн бүсийн аймгуудын хүн амын өсөлтийн төлөв байдал

Монгол улсын хүн ам 2017 онд 3.2 саяд хүрсэн нь сүүлийн 82 жилд ойролцоогоор 4.3 дахин өссөн буюу 1935 оноос хойш жилд дунджаар 4 орчим хувиар өсчээ. Харин 1991 оноос хойш улсын хэмжээний болон аймгуудын шилжих хөдөлгөөн, хүн ам зүйн бүтцэд ихээхэн өөрчлөлт орсон байна. Өөрөөр хэлбэл, 1991-ээс 2017 онд /сүүлийн 26 жилд/ Монгол улсын хүн ам жилд дунджаар 5.6 хувиар өссөн бол говийн дэд бүсийн аймгуудын хувьд 1 орчим хувиар өсчээ. Үүнээс Говьсүмбэр аймгийн хүн амын тооны дундаж өөрчлөлт 1.6 хувь, Дорноговь 1.7 хувь, Дундговь аймаг - 0.5 хувь, Өмнөговь аймгийнх 1.8 хувийн өөрчлөлттэй байна (Зураг 1).


Зураг 1. Говийн бүсийн аймгуудын хүн амын өсөлтийн 2030 он хүртэлх төсөөлөл, хувиар



Тайлбар: *Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хүн амын хувьд тооцсон хүн амын тоо, хүйс, насны бүлэг, аймаг, нийслэлээр, дунд хувилбар 1Б, 2015-2030 он

Монгол улсын нийт хүн амд эзлэх хувь говийн дэд бүсийн хүн амын тоо жилээс жилд буурсаар байна. Тухайлбал, нийт хүн амд Дундговь аймгийн хүн амын эзлэх хувь 1990 онд 2.4 хувь байсан бол 2000 онд 2.1 хувь, 2010 онд 1.4 хувь болж буурчээ. Цаашид энэ хувь хэмжээ 2020 онд 1.4 хувь, 2030 онд 1.3 хувь, 2040 онд 1.2 хувь болж буурах төлөвтэй байна. Харин бусад аймаг, бүсүүдийн хувьд тус хувь хэмжээ харьцангуй өндөр үзүүлэлттэй байна.


Зураг 2. Монгол улсын нийт хүн амд говийн дэд бүсийн аймгуудын хүн амын эзлэх хувь



Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол

Говийн дэд бүсийн аймгуудад шилжин ирсэн /ШИ/ болон явсан /ШЯ/ хүн амын тооноос харвал, сүүлийн 10 жил буюу 2008-2017 онд илүү шилжин явалтын түвшин илүү өндөр байна. Тухайлбал, Өмнөговь аймгийн хувьд тус хугацаанд нийт 784 хүн шилжин ирж, 1660 хүн шилжин явсан тул шилжин явалтын түвшин 2.17 гарчээ.

Зураг 3. Аймгуудын хүн амын шилжилт хөдөлгөөнд гарч буй өөрчлөлт, сүүлийн 10 жилээр



Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол

Судалгаанд хамрагдсан 4 аймаг, 47 сумын буюу говийн дэд бүсийн хүн амын нягтралын дундаж нь 2.7 хувь байгаа нь улсын дундаж болох 2.0 хувиас 0.7 пунктээр өндөр байна. Харин хүн амын ачаалал 50.3 хувь байгаа нь улсын дундаж болох 50.8 хувьтай ойролцоо гарчээ. Хүн амын нягтрал хамгийн өндөртэй орон нутгууд нь Өмнөговь аймгийн төв Даланзадгад (50.5 хувь), Замын үүд (36.0 хувь), Сүмбэр (14.4 хувь), Сайншанд (10.3 хувь) зэрэг сумд байна (Зураг 3).

Зураг 4. Говийн аймгуудын хүн амын нягтрал болон ачаалал, хувиар




Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол

3.2. Говийн дэд бүсийн аймгуудын хөдөлмөрийн салбарын үндсэн үзүүлэлтүүд

Монгол улсын хэмжээнд 2017 онд 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо 1238.3 мянгад хүрсэн нь 1991 онтой харьцуулахад 1.57 дахин өссөн үзүүлэлт юм. Харин Монгол улсын 15 ба түүнээс дээш насны хүн амд говийн бүсийн аймгуудын эзлэх хувь хэмжээ сүүлийн 27 жилд дунджаар 7.2 хувь байгаагаас гадна 2001 оноос хойш буурах төлөв ажиглагдаж байна. Энэхүү хувь хэмжээг аймаг тус бүрээр авч үзвэл, 2017 онд Дорноговь аймаг 2.5 хувь, Өмнөговь аймаг 2.0 хувь, Дундговь аймаг 1.8 хувь, Говьсүмбэр аймаг 0.6 хувьтай гарчээ (Зураг 5).


Зураг 5. 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын улсын нийт дүнд аймгуудын эзлэх хувь



Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол

Сүүлийн 8 жилд буюу 2010 оны 4-р улирлаас 2018 оны 4-р улирлын хооронд 15 ба түүнээс дээш насны хүн амын тооны өөрчлөлтийг Монгол улсын хэмжээнд болон говийн дөрвөн аймгуудаар харьцуулан судлав. Тус хугацаанд улсын хэмжээнд 15-19, 20-24 насны хүн амын тооны өөрчлөлт тус бүр 4.6%, 26.7%-иар буурсан бол 25 ба түүнээс дээш насны хүн амын тоо дийлэнх аймагт өссөн байна (Зураг 6). Дэлгэрэнгүйг хавсралт 4-д оруулав.


Зураг 6. Говийн аймгуудын 15-аас дээш насны ажиллагчдын тооны 2010-2018 оны өөрчлөлт



Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол

Говийн аймгуудаас 29 хүртэл насны хүн ам хамгийн их буурч, 30-аас дээш хүн амын тоо хамгийн ихээр өссөн нь Өмнөговь аймаг байна. Өөрөөр хэлбэл, тус аймгийн хувьд ойрын ирээдүйд хөдөлмөрийн насны хүн амын тоо буурч, тэтгэврийн насны хүн амын тоо өсөх төлөвтэй байгааг илэрхийлж байна (Зураг 7).

Зураг 7. Өмнөговь аймгийн 15-аас дээш насны ажиллагчдын тооны 2010-2018 оны өөрчлөлт



Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол


2017 оны байдлаар, Монгол улс дахь 15 ба түүнээс дээш насны хүн амд, тухайн аймгуудын эзлэх хувь хэмжээнээс үзвэл Дорноговь аймаг 2.5 хувь, Өмнөговь аймаг 2.0 хувь, Дундговь аймаг 1.8 хувь эзэлж байгаа бол Говьсүмбэр аймгийн хувьд 0.6 хувийг бүрдүүлж байна. Харин эдийн засгийн салбараар аваад үзвэл, Өмнөговь аймгийн хувьд хамгийн их хувь нь уул уурхайн салбарт (6.3 хувь) ажиллаж байна (Хавсралт 4).

Хүснэгт 1. 15-аас дээш насны ажиллагчдын тоонд тухайн салбарт ажиллагчдын эзлэх хувь

Эзийн засгийн салбарууд	Улс	Бүс	ГС	ДоГ	ӨГ	ДуГ
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	28.8	38.5	16.9	35.9	34.1	53.9
Уул уурхай, олборлолт	4.2	6.4	10.8	3.7	12.9	1.5
Боловсруулах үйлдвэрлэл	7.5	4.0	2.8	3.7	4.2	4.5
Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	1.4	2.2	4.3	2.7	1.8	1.2
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент	0.4	0.5	0.3	0.4	0.2	0.9
Барилга	5.7	1.7	1.3	2.2	1.8	1.2
Бөөний, жижиглэн худалдаа, машин засвар, үйлчилгээ	16.5	13.2	12.5	13.3	14.7	11.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	5.9	6.8	13.1	11.4	2.6	3.1
Зочид буудал, байр, сууц, нийтийн хоолны үйлчилгээ	2.9	2.2	4.0	2.1	2.0	2.1
Мэдээлэл, холбоо	1.2	1.0	1.6	1.7	0.8	0.0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1.9	1.7	2.2	1.6	1.7	1.7
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Мэргэжлийн шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа	1.0	0.6	0.6	0.5	0.8	0.5
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	1.7	0.7	0.3	0.9	0.8	0.3
Төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгэм хамгаалал	6.6	6.9	12.1	6.8	7.1	5.1
Боловсрол	8.0	8.0	9.7	7.0	9.2	7.3
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	3.2	3.0	3.4	3.8	2.0	3.2
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	0.8	1.0	2.2	0.5	1.1	1.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	1.8	1.5	1.8	1.7	2.1	0.5
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.2	0.2	0.0	0.3	0.2	0.0
ОУ-н байгууллага суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.1	0.0	0.0	0.0	0.0	0.0

Сүүлийн 7 жилийн хугацаанд буюу 2010 оноос хойш говийн бүсийн аймгуудын 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо хамгийн их өсөлттэй байсан салбарууд нь хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа (149.1 хувь), урлаг, үзвэр, тоглоом, наадам (59.0 хувь), мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа (58.3 хувь) зэрэг салбарууд байна. Харин тус хугацаанд хамгийн их буурсан салбар нь олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагааны салбар байна. Өөрөөр хэлбэл, тус салбарт 2010 онд нийт 183 хүн ажиллаж байсан (Дорноговьд 51 хүн, Өмнөговьд 132 хүн) бол 2017 онд говийн 4 аймагт тухайн салбарт нэг ч хүн ажиллаагүй байна (Хүснэгт 1).

Зураг 8. ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалин, 2001, 2009, 2017 оноор, мян төгрөг



Эх сурвалж. Үндэсний статистикийн хороо

2007-2017 оны хооронд буюу сүүлийн 10 жилд Дорноговь, Өмнөговь, Говьсүмбэр аймгуудын цалингийн дундаж өсөлт харьцангуй өндөр байгааг уул уурхайн салбарын хөгжилтэй холбон тайлбарлаж болох юм. ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалинг улсынхтай харьцуулахад Өмнөговь аймгийнх дээгүүр (харьцуулсан оноор харгалзан 2.7 мян.₮, 51.9 мян. ₮, 31.6 мян.₮) байхад Дундговийн хувьд харьцангуй доогуур (харьцуулсан оноор харгалзан 8.9 мян.₮, 24.5 мян. ₮, 304.6 мян.₮) байна. Ялангуяа 2017 онд улсын дунджаас 32.2 хувиар бага байна. Улс болоод говийн аймгуудын ажилгүйдлийн түвшин 2008 он хүртэл буурах төлөвтэй байсан ч 2009 онд дунджаар 7 орчим пунктээр өсчээ. Харин 2009 оноос хойш дийлэнх аймгийн ажилгүйдлийн түвшин буурах төлөвтэй байгаа ч Өмнөговь аймгийн ажилгүйдлийн түвшин 2013 оноос өссөн байна (Зураг 9).


Зураг 9. Ажилгүйдлийн түвшин, хувиар, аймаг тус бүрийн 1992-оос 2017 оны үзүүлэлт



Ажилгүй байгаа иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл, 20-оос 49 хүртэлх насны иргэд хамгийн их ажилгүй байна. Мөн говийн дэд бүсийн аймгууд дахь ажилгүй иргэдийн улсын нийт ажилгүй иргэдийн

тоонд эзлэх хувийг насны бүтцээр нь авч үзвэл, 40-өөс дээш насны иргэд хамгийн их хувийг бүрдүүлж байна. 2018 оныг 2008 онтой харьцуулбал говийн дэд бүсийн аймгуудын бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоонд 25-аас 34 насны залуучуудын эзлэх хувь 26.8 хувиар өссөн бол 35-аас дээш насны ажилгүй иргэдийн тоо 54 хувиар өсчээ (Зураг 10).

Зураг 10. Говийн дэд бүсийн аймгуудын бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлгээр



Говийн дэд бүсийн аймгуудын хөдөлмөрийн салбарын үзүүлэлтүүд улсын нэгдсэн дүнтэй харьцуулбал ажиллах хүчний оролцооны түвшин болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин нь тус бүр 10 болон 8.9 хувиар өндөр байгаа ч ажилгүйдлийн түвшин нь улсын дүнгээс 0.3 пунктээр бага гарчээ. Сүүлийн 10 жилд буюу 2007 оноос хойш говийн дэд бүсийн аймгуудын ажилгүй иргэдийн тоо 5.8 дахин, ажилгүйдлийн түвшин нь 4.34 дахин өсчээ. Тухайн хугацаанд ажилгүй иргэд, ажилгүйдлийн хувь хэмжээ хамгийн их өсөлттэй гарсан нь Өмнөговь аймаг байна (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үндсэн үзүүлэлтийн өөрчлөлт, 2007-оос 2017 он.

Хөдөлмөрийн салбарын үндсэн үзүүлэлтүүд	Улсын дүн		Говийн бүс		Говьсүмбэр		Өмнөговь		Дундговь		Дорноговь	
	2017	Δ	2017	Δ	2017	Δ	2017	Δ	2017	Δ	2017	Δ
15-аас дээш насны хүн ам, мян.хүн	2,220	1.35	133.7	1.31	11.2	1.30	44.0	1.53	30.5	1.00	48.0	1.40
Эдийн засгийн идэвхтэй хүн ам, мян.хүн	1,357	1.29	95.1	1.35	7.7	1.77	30.3	1.35	23.7	1.00	33.4	1.66
Ажиллагчид, мян.хүн	1,238	1.21	86.5	1.25	7.1	1.70	25.3	1.14	22.6	0.98	31.4	1.59
Ажилгүй иргэд, мян.хүн	119	3.98	8.6	5.84	0.6	3.68	5.0	14.66	1.0	1.76	2.0	5.26
Эдийн засгийн идэвхгүй хүн ам, мян.хүн	863	1.47	38.6	1.22	3.5	0.82	13.7	2.16	6.8	0.99	14.6	1.04
Ажиллах хүчний оролцооны түвшин, хувь	61.1	0.95	71.1	1.03	69.0	1.36	68.8	0.88	77.6	1.00	69.7	1.18
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувь	55.8	0.89	64.7	0.96	63.6	1.30	57.5	0.75	74.2	0.98	65.5	1.13
Ажилгүйдлийн түвшин, хувь	8.8	3.09	9.1	4.34	7.8	2.08	16.4	10.89	4.4	1.75	6.1	3.17

Тайлбар: Δ-нь Тухайн үзүүлэлт нь 2007 оноос 2017 оны хооронд хэд дахин өссөн болохыг харуулна.

Өмнөговь аймагт ажилгүй иргэд болоод ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь хөдөлмөрийн насны хүн амын тоо өсөж байгаа ч шинээр бий болж буй ажлын байр цөөн, ажил хийх сонирхолгүй, их дээд сургууль төгсөгчдөд мэргэжлийн дагуу ажил олдохгүй, өндөр цалин хөлстэй ажил хийх сонирхол ихэссэн зэрэг хүчин зүйлсээс хамаарч байна².

² Өмнөговь аймгийн ажиллах хүч, хөдөлмөр эрхлэлтийн 2017 оны танилцуулга, х.21

3.3. Говийн дэд бүсийн аймгуудын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт ба нийлүүлэлт

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийг ажил олгогчдоос ирүүлж буй ажлын байрны захиалгаар, нийлүүлэлтийг ажил идэвхтэй хайж буй бүртгэлтэй иргэдээр тус тус тооцдог. Бид зорилтот аймгуудын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт ба нийлүүлэлтийг 2016-2018 оны 12-р сарын байдлаар тооцов (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Зорилтот аймгуудын хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, 2016-2018 он.

Аймаг	2016.12			2017.12			2018.12		
	Ажлын байрны захиалга	Бүртгэл тэй ажилгүй иргэд	ХЗЗ-ийн тэнцвэр	Ажлын байрны захиалга	Бүртгэл тэй ажилгүй иргэд	ХЗЗ-ийн тэнцвэр	Ажлын байрны захиалга	Бүртгэл тэй ажилгүй иргэд	ХЗЗ-ийн тэнцвэр
Говьсүмбэр	156	197	41	371	320	-51	639	157	-482
Дорноговь	731	1338	607	1263	952	-311	1158	901	-257
Дундговь	310	519	209	1101	633	-468	847	358	-489
Өмнөговь	921	414	-507	1605	386	-1219	2190	258	-1932
Дүн	2118	2468	350	4340	2291	-2049	4834	1674	-3160

Эх сурвалж: Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар

Сүүлийн 2 жилд зорилтот аймгуудын хөдөлмөрийн эрэлт буюу ажлын байрны захиалга нэмэгдэж, харин нийлүүлэлт хомсдолтой байна. Ялангуяа Өмнөговь аймагт гэхэд ажилгүйдлийн түвшин бусад 3 аймагтай харьцуулахад хамгийн өндөр байгаа атал (Хүснэгт 3) хөдөлмөрийн нийлүүлэлт хамгийн олон (1932) хүнээр хомсдолтой байна. Иймээс хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж шалтгааныг тодруулах шаардлага байна.

3.3.1. Ажлын байрны захиалга болон ажилд зуучлагдсан иргэд

Улсын хэмжээнд аваад үзвэл, 2018 онд 64.5 мянган ажлын байрны захиалга ирсэнээс 54.0 хувийг Улаанбаатар хот, Төвийн бүс 29.6 хувийг бүрдүүлж байгаа бол ажилд зуучлагдсан иргэдийн 15 хувийг эзэлж байна.

Төвийн бүсийн өмнийн Говийн дэд бүсийн аймгуудын ажлын байрны захиалгын байдлыг сүүлийн 4 жилийн байдлаар авч үзэхэд, 2016 онд хамгийн бага буюу өмнөх оныхоосоо бараг 50 хувь буурсан байсан бол 2018 онд өмнөх оноосоо 11.4 % (494)-аар өсчээ. Аймгууд дотроос 2018 онд Өмнөговийн хувьд 2017 онтой харьцуулахад 36.4% (585)-аар, Говьсүмбэр 72.2% (268)-аар тус тус өссөн байхад Дундговийнх 29.9 % (254)-аар буурсан байна.

Ажлын байрны захиалгыг 2016-2018 оны дунджаар эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр аваад үзвэл, Говьсүмбэр аймгийн хувьд үйлчилгээний бусад үйл ажиллагаа (17.2%), боловсруулах үйлдвэр (10.9 %), бөөний болон жижиглэн худалдаа (9.7%); Дорноговьд уул уурхай, олборлолт (26.7%), үйлчилгээний бусад үйл ажиллагаа (26.2%), төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа (12.5%); Дундговьд үйлчилгээний бусад үйл ажиллагаа (21.8%), боловсруулах үйлдвэр (17.9 %), ХАА, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур (13.3 %); Өмнөговь аймгийн хувьд уул уурхай, олборлолт (56.6%), үйлчилгээний бусад үйл ажиллагаа (11.5%), боловсрол (4.9%) тус тус давамгайлж байна. Аймгийн хувьд үйлчилгээний бусад үйл ажиллагаанд ажлын байрны эрэлт өндөр байгаа нийтлэг дүр зураг харагдаж байна.

Хүснэгт 4. Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэд, хүнээр

Аймаг	2015		2016		2017			2018			
	Ажлын байрны захиалга	Зуучлагдсан иргэд	Ажлын байрны захиалга	Зуучлагдсан иргэд	АБ ашиглалтын хувь	Ажлын байрны захиалга	Зуучлагдсан иргэд	АБ ашиглалтын хувь	Ажлын байрны захиалга	Зуучлагдсан иргэд	АБ ашиглалтын хувь
Говьсүмбэр	549	328	156	62	39.7	371	359	96.8	639	485	75.9
Дорноговь	1743	1039	731	376	51.4	1263	1243	98.4	1158	1098	94.8
Дундговь	673	576	310	299	96.5	1101	790	71.8	847	688	81.2
Өмнөговь	1248	954	921	835	90.7	1605	892	55.6	2190	998	45.6
Дүн	4213	2897	2118	1572	74.2	4340	3284	75.7	4834	3269	67.6

Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Ажлын байр ашиглалтын байдал 2018 оны 12-р сарын байдлаар аваад үзэхэд, говийн дэд бүсийн аймгуудын дундаж (67.6%) улсын дундаж (66.8%)-тай ойролцоо байгаа ч аймгуудаар ялгаатай байна. Тухайлбал, Дорноговь аймгийн ажлын байр ашиглалтын түвшин хамгийн өндөр буюу 94.8 хувь байхад, Өмнөговийнх хамгийн бага (45.6%) байна.

Зуучлагдсан иргэдийн тоог ажил мэргэжлийн ангиллаар авч үзэхэд, сүүлийн 4 жилд Говьсүмбэр аймгийн хувьд нийт 1234 хүнийг ажилд зуучилж оруулсанаас хамгийн олон хүнийг энгийн ажил мэргэжилд (290), мэргэжилтэн (232) байсан бол Дорноговьд мөн адил 3756 хүнийг ажилд зуучилсанаас 31% (1159) - ийг энгийн ажил мэргэжилд, 15% (545)-ийг мэргэжилтний ажлын байранд оруулсан байна. Дундговь аймагт сүүлийн 4 жилд нийтдээ 3008 хүн зуучлагдсанаас 20% (608) нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан, 19 хувийг мэргэжилтэн эзэлж байгаа бол Өмнөговь аймагт 3679 хүнээс 32% (1172)-ийг худалдаа, үйлчилгээний ажилтан байна (Хавсралт 14). Эндээс харахад, тэднийг гол төлөв мэргэжилтэн, энгийн ажил мэргэжил болоод худалдаа үйлчилгээний ажилтны ажлын байранд зуучилжээ.

3.3.2. Гадаад ажиллагчид

Монгол улсын хэмжээнд аваад үзвэл, 2017 онд 16.5 мянга, 2018 онд 10.7 мянган гадаад ажиллах хүч зөвшөөрөл авчээ. Засгийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 317 дугаар тогтоолын хэрэгжилтийн үр дүнд гадаад ажиллах хүчний тоо өнгөрсөн жилийнхээс 34.9 хувиар буурчээ.

2018 оны 12-р сарын байдлаар хөдөлмөр эрхэлж буй нийт гадаадын иргэдийн 36.7 хувь нь уул уурхай, олборлолтын, 20.4 хувь боловсролын, 17.4 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны, 6.6 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, үлдсэн нь бусад салбарт тус тус ажиллаж байна.

Өмнийн говийн дэд бүсийн 4 аймгийн хувьд ажил эрхэлж буй гадаадын иргэдийн тоо 2018 оны 12-р сард 1305 болж өмнөх оны мөн үеэс 29 хувь өсчээ. Улсын хэмжээнд ажиллаж буй нийт гадаадын иргэдийн 26.4 хувийг Өмнөговь аймаг эзэлж байна.

3.4. Салбар хоорондын балансад суурилсан ажиллах хүчний өөрчлөлт, хэрэгцээ

Судалгааны энэ хэсэгт бид говийн дэд бүсийн аймгууд болон улсын хэмжээний салбар хоорондын балансад тулгуурлан хөрөнгө оруулалтын тодорхой хэмжээний өөрчлөлтөд бий болох эдийн засгийн салбаруудын ажиллах хүчний өөрчлөлт, хэрэгцээг тооцоолов. Тооцооллыг ҮСХ-ноос гаргасан 2016 оны салбар хоорондын тэнцлийн (20x20 матриц) авч ашиглав³. Юуны өмнө бид Монгол улсын хэмжээнд салбар хоорондын баланс дахь ажил эрхлэлтийн үржүүлэгчийг тооцоолов. Энэхүү үржүүлэгч

³ ҮСХ-ноос хамгийн сүүлд 2016 оны улсын хэмжээний салбар хоорондын баланс гаргасан байна.

нь тухайн нэг салбарт хөрөнгө оруулалтыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэхэд тухайн салбар болон бусад салбарт хэдий хэмжээний ажлын байрыг шууд болон шууд бусаар бий болж байгааг харуулдаг. Үүнд:

Хүснэгт 5. Ажиллах хүчний өсөлтөд хөрөнгө оруулалтын үзүүлэх нөлөө /Үржүүлэгчээр/

	Эдийн засгийн салбарууд	Шууд нөлөө	Шууд бус нөлөө	Нийт нөлөө
S1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.0890	0.0051	0.0940
S2	Уул уурхай, олборлолт	0.0046	0.0093	0.0138
S3	Боловсруулах үйлдвэрлэл	0.0186	0.0321	0.0507
S4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0.0193	0.0093	0.0286
S5	Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.0216	0.0123	0.0339
S6	Барилга	0.0223	0.0154	0.0378
S7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	0.0411	0.0079	0.0490
S8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.0276	0.0065	0.0340
S9	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	0.0522	0.0210	0.0732
S10	Мэдээлэл, холбоо	0.0180	0.0104	0.0284
S11	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0.0140	0.0048	0.0188
S12	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0.0004	0.0061	0.0064
S13	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	0.0163	0.0101	0.0264
S14	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0.0309	0.0139	0.0448
S15	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0.0382	0.0055	0.0437
S16	Боловсрол	0.0658	0.0072	0.0729
S17	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	0.0495	0.0078	0.0573
S18	Урлаг, үзвэр, тоглоом, наадам	0.0566	0.0089	0.0654
S19	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.0623	0.0136	0.0760
S20	Бусад үйл ажиллагаа	0.4127	0.0000	0.4127
	Нийт нөлөөлөл	1.0609	0.2071	1.2680

Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол

Улсын хэмжээнд ажил эрхлэлтийн үржүүлэгч хамгийн ихтэй салбарууд нь ХАА; бусад үйл ажиллагаа; үйлчилгээ зэрэг салбарууд байгаа бол уул уурхай, олборлолт; үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа; мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа зэрэг салбарууд нь хөдөлмөрийн үржүүлэгч хамгийн багатай гарсан байна. Харин өөр салбарт ажил эрхлэлтийг хамгийн ихээр бий болгож буй салбаруудад боловсруулах үйлдвэрлэл, байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа, барилга орж байна.

Эдийн засгийн 20 салбар тус бүрд 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхэд нийт 1268 ажлын байр шинээр нэмэгдэхээр байна. Үүнээс өөрийн салбарын ажил эрхлэлтэд буюу шууд байдлаар 1061 ажлын байр /83.7 хувь/, бусад салбарын ажил эрхлэлтэд буюу шууд бус байдлаар 207 ажлын байр /16.3 хувь/ шинээр бий болдог байна (Хүснэгт 5).

Харин салбар тус бүрийн хувьд шууд болон шууд бус нөлөө нь харилцан адилгүй байна. Тухайлбал, S1 буюу хөдөө аж ахуйн салбарт 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт орвол, шууд байдлаар 89 /хөдөө аж ахуйн салбарт/, шууд бус байдлаар 5 /бусад салбарт/ буюу нийт эдийн засагт 94 хүний ажлын байрны хэрэгцээ шинээр бий болж байна (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний дараах ажил эрхлэлтийн өөрчлөлт

Салбар	S1	S2	S3	S4	S5	S6	S7	S8	S9	S10	S11	S12	S13	S14	S15	S16	S17	S18	S19	S20	Дүн
S1	89	1	24	1	1	3	1	0	9	1	0	0	1	2	1	2	1	1	2	0	140
S2	0	5	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	5
S3	0	1	19	1	1	2	0	0	4	1	0	0	1	1	0	1	1	1	1	0	35
S4	0	1	1	19	2	0	1	0	1	0	0	0	0	1	1	1	1	1	1	0	30
S5	0	0	0	2	22	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	25
S6	0	1	0	1	1	22	0	0	0	0	0	3	0	0	0	0	0	0	0	0	32
S7	2	2	5	2	2	5	41	3	4	3	1	1	2	3	1	1	2	2	2	0	83
S8	1	2	1	2	1	2	3	28	1	1	0	0	2	3	0	0	0	1	1	0	49
S9	0	0	0	0	0	0	1	0	52	1	0	0	1	2	0	0	0	1	1	0	62
S10	0	0	0	0	0	0	0	0	0	18	0	0	1	1	0	0	0	1	1	0	24
S11	1	1	1	0	0	1	0	0	0	0	14	0	0	0	0	0	0	0	0	0	21
S12	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
S13	0	0	0	0	1	0	0	0	0	0	1	0	16	0	1	0	0	1	1	0	23
S14	0	0	0	0	0	1	1	1	1	1	0	0	1	31	0	0	0	0	1	0	40
S15	0	0	0	0	0	1	0	0	0	1	0	0	0	1	38	0	0	0	0	0	42
S16	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	66	0	0	0	0	68
S17	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	49	0	0	0	51
S18	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	57	0	0	58
S19	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	0	0	0	0	0	0	0	62	0	66
S20	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	413	413
Дүн	94	14	51	29	34	38	49	34	73	28	19	6	26	45	44	73	57	65	76	413	1268

Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол

Үүний дараа бид говийн дэд бүсийн аймгуудын хөдөлмөрийн салбарын үржүүлэгчийг тооцоолов. ҮСХ-ноос салбар хоорондын балансыг зөвхөн улсын хэмжээнд гаргадаг тул тус судалгааг хийхдээ судалгаанд хамрагдсан аймаг тус бүрийн эдийн засгийн салбараарх ажиллагчдын тоо болон дотоодын нийт бүтээгдэхүүнийг хамруулсан. Тус аймгуудын ажиллагчдын тоо нь дээрх 20 салбарын хүрээнд гарах боломжтой боловч дотоодын нийт бүтээгдэхүүн нь нийт 9 дэд салбараар гарч байлаа.

Тиймээс бид улсын хэмжээний салбар хоорондын тэнцлийг эдгээр 9 салбар руу нэгтгэв. Үүний дараа аймаг тус бүрийн салбар хоорондын балансыг гаргахдаа тухайн аймгийн ДНБ-д салбаруудын эзлэх хувийн жинд үндэслэн тооцоолов. Ажиллах хүчний коэффициентыг мөн 9 салбарын хүрээнд гаргахдаа 20 салбарт ажиллаж буй ажиллагчдыг 9 салбар руу нэгтгэв. Эцэст нь бид аймаг тус бүрийн салбар хоорондын балансад суурилсан ажил эрхлэлтийн үржүүлэгчийг тооцов.

Говьсүмбэр аймгийн хувьд тухайн салбарт 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхэд өөрийн салбартаа хамгийн ихээр ажлын байр бий болгох эрэмбээр авч үзвэл, Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ (972); хөдөө аж ахуй (512), барилга (358) байна.

Тодруулж тайлбарлавал, Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээний салбарт 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийвэл өөрийн салбарын ажил эрхлэлтийг 972 хүнээр, бусад салбарын ажил эрхлэлтийг 27 хүнээр, нийтдээ 998 хүний ажлын байрыг бий болгож байна. Харин эсрэгээрээ, боловсруулах үйлдвэрлэлд 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийвэл бусад салбарын ажил эрхлэлтийг хамгийн ихээр бий болгохоор үр дүн харагдаж байна (Хүснэгт 7).

Хүснэгт 7. Говьсүмбэр аймгийн салбарын тэнцэлд суурилсан ажил эрхлэлтийн үржүүлэгч

№	Салбар	S1	S2	S3	S4	S5	S6	S7	S8	S9
S1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.512	0.005	0.227	0.008	0.012	0.011	0.004	0.001	0.007
S2	Уул уурхай, олборлолт	0.000	0.004	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000
S3	Боловсруулах үйлдвэрлэл	0.001	0.001	0.108	0.002	0.005	0.003	0.001	0.000	0.002
S4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0.000	0.002	0.002	0.063	0.001	0.002	0.001	0.001	0.003
S5	Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.000	0.000	0.000	0.000	0.243	0.000	0.000	0.001	0.000
S6	Барилга	0.008	0.007	0.019	0.008	0.015	0.358	0.011	0.002	0.006
S7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	0.002	0.004	0.002	0.004	0.003	0.005	0.972	0.002	0.003
S8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.001	0.001	0.001	0.000	0.001	0.001	0.001	0.021	0.000
S9	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	0.002	0.004	0.004	0.003	0.007	0.007	0.009	0.003	0.155
Өөрийн салбарын ажил эрхлэлт /шууд нөлөө/		0.512	0.004	0.108	0.063	0.243	0.358	0.972	0.021	0.155
Бусад салбарын ажил эрхлэлт /шууд бус/		0.015	0.024	0.256	0.026	0.045	0.029	0.027	0.010	0.023
Нийт ажил эрхлэлт /нийт нөлөө/		0.527	0.028	0.364	0.089	0.288	0.387	0.998	0.030	0.178

Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

Дорноговь аймгийн хувьд хэрвээ 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийвэл өөрийн салбарын ажил эрхлэлтийг хамгийн ихээр дэмжих салбарыг эрэмбээр авч үзэхэд, барилга (167), хөдөө аж ахуй (107), цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж (77) зэрэг салбар байна. Эсрэгээрээ 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхэд боловсруулах үйлдвэрлэлийн салбарт бий болох шууд ажлын байр бага (19) ч дам ажлын байр хамгийн их бий болохоор (85) байна (Хүснэгт 8).

Хүснэгт 8. Дорноговь аймгийн салбарын тэнцэлд суурилсан ажил эрхлэлтийн үржүүлэгч

№	Салбар	S1	S2	S3	S4	S5	S6	S7	S8	S9
S1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.107	0.002	0.063	0.003	0.006	0.004	0.002	0.001	0.003
S2	Уул уурхай, олборлолт	0.000	0.037	0.000	0.001	0.000	0.000	0.000	0.000	0.000
S3	Боловсруулах үйлдвэрлэл	0.000	0.000	0.019	0.001	0.002	0.001	0.000	0.000	0.001
S4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0.001	0.003	0.003	0.077	0.002	0.003	0.002	0.001	0.004
S5	Усан хангамж; бохир ус, хог, хаягдал, цэвэрлэх үйл ажиллагаа	0.000	0.001	0.000	0.001	0.044	0.000	0.000	0.002	0.000
S6	Барилга	0.004	0.004	0.009	0.004	0.008	0.167	0.006	0.001	0.003
S7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	0.005	0.009	0.007	0.010	0.010	0.014	0.073	0.005	0.009
S8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.002	0.001	0.001	0.001	0.001	0.002	0.001	0.024	0.001
S9	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	0.001	0.002	0.002	0.002	0.004	0.004	0.004	0.002	0.052
Өөрийн салбарын ажил эрхлэлт /шууд/		0.107	0.037	0.019	0.077	0.044	0.167	0.073	0.024	0.052
Бусад салбарын ажил эрхлэлт /шууд бус/		0.013	0.023	0.085	0.022	0.032	0.028	0.015	0.012	0.021
Нийт ажил эрхлэлт /дам нөлөөлөл/		0.120	0.060	0.104	0.099	0.076	0.195	0.088	0.035	0.073

Эх сурвалж: Судалгааны багийн тооцоолол

Дундговь аймгийн хувьд мөн адил хэрвээ 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийвэл өөрийн салбарт ажил эрхлэлтийг хамгийн ихээр бий болгох уул уурхай (155), барилга (106), усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент (102) салбарууд багтаж байна. Эсрэгээрээ 1 тэрбум төгрөгийн

хөрөнгө оруулалт хийхэд боловсруулах үйлдвэрлэлийн салбарт бий болох шууд ажлын байр бага (2) ч дам ажлын байр хамгийн их бий болохоор (20) байна (Хүснэгт 9).

Хүснэгт 9. Дунговь аймгийн салбарын тэнцэлд суурилсан ажил эрхлэлтийн үржүүлэгч

№	Салбар	S1	S2	S3	S4	S5	S6	S7	S8	S9
S1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.010	0.000	0.013	0.000	0.001	0.001	0.000	0.000	0.001
S2	Уул уурхай, олборлолт	0.000	0.155	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000
S3	Боловсруулах үйлдвэрлэл	0.000	0.000	0.002	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000
S4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0.000	0.000	0.001	0.034	0.000	0.000	0.000	0.000	0.001
S5	Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.000	0.000	0.000	0.000	0.102	0.000	0.000	0.000	0.000
S6	Барилга	0.001	0.001	0.004	0.001	0.002	0.107	0.001	0.000	0.001
S7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	0.000	0.001	0.001	0.001	0.001	0.001	0.039	0.000	0.001
S8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.000	0.003	0.000
S9	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	0.000	0.000	0.001	0.000	0.001	0.001	0.001	0.000	0.022
Өөрийн салбарын ажил эрхлэлт /шууд/		0.010	0.155	0.002	0.034	0.102	0.107	0.039	0.003	0.022
Бусад салбарын ажил эрхлэлт /дам нөлөө/		0.003	0.003	0.020	0.002	0.006	0.004	0.003	0.001	0.003
Нийт ажил эрхлэлт /нийт нөлөө/		0.012	0.159	0.022	0.036	0.108	0.111	0.042	0.005	0.025

Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол

Өмнөговь аймгийн хувьд тухайн салбарт 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийхэд өөрийн салбартаа хамгийн ихээр ажлын байр бий болгох салбарыг эрэмбээр авч үзвэл, цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж (77), барилга (102), хөдөө аж ахуй (88) байна. Харин эсрэгээрээ, боловсруулах үйлдвэрлэлд 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийвэл бусад салбарын ажил эрхлэлтийг хамгийн ихээр буюу 51 хүний ажлын байр бий болгохоор үр дүн харагдаж байна (Хүснэгт 10).

Хүснэгт 10. Өмнөговь аймгийн салбарын тэнцэлд суурилсан ажил эрхлэлтийн үржүүлэгч

№	Салбар	S1	S2	S3	S4	S5	S6	S7	S8	S9
S1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.088	0.001	0.043	0.001	0.002	0.002	0.001	0.000	0.001
S2	Уул уурхай, олборлолт	0.000	0.010	0.000	0.001	0.000	0.000	0.000	0.000	0.000
S3	Боловсруулах үйлдвэрлэл	0.000	0.000	0.016	0.000	0.001	0.000	0.000	0.000	0.000
S4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	0.000	0.001	0.001	0.106	0.000	0.001	0.000	0.000	0.001
S5	Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0.000	0.000	0.000	0.000	0.007	0.000	0.000	0.000	0.000
S6	Барилга	0.002	0.002	0.005	0.001	0.004	0.102	0.003	0.000	0.001
S7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	0.000	0.001	0.001	0.001	0.001	0.001	0.017	0.000	0.001
S8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.001	0.001	0.001	0.000	0.000	0.001	0.000	0.017	0.000
S9	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	0.001	0.001	0.001	0.001	0.002	0.002	0.002	0.001	0.051
Өөрийн салбарын ажил эрхлэлт /шууд/		0.088	0.010	0.016	0.106	0.007	0.102	0.017	0.017	0.051
Бусад салбарын ажил эрхлэлт /дам нөлөө/		0.004	0.006	0.051	0.004	0.010	0.007	0.007	0.002	0.005
Нийт ажил эрхлэлт /нийт нөлөө/		0.092	0.016	0.067	0.110	0.017	0.109	0.024	0.020	0.056

Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол

Ийнхүү, зорилтот аймгуудын салбар хоорондын балансад суурилсан ажил эрхлэлтийн үржүүлэгчийг тооцон үзэхэд, аймаг бүрийн хувьд 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тодорхой салбарт хийхэд шууд болон шууд бусаар бий болох ажлын байр харилцан адилгүй байна. Дээрх тооцооллыг ашиглан ямар салбарт хөрөнгө оруулалт хийвэл хөдөлмөр эрхлэлтийг илүү дэмжиж болохыг бодлогын баримтууд боловсруулахдаа харгалзан үзэж болох юм.

3.5. Говийн дэд бүсийн аймагт баригдах ЖДҮ-д шаардагдах ажиллах хүчний хэрэгцээ

Тооцоолол хийхдээ ЭЗХЯ-аас гаргасан “Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөө” -д судлагдсан жишиг үйлдвэрүүдийн хүний нөөц, хөрөнгө оруулалт болон аймгуудын холбогдох нөөцийн мэдээнд тулгуурлав. Энэхүү жишиг ЖДҮ-үүдийг Архангай аймгийн Эрдэнэмандал сум, түүнээс 50 км радиусд байрлах Хайрхан, Жаргалант, Өндөр-Улаан, Цэцэрлэг гэсэн нийт 5 сумын хувьд тооцоолсон боловч говийн аймгуудын хувьд малын тоо, хүн амын төвлөрөл, нягтаршил болон бусад нөөцүүд нь харилцан адилгүй тул 50 км радиусын хүрээнд эдгээр жишиг үйлдвэрүүдийг байршуулах нь тохиромжгүй юм. Иймд бид тухайн аймгуудын нөөцийн мэдээлэлд тулгуурлан салбар бүрийн ЖДҮ-ийг говийн дэд бүсийн 4 аймагт хэдий хэмжээтэйг байгуулвал зохистойг тооцоолов. Гэвч зарим жишиг үйлдвэрүүдийн ажиллах хүчин, хөрөнгө оруулалт зэрэг мэдээлэл дутмаг байснаас гадна говийн аймгуудын зарим нөөцийн мэдээлэл хомс байсан тул зарим үйлдвэрийг ойролцоо тоогоор үнэлсэн.

- Сүүний боловсруулах цех байгуулах жишиг тооцоолол

Хүснэгт 11. Говийн дэд бүсийн аймгуудад барих боломжтой сүүний цехийн тоо

Сумдууд	Саалийн хонь	Саалийн ямаа	Саалийн үнээ	Нийт
Өндөр-Уул	11099	5138	2549	18786
Хайрхан	23100	10781	1736	35617
Жаргалант	22088	13129	3302	38519
Цэцэрлэг	22166	13100	1433	36699
Эрдэнэмандал	82265	29807	5128	117200
Нийт дүн	160718	71955	14148	246821
Сүүний нөөц /жилд, литр/	1,449,514	1,099,907	11,480,791	14,030,212
Саалинд хамрагдах хоног	54	72	171	99
Сүүний өдрийн нөөц, Литр	26,843	15,276	67,139	109,258

Эх сурвалж. УХГ, Хөгжлийн бодлого боловсруулагчдад зориулсан гарын авлага

Дээрх 5 сумын хувьд саалинд хамрагдах нийт малын тоо 246.8 мянга, сүүний нөөц 14 сая литр, сүүний өдрийн нөөц литр, сүү боловсруулах цехийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 581,3 сая төгөрг, ажилчдын тоо 12, нэг ажилчинд ногдох хөрөнгө оруулалт 48,44 сая төгрөг, 100 сая төгрөгийн хөрөнгө оруулалт тутамд бий болох ажлын байр 20.6 хүн байна. Харин говийн дэд бүсийн аймгуудад дараах байдалтай байхаар байна. Үүнд:

Хүснэгт 12. Говийн дэд бүсийн аймгуудад барих боломжтой сүүний цехийн тоо

Аймгууд	Нийт малын тоо, мян.тол			Хэлтэгч малын тоо, толгой			Сүүний нөөц, т	Үйлдвэрийн тоо, ширхэг
	Хонь	Ямаа	Үхэр	Хонь	Ямаа	Үхэр		
Дорноговь	861.5	893.6	72.6	380,201	376,731	29,645	19,886.9	1.42 /1 ш/
Дундговь	1,686.2	1,634.6	75.3	741,243	665,636	29,645	41,563.6	2.96 /3 ш/
Өмнөговь	614.0	1,773.5	27.0	253,088	723,590	10,466	24,282.2	1.73 /1 ш/
Говьсүмбэр	205.2	195.1	14.9	96,971	90,652	6,147	4,322	0.31 /1 ш/
Нийт мал	3,366.9	4,496.8	189.8	1,471,503	1,856,609	75,903	90,054.7	6.42 /6 ш/

Говийн дэд бүсийн 4 аймгийн хувьд нийт 75.9 мянган толгой хээлтэгч мал байгаа ба жилд дунджаар 90 орчим сая литр сүүний нөөцтэй байна. Тиймээс эдгээр аймгуудын дунд ойролцоогоор 6 ширхэг сүү боловсруулах цех байгуулах боломжтой байна. Говьсүмбэр амийгийн хувьд 0.31 гэж гарсан нь тус аймагтай ойролцоо бусад говийн аймгуудын сумаас сүү татах 1 цех, харин Дундговь аймгийн хувьд 2.96 ширхэг цех гэж гарсан тул тус аймагт ойролцоогоор 3 цех барих, Дорноговь болон Өмнөговь аймгуудын хувьд зай болон малын тоо зэргээс харгалзан 1-2 цех байгуулах ба кластерий тооцооллыг хийхдээ дунд нь 6 цех байхаар тооцох нь зүйтэй.

Аймгуудад баригдах 6 сүү боловсруулах цехэд нийт 72 хүн, 11 төрлийн албан тушаал дээр ажиллана. Үүнээс, гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, ерөнхий технологич, микробиологич, механик инженер, шугамын мастер, борлуулалтын менежер, түгээгч жолооч, үйлчлэгч тус бүрээс 6 хүн, савлагч 12 хүн байхаар байна.

Хүснэгт 13. Сумын ҮТП-д жишээ авсан Архангай аймийн 5 сумын статистик, 2013 он

Сум сум	Нийт	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Хүн ам	Өрх	Өрхийн дундаж хүн
Өндөр-Улаан	255.3	19.9	41.6	132.8	61	4,020	1280	3.1
Хайрхан	250.2	23.4	19.4	141.1	66.2	5,310	1608	3.3
Жаргалант	189.2	9	19.7	100.6	59.9	3,493	1116	3.1
Цэцэрлэг	248.4	12.1	13	140.2	83.1	3,512	1034	3.4
Эрдэнэмадал	372.3	21.6	26.1	240.4	84.1	5,096	1601	3.2
Нийт дүн	1315.4	86	119.8	755.1	354.3	21,431	6639	3.2

Эх сурвалж. Үндэсний статистикийн хороо

Говийн дэд бүсийн аймгуудад баригдах боломжтой бусад үйлдвэрүүдэд шаардагдах хүний нөөц, хөрөнгө оруулалтын хэмжээг тооцоходоо бид дээрх 5 сумын 2013 оны статистик тоон мэдээлэлд тулгуурлан дараах 17 жижиг үйлдвэрийн хүрээнд боловсруулав. Үүнд:

Хүснэгт 14. Архангай аймгийн 5 сумын дунд баригдах жишиг ҮТП-ийн тооцоолол, 2013 оноор.

Дэд салбар	Архангай аймгийн 5 сумын дунд баригдах ҮТП-ийн жижиг, дунд үйлдвэрлэлийн төрөл		Хөрөнгө оруулалт	Ажилчдын тоо	1 ажилчинд ногдох хөрөнгө оруулалт
Мал аж ахуй	K1	Мал төхөөрөх цех	1,091,987,600	58	18,827,372
	K2	Мал бордох цех	318,691,683	8	39,836,460
	K3	Арьс ширний анхан шатны тордолтын цех	179,086,800	6	29,847,800
	K4	Арьс ширэн жижиг эдлэлийн цех	27,346,000	4	6,836,500
	K5	Ноос, ноолуур бэлтгэх, ангилах цех	312,821,440	8	39,102,680
	K6	Эсгийний цех	27,000,000	6	4,500,000
	K7	Сүү боловсруулах цех	581,321	12	48,443
Газар тариалан	K8	Хүлэмжийн аж ахуй	1,100,000	12	91,667
	K9	Хүнс, ногоо боловсруулах цех	376,571	18	20,921
	K10	Ургамлын цайны үйлдвэр	177,372,500	55	3,224,955
	K11	Төмс, хүнсний ногооны механикжсан агуулах	388,641	6	64,774
Худалдаа	K12	Бөөний худалдаа, ложистикийн төв	310,120	26	11,928
Хүнс	K13	Цэвэр ус үйлдвэрлэх цех	248,669	9	27,630
	K14	Талх, нарийн боовны цех	6,000,000	3	2,000,000
Бусад	K15	Засвар үйлчилгээний цех	43,400,000.00	7	6,200,000
	K16	Оёдлын цех	14,620,000.00	7	2,088,571
	K17	Модон эдлэл, мужааны цех	27,000,000	4	6,750,000
Нийт дүн			2,228,331,345	249	159,479,701

Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол

Хүснэгт 15. Говийн дэд бүсийн аймгуудад барих боломжтой ЖДҮ-д шаардагдах ажлын байр

№	Говийн дэд бүсийн аймагт баригдах үйлдвэрийн тоо					Аймгуудад баригдах үйлдвэрт шаардагдах ажиллах хүчин					Шууд болон шууд бусаар өгөөж хүртэх боломжтой хүн амын тоо				
	ДоА	ДуА	ӨГА	ГСА	Нийт	ДоА	ДуА	ӨГА	ГСА	Нийт	ДоА	ДуА	ӨГА	ГСА	Нийт
К1	1	3	2	1	7	58	174	116	58	406	273	539	348	191	1351
К2	1	3	2	1	7	8	24	16	8	56	38	74	48	26	186
К3	1	3	2	1	7	6	18	12	6	42	28	56	36	20	140
К4	1	2	2	3	8	4	8	8	12	32	19	25	24	40	107
К5	1	3	2	1	7	8	24	16	8	56	38	74	48	26	186
К6	1	2	1	1	5	6	12	6	6	30	28	37	18	20	103
К7	1	3	1	1	6	12	36	12	12	72	56	112	36	40	244
К8	1	2	2	3	8	12	24	24	36	96	56	74	72	119	322
К9	1	2	2	3	8	18	36	36	54	144	85	112	108	178	482
К10	1	2	2	3	8	55	110	110	165	440	259	341	330	545	1474
К11	1	2	2	3	8	6	12	12	18	48	28	37	36	59	161
К12	1	2	2	3	8	26	52	52	78	208	122	161	156	257	697
К13	1	2	2	3	8	9	18	18	27	72	42	56	54	89	241
К14	1	2	2	3	8	3	6	6	9	24	14	19	18	30	80
К15	1	2	2	3	8	7	14	14	21	56	33	43	42	69	188
К16	1	2	2	3	8	7	14	14	21	56	33	43	42	69	188
К17	1	2	2	3	8	4	8	8	12	32	19	25	24	40	107
Дүн	17	39	32	39	127	249	590	480	551	1870	1170	1829	1440	1818	6258

Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол

Говийн дэд бүсийн 4 аймагт нийт 17 төрлийн 127 ЖДҮ баригдах боломжтой бөгөөд шууд байдлаар 1870 хүн ажлын байртай болно. Шууд болон шууд бус (1 ажилчны цаана байгаа дундаж өрхөд ногдох хүний тоо аймаг бүрээр ялгаатай байна) байдлаар нийт 6258 хүн тус үйлдвэрүүдээс өгөөж хүртэнэ. Мөн эдгээр 127 жижиг, дунд үйлдвэрт шаардагдах нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нь ойролцоогоор 20.8 тэрбум төгрөг байхаар байна (Хүснэгт 16).

Хүснэгт 16. Говийн дэд бүсийн аймгуудад барих боломжтой ЖДҮ-ийг барихад шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээ, сая төг

№	Аймгуудад баригдах үйлдвэрийн хөрөнгө оруулалтын хэмжээ, 2013 оны тооцоогоор, сая төг					Говийн дэд бүсийн аймгуудад баригдах боломжтой үйлдвэрийн хөрөнгө оруулалт, 2018 оноор, сая төг				
	ДоА	ДуА	ӨГА	ГСА	Нийт	ДоА	ДуА	ӨГА	ГСА	Нийт
К1	1092.0	3276.0	2184.0	1092.0	7643.9	1,431.3	4,294.0	2,862.6	1,431.3	10,019.3
К2	318.7	956.1	637.4	318.7	2230.8	417.7	1,253.2	835.5	417.7	2,924.1
К3	179.1	537.3	358.2	179.1	1253.6	234.7	704.2	469.5	234.7	1,643.2
К4	27.3	54.7	54.7	82.0	218.8	35.8	71.7	71.7	107.5	286.8
К5	312.8	938.5	625.6	312.8	2189.8	410.0	1,230.1	820.1	410.0	2,870.2
К6	27.0	54.0	27.0	27.0	135.0	35.4	70.8	35.4	35.4	177.0
К7	0.6	1.7	0.6	0.6	3.5	0.8	2.3	0.8	0.8	4.6
К8	1.1	2.2	2.2	3.3	8.8	1.4	2.9	2.9	4.3	11.5
К9	0.4	0.8	0.8	1.1	3.0	0.5	1.0	1.0	1.5	3.9
К10	177.4	354.7	354.7	532.1	1419.0	232.5	465.0	465.0	697.5	1,859.9
К11	0.4	0.8	0.8	1.2	3.1	0.5	1.0	1.0	1.5	4.1
К12	0.3	0.6	0.6	0.9	2.5	0.4	0.8	0.8	1.2	3.3
К13	0.2	0.5	0.5	0.7	2.0	0.3	0.7	0.7	1.0	2.6
К14	6.0	12.0	12.0	18.0	48.0	7.9	15.7	15.7	23.6	62.9

K15	43.4	86.8	86.8	130.2	347.2	56.9	113.8	113.8	170.7	455.1
K16	14.6	29.2	29.2	43.9	117.0	19.2	38.3	38.3	57.5	153.3
K17	27.0	54.0	54.0	81.0	216.0	35.4	70.8	70.8	106.2	283.1
Дүн	2228.3	6359.8	4429.1	2824.7	15841.9	2,920.8	8,336.2	5,805.4	3,702.4	20,764.8

Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол

3.6. Говийн дэд бүсийн аймагт баригдах ЖДҮ-д шаардагдах ажиллах хүчний эрэлт ба нийлүүлэлтийн төлөв байдал

Судалгааны баг тайлангийн 3.5-д зорилтот аймгуудын нөөцөд тулгуурлан ойрын ирээдүйд баригдах боломжтой ЖДҮ-үүдэд шаардагдах ажиллах хүчний хэрэгцээг хэрхэн хангах талаарх ерөнхий төсөөллийг ажил албан тушаалаар гаргалаа (*Хавсралт 15. Ажиллах хүчний эрэлт ба нийлүүлэлтийн матриц*).

Энэхүү ойрын ирээдүйд шаардагдах ажиллах хүчний эрэлт ба нийлүүлэлтийн төсөөллийг гаргахдаа 2014 онд ЭЗХЯ-наас эрхлэн гаргасан “Орон нутгийн бодлого төлөвлөлт” гарын авлагад ЖДҮ-ийн жишиг ТЭЗҮ-д тусгасан шаардлагатай ажиллах хүчний хэрэгцээний албан тушаал (ажил мэргэжил)-ийн хэрэгцээг суурь болгон авч Говийн дэд бүсийн аймгуудад үйл ажиллагаагаа явуулж буй МБСБ-ын бэлтгэн гаргаж буй мэргэжлээр, бусад боломжит эх үүсвэр (ИДСК, ажилгүй иргэд болон бусад)-ээс нийлүүлэлтийг хангах төлвийг гаргасан болно. Албан тушаал бүрээр нийлүүлэлтийн боломжит эх үүсвэрийн товъёог Ажиллах хүчний эрэлт ба нийлүүлэлтийн матрицаас харна уу (*Хавсралт 15*).

Бидний тооцооллоор, ойрын ирээдүйд баригдах мал аж ахуйн 7 жижиг цех (мал төхөөрөх; мал бордох; арьс ширний анхан шатны тордолт; ноос ноолуур бэлтгэх, ангилах; эсгий болон сүү боловсруулах)-ээр 694, газар тариалангийн 4 чиглэл (хүлэмжийн аж ахуй; хүнсний ногоо боловсруулах; ургамлын цайны үйлдвэр; төмс, хүнсний ногооны механикжсан агуулах)-ээр 728, бөөний худалдаа ба ложистикийн төвд 208, хүнсний чиглэл(цэвэр ус үйлдвэрлэх, талх нарийн боовны)-ээр 96, бусад чиглэл(засвар үйлчилгээ, оёдол болон модон эдлэл, мужаан)-ээр 144 ажлын байр, нийтдээ шуудаар 1870 ажлын байр бий болохоор байгаа юм.

Эрэлтийг ажил албан тушаалын төрлөөр нь аваад үзвэл, нийтдээ 70 орчим төрлийн ажлын байранд ажиллах хүч шаардлагатай байна (*Хавсралт 16*). Үүнээс 50 орчим хувь нь нарийн мэргэшил, ур чадвар шаардахгүй бага тушаалын үйлдвэрийн туслах ажилчид, зуухны ажилчид, мал нядлагчид, манаач, үйлчлэгч зэрэг байна. Эдгээр ажлын байранд тухайн орон нутгийн хөдөлмөрийн зах зээл дээр байгаа ажилгүй иргэдийг давтан сургалтад хамруулах байдлаар бэлтгэх боломжтой.

Зорилтот аймгуудад байгаа МСҮТ, ПТК-д мэргэжилтэй ажилчид бэлтгэж буй мэргэжлийн чиглэлээс харахад, нийт эрэлтийн 28 орчим хувь буюу тооцооны нягтлан бодогч, нярав, жолооч, зарим цехийн мастер, малчин, оёдолчин, ногоочин, цахилгаанчин, гагнуурчин, сантехникч, механик засварчин, мужаан зэрэг ажлын байранд МБСБ-ийн төгсөгчдөөс хангах боломжтой байна.

3.7. Хөдөлмөрийн салбарын хөгжлийн олон улсын чиг хандлага

Энэ хэсэгтээ ОУХБ-аас жил бүр гаргадаг “Дэлхийн хөдөлмөр эрхлэлт болон Нийгмийн Тойм-2018 Хандлагууд” болон “Дэлхийн хөдөлмөр эрхлэлт болон Нийгмийн Тойм” болоод 2018 онд Дэлхийн эдийн засгийн форумаас хийсэн “Ирээдүйн ажил мэргэжлийн судалгаа-2018”-ын тайлан болон бусад олон улсын байгууллагын судалгааны үр дүнгээс тоймлон авлаа.

3.7.1. Хөдөлмөрийн зах зээл, хөдөлмөр эрхлэлтийн өөрчлөлтийн чиг хандлага

“Дэлхийн хөдөлмөр эрхлэлт болон Нийгмийн Тойм-2018 Хандлагууд” судалгаа нь хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн төлөв байдлыг судалж, хамгийн сүүлийн үеийн хөгжлийн хандлагыг үнэлэн глобал болоод бүс нутгийн хүрээнд ажилгүйдэл, ажилгүйдэлд өртөж болзошгүй буюу эмзэг ажил эрхлэлт /vulnerable employment/, ажилтай ядуучууд (working poverty)-ын талаарх төлвийг тодорхойлдог. Энэ тайланд дэлхийн эдийн засаг сэргэж байгаа ч ажиллах хүчний өсөлттэй байгаагаас 2018 онд глобал түвшинд ажилгүйдэл өмнөх оны түвшинд байх буюу тогтвортой, харин хөгжиж буй орнуудын хувьд 4 ажилтан тутмын нэг (1/4) нь ажилгүйдэлд өртөж болзошгүй байгааг онцолжээ. Хөдөлмөр эрхлэлтийн салбарын бүтцэд гарч буй өөрчлөлтөөс харахад, үйлчилгээний салбарын ажлын байрууд ажил эрхлэлтийн ирээдүйн өсөлтийн хөдөлгөгч хүч болохоор төлөвтэй байгаа бөгөөд хөдөө аж ахуй, боловсруулах аж үйлдвэрийн салбарын хөдөлмөр эрхлэлт буурсаар байхаар байна. Энд тэмдэглэсэнээр, дэлхий даяар ажиллах хүчний өсөлт нь тэтгэврийн хүн амын хурдацтай тэлэлтийг нөхөхөд хангалтгүй байх болно гэдгийг харуулж байна. Таамаглалаар, 2017 онд ажиллагчдын дундаж нас 40-өөс доош байсан бол 2030 онд гэхэд 41-ээс дээш болж өсөхөөр байна.

Ази, Номхон далайн бүсийн хувьд, ажилгүйдэл олон улсын стандартаас доогуур, төсөөлж буй хугацаанд харьцангуй тогтвортой 4.2 хувь, харин 2017-2019 онд хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн тоо 23 сая хүнээр нэмэгдэхээр, харин нийт ажиллагчдын бараг тэн хагас нь ажилгүйдэлд өртөж болзошгүй төлөвтэй байх таамаглал гарчээ.

“Ирээдүйн ажил мэргэжлийн судалгаа-2018”-ын үр дүнгээс харахад, 2022 он гэхэд хиймэл оюун ухааныг ашигласнаар ажлын байранд хүний оролцоо багассанаар хөдөлмөр эрхлэлтийн төрөлд бүтэн цагаар ажиллагчдын тоо буурна гэдэгт судалгаанд оролцсон ажил олгогчдын 50 хувь нь хүлээлттэй байна. Өөрөөр хэлбэл, ирээдүйд хагас цагийн ажил эрхлэлт давамгайлах төлөвтэй байгааг илтгэж байгаа юм. Үүнээс гадна илүү нарийн мэргэжил, ур чадвар шаардсан ажлыг гэрээт гүйцэтгэгчээр дамжуулан гүйцэтгүүлэх буюу “аутсорсинг”-ийг ашиглахыг илүүд үзэж байгаагаар илэрхийлсэн ажээ.

3.7.2. Ажлын байрны өөрчлөлтийн чиг хандлага

ОУХБ-аас гаргасан “Дэлхийн хөдөлмөр эрхлэлт болон Нийгмийн Тойм-2018” тайланд дэлхийн хэмжээний дулааралтай холбоотойгоор глобал түвшинд ажлын байраа алдах болоод ажил байр бий болголт илүү ногоон эдийн засаг рүү шилжиж байгааг онцолжээ. Үүнтэй холбоотойгоор Парисын гэрээний зорилгод хүрэхийн тулд дэлхийн хэмжээнд 2030 он гэхэд 24 сая ногоон ажлын байр бий болох бол 6 сая ажлын байр алга болж, 1.2 сая ажлын байр тогтвортой болоод илүү эрүүл орчноос шалтгаалахыг тэмдэглэжээ. Тухайлбал, ХАА, загас, ойн салбар, түүнчлэн аялал жуулчлал, эм зүй болоод бусад салбарынх унаган байгалийн хүрээлэн буй орчны үйл явцаас илүү хамаарахаар байна.

Шинэ ажлын байрууд ихэвчлэн эрчим хүч (эрчим хүчний хольц дахь өөрчлөлтүүд, цахилгаанаар ажилладаг тээврийн хэрэгслүүдийг ашиглахыг идэвхжүүлэх, байшин барилгын эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн); экосистемийн үйлчилгээ (агаар ба усны цэвэршүүлэх, хөрсийг нөхөн сэргээх ба бордох, хортон шавьжтай тэмцэх, цаг агаарын онцгой нөхцлөөс хамгаалах)-ний салбарт бий болох юм байна. Иймээс улс орнууд ногоон эдийн засагт шилжихэд шаардлагатай ур чадваруудад ажилтнуудаа сургах талаар яаралтай арга хэмжээ авахыг анхааруулжээ. Түүнчлэн бага болоод дунд орлоготой орнуудын хувьд өгөгдлүүд цуглуулах ба хөгжүүлэх, хүрээлэн буй орчиндоо ээлтэй тогтвортой эдийн засаг, нийгэмд шударгаар шилжихэд чиглэсэн стратеги, санхүүгийн дэмжлэг авах шаардлага урьдын адил байсаар байна.

3.7.3. Ажил мэргэжлийн өөрчлөлтийн чиг хандлага

“Дэлхийн эдийн засгийн форум-2018”-ийн хүрээнд хийгдсэн судалгааны тайлангаас харахад, ажил мэргэжил, ур чадварын өөрчлөлтөд мэдээлэл, харилцаа холбооны техник технологийн дэвшил хөдөлгөгч хүч болж байна: (1) өндөр хурд бүхий хөдөлгөөнт интернет, (2) хиймэл оюун ухаан, (3) их тоон өгөгдлийн шинжилгээний өргөн тархалт, (4) үүлэн технологи. Эдгээр өөрчлөлтийн жолоодогч хүчин зүйлс нь 2018-2022 онуудад давамгайлахаас гадна бизнесийн өсөлтөд эерэгээр нөлөөлөхөөр байна. Иймээс 2022 он гэхэд хамгийн эрэлттэй байх ажил мэргэжилд тоон өгөгдлийн шинжээчид ба эрдэмтэд; хиймэл оюун ухаан, машин сургалтын мэргэжилтнүүд, ерөнхий ба үйл ажиллагааны менежерүүд, программ хангамж болон аппликейшн хөгжүүлэгч, шинжээчид; их тоон өгөгдлийн мэргэжилтэн; дижитал хувьсгалын мэргэжилтнүүд; байгууллагын хөгжлийн мэргэжилтнүүд; мэдээллийн технологийн үйлчилгээ зэрэг мэргэжлүүд тэргүүлж байгаа бол эсрэгээрээ, эрэлт хэрэгцээ нь буурах ажил мэргэжлүүдэд тоон өгөгдөл оруулах ажилтан, нягтлан бодох бүртгэл, нярав; захиргааны болон гүйцэтгэх нарийн бичгийн дарга, хурлын болон үйлдвэрийн ажиллагчид; хэрэглэгчийн мэдээлэл, хэрэглэгчийн үйлчилгээний ажилтан; бизнес үйлчилгээ, удирдлагын менежерүүд; аудиторууд; баримт бичиг хариуцсан ажилтан, архивч; шуудангийн үйлчилгээний ажилтан зэрэг багтаж байна. Өөрөөр хэлбэл, хүний оролцоотой хийгддэг “техник”-ийн шинжтэй ажлыг хиймэл оюун ухаан буюу машин орлон гүйцэтгэдэг болсоноор дээрх ажил мэргэжлийн эрэлт буурч, улмаар цаашид хөдөлмөрийн зах зээлээс шахагдана гэсэн үг.

3.7.4. Ажиллагчдын ур чадварын өөрчлөлтийн хандлага

Мэдээлэл, харилцааны холбооны салбарын техник, технологийн дэвшилтэт ололтууд нь хүн машин хооронд хөдөлмөрийн шилжилтийг бий болгож байгаатай уялдан 2022 он гэхэд тодорхой ажлыг гүйцэтгэхэд шаардагдах ур чадварт өөрчлөлт гарахаас гадна бизнесийн загварын өөрчлөлтөөс шалтгаалан ажил олгогчдын зүгээс ажилтанд тавигдах шаардлага өндөрсөхөөр хандлагатай байна. Тухайлбал, 2018-2022 онд одоогийн ажил, үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай ур чадварын 58.0 хувь нь хэвээр хадгалагдах бол үлдсэн 42.0 хувь нь өөрчлөгдөх хүлээлттэй байна. Ур чадварын өөрчлөлт нь техник ур чадвараас илүүтэйгээр хүний бүтээлч сэтгэлгээ, асуудлыг шийдвэрлэх, санаачилгатай байх, шүүмжлэлт сэтгэлгээ гээд машины гүйцэтгэж чадахгүй зөвхөн хүний оюун ухаанаар бүтээгдэх мэдлэг, ур чадварт чиглэж байна.

4. ТӨВИЙН БҮСИЙН ГОВИЙН ДЭД БҮСИЙН ДӨРВӨН АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН УЯЛДАА, НИЙЦЛИЙН СУДАЛГАА

4.1. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа

Судалгаандаа бид говийн дэд бүсийн аймгуудад хэрэгжүүлж буй аймгуудын хөгжлийн бодлого, хөтөлбөр, цогц бодлого; аймгуудын эдийн засаг, ниймийг хөгжүүлэх үндсэн чиглэл; аймгийн ЗДТГ-ын харьяа агентлагуудын бодлого, дэд хөтөлбөрүүд; аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөр зэргийг үндэсний болоод бүсийн хэмжээнд мөрдөгдөж буй бодлогын баримт бичгүүд; хөдөлмөрийн салбартай холбоотой хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүд; эдийн засгийг бүсчилсэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого; Мянганы хөгжлийн зорилтод сурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого болон Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай харьцуулан судалсан. Хөгжлийн бодлогын баримт бичгийн судалгааг хийх ерөнхий арга зүйн бүдүүвчийг Хавсралт 17-ээс харна уу.

Олон улс, улс, бүс, аймаг, сумын түвшний хөгжлийн баримт бичиг болон хөдөлмөрийн салбарт хэрэгжиж буй хууль, бодлогын уялдааг гаргахдаа авч үзвэл зохих 170 орчим хөгжлийн бодлогын баримт бичгүүд, хууль байна (*Хавсралт 1, 2*).

Бид үндэсний, бүс, аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоог гаргахдаа тэдгээргийн зорилго, зорилтууд агуулгын хувьд хөдөлмөрийн салбарт хэрэгжиж буй бодлоготой хэр нийцэж байгааг гарган нэгтгэлийг матрицаар гаргасан болно. Ингэхдээ дараах түвшингээр уялдааг гаргалаа (*Хавсралт 18-19*). Үүнд:

- а) Зорилтот аймгуудын хөгжлийн бодлогын баримт бичиг (аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө эсхүл цогц бодлого, стратеги төлөвлөгөө) нь үндэсний болоод бүсийнхтэй (*Хавсралт 18*);
- б) Аймгуудын хөгжлийн бодлого, төлөвлөгөө МУЗГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, хүн ам болоод хөдөлмөрийн салбарын бодлоготой уялдаж буй байдал (*Хавсралт 19*);
- в) Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд дэх хөдөлмөрийн салбартай холбоотой зорилтууд, тэдгээрийн хоорондын нийцэл болоод хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүдтэй уялдаж буй байдал (*Хавсралт 19.1-19.3*).

Харин сумдын хөгжлийн бодлогууд аймаг болоод хөдөлмөрийн салбарынхтай уялдах уялдааг гаргаагүй болно.

Дээр дурдсан гурван түвшнээр үр дүнг гарган харвал:

- а) Аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө эсхүл хөгжлийн цогц бодлогууд цаг хугацааны хувьд 2010-2021 онд 2 үе шаттайгаар хэрэгжихээр боловсруулж хэрэгжүүлж байгаа бөгөөд түүнийг МХЗ-д суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгасан хөдөлмөрийн салбартай холбоотой зорилтуудын нийцлийн түвшин аймгуудын нэгтгэлээр авч үзэхэд 81.2 хувьтай байна. Аймгуудаар авч үзвэл, Дорноговь, Өмнөговь аймгийн хувьд нийцэл 87.5%, Говьсүмбэр, Дундговь аймгийнх 75 хувь байна.

Монгол улсын ТХҮЗ-2030-ийг аймгуудын мастер төлөвлөгөө эсхүл цогц бодлогын зорилтуудын уялдааны нийцлийн ерөнхий хувь 72.2 хувь, харин Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцлийн хувь (аймгуудын дүн) хамгийн бага буюу 54.2 хувь байна. Гэтэл Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай уялдах уялдаа хамгийн бага буюу нийцлийн ерөнхий хувь 16.7 хувь байна.

- б) Аймгуудын хөгжлийн бодлого, төлөвлөгөө нь МУЗГ-ын мөрийн хөтөлбөр болоод төрөөс хүн ам болоод хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлоготой уялдаж байгаа уялдаа гаргаж харахад,

нийцлийн ерөнхий хувь 68.5 хувь байна. Аймаг бүрээр харилцан адилгүй байгаагаас Өмнөговь аймгийн хувьд Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлоготой нийцлийн хувь хамгийн өндөр 81.3%, харин хамгийн бага нийцлийн хувьтай нь Дундговь аймаг (56.3 %) байна.

- с) Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд дэх хөдөлмөрийн салбарт дэвшүүлсэн зорилтууд, тэдгээрийн хоорондын уялдаа болоод хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрүүдийн нийцлийн судалгааны гол үр дүн нь аймаг бүрийн хувьд харилцан адилгүй байна. Иймээс аймаг бүрээр дэлгэрүүлэн авч үзсэн.

4.2. Дорноговь аймгийн хөгжлийн бодлогын голлох баримт бичгүүдийн хөдөлмөрийн салбарынхтай уялдаж буй байдал

2011-2021 онд хэрэгжүүлэх мастер төлөвлөгөөний хувьд бүсийн хөгжлийн давуу тал, нөөц боломжид тулгуурлан судалгаанд суурилсан хөдөлмөрийн зах зээлийн бодлогыг үндсэн чиглэлээ болгон боловсруулсан байна. Аймгийн засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хувьд иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулах, малчдыг ажлын байраар хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ажил олгогч, төр, иргэд хооронд хамтын ажиллагааг сайжруулах, МСҮТ-ийн үйл ажиллагааг дэмжин ажиллах зэрэгт төвлөрсөн.

2018 онд хэрэгжүүлэх үндсэн чиглэл нь өмнөх 2017 оны үндсэн чиглэлээсээ нэг их ялгаагүй байсан ба хүн амын зохистой хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах; МБСБ, МСҮТ, ажил олгогч төрийн хамтын ажиллагааг сайжруулах; төгсөгчдийг ажлын байраар хангах; бусад улсаас туршлага судлах тал дээр анхаарчээ. Харин гурван тулгуурт хөгжлийн бодлогын хувьд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд суурилсан хүний нөөц бэлтгэх, төлөвлөх; бичил, өрхийн бизнесийг санхүүгийн болон зээлийн урамшуулалд хамруулах; ядуу болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангах; ур чадварт суурилсан ажлын байр бий болгоход түлхүү анхаарсан байна. Тус аймгийн бодлого хоорондын нийцэл нь 83.8 хувьтай гарчээ.

4.3. Говьсүмбэр аймгийн хөгжлийн бодлогын голлох баримт бичгүүдийн хөдөлмөрийн салбарынхтай уялдаж буй байдал

Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлогод хүний хөгжлийг бүхий л талаар дэмжих; байнгын болон улирлын ажлын байрыг нэмэгдүүлж, нийгмийг бүтээхэд оролцдог иргэдийн тоог нэмэгдүүлэхэд чиглэсэн байна. Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх; зорилтот бүлэгт чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлого хэрэгжүүлэх тал дээр түлхүү анхаарсан бол Аймгийн засаг даргын 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд зохистой хөдөлмөр болон хувийн бизнес эрхлэх чадамжийг бий болгох; хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийг сайжруулахад төвлөрчээ.

Гэвч аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй хөгжлийн бодлогын баримт бичгүүд дэх хөдөлмөрийн салбартай холбоотой зорилтууд нь улс, үндэсний болоод бүсийн хэмжээнд хэрэгжүүлж буй бодлогын баримт бичгүүдтэй нийцэл тааруу байна. Тухайлбал, Монгол улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлогын зорилтуудад тусгасан иргэний хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, бүтээмж, ур чадварыг хөгжүүлэх үндсэн дээр цалин хөлсийг нэмэгдүүлэх, бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих, нийгмийн түншлэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг оновчтой, үр ашигтай болгох асуудлуудтай нийцэл муу гарчээ.

Үүнээс гадна Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тусгасан хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн төвшинг бууруулах; ХАА, аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэх, төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг дэмжих, албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах, ЖДҮ-ийг хөгжүүлэх гэсэн зорилтуудыг тодорхой тусгаагүй байна.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд хөдөлмөрийн салбартай холбоотой 5 дэд хөтөлбөр хэрэгжиж байгаа ч аймгийн болон бүсийн хэмжээний хөгжлийн бодлогуудын зорилтуудтай нийцэл тааруу байна. Тухайлбал, бүсчилсэн хөгжлийн үзэл, баримтлалын зорилт болох орон нутгийн хүн амын хөдөлмөрийн дадлага, чадварыг дээшлүүлэх шаардлагад зохицсон жижиг, дунд үйлдвэрлэлийн сүлжээ бүрдүүлэх; тухайн бүсийн хүрээнд хот, хөдөөгийн хүн ам амьдрах арга ухаан, хөдөлмөрлөх дадлага, туршлагаа харилцан солилцох, уугуул нутгаа хөгжүүлэх талаар орон нутгийн байгууллага, төрийн бус байгууллагууд хамтран ажиллах явдлыг хөхүүлэн дэмжих зэрэг зорилтуудтай тус аймгийн хөгжлийн бодлогууд, дэд хөтөлбөрүүдийг зорилтууд нь уялдаа муутай байна.

4.4. Дундговь аймгийн хөгжлийн бодлогын голлох баримт бичгүүдийн хөдөлмөрийн салбарынхтай уялдаж буй байдал

Аймгийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө болон засаг даргын 2018 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд иргэдийн нийгмийн баталгаа, хангамж, эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөл боломж, хөдөлмөрийн аюулгүй байдлыг анхаарах; хүний нөөцийг чадавхижуулах; зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх; ААНБ, нөхөрлөл, хороо, бүлгийг дэмжих замаар ажлын байрыг бий болгох зэрэг олон асуудлыг тусгасан байна. Гэсэн хэдий ч эдгээр бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой дэд хөтөлбөрүүд хангалтгүй байгаа ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих дэд хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэх, дэмжлэгтэйгээр ажилд зуучлах, тэдний аж ахуй эрхлэлт болон хөдөлмөр эрхлэлтийн тусгай үйлчилгээ, арга хэмжээнд хамруулж дэмжлэг үзүүлэх замаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилтуудыг түлхүү тусгасан байна.

4.5. Өмнөговь аймгийн хөгжлийн бодлогын голлох баримт бичгүүдийн хөдөлмөрийн салбарынхтай уялдаж буй байдал

Өмнөговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөөнд хөдөлмөрийн салбартай холбоотой 10 дэд зорилт дэвшүүлсэн бөгөөд аймаг болон бүсийн хөгжлийн давуу тал, нөөц боломжийг ашиглан ЖДҮ, үйлчилгээг дэмжих замаар ажлын байрыг бий болгох; малчдын хөдөлмөр эрхлэлт болон хувь хүнийг чадваржуулах зэрэг асуудлыг түлхүү тусгасан байна. Аймгийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зорилтуудыг агуулсан нийт 15 дэд хөтөлбөр хэрэгжиж байна.

Орон нутагт дутагдалтай хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр нь Бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн чухал салбарууд дахь дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх, сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх, ААНБ, хувийн хэвшлийн хүний нөөцийг бүрдүүлэхэд чиглэсэн байна.

2017-2020 онд хэрэгжүүлэх Зөгийн үүр хөтөлбөрийн хүрээнд орон нутагтаа тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллаж буй иргэдийг хилийн чанадад сурах, мэргэжлээ дээшлүүлэх, мэргэшихэд дэмжлэг үзүүлэх тал дээр дэмжлэг үзүүлж байгаа нь Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого,

Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бүсчилсэн хөгжлийн бодлоготой нийцэж байна. Энэ мэтчлэн аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрүүд нь аймгийн, бүсийн, үндэсний болоод хөдөлмөрийн салбартай холбоотой хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдтэй нийцэл сайтай гарчээ.

4.6. Бодлогын баримт бичгүүд дэх хөдөлмөрийн салбартай холбоотой шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийн байдал, цаашдын төлөв

ТХҮБ-ийн I үе шатны зорилгод (2016-2020 он) ажилгүйдлийн түвшинг 6 хувь, II үе шатанд (2021-2025 он) 4 хувь, III үе шатанд (2026-2030 он) 3 хувь, Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого дахь “Эдийн засгийн өсөлт, хөгжлийн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөө”-г хэмжих гол шалгуур болох ажилгүйдлийн түвшинг 2020 онд 5.6 хувь, 2025 онд 5 хувьд хүргэхээр тус тус заажээ.

Бодлогын баримт бичгүүдэд, ТХҮБ-2030-ын гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хоёр жил тутам, Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын хяналт-үнэлгээг жил тутам хийж байхаар заажээ.

Аймгууд ТХҮБ-2030-ийн эхний хоёр жилийн биелэлтийг 2018 оны эцэст гаргасан биелэлтийн тайлангаас харахад, ХАА, аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэх, төгсөгчид ажлын байрыг өөрөө бий болгоход чиглэсэн мэргэжлийн боловсрол, сургалтын үйл ажиллагааг дэмжих зэрэг ихэнх үзүүлэлтийн биелэлтийг хэт ерөнхийлөн ихэвчлэн 100 хувь гаргасан байгаа нийтлэг дутагдал байна. Аймгуудад албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах дэд үзүүлэлтийн хувьд хамгийн бага биелэлттэй байна.

Судалгааны багийн зүгээс сүүлийн жилүүдийн статистик дээр тулгуурлан ажилгүйдлийн түвшин, ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшингийн биелэлтийг гарган, 2020 онд зорилтот түвшинд хүрэхийн тулд аймаг бүр дээрх үзүүлэлтүүдийг ямар байлгахаар төлөвлөх шаардлагатайг тооцоолон орууллаа (Хүснэгт 17-19).

Хүснэгт 17. Ажилгүйдлийн түвшиний зорилтот түвшин болон гүйцэтгэл, хувиар

Аймаг, бүс, улс	2016-2020	2015			2016		2017		2018.III		2019	2020	Гүйцэтгэлийн зөрүү			
		Суурь	Гүйц	Зорь	Гүйц	Зорь	Гүйц	Зорь	Зорь	Зорь	2016	2017	2018	Дунд		
Улсын хэмжээнд	ТХҮБ-ийн I үе шатны зорилтот түвшинг 6 хувь	7.5	10	7.2	8.8	6.9	6.9	6.6	6.3	6.0	-2.8	-1.9	-0.3	-1.7		
Говийн бүс		12.0	11.9	10.8	8.7	9.6	4.5	8.4	7.2	6.0	-1.1	0.9	3.9	1.2		
Говьсүмбэр		16.5	18.1	14.4	7.8	12.3	6.3	10.2	8.1	6.0	-3.7	4.5	3.9	1.6		
Дорноговь		14.0	9.9	12.4	6.1	10.8	2.6	9.2	7.6	6.0	2.5	4.7	6.6	4.6		
Дундговь		5.5	5.1	5.6	4.4	5.7	2.3	5.8	5.9	6.0	0.5	1.3	3.5	1.8		
Өмнөговь		11.8	14.3	10.6	16.4	9.5	6.8	8.3	7.2	6.0	-3.7	-6.9	1.5	-3.0		

Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол

Говийн дэд бүсийн 4 аймгийн хувьд 2018 оны 3-р улирлын байдлаар ажилгүйдлийн түвшин дунджаар 4.5 хувьтай байгаа нь улсын түвшин болох 6.9 хувиас 2.4 пунктээр өндөр байна. Хэдийгээр бүсийн түвшинд бага байгаа ч ажилгүйдлийн түвшин Өмнөговь аймагт 6.8 хувь, Говьсүмбэр аймагт 6.3 хувь байгаа тул эдгээр аймгууд 2020 оны зорилтот түвшиндээ хүрэхийн тулд 2019, 2020 онуудад ажилгүйдлийн түвшингээ жилд дунджаар 0.3-0.4 пунктээр бууруулах шаардлагатай байна.

ТХҮБ-ийн I үе шатны зорилтот хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг 66 хувь, II үе шатанд 68 хувь, III үе шатанд 70 хувьд хүргэнэ гэж заасан бол

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого дахь “Ажиллах хүчний нөөц ашиглалтын түвшин”-ний шалгуур үзүүлэлт болох ажиллах хүчний оролцооны түвшинг 2020 онд 66 хувь, 2025 онд 68 хувьд бол хүргэхээр заасан байдаг.

Хүснэгт 18. Ажиллах хүчний оролцооны түвшний зорилтот түвшин болон гүйцэтгэл, хувиар

Аймаг, бүс, улс	2016-2020 он	2015		2016		2017		2018.Ш		2019		2020		Гүйцэтгэлийн зөрүү			
		Суурь	Гүйц	Зорь	Гүйц	Зорь	Гүйц	Зорь	Зорь	Зорь	Зорь	Зорь	2016	2017	2018	Дунд	
Улсын хэмжээнд	ТХУБ-ийн I үе шатны зорилтот түвшин 66 хувь	61.5	60.5	62.4	61.1	63.3	61.3	64.2	65.1	66.0	1.9	2.2	2.9	2.3			
Говийн бүс		68.9	68.2	68.3	71.3	67.7	64.3	67.2	66.6	66.0	0.1	-3.5	2.8	-0.2			
Говьсүмбэр		64.7	62.0	65.0	69.0	65.2	52.9	65.5	65.7	66.0	3.0	-3.8	12.6	3.9			
Дорноговь		68.0	68.3	67.6	69.7	67.2	61	66.8	66.4	66.0	-0.7	-2.5	5.8	0.9			
Дундговь		73.1	73.4	71.7	77.6	70.3	79.8	68.8	67.4	66.0	-1.7	-7.3	-11.0	-6.7			
Өмнөговь		69.7	69	69.0	68.8	68.2	63.6	67.5	66.7	66.0	0.0	-0.6	3.9	1.1			

Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол

Судалгаанд хамрагдсан аймгуудын хувьд 2018 оны 3-р улирлын байдлаар энэхүү шалгуур үзүүлэлт нь дунджаар 64.3 хувьтай байгаа нь улсын түвшин болох 61.3 хувиас 3.0 пунктээр өндөр байгаа ч 2020 оны зорилтод түвшин болох 66 хувиас 2 орчим пунктээр доогуур байгаа тул 2019, 2020 онуудад жилд дунджаар 1 орчим пунктээр нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Тэр дундаа Говьсүмбэр аймаг нь зорилтод түвшингээс 13.1 пунктээр доогуур байгаа тул 2020 оны шалгуурыг хангахын тулд 2020 он хүртэл ажиллах хүчний оролцооны түвшингээ жилд дунджаар 6.5 пунктээр нэмэгдүүлэх шаардлагатай байна (Хүснэгт 18).

Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого дахь “Зохистой хөдөлмөр эрхлэлт”-ийг хэмжих үндсэн шалгуур болох хөдөлмөр эрхлэлтийн түвшинг 2020 онд 65.7 хувь, 2025 онд 70.0 хувьд хүргэнэ гэж заасан. Гэвч тус үзүүлэлт нь 2018 оны 3-р улирлын байдлаар улсын хэмжээнд 57.0 хувь, бүсийн хэмжээнд 62.7 хувьтай гарсан байна. Тус шалгуур үзүүлэлтийг одоогийн байдлаар хангаад байгаа нь Дундговь аймаг /77.9 хувь/ бол хамгийн тааруу үзүүлэлттэй нь Говьсүмбэр аймаг /49.6 хувь/ байна. Эдгээр аймгуудын хувьд 2020 он гэхэд ТХУБ болон ТХЭТББ-ын шалгууруудыг хангахын тулд хөдөлмөр эрхлэлтийн түвшинг Говьсүмбэр аймаг жилд дунджаар буюу 2019, 2020 онуудад 8 пунктээр, Дорноговь болон Өмнөговь аймгууд тус бүр 3 орчим пунктээр нэмэгдүүлэх хэрэгтэй байна (Хүснэгт 19).

Хүснэгт 19. Хөдөлмөр эрхлэлтийн түвшний зорилтот түвшин ба гүйцэтгэл /албан/, хувиар

Аймаг, бүс, улс	2016-2020 он	2015		2016		2017		2018.Ш		2019		2020		Гүйцэтгэлийн зөрүү			
		Суурь	Гүйц	Зорь	Гүйц	Зорь	Гүйц	Зорь	Зорь	Зорь	Зорь	2016	2017	2018	Дунд		
Улсын хэмжээнд	ТХУБ-ийн I үе шатны зорилтот түвшин 65.7 хувь	56.9	54.5	58.7	55.8	60.4	57.0	62.2	63.9	65.7	4.2	4.6	5.2	4.7			
Говийн бүс		60.8	60.3	61.8	65.2	62.7	61.6	63.7	64.7	65.7	1.5	-2.4	2.2	0.4			
Говьсүмбэр		54.0	50.8	56.3	63.5	58.7	49.6	61.0	63.4	65.7	5.5	-4.8	11.4	4.0			
Дорноговь		58.5	61.5	59.9	65.5	61.4	59.4	62.8	64.3	65.7	-1.6	-4.1	3.4	-0.8			
Дундговь		69.1	69.7	68.4	74.2	67.7	77.9	67.1	66.4	65.7	-1.3	-6.5	-10.8	-6.2			
Өмнөговь		61.5	59.1	62.3	57.5	63.2	59.3	64.0	64.9	65.7	3.2	5.7	4.7	4.5			

Эх сурвалж. Судалгааны багийн тооцоолол

Эдийн засгийн өсөлт, хөгжлийн хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөө гэсэн ерөнхий шалгуур үзүүлэлтийн өөр нэг үзүүлэлт бол ногоон ажлын байрны эзлэх хувь байгаа боловч энэ үзүүлэлт одоогоор аймаг

бүрээр гарах боломжгүй байна. Харин 2016 оны 2-р улиралд явуулсан “Байгаль орчны салбарын хөдөлмөр эрхлэлт, ногоон ажлын байр” туршилт судалгааны дүнгээс харахад, улсын хэмжээнд 9.8 хувьтай байна.

Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад зохистой хөдөлмөрийн үзүүлэлтүүд чухал үүрэгтэй. Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын хүрээнд тусгасан шалгуур үзүүлэлтийн нэг албан бус салбарын ажиллагчдын эзлэх хувийн биелэлтийг Ажиллах хүчний судалгаанаас гаргасан боловч аймгуудаас ирүүлсэн тайланд бусад үзүүлэлтүүдтэй харьцуулахад хамгийн бага хувьтай байсан. Энэ нь нэг талаас ТХҮЗ-2030-д заасан чухал шалгуурын нэг албан бус секторын бүртгэл, мэдээллийн систем хөгжөөгүй, эхлэлийн байдалтай байгаатай холбоотой байж болно. “Зохистой хөдөлмөрийг дэмжиж 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь: ТХЗ-ын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, Монгол улсын төлөв байдал” тайланд тусгасан зохистой хөдөлмөр, ТХЗ-той хамааралтай үзүүлэлтүүдийн төлөв байдлыг нарийвчлан гаргасныг дэлгэрэнгүйгээр 22-р хавсралтаар орууллаа.

4.7. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгасан шалгуур үзүүлэлтүүдийн төлөв байдал

Монгол улсын хувьд хөдөлмөр эрхлэлтийн салбарын орцын үзүүлэлтээр бид нийт 34 үндсэн үзүүлэлтийг авсан (Хавсралт 20). Эдгээр үзүүлэлтээс ТХҮБ-ийн шалгуур үзүүлэлтэд 9 /26.5 хувь/, ТХЭТББ-ийн шалгуур үзүүлэлтэд 10 /29.4 хувь/ нь тус тус ашиглагдаж байна (Хавсралт 21).

Дээрх хоёр хөгжлийн бодлогын баримтад тусгасан хөдөлмөр эрхлэлттэй холбоотой зорилтуудын шалгуурыг хэмжих болон бусад зорилгоор хэрэглэдэг хөдөлмөрийн салбарын голлох 13 индикатор байдагаас ТХҮБ-д 2 шалгуур /15.4 хувь/, ТХЭТББ-ийн 7 шалгуур /53.8 хувь/ нь ашиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн салбарын хөгжил болоод төлөв байдал, хүндрэл бэрхшээл зэргийг илэрхийлдэг эдгээр 13 индикатор нь улс орон бүрт чухал ач холбогдолтой хэдий ч ТХҮЗ, ТХЭТББ зэрэг хөгжлийн бодлогын гол баримт бичгүүдийн шалгуур үзүүлэлтэд оруулаагүй орхигдсон чухал үзүүлэлт цөөнгүй байна.

Тиймээс ТХҮБ, ТХЭТББ, ЗГҮАХ, БХҮБ, аймгуудын хөгжлийн хөтөлбөр зэрэг улс, бүс, аймгуудын хөгжлийн хөтөлбөр дэх хөдөлмөрийн салбартай холбоотой төлөвлөлт, түүний хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтэд хөдөлмөрийн бүтээмж, хөдөлмөрийн мэдрэмж зэрэг зарим индикаторуудыг оруулж, тооцдог байх нь тус салбарын хөгжилд чухал ач холбогдолтой.

Монгол улсын хөдөлмөрийн салбарын хувьд “Тогтвортой хөгжлийн зорилго-2030”-ын хэрэгжилтийн хүрээнд тооцвол зохих зохистой хөдөлмөрийн үзүүлэлтүүдийн төлөв байдлын дэлгэрэнгүйг хавсралт 22-д тусгалаа.

5. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

1. Хүн ам зүйн болоод хөдөлмөрийн үндсэн үзүүлэлтүүдийн 2-10 жилийн өөрчлөлтөөс харахад, хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал говийн дэд бүсийн аймгуудад харилцан адилгүй дүр зураг харагдаж байна.
 - **Говьсүмбэр аймгийн хувьд** говийн аймгууд дотроос ЭЗИХА болоод ажиллагчдын тооны өсөлтийн дундаж хурд өндөр (1.11), ажиллах хүчний оролцооны түвшин 2007 онтой харьцуулахад 2017 онд 36 хувиар, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 38 хувиар тус тус өссөн, харин дундаж цалин 2.8 дахин өсөлттэй ч улсын дунджаас 7.4 хувиар доогуур байна. Ажилгүйдлийн түвшин 2017 оны байдлаар 7.8 хувь байгаа нь улсын дунджаас 1 пунктээр доогуур байна.
 - **Дорноговь аймаг** говийн аймгуудаас ажилгүйчүүдийн тооны дундаж хурд (0.97) бага, 2007 онтой харьцуулахад 2017 онд ажиллах хүчний оролцооны түвшин 18 хувиар, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 13 хувиар тус тус өссөн, дундаж цалингийн өсөлт өндөр (4.7 дахин) байгаа ч улсын дунджаас 11 хувиар бага байна. Сүүлийн 2 жилийн байдлаар ажилгүйдлийн түвшин буурч 2017 онд 6.1 хувь байгаа нь улсынхтай харьцуулахад 1.7 пунктээр бага байна.
 - **Дундговь аймгийн хувьд** говийн аймгууд дотроос сүүлийн 10 жилийн байдлаар ажиллах хүчний оролцооны түвшин болоод ажилгүйдлийн түвшний өөрчлөлт хамгийн бага (1.75), 2017 оны байдлаар ажилгүйдлийн түвшин хамгийн бага (4.4), хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж ойрын 3 жилийн хөдөлмөрийн эрэлт ба нийлүүлэлтээ ажил мэргэжлээр тодорхойлсон зэрэг онцлог давуу талууд байгаагийн зэрэгцээгээр хүн амын тооны өсөлт дэд бүсийн дунджаас 50 хувь бага, Монгол улсын нийт хүн амд эзлэх хувь эрс буурсан, мөн цаашид буурах төлөвтэй байгаа (1990 онд 2.4 % байсан бол 2010 онд 1.4, 2030 онд 1.3 %), сарын дундаж цалингийн хэмжээ улсын дунджаас эрс доогуур (32.2 хувь) байна.
 - **Өмнөговь аймгийн хувьд** говийн аймгууд дотроос сарын дундаж цалингийн түвшин өндөр, хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэдийн тоо болоод эзлэх хувь хамгийн өндөр (улсын хэмжээнд ажиллаж буй нийт гадаадын иргэдийн ¼ нь Өмнөговь аймагт ногдож байна), орон нутгийн түвшинд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр олон дэд хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа зэрэг давуу талуудтай боловч ажиллах хүчний оролцооны түвшин 2007 онтой харьцуулахад 11.8 хувиар, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 25.1 хувиар буурч, 2017 оны ажилгүйдлийн түвшин (16.4)-г улсынхтай харьцуулахад өндөр (1.86 дахин), шилжин явалтын түвшин ирэлтээсээ их байна. Түүнчлэн 15 ба түүнээс дээш ажиллагчдын тооны өөрчлөлтөөс ойрын ирээдүйд хөдөлмөрийн насны хүн амын тоо буурч, тэтгэврийн насных өсөх төлөв ажиглагдаж байгаа тул хөдөлмөрийн нөөцийн дутагдалд орох магадлал өндөр байна.
2. Говийн дэд бүсийн хувьд сүүлийн 3 жилээр аваад үзэхэд, хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдал алдагдаж, нийлүүлэлтийн хомсдол аймаг бүрт байгаагийн зэрэгцээ ажлын байр ашиглалтын түвшин буурч байна. Үүнийг аймаг бүрээр авч үзвэл:
 - **Говьсүмбэр аймгийн хувьд** сүүлийн 2 жилд хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэр алдагдаж, хөдөлмөрийн нийлүүлэлтийн хомсдол 2018 онд өмнөх оны мөн үеэс 9.4 дахин нэмэгдсэн байна. Ажлын байр ашиглалтын хувь эрс хэлбэлзэлтэй байна. 2016 онд говийн аймгуудаас хамгийн бага (39.7%) байсан бол 2017 онд өмнөх оноосоо 2.4 дахин нэмэгджээ. Ажил мэргэжлийн ангиллаар аваад үзвэл, сүүлийн 3 жилд хамгийн олон хүнийг энгийн ажил мэргэжилд (290), мэргэжилтэн (232)-г ажилд зуучлан оруулжээ.

- **Дорноговь аймаг** говийн аймгуудаас сүүлийн 2 жилд ажлын байр ашиглалтын түвшин өндөр (96.6%) байгаа нь 2016 онтой харьцуулахад 45 пунктээр нэмэгджээ. Энэ хугацаанд хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэр алдагдсан байгаа ч нийлүүлэлтийн хомсдол 2018 онд 17.3 хувиар буурсан байна.
 - **Дундговь аймгийн хувьд** 2018 онд ажлын байрны захиалгыг 2017 онтой харьцуулахад буурсан (29.9 %) ч ашиглалтын түвшин нэмэгдсэн дүр зураг харагдаж байна.
 - **Өмнөговь аймгийн хувьд** сүүлийн 3 жилийн байдлаар ажлын байрны ашиглалтын хувь эрс буурч байгаа (90.7-45.6 %) төдийгүй говийн аймгууд дотроос хамгийн бага (45.6 %), мөн хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэр алдагдаж, нийлүүлэлт хамгийн олон (1932) хүнээр хомсдолтой байна.
3. Салбар хоорондын балансын тооцооллоос харахад, улсын хэмжээнд эдийн засгийн 20 салбар тус бүрд 1 тэрбум төгрөгийн хөрөнө оруулалт нэмэгдвэл нийт 1268 ажлын байр шинээр бий болж байгаагаас гадна үйлчилгээний бусад, ХАА, боловсрол зэрэг салбарт хамгийн их ажлын байр нэмэгдэж байна. Харин говийн дэд бүсийн аймгуудаас салбар хоорондын тэнцэл дэх ажил эрхлэлтийн үржүүлэгч хамгийн өндөртэй нь Говьсүмбэр, хамгийн бага гарсан нь Өмнөговь аймаг байна.
 4. Говийн дэд бүсийн 4 аймагт нийт 17 төрлийн 127 ЖДҮ баригдвал шуудаар 1870 хүн ажлын байртай болохоос гадна шууд бус байдлаар нийт 6258 хүн тус өгөөж хүртэх боломжтой ба эдгээрийг барихад 20,76 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдахаар байна.
 5. Шинээр бий болох 1870 ажлын байрны 80 орчим хувийг дэд бүсийн аймгуудын хөдөлмөрийн зах зээл дээр байгаа ажилгүйчүүдийг давтан сургалтад хамруулах болоод МСҮТ-ээр дамжуулан бэлтгэх боломжтой. Харин хүнс ба хөнгөн үйлдвэрийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх боломжийг эрэлхийлэх шаардлага байна.
 6. ОУХБ-ын гурван үндсэн конвенцийг Монгол улс соёрхон баталсан байна: Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай ОУХБ-ын 122 дугаар конвенци (1976), Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай ОУХБ-ын 88 дугаар конвенци (2016), Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай ОУХБ-ын 181 дүгээр конвенци (2016).
 7. Монгол улсад хөдөлмөрийн харилцааг шууд зохицуулах Хөдөлмөрийн тухай хууль (1999), Төрийн албаны тухай хууль (2017), Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль (2008), үндсэн 4 хуулиас гадна Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай (2001), Нийгмийн даатгалын тухай багц хууль (1994), Эрүүл мэндийн даатгалын тухай хууль (2015), Хувь хүний орлогын албан татварын тухай (2006), Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль (2010), Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль (2009), Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль зэрэг дагалдах хуулиуд үйлчилж байна.
 8. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөдөлмөрийн тухай хууль 1999 онд батлагдсанаас хойш 18 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ. Одоо энэ хуулийн шинэчилсэн найруулга УИХ-д өргөн баригдсан байна.
 9. Хөдөлмөрийн салбарт Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар 2016-2025 онд баримтлах бодлого (2016), Ажил, мэргэжлийн чиг баримжааг 2016-2020 онд хөгжүүлэх чиглэл (2016), Цалин хөлсний талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого (2012) гэсэн дунд, урт хугацааны бодлогын баримт бичгүүд хүчин төгөлдөр үйлчилж байгаагаас гадна 2015 оноос хойш богино хугацааны Ажлын байрыг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжих,

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт гарааны бизнесийг дэмжих, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг дэмжих, Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох, Нийтийг хамарсан ажил зохион байгуулах, Залуучууд, мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг хөтөлбөрүүд үндэсний хэмжээнд хэрэгжсээр байна.

10. Дээрх хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөрүүдээс гадна аймаг орон нутгийн төрийн албан хаагч, иргэд, сурагч, оюутан залуучуудын авъяас чадварын хөгжил, хөдөлмөрийн дадал туршлага олгох, иргэдийн эрүүл зан үйл, амьдрах зөв арга барил болоод шинээр ажлын байр бий болгоход чиглэсэн дараах хөтөлбөр, дэд хөтөлбөрүүд хэрэгжиж байна.
 - **Говьсүмбэр аймагт** “Боловсролыг дэмжих”, “Төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ёс зүйг сайжруулах”, “Залуучуудын хөгжлийг дэмжих”, “Зорилтот бүлэгт чиглэсэн”, ЖДҮҮ-г хөгжүүлэх дэд хөтөлбөрүүд;
 - **Дорноговь аймагт** “Хөрш орноосоо суралцъя”, “Орлоготой залуу”, “Оюутан ажлын байр”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”, “Ажлын байр” зэрэг дэд хөтөлбөрүүд;
 - **Дундговь аймагт** “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих”, “Архидалтгүй аймаг-Дундговь”, “Гэрээт малчин-Өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих” төсөл;
 - **Өмнөговь аймагт** “Орон нутагт дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх”, “Дадлагажигч оюутан”, “Оюутан залуусыг дэмжих”, “Говийн тэтгэлэг”, “Шинэ төгсөгчид”, “Мэргэжил олгох”, “Оюуны хурд”, “Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тусламж дэмжлэг үзүүлэх”, “Зөгийн үүр”, “Англи хэлтэй Өмнөговьчүүд”, “Говийн дэмжлэг”, “Хүүхэд хөгжлийн түлхүүр” хөтөлбөрүүд.
11. Монгол улсын ТХҮЗ-2030-ийг аймгуудын мастер төлөвлөгөө эсхүл цогц бодлогын зорилтуудын уялдааны нийцэл говийн дэд бүсийн хувьд 72.2 хувь, харин Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай нийцлийн хувь (аймгуудын дүн) хамгийн бага буюу 54.2 хувь байна. Гэтэл Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай уялдах уялдаа хамгийн бага буюу нийцлийн ерөнхий хувь 16.7 хувь байна.
12. Аймгуудын хөгжлийн бодлого, төлөвлөгөө нь МУЗГ-ын мөрийн хөтөлбөр болоод төрөөс хүн ам болоод хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлоготой уялдаж байгаа уялдаа гаргаж харахад, говийн дэд бүсийн нийцлийн ерөнхий хувь 68.5 хувь байна. Аймаг бүрээр харилцан адилгүй байгаагаас Дорноговь аймаг 74.2%, Говьсүмбэр -64.5%, Дундговь-58.1%, Өмнөговь - 77.4 % байна.

6. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

1. Улсын хэмжээний нийт хүн амд Говийн дэд бүсийн хүн амын тооны эзлэх хувь буурч, зорилтот аймгуудад хүн амын шилжин явалт ирэлтийн түвшнээс өндөр байна. Энэ нь цаашид говийн бүсэд хөдөлмөрийн нөөц буурах нөхцөл болж байна.
2. Сүүлийн 10 жилд говийн дэд бүсийн аймгуудын ажилгүй иргэдийн тоо (5.8 дахин), ажилгүйдлийн түвшин (4.34 дахин) үлэмж өссөнд Өмнөговь аймгийн ажилгүй иргэд, ажилгүйдлийн түвшин хамгийн ихээр нөлөөлжээ.

3. Говийн дэд бүсийн хувьд хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдал алдагдаж, нийлүүлэлтийн хомсдол аймаг бүрт байгаагийн зэрэгцээ ажлын байр ашиглалтын түвшин буурах хандлагатай байна.
4. Говийн дэд бүсийн 4 аймгийн хөгжлийн хөтөлбөр дэх хөдөлмөрийн салбарт дараах онцлох асуудал, боломж ба шийдлүүд байж болохоор байна. Үүнд:

Дорноговь аймаг: Аймгийн хөгжлийн хөтөлбөр нь бүсийн хөгжлийн давуу тал, нөөц боломжид тулгуурлан судалгаанд суурилсан хөдөлмөрийн зах зээлийн бодлогыг үндсэн чиглэлээ болгосон байна. Цаашид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах; ажлын байр хадгалан, шинээр нэмж буй ажил олгогчийг урамшуулах; гарааны бизнес эрхлэгч иргэдийг дэмжих; хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлж, ажлын байраар хангах; төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогын уялдааг сайжруулах түлхүү анхаарах.

Говьсүмбэр аймаг: Аймгийн хөгжлийн цогц бодлогод хүний хөгжлийг бүхий л талаар дэмжих, байнгын болон улирлын ажлын байрыг нэмэгдүүлж, нийгмийг бүтээхэд оролцдог иргэдийн тоог нэмэгдүүлэхэд чиглэжээ. Тус аймгийн хувьд ажиллах хүчний оролцооны түвшин болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин бусад 3 аймгаасаа доогуур гарсан. Цаашид иргэдийнхээ хөдөлмөрлөх эрхийг хамгаалах; бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих; нийгмийн түншлэлийг төлөвшүүлэхэд чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогоор дамжуулан хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг оновчтой, үр ашигтай болгох; томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэх; албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулах тал дээр түлхүү анхаарах нь шаардлагатай байна.

Дундговь аймаг: Аймгийн хөгжлийн бодлогод эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцөл боломж, хөдөлмөрийн аюулгүй байдал, хүний нөөцийг чадавхижуулах, зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд түлхүү анхаарсан байна. Тус аймгийн хувьд бусад 3 аймагтай харьцуулбал дундаж цалин хамгийн багатай байгаа. Цаашид хүн амын бүлгүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлт болон ажлын байрны тогтвортой байдлыг урамшуулах; эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх; орон гэргүй, тэнэмэл, ажилгүй, ядуу хөдөлмөрийн чадвартай иргэдийг мэргэжлийн боловсролын сургалтад хамруулж, ажил хөдөлмөрт татан оролцуулах, бүтээмж, ур чадварыг хөгжүүлэх үндсэн дээр цалин хөлсийг нэмэгдүүлэхэд анхаарах.

Өмнөговь аймаг: Аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөөнд аймаг, бүсийн хөгжлийн давуу тал, нөөц боломжид тулгуурлан ЖДҮ, үйлчилгээг дэмжих замаар ажлын байрыг бий болгох; малчдын хөдөлмөр эрхлэлт болон хувь хүнийг чадваржуулах асуудлыг түлхүү тусгасан байна. Гэвч тус аймгийн хувьд ажилгүйдлийн төвшин хамгийн өндөр байсаар байна. Тиймээс цаашид орон нутагтаа шинээр ажлын байр бий болгож, түр болон байнгын тогтвортой ажлын байрыг нэмэгдүүлж, ажилчдынхаа өмнө тавьсан нийгмийн хариуцлагаа тогтмол хэрэгжүүлж буй ажил олгогч ААНБ-уудад төрөл бүрийн тусламж, дэмжлэг үзүүлэх; хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулж, осол, гэмтлийн улмаас нас барах явдлыг тогтвортой бууруулах; хүн амыг олдмол хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх зэрэг зорилтуудыг хөгжлийн бодлогодоо тодорхой тусгаж, хэрэгжүүлэхээс гадна хөдөлмөрийн зах зээлийн судалгаанд тулгуурлан ажиллах ажилгүйдлийг бууруулах дэд хөтөлбөр хэрэгжүүлэх.

5. Улсын хэмжээнд ажиллах хүчний ашиглалт, хөдөлмөрийн эрэлт ба нийлүүлэлтийн шинжилгээ хийхэд ажилгүйчүүд, ААНБ-д ажиллагчдын мэргэжлийн талаарх мэдээлэл байхгүй, мөн сумдын түвшинд хөдөлмөрийн салбарын үндсэн үзүүлэлтүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл байхгүйгээс тэдгээрийн ажиллах хүчний ашиглалт, хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдал дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байна.
6. Зорилтот аймгуудад албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн систем хөгжөөгүй байгаагаас улбаалан хөдөлмөрийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага, тус салбарт шаардагдах ажиллах хүчний зах зээлийн нарийвчилсан судалгааг боловсруулахад хүндрэлтэй байна.
7. Улсын хэмжээнд ажил эрхлэлтийн үржүүлэгч хамгийн ихтэй салбаруудад ХАА, бусад үйл ажиллагаа; үйлчилгээ зэрэг салбарууд байгаа бол уул уурхай, олборлолт; үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа; мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа зэрэг салбарууд нь хөдөлмөрийн үржүүлэгч хамгийн багатай гарсан байна.
8. Хөрөнгө оруулалтын нөлөөгөөр өөрийн салбарын ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх шууд нөлөө нь 4 аймгийн дунджаар 84.2 хувь, бусад салбарын ажил эрхлэлтэд үзүүлж буй шууд бус нөлөө нь 15.8 орчим хувь гарсан нь улсын дүнтэй харьцуулахад шууд нөлөө нь харьцангуй өндөр байгааг харуулж байна. Ажил эрхлэлтийн үржүүлэгч нь Говьсүмбэр аймагт бөөний болон жижиглэн худалдаа, засвар, үйлчилгээ; Өмнөговь аймагт цахилгаан, хий, уур, агааржуулалт, хангамж; Дорноговь аймагт барилга; Дундговь аймагт уул уурхай, олборлолтын салбаруудад хамгийн өндөр гарсан байна.
9. Мэдээлэл, харилцаа холбооны техник технологийн дэвшил нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт ба нийлүүлэлт, хөдөлмөр эрхлэлт, ажлын байр, ажил мэргэжил, ур чадварын өөрчлөлтөд ихээхэн нөлөөлж байгаагаас гадна дэлхийн хэмжээнд ажилгүйдэл, ажилгүйдэлд өртөж болзошгүй ажиллагчид, ажилтай ядуучуудын тоо өсөх хандлагатай байгааг олон улсын байгууллагуудын судалгааны үр дүн харуулж байна.
10. Хөдөлмөрийн харилцаа хэлбэр, агуулгын хувьд өргөжин гүнзгийрч хөдөлмөр эрхлэлтийн гурвалсан харилцаа, хагас цагаар болон зайнаас ажиллах, хувь хоорондын гэрээгээр ажиллах, алслагдмал газар байрлаж ажил үүргээ гүйцэтгэх зэрэг шинэ хандлага, арга хэлбэр нэвтэрсээр байхад одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулах боломжгүй байна.
11. Аймгуудын хөгжлийн мастер төлөвлөгөө эсхүл стратеги төлөвлөгөөний зорилтууд нь үндэсний хэмжээний бусад хөгжлийн бодлого эсхүл хуулийнхтай харьцуулахад Монгол улсын МХЗ-д суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлоготой илүү сайн уялдсан (81.25 %) байна. Харин эсрэгээрээ, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай тун хангалтгүй буюу хамгийн бага (16.7 %), Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай тааруу (54.2 %) байна.
12. Аймгуудын хөгжлийн төлөвлөгөө эсхүл цогц бодлогыг боловсруулж баталсан хугацааны хувьд МУЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийнхтэй нэлээд зөрүүтэй хэдий ч хөдөлмөрийн салбарт дэвшүүлсэн зорилтуудын нийцлийн хувь бүх аймгуудад жигд (75 %) байгаа нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байр бий болгох замаар ажилгүйдлийг бууруулах асуудал нийгмийн салбарын бодлогын гол асуудал байсаар байгааг харуулж байна.
13. Аймгийн хөгжлийн бодлогын баримт бичгүүд болон хөдөлмөрийн салбарт хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүд хоорондын уялдаа Говьсүмбэрээс бусад аймагт харьцангуй сайн байгаа ч хэрэгжилтийг дүгнэхдээ ерөнхийлөх хандлага давамгайлж байна.

7. НЭГДСЭН САНАЛ, ЗӨВЛӨМЖ

ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД

1. Монгол улсын дунд болоод урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан хөдөлмөрийн салбарын шалгуур үзүүлэлтүүдийг бүс нутаг, аймгийн түвшинд хэрхэн буулгаж тооцон төлөвлөх талаар нэгдсэн удирдамж эсхүл чиглэл гаргах нэн шаардлагатай байна;
2. Хиймэл оюун ухааны хөгжлийн нөлөө(хүний хөдөлмөрийг машин техник орлох)-гөөр зарим ажил мэргэжил устаж/шинээр бий болох зэрэг олон улсын хөдөлмөрийн зах зээл дээр гарч буй томоохон өөрчлөлтүүдийг үндэсний хэмжээнд буулган судалж, ирээдүйд эрэлттэй байх ажил мэргэжлийн эрэлт ба нийлүүлэлтийн талаар суурь судалгаа хийх, нийлүүлэлтийг хангах дунд ба урт хугацааны бодлого боловсруулж хэрэгжүүлэх нэн шаардлагатай байна;
3. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээл, ажил мэргэжил, ажлын байранд тавигдах шаардлагад гарах ирээдүйн төлөв байдалтай уялдуулан Монгол улсын хувьд 2025, 2035, 2045 онд бэлтгэх мэргэжилтний дүр зургийн талаар урьдчилсан төсөөлөл гаргах нэн шаардлагатай байна. Энэхүү төсөөлөлтэй уялдуулан суурь боловсролоос эхлэн бүх шатны боловсролын тогтолцоо болоод стандартад өөрчлөлт оруулах талаар бодлогын судалгааг ойрын жилүүдэд хийх хойшлуулшгүй хийх хэрэгтэй;
4. Салбар хоорондын уялдааг хангах замаар Үндэсний хөрөнгө оруулалт/бүтээн байгуулалтын төлөвлөлттэй уялдуулан МБСБ болоод их дээд сургуульд элсэн суралцах мэргэжлийн чиглэлийг тогтоодог байх хэрэгтэй;
5. Хөдөлмөрийн статистикийг гаргахдаа ажиллагчид, ажилгүй иргэдийг мэргэжлээр нь дэлгэрэнгүй гаргах, үндэсний хэмжээнд хөдөлмөрийн баланс гаргадаг болох;
6. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн системийг сайжруулах шаардлагатай байна.
7. Улсын хэмжээний бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хүрсэн түвшинд бодитойгоор үнэлгээ өгөх, зорилтот түвшинд хүрэх зөвлөмж өгөх үнэлгээ, мониторингийн системийг хөгжүүлэх шаардлагатай байна.

ГОВИЙН ДЭД БҮСИЙН ТҮВШИНД

1. Монгол улсын нийт хүн амд говийн дэд бүсийн хүн амын эзлэх хувь жилээс жилд буурсаар байгаа тул дэд бүсийн хэмжээнд хүн амын өсөлтийг дэмжих чиглэлээр тусгайлсан бодлого, хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх нэн шаардлагатай байна.
2. Бүс болоод дэд бүсийн түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн нэгдсэн удирдлага, зохицуулалтыг ямар байгууллага хийх/удирдлага зохион байгуулалтын талаар холбогдох хуульд тусгах хэрэгтэй;
3. Говийн дэд бүсийн аймгуудад томоохон бүтээн байгуулалтууд баригдах үед зарим салбар дахь ажиллах хүчний эрэлтэд хомсдол үүсэх төлөвтэй байгаа тул бусад орон нутгаас хэзээ, хэдий хэмжээний, ямар мэргэжилтэй хүн татах, өөрийн нөөц боломжоо хэрхэн оновчтой ашиглах, цаашид орон нутгууд дахь МСҮТ-үүдэд ямар мэргэжилтэн хэдий хэмжээгээр, хэрхэн бэлтгэх талаар нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4. Дэд бүсийн хувьд МАА-г эрчимжүүлэх, тэр тусмаа тэмээн сүргийг хөгжүүлж, түүнээс гарах түүхий эд бэлтгэлийн нийлүүлэлтийн сүлжээг говийн дөрвөн аймаг нэгдсэн байдлаар хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх боломжтой;
5. Өмнөговь аймгийн хөдөлмөрийн салбарт хэрэгжиж буй зарим дэд хөтөлбөр (Орон нутагт дутагдалтай хүний нөөцийг бүрдүүлэх дэд хөтөлбөр, шинэ төгсөгчдийн хөтөлбөр, Говийн дэмжлэг зэрэг)-үүдийг өргөтгөн бусад говийн дэд бүс төдийгүй бусад бүсэд “сайн туршлага” болгон хэрэгжүүлэх хэрэгтэй.
6. Дэд бүсийн хэмжээнд дутагдалтай байгаа хөнгөн болоод хүнсний үйлдвэрийн чиглэлээр нарийн мэргэжлийн ажилчид, тухайлбал, хүнсний технологич, чанар шалгагч, мэргэжлийн ажилчдыг бэлтгэхэд тухайн орон нутагт байгаа МСҮТ-үүд анхаарч, шинэ мэргэжлийн анги нээх шаардлага байна. Хөнгөн ба хүнсний үйлдвэрийн технологич, хөргөлтийн инженер, малын эмч, цахилгааны инженер, агрономич, микробиологич мэргэжлээр үндэсний их, дээд сургууль төгсөгчдийг татах эсхүл захиалгаар бэлтгэх шаардлага байна. Үүний тулд дэд бүс дотроо ажиллах хүчээ солилцох, шижлин ажиллах боломжийг хайх, МСҮТ-эд захиалгаар хэрэгцээтэй байгаа мэргэжлээр мэргэжилтэй ажиллах хүч бэлтгэхэд хөгжлийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг бүсийн түвшинд бодлогоор дэмжих, урамшуулах, нэгдсэн зохицуулалт хийх шаардлага байна.

АЙМГИЙН ТҮВШИНД

1. Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан хөдөлмөрийн салбарын үндсэн шалгуур үзүүлэлтүүд (ажилгүйдлийн түвшин, ажиллах хүчний оролцооны түвшин, хөдөлмөр эрхлэлтийн түвшин)-ийн 2020 оны зорилтот түвшинд хүрэхийн тулд ажилгүйдлийг бууруулах, ажиллах хүчний оролцоо болоод хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөр, үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх, үр дүн, нөлөөг сайжруулах;
2. Аймгууд тодорхой давтамжгайгаар хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийн ажилгүйдэл болоод ажиллах хүчний хомсдолын шалтгааныг тодорхойлж, аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөө боловсруулахдаа тухайн орон нутгийнхаа хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэргэжилтэн, мэргэжилтэй ажиллах хүчийг бэлтгэх болоод тэдний ашиглалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
3. Салбар хоорондын балансын матрицийн хэмжээнээс хамаараад хөрөнгө оруулалт болон бусад орцуудын гарцад үзүүлэх нөлөө нь харилцан адилгүй байдгаас гадна, аймгуудын түвшинд тооцоолол хийхэд учир дутагдалтай байгаа. Тиймээс орон нутгийн хувьд эдийн засгийн салбаруудад оруулсан орц болон гарцын харилцан уялдааг тооцож, төлөвлөхдөө Top-Down аргаар бус Down-Top аргаар үнэлэх нь илүү тохиромжтой гэж үзэж байна.
4. Аймгуудын статистикийн газар нь салбар хоорондын баланс болон бусад макро түвшний статистик мэдээллийн баазыг тогтмол гаргаж, мэдээлж байх. Орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт боловсруулагчид нь ажиллах хүч болон бусад нөөцөд тулгуурласан аймгийн салбар хоорондын балансын шинжилгээг ашиглан шийдвэр гаргах нь зүйтэй байна.
5. Орон нутгуудад үйлдвэржилтэд шаардагдах хүний нөөц болон бусад нөөцийн нарийвчилсан тооцоолол хийх, түүн дээрээ тулгуурлан хөгжил, байршлаа төлөвлөж байх нь чухал.
6. Хөдөлмөрийн салбарын чиглэлээр олон улсын болоод үндэсний хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд заасан чухал шалгуур үзүүлэлтүүд болох зохистой ажлын байр, ногоон ажлын байр бий болгоход чиглэсэн ус бага ашиглах эсхүл хэмнэлттэй технологийг нэвтрүүлэх, уул уурхайн нөхөн сэргээх, ойжуулах болоод нийлүүлэлтийг сүлжээг үүсгэн байгуулсанаар шинээр бий

болох ажлын байрыг түлхүү дэмжих, дээрх санаачилгыг өрнүүлэн ажил хэрэг болгож буй ААНБ-ын үйл ажиллагаа, жижиг дунд бизнесийг бодлогоор дэмжин, урамшуулах;

7. Аймгийн түвшинд бизнесийн загваруудыг өөрчлөх замаар ажлыг баяжуулах, төрөлжүүлсэнээр ажил олгогчдын зүгээс шинээр тавих шаардлагад нийцсэн мэдлэг, ур чадвар, төлөвшилтэй ажиллах хүчин бэлтгэх болоод ахмад настны ур чадвар, туршлагыг ашиглах зорилгоор коуч, менторийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
8. Аймгийн түвшний бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хүрсэн түвшинд бодитойгоор үнэлгээ өгөх, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх, зорилтот түвшинд хүрэх зөвлөмж өгөх үнэлгээ, мониторингийн системийг хөгжүүлэх шаардлагатай байна.
9. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд тухайн аймаг доторх зах зээл болоод өөрчлөлтийг судлах, нөөцийн өөрчлөлт болоод ирээдүйд гэнэт гарах томоохон өөрчлөлт, аймаг орон нутгийн нөөцүүдийн шилжилтийн төлвийг таамаглан хөгжлийн бодлогод нийцүүлэх талаар санал оруулах чиг үүрэг бүхий Судалгааны нэгж байгуулах.

8. АШИГЛАСАН МАТЕРИАЛ, ЭХ СУРВАЛЖУУД

1. Frank Cörvers and Maud Hensen. Forecasting regional labour-market developments by occupation and education. **Available at:** (Accessed: 25 February 2019).
2. Linda Scott, Dr John Buchanan, Dr Tanya Bretheron. Better workforce planning Reflections on recent experiences in Norway, Singapore, the UK and the USA. **Available at:**
https://docs.education.gov.au/system/files/doc/other/better_workforce_planning_paper-2011.pdf
(Accessed: 25 February 2019).
3. Guidelines for an Employment and Labour Market Analysis (ELMA) published by GIZ, 2014 **Available at:**
http://www2.giz.de/wbf/4tDx9kw63gma/201403_Guidelines_Employment%20Analysis_ELMA_Final_web.pdf
(Accessed: 15 December 2018).
4. World Employment and Social Outlook – Trends 2018. **Available at:**
<https://www.ilo.org/global/research/global-reports/weso/2018/lang--en/index.htm> (Accessed: 10 January 2019).
5. World Employment and Social Outlook 2018: Greening with jobs. **Available at:**
https://www.ilo.org/global/publications/books/WCMS_628654/lang--en/index.htm (Accessed: 10 January 2019).
6. The future of jobs reports 2018, World Economic Forum. **Available at:**
http://www3.weforum.org/docs/WEF_Future_of_Jobs_2018.pdf (Accessed: 10 January 2019).
7. ҮСХ, ОУХБ. “Зохистой хөдөлмөрийг дэмжиж 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь: ТХЗ-ын хэрэгжилтийн хяналт шинжилгээ, Монгол улсын төлөв байдал” тайлан, 2019
8. ХНХЯ-ны статистик мэдээлэл
9. ХХҮЕГ-ын сарын танилцуулга
10. ХНСИ. Барометрийн судалгаа 2018
11. Дундговь аймгийн хөдөлмөрийн зах зээлийн судалгаа-2018
12. ҮСГ. Статистик мэдээллийн нэгдсэн сан. www.1212.mn
13. Хуулийн мэдээллийн нэгдсэн сан. www.legalinfo.mn
<http://citeseerx.ist.psu.edu/viewdoc/download?doi=10.1.1.521.6707&rep=rep1&type=pdf>

9. ХАВСРАЛТ

Хавсралт 1. Хөдөлмөрийн салбартай хамааралтай бодлогын үндсэн баримт бичгүүд

Бодлогын баримт бичгийн төрөл	Бодлогын баримт бичиг	Батлагдсан баримт бичгийн тоо	Хөдөлмөрийн салбартай хамааралтай баримт бичгийн нэр	Батлагдсан огноо	Баталсан субъект	Хүчин төгөлдөр эсэх		
Урт (15-20 жил)	Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал	3	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	2016.02.05	УИХ-ын тогтоол №19	Тийм		
			Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал	2001.06.14	УИХ-ын тогтоол №57	Тийм		
			Монгол Улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого 2007-2021	2008.01.31	УИХ-ын тогтоол №12	Үгүй		
Дунд 3-10 жил	3-5 жил	1	МҮЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр (2016.09.09)	2016.09.09	УИХ-ын тогтоол №45	Тийм		
		51	Зорилтот аймгууд болон сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрүүд	2016	Аймгийн болоод сумдын ИХТ-дийн тогтоол	Тийм		
		5	Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр(2016-2021)	2016	ЗГ-ын тогтоол №304	Тийм		
			Ажил, мэргэжлийн чиг баримжааг хөгжүүлэх чиглэл /2016-2020 он/ батлах тухай	2016	Хөдөлмөрийн сайд, БСШУС-ын хамтарсан А165/А266	Тийм		
			Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 5 дахь хөтөлбөр	2017	ЗГ-ын тогтоол №304	Тийм		
			Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр	2018	ХЭҮЗ-ийн тогтоол №02	Тийм		
			“Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр	2018	ЗГ-ын тогтоол №36	Тийм		
		1	Хөгжлийн бодлого	1	Гурван тулгуурт хөгжлийн бодлого	2018	ЗГ-ын тогтоол №42	Тийм
		1	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр	1	Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр	2018	ЗГ-ын тогтоол №140	Тийм

8-10 жил	Төрөөс баримтлах бодлого	3	Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого	2006.01.05	УИХ-ын тогтоол № 01	Үгүй
			Цалин хөлсний талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого батлах тухай (2012-2021)	2012.10.31	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны тогтоол № 01	Тийм
			Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого	2016.06.13	ЗГ-ын тогтоол №320	Тийм
	Аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт	51	---	2016	Аймгийн ИХТ-дийн тогтоол	
Богино (1 жил)	Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	1	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	2017.05.31	УИХ-ын тогтоол №42	
	Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл	51	Зорилтот аймгууд болон сумдын 2018 онд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлүүд	2017	Аймаг, сумдын ИХТ- дийн тогтоол	
	Улсын болон орон нутгийн төсөв	1	Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль (2016.11.14)	2016		
	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр богино хугацаанд хэрэгжиж буй хөтөлбөрүүд	5	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох	2019.01.14	ХЭҮЗ-ийн тогтоол № 01	Тийм
			Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	2019.01.14	ХЭҮЗ-ийн тогтоол № 01	Тийм
			Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	2019.01.14	ХЭҮЗ-ийн тогтоол № 01	Тийм
			Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	2019.01.14	ХЭҮЗ-ийн тогтоол № 01	Тийм
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр			2019.01.14	ХЭҮЗ-ийн тогтоол № 01	Тийм	
Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	2019.01.14	ХЭҮЗ-ийн тогтоол № 01	Тийм			


Хавсралт 2. Хөдөлмөрийн салбарт хамааралтай ОУ-ын конвенци, холбогдох хуулийн жагсаалт

	Эрх зүйн баримтын төрөл	Батлагдсан огноо	Баталсан субъект	Хүчин төгөлдөр эсэх
ОУХБ-ын конвенци -3				
1	Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын тухай ОУХБ-ын 122 дугаар конвенц	1976	УИХ-ын тогтоол	тийм
2	Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай ОУХБ-ын 88 дугаар конвенц	2016	УИХ-ын тогтоол	тийм
3	Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай ОУХБ-ын 181 дүгээр конвенц	2016	УИХ-ын тогтоол	тийм
Хөдөлмөрийн салбарын үндсэн болон дагалдах хуулиуд -12				
1	Хөдөлмөрийн тухай хууль	1999	УИХ-ын тогтоол	тийм
2	Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)	2017	УИХ-ын тогтоол	тийм
3	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (шинэчилсэн найруулга)	2012	УИХ-ын тогтоол	тийм
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль	2008	УИХ-ын тогтоол	тийм
5	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай	2001	УИХ-ын тогтоол	тийм
6	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль	2010	УИХ-ын тогтоол	тийм
7	Нийгмийн даатгалын тухай хууль	1994	УИХ-ын тогтоол	тийм
8	Эрүүл мэндийн даатгалын тухай хууль	2015	УИХ-ын тогтоол	тийм
9	Хувь хүний орлогын албан татварын тухай	2006	УИХ-ын тогтоол	тийм
10	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль	2009	УИХ-ын тогтоол	тийм
11	Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль	1991	УИХ-ын тогтоол	тийм
12	Эвлэрүүлэн зуучлах тухай хууль	2012	УИХ-ын тогтоол	тийм


Хавсралт 3. Хөдөлмөрийн салбартай хамаарал бүхий Хөгжлийн бодлогын үндсэн баримт бичгүүдэд байршилтай холбоотой заалтуудын товъёо

	Бодлогын баримт бичиг	Заалт дугаар	Байршилтай хамааралтай заалтууд
1	ТХҮЗ-2030		Холбогдох заалт байхгүй
	БХҮЗ -2020	4.7.4.в.	Хөдөөгийн хүн амын ядуурлыг бууруулах, ажил эрхлэлтийг дэмжих сум дундын зориулалтын санхүүгийн механизм бий болгох, алслагдсан болон говийн бүс нутагт ажлын байр бий болгосон хөрөнгө оруулагчдыг татварын бодлогоор урамшуулах;
		4.7.4.д.	Алслагдсан болон говь нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагч, багш, эмч нарт цалин хөлсний нэмэгдэл урамшуулал олгох, амьдралын нөхцөлийг нь сайжруулах, тогтвор суурьшилтай аж төрөхөд нь дэмжлэг үзүүлэх;
4.7.4.з.	Тухайн бүсийн хүрээнд хот, хөдөөгийн хүн ам амьдрах арга ухаан, хөдөлмөрлөх дадлага, туршлагаа харилцан солилцох, уугуул нутгаа хөгжүүлэх талаар орон нутгийн байгууллага, төрийн бус байгууллагууд хамтран ажиллах явдлыг хөхүүлэн дэмжих		
2	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого 2016-2025	4.2.10.	Бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг орон нутгийн хөгжил, хүн амын хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг нэмэгдүүлэхэд эерэгээр нөлөөлөхөөр зохион байгуулж, хэрэгжилт, хяналтыг сайжруулах;
		4.2.11.	ажиллах хүчний бүс, орон нутаг, эдийн засгийн салбар, ажил, мэргэжил хооронд дотоод шилжих хөдөлгөөнийг уян хатан, оновчтой зохицуулах замаар ажиллах хүчний нөөцийг үр дүнтэй ашиглах.
3	Цалин хөлсний талаар үндэсний хэмжээнд баримтлах бодлого батлах тухай (2012-2021)	4.1.2.	үндэсний болон бүс нутаг, салбарын түвшинд тарифын хэлэлцээрээр цалин хөлсний зохистой тогтолцоог бүрдүүлэх нийгмийн түншлэлийг төлөвшүүлэн хөгжүүлэх
4	“Байгалийн баялаг-Сайн засаглал-Хөгжсөн Өмнөговь” аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2020)/Өмнөговь аймгийн бүсчилсэн хөгжлийн хөтөлбөр	3.4.3.5.	Даланзадгад суманд уул уурхайн дагалдах үйлчилгээний чиглэлээр мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх МСҮТ-ийг байгуулна
		3.4.3.7.	Даланзадгад сумын МСҮТ-ийг Монголын Говийн бүсийн уул уурхайн бүрэн бус дунд мэргэжилтэй ажилчид бэлтгэх төв болгоход чиглэсэн бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.


Хавсралт 4. Нийт 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоонд эзлэх хувь, эдийн засгийн салбараар




Хавсралт 5. 15-аас дээш насны ажиллагчдын тооны өөрчлөлт, ЭЗ-ийн салбараар, 2010-аас 2017 он.




Хавсралт 6. ААНБ-ын ажиллагчдын сарын дундаж цалингийн өсөлт, 2007-оос 2017 он, мянган төгрөг




Хавсралт 7. Монгол улсын нийт бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоонд тухайн аймгийн эзлэх хувь




Хавсралт 8. Ажилгүйдлийн түвшин, хувиар, хүйсийн ангилалаар, 1997, 2007, 2017 он.




Хавсралт 9. Ажиллах хүчний оролцооны түвшин, хүйсээр, хувиар, 1997-оос 2017 он




Хавсралт 10. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хүйсээр, хувиар, 1997-оос 2017 он




Хавсралт 11. Говийн бүсийн аймгуудын ажилгүй иргэдийн тоо, улсын дүнд эзлэх хувь, насны бүлгээр




Хавсралт 12. Говийн аймгуудын ажилгүй иргэдийн тооны өөрчлөлт, насны бүлгээр, 2009, 2013, 2017 он



Хавсралт 13. Ажилд зуучлагдсан иргэд, ажил мэргэжлийн ангиллаар (хүн), 2015-2017



Хавсралт 14. Ажилд зуучлагдсан иргэд, ажил мэргэжлийн үндсэн ангиллаар, 2015-2017



Хавсралт 15. Говийн дэд бүсийн аймагт баригдах ЖДУ-д шаардагдах ажиллах хүчний хэрэгцээ, нийлүүлэлтийн төлөв байдлын матриц

Код	ЖДУ-ийн нэр	Ажиллагчдын тоо/эрэлт	Нийлүүлэлтийн эх үүсвэр						Тайлбар
			ИДС	ДоГ МСУТ	ДуГ МСУТ	ГС ПТК	ӨГ ПТК	А-гүй иргэд	
	БҮГД	1870							
К1	Мал төхөөрөх цех	406							
1	Захирал/Цехийн дарга	7							
2	Борлуулалтын менежер	7							Худалдааны газрын үндсэн ажилтан
3	Нягтлан бодогч	7							НББ тооцооны ажилтан
4	Малын эмч /байцаагч	21							
5	Хөргөлтийн технологич техникч	7							ХТК
6	Цахилгааны инженер техникч	7							
7	Нярав	7							Хангамжийн нярав, НББ тооцооны ажилтан
8	Жолооч	14							Мэргэшсэн жолооч
9	Мал нядлагчид	49							
10	Махны цогцолборын ерөнхий технологич	7							
11	Бохир, цэвэр орчинд ажиллах туслах ажилчид	98							
12	Мах ангилан шулах цехийн мастер	7							Үйлдвэрлэлийн техникч
13	Мах ангилагч	14							
14	Мах шулагч	28							
15	Дайвар бүтээгдэхүүний цехийн мастер/технологич	7							
16	Ажилчид	28							
17	Хагас боловруулсан бүтээгдэхүүний цехийн ажилчид	28							
18	Био тэжээл, бордооны цехийн агрономич	7							
19	Ажилчид	14							
20	Мал үржлийн зөвлөх	7							

21	Малчин		14							Малчин, Малын асаргаа
22	Бусад туслах ажилчид		21							
K2	Мал бордох цех		56							
1	Хоршооны дарга		7							Уламжлалт мал аж ахуйн фермер
2	Нягтлан бодогч		7							НББ тооцооны ажилтан
3	Малчин		21							612124 Малчин, малын асаргаа
4	Малын эмч		7							
5	Туслах ажилчин		7							
6	Тракторчин		7							
K3	Арьс ширний анхан шатны тордолтын цех		42							
1	МАШУ Холбооны төлөөлөгч		7							
2	Арьс, ширний чанар шалгагч		7							
	Арьс, ширний ангиан бэлтгэгч		7							
3	Халимлах машины операторчин		7							
4	Туслах ажилчин		14							
K4	Арьс ширэн жижиг эдлэлийн цех		32							
1	Захирал/дарга		6							
2	Оёдолчин		6							Оёмол бүтээгдэхүүний оёдолчин
3	Гүйцэтгэгч		6							
4	Борлуулалтын менежер		6							Худалдааны газрын үндсэн ажилтан
K5	Ноос, ноолуур бэлтгэх, ангилах цех		56							
1	Цехийн ахлагч/түүхий эдийн ня-бо		7							НББ тооцооны ажилтан
2	Ноос Пресслэгч		14							
3	Ноос Ангилагч		14							
4	Чанар шалгагч		7							
5	Манаач		7							
6	Үйлчлэгч		7							
K6	Эсгийний цех		30							
1	Үйлдвэрийн дарга/Хөнгөн үйлдвэрийн технологич		5							
2	Зулагч		5							

3	Сэмлэгч	5									
4	Самнагч	5									
5	Бутлагч	5									
6	Борлуулалтын ажилтан	5									Худалдааны газрын үндсэн ажилтан
К7	Сүү боловсруулах цех	72									
1	Гүйцэтгэх захирал	6									
2	Нягтлан бодогч	6									НББ тооцооны ажилтан
3	Ерөнхий технологич	6									
4	Микробиологич	6									
5	Механик инженер	6									
6	Шугамын мастер	6									Үйлдвэрлэлийн техникч
7	Нярав	6									Хангамжийн нярав, НББ тооцооны ажилтан
8	Борлуулалтын менежер	6									Худалдааны газрын үндсэн ажилтан
9	Түгээгч/Жолооч	6									
10	Савлагч	12									
11	Үйлчлэгч	6									
К8	Хүлэмжийн аж ахуй	96									
1	Агрономич/ захирал	8									
2	Менежер	8									Хүлэмжийн ААН фермер
3	Нягтлан бодогч	8									НББ тооцооны ажилтан
4	Нярав	8									Хангамжийн нярав
5	Ногоочин	32									Хүлэмжийн ААН фермер
6	Засварчин	8									
7	Борлуулагч жолооч	8									Худалдааны газрын үндсэн ажилтан
8	Зуухны ажилчин	16									
К9	Хүнс, ногоо боловсруулах цех	144									
1	Цехийн эрхлэгч	8									
2	Технологич	16									
3	Борлуулалтын менежер	16									Худалдааны газрын үндсэн ажилтан
4	Ногоо цэвэрлэгч	32									

ГАЗАР ТАРИАЛАН/К8-К11/

5	Ногоо хэрчигч	16																						
6	Шил угаагч	16																						
7	Савлагч	16																						
8	Туслах ажилчин	24																						
K1 0	Ургамлын найны үйлдвэр	440																						
1	Агрономич	8																						
2	Ерөнхий менежер	8																						
3	Ерөнхий инженер	8																						
4	Үйлдвэрийн ажилтан	32																						Ойжуулагч
5	Жолооч	8																						Мэргэшсэн жолооч
6	Манаач	8																						
7	Талбай арчлагч	48																						Ойжуулагч
8	Ургамал хураагч	160																						
9	Ургамлын үр түүх суулгах туслах ажилтан	160																						
K1 1	Төмс, хүнсний ногооны механикжсан агуулах	48																						
1	Агуулахын эрхлэгч/агрономич	8																						
2	Борлуулагч	8																						Худалдааны газрын үндсэн ажилтан
3	Нярав	8																						Хангамжийн нярав
4	Жолооч	8																						Мэргэшсэн жолооч
5	Туслах ажилчин	16																						
K1 2	Бөөний худалдаа, логистикийн төв	208																						
1	Эрхлэгч	8																						
2	Менежер	24																						Худалдааны газрын үндсэн ажилтан
3	Нягтлан бодогч	8																						НББ тооцооны ажилтан
4	Нярав	24																						Хангамжийн нярав
5	Худалдагч	32																						Худалдааны газрын үндсэн ажилтан
6	Жолооч/холын тээвэр	16																						Мэргэшсэн жолооч
7	Жолооч /ойрын тээвэр	16																						Мэргэшсэн жолооч
8	Туслах ажилчид	64																						
9	Манаач	16																						
ХУДАЛДАА																								

ХҮНС /K13-K14/		Цэвэр ус үйлдвэрлэх цех	72										
K1 3	1	Цехийн эрхлэгч/технологич	8										
	2	Менежер	8										Үйлдвэрлэлийн техникч
	3	Нягтлан бодогч	8										НББ тооцооны ажилтан
	4	Нярав	8										Хангамжийн нярав
	5	Технологийн ажилчид	32										Үйлдвэрлэлийн техникч
	6	Жолооч	8										Мэргэшсэн жолооч
K1 4		Талх, нарийн боовны цех	24										
	1	Нарийн боовны технологийг/Цехийн дарга	8										
	2	Зуурагч (чанар шалгагч)	8										
	3	Шарагч (савлагч)	8										
K1 5		Засвар үйлчилгээний цех	56										
	1	Дулааны инженер/Цехийн дарга/	8										
	2	Мастер	8										Цахилгааны техникч
	3	Цахилгаанчин	8										Барилгын цахилгаанчин, цахилгаанчин
	4	Гагнуурчин	8										Гагнуурчин
	5	Токарьчин	8										
	6	Сантехникч	8										Барилгын сантехникч, сантехникч
	7	Механик засварчин	8										ХММЗасварчин, Автомашин засварчин
K1 6		Оёдлын цех	56										
	1	Захирал/загвар зохион бүтээгч	8										
	2	Чанар шалгагч	8										Үйлдвэрлэлийн техникч
	3	Оёдолчин	24										Оёмол бүтээгдэхүүний оёдолчин
	4	Эсгүүрчин	8										
	5	Индүүчин	8										
K1 7		Модон эдлэл, мужааны цех	32										
	1	Үйлдвэрийн дарга/модны инженер	8										

2	Ахлах мужаан	8							Барилгын мужаан, Модон эдлэлийн мужаан
3	Мужаан	16							Барилгын мужаан, Модон эдлэлийн мужаан
		1870	Дог	Дуг	ГС	ӨГ	А-гүй	Бусад	
	ИДС , коллеж төгсөгчдөөс								
	Тухайн аймагт байгаа МСУТ болон ПДК төгсөгчдөөс								
	Орон нутагт байгаа ажилгүй иргэд болон бусад эх үүсвэрээс								
	Бэлтгэх шаардлагатай байгаа нарийн мэргэжлийн ажилчид								
	Орон нутагт дахин мэргэшүүлэх эсхүл ур чадвар олгох сургалтаар бэлтгэх боломжтой ААТ								

Хавсралт 16. Говийн дэд бүсийн аймагт баригдах ЖДҮ-д шаардагдах ажиллах хүчний хэрэгцээ

1	Агрономич	24
2	Ажилчид	42
3	Арьс, ширний ангилан бэлтгэгч	7
4	Арьс, ширний чанар шалгагч	7
5	Био гэжээл, бордооны цехийн агрономич	7
6	Борлуулалтын менежер	56
7	Бохир, цэвэр орчинд ажиллах туслах ажилчид	98
8	Бусад туслах ажилчид	21
9	Бутлагч	5
10	Гагнуурчин	8
11	Гүйцэтгэгч	6
12	Гүйцэтгэх захирал	19
13	Дайвар бүтээгдэхүүний цехийн мастер/технологич	7
14	Дулааны инженер /Цехийн дарга/	8
15	Жолооч	76
16	Загвар зохион бүтээгч/ захирал	8
17	Засварчин	8
18	Зулагч	5
19	Зуурагч (чанар шалгагч)	8
20	Зуухны ажилчин	16
21	Индүүчин	8

22	Инженер	8
23	Мал нядлагчид	49
24	Мал уржлийн зөвлөх	7
25	Малчин	35
26	Малын эмч	28
27	Манаач	31
28	Мастер	8
29	Мах ангилагч	14
30	Мах ангилан шулах цехийн мастер	7
31	Мах шулагч	28
32	Махны погдолборын ерөнхий технологич	7
33	МАШУХолбооны төлөөлөгч	7
34	Менежер	48
35	Механик засварчин	8
36	Механик инженер	6
37	Микробиологич	6
38	Мужаан	24
39	Нарийн боовны технологич/Цехийн дарга	8
40	Ногоо хэрчигч	16
41	Ногоо цэвэрлэгч	32
42	Ногоочин	32
43	Ноос Ангилагч	14
44	Ноос Пресслэгч	14
45	Нягтлан бодогч	44
46	Нярав	61
47	Оёдочин	39
48	Савлагч	28
49	Самнагч	5
50	Сантехникч	8
51	Сэмлэгч	5
52	Талбай арчлагч	48
53	Технологич	54
54	Тожарьчин	8
55	Тракторчин	7
56	Туслах ажилчид	125
57	Ургамал хураагч	160

58	Ургамлын үр түүх суулгах туслах ажилтан	160
59	Үйлдвэрийн ажилтан	32
60	Үйлдвэрийн дарга	13
61	Үйлчлэгч	13
62	Хагас боловруулсан бүтээгдэхүүний цехийн ажилчид	28
63	Халимлах машины операторчин	7
64	Хоршооны дарга	7
65	Хөргөлтийн технологич техникч	7
66	Худалдагч	31
67	Цахилгаанчин	15
68	Цехийн мастер/эрхлэгч	23
69	Чанар шаллагч	15
70	Шарагч (савлагч)	8
71	Шил угаагч	16
72	Шугамын мастер	6
73	Эрхлэгч	8
74	Эсгүүрчин	8

	Ажиллах хүчнийг хангах эх үүсвэр	1870	%
	Орон нутагт байгаа туршлагагай ахмад хүмүүсээс бэлтгэх эсхүл бусад эх үүсвэрээс бэлтгэх	55	2.9
	Нарийн мэргэжил ур чадвар шаардахгүй, орон нутгийн хөдөлмөрийн зах зээл дээр байгаа ажилгүйчүүд болон бусад эх үүсвэрээс олж давтан сургах байдлаар нийлүүлэх боломжтой ажлын байрууд	919	49.1
	ИДСК төгсөгчид эсхүл захиалгаар бэлтгэх боломжтой	110	5.9
	Орон нутагт байгаа МСУТ-ээр бэлтгэх боломжтой	523	28.0
	ИДСК төгсөгчдөөс авч болох хэдий ч нэн хэрэгцээтэй байгаа инженер, технологич болон мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх, МСУТ-эд мэргэжлийн шинэ анги нээх	263	14.1
		1870	100.0

Хавсралт 17. Хөдөлмөрийн салбартай холбоотой бодлогын баримт бичгийн судалгааны арга зүйн схем



Хавсралт 18. Аймгуудын хөгжлийн бодлого нь үндэсний хэмжээний бодлогуудтай уялдаж буй байдал

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮД	ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ (2011-2021)	ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО (2010-2021)	ДУНДГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ /2012- 2031/	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ (2010-2021)
1. МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО <i>Бодлогын нийцлийн ерөнхий хувь 81.25%</i>	Шууд тусгагдсан-3	Шууд тусгагдсан-3	Шууд тусгагдсан-2	Шууд тусгагдсан-4
	Агуулга уялдсан-4	Агуулга уялдсан-3	Агуулга уялдсан-4	Агуулга уялдсан-3
	Огт тусгагдаагүй-1	Огт тусгагдаагүй-2	Огт тусгагдаагүй-2	Огт тусгагдаагүй-1
	Нийцлийн тоо-7	Нийцлийн тоо-6	Нийцлийн тоо-6	Нийцлийн тоо-7
	Нийцлийн хувь 87.5%	Нийцлийн хувь 75.0%	Нийцлийн 75.0%	Нийцлийн хувь 87.5%
	Иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хамгаалах болон амьдралын түвшинг дээшлүүлэхэд нь дэмжлэх үзүүлэх тал дээр анхаарах	Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг оновчтой, үр ашигтай болгох. Хүн амын бүлгүүдийн зохицсон хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд анхаарах	Нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хүн амын зорилтод бүлгүүдийн хөдөлмөрлөх эрх, боломжийг бүрдүүлэх	Бизнесийн орчин, ажлын байрны тогтвортой байдлыг дэмжих, иргэдийн цалин хөлс, амжиргааны түвшинг нэмэгдүүлэх
	Шууд тусгагдсан-3	Шууд тусгагдсан-2	Шууд тусгагдсан-3	Шууд тусгагдсан-4
	Агуулга уялдсан-4	Агуулга уялдсан-4	Агуулга уялдсан-3	Агуулга уялдсан-3
	Огт тусгагдаагүй-2	Огт тусгагдаагүй-3	Огт тусгагдаагүй-3	Огт тусгагдаагүй-2
	Нийцлийн тоо-7	Нийцлийн тоо-6	Нийцлийн тоо-6	Нийцлийн тоо-7
Нийцлийн хувь-77.8%	Нийцлийн хувь-66.7%	Нийцлийн хувь-66.7%	Нийцлийн хувь-77.8%	
2. МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ - 2030 <i>Бодлогын нийцлийн ерөнхий хувь 72.2%</i>	Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн насны хүн амын идэвхтэй байдлыг нэмэгдүүлэхэд анхаарах	ХАА, аж үйлдвэр, дэд бүтцийн томоохон төслүүдийн хөдөлмөрийн хэрэгцээ, зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн ажилчдыг бэлтгэх	Хувийн бизнес эрхлэх мэдлэг чадвартай залуу үеийг төлөвшүүлэх, төгсөгчид ажлын байр өөрөө бий болгоход нь дэмжлэг үзүүлэх	Хөдөлмөрийн насны хүн амын эдийн засгийн идэвхтэй байдлыг нэмэгдүүлэх, АБХЭ-ийг бүртгэлийг сайжруулах
	Шууд тусгагдсан-1	Шууд тусгагдсан-0	Шууд тусгагдсан-0	Шууд тусгагдсан-1
	Агуулга уялдсан-2	Агуулга уялдсан-2	Агуулга уялдсан-3	Агуулга уялдсан-3
	Огт тусгагдаагүй-3	Огт тусгагдаагүй-4	Огт тусгагдаагүй-3	Огт тусгагдаагүй-2
	Нийцлийн тоо-3	Нийцлийн тоо-2	Нийцлийн тоо-3	Нийцлийн тоо-4
	Нийцлийн хувь-50%	Нийцлийн хувь-33.3%	Нийцлийн хувь-50.0%	Нийцлийн хувь-66.7%
	Хүн ам нутагтаа тогтвор, суурьшилтай ажиллаж, амьдрах, сурах нөхцөл боломжийг бүрдүүлэх	Орон нутгийн хүн амын хөдөлмөрийн дадлага, чадварыг дээшлүүлэх чиглэсэн ЖДҮ-ийн сүлжээ бүрдүүлэхэд анхаарах	Хөдөөгийн хүн ам амьдрах арга ухаан, хөдөлмөрлөх дадлага, туршлагаа харилцан солилцох	Иргэд аймаг, орон нутгийнхаа амьдралд идэвхтэй, эрх тэгш хамтран оролцох боломж
	Шууд тусгагдсан-0	Шууд тусгагдсан-0	Шууд тусгагдсан-0	Шууд тусгагдсан-0
	Агуулга уялдсан-1	Агуулга уялдсан-0	Агуулга уялдсан-0	Агуулга уялдсан-1
	Огт тусгагдаагүй-2	Огт тусгагдаагүй-3	Огт тусгагдаагүй-3	Огт тусгагдаагүй-2
Нийцлийн тоо-1	Нийцлийн тоо-0	Нийцлийн тоо-0	Нийцлийн тоо-1	
Нийцсэн хувь-33.3%	Нийцсэн хувь-0%	Нийцсэн хувь-0%	Нийцсэн хувь-33.3%	
4. МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ <i>Бодлогын нийцлийн ерөнхий хувь 16.7%</i>	Тухайн орон нутаг нь нутаг дэвсгэртээ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн зэрэг хууль тогтоомжид заасан санг бүрдүүлэх, захиран зарцуулах ажлыг ерөнхий удирдлагаар хангах. Нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулдаг үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага үйлдвэрлэлийн ариун цэвэр, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны арга технологи, шаардлагыг хэрхэн сахих байгаад хяналт тавих ажлыг зохион байгуулах.			
	Шууд тусгагдсан-7	Шууд тусгагдсан-5	Шууд тусгагдсан-5	Шууд тусгагдсан-9
	Агуулга уялдсан-11	Агуулга уялдсан-9	Агуулга уялдсан-10	Агуулга уялдсан-10
	Огт тусгагдаагүй-8	Огт тусгагдаагүй-12	Огт тусгагдаагүй-11	Огт тусгагдаагүй-7
	Нийцлийн тоо-18	Нийцлийн тоо-14	Нийцлийн тоо-15	Нийцлийн тоо-19
	Нийцсэн хувь-69.2%	Нийцсэн хувь-53.8%	Нийцсэн хувь-57.7%	Нийцсэн хувь-73.1%

Хавсралт 19. Аймгийн хөгжлийн төлөвлөгөө МУЗГ болон хүн ам, хөдөлмөрийн салбарын бодлоготой уялдаж буй байдал

МУЗГ БОЛОН ТӨРӨӨС ХӨДӨЛМӨРИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮҮЛЖ БҮЙ БОДЛОГУУД	ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ (2011-2021)	ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЦОГТ БОДЛОГО (2010-2021)	ДУНДГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨГ /2012-2031/	ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ (2010-2021)	ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНГИЙН ТАЙЛБАР, ДҮГНЭЛТ БОЛОН ГОЛ ЗӨВЛӨМЖҮҮД			
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР	Шууд тусгагдсан-2 Агуулга уялдсан-1 Огт тусгагдаагүй-1 Нийцлийн тоо-3% Нийцсэн хувь-75%	Шууд тусгагдсан-1 Агуулга уялдсан-2 Огт тусгагдаагүй-1 Нийцлийн тоо-3 Нийцсэн хувь-75%	Шууд тусгагдсан-1 Агуулга уялдсан-2 Огт тусгагдаагүй-1 Нийцлийн тоо-3 Нийцсэн хувь-75%	Шууд тусгагдсан-2 Агуулга уялдсан-1 Огт тусгагдаагүй-1 Нийцлийн тоо-3 Нийцсэн хувь-75%	Хүн амын орлогыг дээшлүүлэн дундаж давхаргын хүрээг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг сайжруулах, хөдөлмөрийн салбарын эрэлтэд нийцүүлэн мэргэжилтэн бэлдэх			
	Шууд тусгагдсан-3 Агуулга уялдсан-5 Огт тусгагдаагүй-3 Нийцлийн тоо-8 Нийцсэн хувь-72.7%	Шууд тусгагдсан-2 Агуулга уялдсан-5 Огт тусгагдаагүй-4 Нийцлийн тоо-7 Нийцсэн хувь-63.6%	Шууд тусгагдсан-2 Агуулга уялдсан-4 Огт тусгагдаагүй-5 Нийцлийн тоо-6 Нийцсэн хувь-54.5%	Шууд тусгагдсан-4 Агуулга уялдсан-4 Огт тусгагдаагүй-3 Нийцлийн тоо-8 Нийцсэн хувь-27.7%		Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг сайжруулах, хүн бүр боловсро эзэмших, хөгжих боломжийг бүрдүүлэх, хөдөлмөр эрхлэх сонирхолыг нэмэгдүүлэх		
	Шууд тусгагдсан-4 Агуулга уялдсан-8 Огт тусгагдаагүй-4 Нийцлийн тоо-12 Нийцсэн хувь-75.0%	Шууд тусгагдсан-3 Агуулга уялдсан-7 Огт тусгагдаагүй-6 Нийцлийн тоо-10 Нийцсэн хувь-62.5%	Шууд тусгагдсан-2 Агуулга уялдсан-7 Огт тусгагдаагүй-7 Нийцлийн тоо-9 Нийцсэн хувь-56.3%	Шууд тусгагдсан-4 Агуулга уялдсан-9 Огт тусгагдаагүй-3 Нийцлийн тоо-13 Нийцсэн хувь-81.3%			Ногоон ажлын байрны үнэлэмжийг дээшлүүлж, эрэлт нийлүүлэлтийг дэмжих, ажиллах хүчний нөөцийг үр дүнтэй ашиглах, хөдөлмөрийн хяналтыг сайжруулах	
	Шууд тусгагдсан-9 Агуулга уялдсан-14 Огт тусгагдаагүй-8 Нийцлийн тоо-23 Нийцсэн хувь-74.2%	Шууд тусгагдсан-6 Агуулга уялдсан-14 Огт тусгагдаагүй-11 Нийцлийн тоо-20 Нийцсэн хувь-64.5%	Шууд тусгагдсан-5 Агуулга уялдсан-13 Огт тусгагдаагүй-13 Нийцлийн тоо-18 Нийцсэн хувь-58.1%	Шууд тусгагдсан-10 Агуулга уялдсан-14 Огт тусгагдаагүй-7 Нийцлийн тоо-24 Нийцсэн хувь-77.4%				Аймгуудын нийт үнэлгээ нь шууд тусгагдсан 30, агуулла уялдсан 55, огт тусгагдаагүй 39 буюу бүсийн түвшинд нийцлийн түвшин 68.6 хувьтай /хангалтгүй/ гарсан байна.

Хавсралт 19.1. Дорноговь аймгийн хөгжлийн бодлогын голлох баримт бичгүүд дэх хөдөлмөрийн салбартай холбоотой зорилтуудын уялдаа

<p>ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ХООРОНДЫН НИЙЦЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ МАТРИЦ</p>	<p>ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ (2011-2021)</p>	<p>АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР</p>	<p>АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ</p>	<p>ГУРВАН ТУЛГУУРТ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ 2018-2020</p>
<p>ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ (2011-2021)</p>	<p>Тэргүүлэх 3, Дэд 8 зорилт 2011.05.02-нд баглагдсан 2011-2021 онд хэрэгжинэ ИТХХ-ын №26-р тогтоол</p>	<p>Шууд тусгагдсан-5 Агуулгын хувьд уялдсан-4 Огт тусгагдаагүй-1 Нийцлийн тоо/хувь- 9/90%</p>	<p>Шууд тусгагдсан-5 Агуулгын хувьд уялдсан-3 Огт тусгагдаагүй-2 Нийцлийн тоо/хувь-8/80%</p>	<p>Шууд тусгагдсан-3 Агуулгын хувьд уялдсан-2 Огт тусгагдаагүй-2 Нийцлийн тоо/хувь-5/71%</p>
<p>АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР</p>	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах тал дээр уялдаа тааруу байна.</p>	<p>Тэргүүлэх 2, Дэд 10 зорилт 2016.09.29-нд баглагдсан 2016-2020 онд хэрэгжинэ ИТХХ-ын №2/11-р тогтоол</p>	<p>Шууд тусгагдсан-7 Агуулгын хувьд уялдсан-2 Огт тусгагдаагүй-1 Нийцлийн тоо/хувь-9/90%</p>	<p>Шууд тусгагдсан-3 Агуулгын хувьд уялдсан-3 Нийцлийн тоо/хувь-1 Огт тусгагдаагүй-6/86%</p>
<p>АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ</p>	<p>Ажлын байр хадгалан, шинээр нэмж буй ажил олгогчийг урамшуулах бодлогын уялдаа байхгүй.</p>	<p>Шинээр сургууль төгссөн залуусыг ажлын байранд зуулах, ажилд авсан ААНБ - уудыг дэмжин ажиллах.</p>	<p>Тэргүүлэх 1, Дэд 10 зорилт 2016.12.05-нд баглагдсан 2018 онд хэрэгжинэ ИТХХ-ын №3/05-р тогтоол</p>	<p>Шууд тусгагдсан-4 Агуулгын хувьд уялдсан-2 Огт тусгагдаагүй-1 Нийцлийн тоо/хувь-6/86%</p>
<p>ГУРВАН ТУЛГУУРТ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ 2018-2020</p>	<p>Гарааны бизнес эрхлэгч иргэдийг дэмжих, санхүү зээлийн урамшуулалд хамруулах уялдаа тааруу</p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажиллах орчин нөхцлийг бүрдүүлж, ажлын байраар хангах бодлого сул.</p>	<p>Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ажлын байрыг нэмэгдүүлэх бодлогын уялдаа байхгүй.</p>	<p>Тэргүүлэх 2, Дэд 7 зорилт 2018.09.26-нд баглагдсан 2018-2010 онд хэрэгжинэ ИТХХ-ын №3/5-р тогтоол</p>
<p>ТАЙЛБАР, ДҮГНЭЛТ</p>	<p>Тус аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөөнд хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тэргүүлэх 3, дэд 8 зорилт байгаа ба бүсийн хөгжлийн давуу тал, нөөц боломжид тулгуурлан судалгаанд суурилсан хөдөлмөрийн зах зээлийн бодлогыг үндсэн чиглэлээ болгоон боловсруулсан байна.</p>	<p>Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамруулах, малчдыг ажлын байраар хангах, ХАБ, ажил олгогч, төр, иргэд хооронд хамтын ажиллагааг сайжруулах, МЭСҮТ-ийн үйл ажиллагааг дэмжин ажиллах зэрэгт төвлөрсөн.</p>	<p>2018 онд хэгжүүлэх үндсэн чиглэл нь өмнөх 2017 оны үндсэн чиглэлээс нэг их ялгаагүй байсан ба хүн амын зохистой хөдөлмөр эрхлэлтийг сайжруулах; МБСБ, МСҮТ, ажил олгогч төрийн хамтын ажиллагааг сайжруулах, төгсөгчдийг ажлын байраар хангах; бусад улсаас туршлага судлах тал дээр анхаарчээ.</p>	<p>Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд суурилсан хүний нөөц бэлтгэх, төлөвлөх; бичил, өрхийн бизнесийг санхүүгийн болон зээлийн урамшуулалд хамруулах; ядуу болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар ханах; ур чадарт суурилсан ажлын байр бий болгоход түлхүү анхаарсан байна.</p>

Хавсралт 19.2. Дорноговь аймгийн хөгжлийн бодлогууд болон хөдөлмөрийн салбарт хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрүүдийн уялдаа

ХӨДӨЛМӨРИЙН САЛБАР ХЭРЭГЖИЖ БУЙ ДЭД ХӨТӨЛБӨРҮҮДИЙН УЯЛДАА	ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨГЖЛИЙН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ (2011-2021)	АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР	АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	ГУРВАН ТУЛГУУРТ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫГ 2018-2020	ТАЙЛБАР, ДҮГНЭЛТ
1. БАГШ НАРЫГ ЧААВХЖУУЛАХ ДЭД ХӨТӨЛБӨР /ИТХ-ийн 2017.05.10-ны өдрийн №40-р тогтоол/	Шууд тусгагдсан-1 Агуулга уялдсан-3 Огт тусгагдаагүй-0 Нийцлийн тоо-4 Нийцсэн хувь 100%	Шууд тусгагдсан-1 Агуулга уялдсан-3 Огт тусгагдаагүй-0 Нийцлийн тоо-4 Нийцсэн хувь-100%	Шууд тусгагдсан-1 Агуулга уялдсан-3 Огт тусгагдаагүй-0 Нийцлийн тоо-4 Нийцсэн хувь-100%	Шууд тусгагдсан-0 Агуулга уялдсан-3 Огт тусгагдаагүй-1 Нийцлийн тоо-3 Нийцсэн хувь-75%	Дэд хөтөлбөрт тусгагдсан 4 зорилт нь аймгийн хөгжлийн голлох бодлогуудад агуулгын хувьд ихэвчлэн уялдсан байна. Багш нарын мэргэжилийг дээшлүүлж, түгээн дэлгэрүүлэх тал дээр анхаарах.
2. ХӨРШ ОРНООСОО СУРАЛЦЬЯ ДЭД ХӨТӨЛБӨР /ИТХ-ийн 2017.05.10-ны өдрийн №41-р тогтоол/	Шууд тусгагдсан-0 Агуулга уялдсан-3 Огт тусгагдаагүй-0 Нийцлийн тоо-4 Нийцлийн хувь-100%	Шууд тусгагдсан-0 Агуулга уялдсан-3 Огт тусгагдаагүй-0 Нийцлийн тоо-4 Нийцлийн хувь-100%	Шууд тусгагдсан-2 Агуулга уялдсан-1 Огт тусгагдаагүй-0 Нийцлийн тоо-4 Нийцлийн хувь-100%	Шууд тусгагдсан-1 Агуулга уялдсан-2 Огт тусгагдаагүй-0 Нийцлийн тоо-4 Нийцлийн хувь-100%	Туршага судлах, сургалт, мэргэжилийн дээшлүүлэх олон талт хамтын ажиллагаа болон багшийн хөгжлийг дэмжих болдог нь шууд хэлбэрээр тусгагдаагүй ч агуулгын хувьд тусгагдсан байна.
3. ЗӨЛУУЧУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР /ИТХ-ийн 2017.05.10-ны өдрийн №46-р тогтоол/	Шууд тусгагдсан-0 Агуулга уялдсан-4 Огт тусгагдаагүй-0 Нийцлийн тоо-4 Нийцлийн хувь-100%	Шууд тусгагдсан-2 Агуулга уялдсан-2 Огт тусгагдаагүй-0 Нийцлийн тоо-4 Нийцлийн хувь-100%	Шууд тусгагдсан-2 Агуулга уялдсан-2 Огт тусгагдаагүй-0 Нийцлийн тоо-4 Нийцлийн хувь-100%	Шууд тусгагдсан-1 Агуулга уялдсан-3 Огт тусгагдаагүй-0 Нийцлийн тоо-4 Нийцсэн хувь-100%	Огт тусгагдаагүй зорилт байхгүй байгаа ч агуулгын хувьд нийцэж байна. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ санхүү, татварын хөнгөлөлт урамшуулал үзүүлэх замаар дийлэнх хөгжлийн бодлогод тусгагдсан байна.
4. ОЮУТАН, СУРАГЧДИЙГ АЖЛЫН БАЙРААР ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨР /ИТХ-ийн 2017.05.10-ны өдрийн №47-р тогтоол/	Шууд тусгагдсан-1 Агуулга уялдсан-2 Огт тусгагдаагүй-1 Нийцлийн тоо-3 Нийцсэн хувь-75%	Шууд тусгагдсан-1 Агуулга уялдсан-2 Огт тусгагдаагүй-1 Нийцлийн тоо-3 Нийцсэн хувь-75%	Шууд тусгагдсан-1 Агуулга уялдсан-3 Огт тусгагдаагүй-0 Нийцлийн тоо-4 Нийцсэн хувь-100%	Шууд тусгагдсан-1 Агуулга уялдсан-3 Огт тусгагдаагүй-0 Нийцлийн тоо-4 Нийцсэн хувь-100%	Оюутнуудад дадлага, практик мэдлэг, чадвар олгуулах тал дээр дэд хөтөлбөрт тусгасан байгаа ч хөгжлийн бодлогуудад залуучуудыг шинэ ажлын байртай болгох, ажлуудад зуучлах зэрэг хэтэрхий ерөнхий байдлаар тусгагдсан байна.
5. ЗОРИЛТОТ ӨРХИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ ДЭД ХӨТӨЛБӨР /ИТХ-ийн 2017.05.10-ны өдрийн №48-р тогтоол/	Шууд тусгагдсан-1 Агуулга уялдсан-2 Огт тусгагдаагүй-1 Нийцлийн тоо-3 Нийцсэн хувь-75%	Шууд тусгагдсан-2 Агуулга уялдсан-1 Огт тусгагдаагүй-1 Нийцлийн тоо-3 Нийцсэн хувь-75%	Шууд тусгагдсан-2 Агуулга уялдсан-1 Огт тусгагдаагүй-1 Нийцлийн тоо-3 Нийцсэн хувь-75%	Шууд тусгагдсан-1 Агуулга уялдсан-2 Огт тусгагдаагүй-1 Нийцлийн тоо-3 Нийцсэн хувь-75%	Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал, хөгжил амжиргаа, хөдөлмөр эрхлэлтийн талаарх цахим мэдээллийн санг бүрдүүлж, түүний хэрэглээг нэмэгдүүлэх тал дээр аймгийн хөгжлийн бодлогын гол баримт бичгүүдэд шууд болон агуулгын хувьд тусгаагүй байна.
	Шууд тусгагдсан-1	Шууд тусгагдсан-2	Шууд тусгагдсан-1	Шууд тусгагдсан-0	

6. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ДЭД ХӨТӨЛБӨР /ИТХ-ийн 2017.11.30-ны өдрийн №93-р тогтоол/	Агуулга уялдсан-3	Агуулга уялдсан-3	Агуулга уялдсан-3	Агуулга уялдсан-3	ХАБ, эрүүл ахуйн талаарх тогтолоог бэхжүүлэх, судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулах, эрүүл аюулгүй ажиллагааны дүрэм, журмам, заавар зааварчилгааг мөрдлөг болгох зэрэг зорилтууд огт тусгагдаагүй байна.
	Огт тусгагдаагүй-2	Огт тусгагдаагүй-2	Огт тусгагдаагүй-2	Огт тусгагдаагүй-3	
	Нийцэлийн тоо-4	Нийцэлийн тоо-5	Нийцэлийн тоо-4	Нийцэлийн тоо-3	
	Нийцсэн хувь-67%	Нийцсэн хувь-83%	Нийцсэн хувь-67%	Нийцсэн хувь-50%	
	Шууд тусгагдсан-1	Шууд тусгагдсан-1	Шууд тусгагдсан-1	Шууд тусгагдсан-1	Ажлын байр нэмэгдүүлж буй ажил олгогч байгууллагыг урамшуулах, тус аймагт бүртгэлтэй ЖДҮЭ нь Дорноговь аймгийн ажилгүй иргэдийг ажилд авсан бол урамшуулах асуудал дурьдагдаагүй.
	Агуулга уялдсан-1	Агуулга уялдсан-3	Агуулга уялдсан-3	Агуулга уялдсан-2	
	Огт тусгагдаагүй-2	Огт тусгагдаагүй-0	Огт тусгагдаагүй-0	Огт тусгагдаагүй-1	
	Нийцэлийн тоо-2	Нийцэлийн тоо-4	Нийцэлийн тоо-4	Нийцэлийн тоо-3	
	Нийцсэн хувь-50%	Нийцсэн хувь-100%	Нийцсэн хувь-100%	Нийцсэн хувь-75%	
	Шууд тусгагдсан-5	Шууд тусгагдсан-9	Шууд тусгагдсан-10	Шууд тусгагдсан-5	Аймгийн хэмжээнд 20 орчим дэд хөтөлбөр байгаагаас 8 дэд хөтөлбөр нь хөдөлмөрийн салбартай холбоотой байгаа ба хөгжлийн гол боллогтойгоо 80 –аас дээш хувийн нийцэлтэй байна.
7. АЖЛЫН БАЙР ДЭД ХӨТӨЛБӨР /ИТХ-ийн 2017.05.30-ны өдрийн №56-р тогтоол/	Агуулга уялдсан-19	Агуулга уялдсан-17	Агуулга уялдсан-17	Агуулга уялдсан-19	
	Огт тусгагдаагүй-6	Огт тусгагдаагүй-4	Огт тусгагдаагүй-3	Огт тусгагдаагүй-6	
	Нийцэлийн тоо-24	Нийцэлийн тоо-26	Нийцэлийн тоо-27	Нийцэлийн тоо-24	
	Нийцсэн хувь-80%	Нийцсэн хувь-86.7%	Нийцсэн хувь-90%	Нийцсэн хувь-80%	
Аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй дэд хөтөлбөрүүдийн нийцлийн үнэлгээний нэгдсэн дүн	Шууд тусгагдсан-5	Шууд тусгагдсан-9	Шууд тусгагдсан-10	Шууд тусгагдсан-5	
	Агуулга уялдсан-19	Агуулга уялдсан-17	Агуулга уялдсан-17	Агуулга уялдсан-19	
	Огт тусгагдаагүй-6	Огт тусгагдаагүй-4	Огт тусгагдаагүй-3	Огт тусгагдаагүй-6	
	Нийцэлийн тоо-24	Нийцэлийн тоо-26	Нийцэлийн тоо-27	Нийцэлийн тоо-24	
	Нийцсэн хувь-80%	Нийцсэн хувь-86.7%	Нийцсэн хувь-90%	Нийцсэн хувь-80%	

Хавсралт 19.3. Дорноговь аймгийн хөгжлийн бодлогууд нь үндэсний болоод бүсийн хэмжээний бодлогуудтай уялдаж буй байдал

Үндэсний болоод бүсийн хэмжээний бодлогууд	Дорноговь аймгийн хөгжлийн бодлогууд	Аймгийн засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийн эдийн засаг, нийгмийн 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	Гурван тулгуурт хөгжлийн бодлогыг 2018-2020	Тайлбар, дүгнэлт
1. МОНГОЛ УЛСЫН МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОД СУУРИЛСАН ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ЦОГЦ БОДЛОГО	Шууд тусгагдсан-3	Шууд тусгагдсан-3	Шууд тусгагдсан-3	Шууд тусгагдсан-3	Зохистой хөдөлмөр эрхлэлт, гэр дундаа нийгмийн эмзэг бүлгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих; хөдөлмөрлөх эрхийг хамгаалах, цалин хөлсийг нэмэх зэрэг асуудлууд хангалттай тусгагдаагүй
	Агуулга уялдсан-5	Агуулга уялдсан-7	Агуулга уялдсан-6	Агуулга уялдсан-4	
	Огт тусгагдаагүй-1	Огт тусгагдаагүй-1	Огт тусгагдаагүй-2	Огт тусгагдаагүй-1	
	Нийцлийн тоо-8	Нийцлийн тоо-10	Нийцлийн тоо-9	Нийцлийн тоо-7	
	Нийцэх хувь 88.9%	Нийцэх хувь-90.1%	Нийцэх хувь-81.8%	Нийцэх хувь-87.5%	
	Шууд тусгагдсан-3	Шууд тусгагдсан-4	Шууд тусгагдсан-4	Шууд тусгагдсан-4	
	Агуулга уялдсан-6	Агуулга уялдсан-6	Агуулга уялдсан-5	Агуулга уялдсан-4	
	Огт тусгагдаагүй-0	Огт тусгагдаагүй-1	Огт тусгагдаагүй-2	Огт тусгагдаагүй-0	
	Нийцэх тоо-9	Нийцэх тоо-10	Нийцэх тоо-9	Нийцэх тоо-8	
	Нийцэх хувь-100%	Нийцэх хувь-90.1%	Нийцэх хувь-81.8%	Нийцэх хувь-100%	
2. МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ - 2030	Шууд тусгагдсан-2	Шууд тусгагдсан-3	Шууд тусгагдсан-2	Шууд тусгагдсан-1	Хувийн бизнес эрхлэх мэдлэг, чадвартай залуу үеийг төлөвшүүлэх; албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээг сайжруулах, хүн амын эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлэх асуудал сул байна
	Агуулга уялдсан-5	Агуулга уялдсан-5	Агуулга уялдсан-5	Агуулга уялдсан-4	
	Огт тусгагдаагүй-2	Огт тусгагдаагүй-3	Огт тусгагдаагүй-4	Огт тусгагдаагүй-3	
	Нийцэх тоо-7	Нийцэх тоо-8	Нийцэх тоо-7	Нийцэх тоо-5	
	Нийцэх хувь-77.8%	Нийцлийн хувь-72.7%	Нийцэх хувь-63.6%	Нийцэх хувь-62.5%	
	Шууд тусгагдсан-8	Шууд тусгагдсан-10	Шууд тусгагдсан-9	Шууд тусгагдсан-8	
	Агуулга уялдсан-16	Агуулга уялдсан-18	Агуулга уялдсан-16	Агуулга уялдсан-12	
	Огт тусгагдаагүй-3	Огт тусгагдаагүй-5	Огт тусгагдаагүй-8	Огт тусгагдаагүй-4	
	Нийцлийн тоо-24	Нийцлийн тоо-28	Нийцлийн тоо-25	Нийцлийн тоо-20	
	Нийцсэн хувь-89%	Нийцсэн хувь-85%	Нийцсэн хувь-76%	Нийцсэн хувь-83%	
3. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ	Шууд тусгагдсан-2	Шууд тусгагдсан-3	Шууд тусгагдсан-2	Шууд тусгагдсан-1	Нутагтаа тогтвор, суурьшилтай ажиллаж амьдрах; хүн амын амьдрах арга ухаан, хөдөлмөрлөх туршлагаа харилцан солилцох; орон нутаг, бүсийн давуу талд тулгуурласан бодлог хангалтгүй байна.
	Агуулга уялдсан-5	Агуулга уялдсан-5	Агуулга уялдсан-5	Агуулга уялдсан-4	
	Огт тусгагдаагүй-2	Огт тусгагдаагүй-3	Огт тусгагдаагүй-4	Огт тусгагдаагүй-3	
	Нийцэх тоо-7	Нийцэх тоо-8	Нийцэх тоо-7	Нийцэх тоо-5	
	Нийцэх хувь-77.8%	Нийцлийн хувь-72.7%	Нийцэх хувь-63.6%	Нийцэх хувь-62.5%	
	Шууд тусгагдсан-8	Шууд тусгагдсан-10	Шууд тусгагдсан-9	Шууд тусгагдсан-8	
	Агуулга уялдсан-16	Агуулга уялдсан-18	Агуулга уялдсан-16	Агуулга уялдсан-12	
	Огт тусгагдаагүй-3	Огт тусгагдаагүй-5	Огт тусгагдаагүй-8	Огт тусгагдаагүй-4	
	Нийцлийн тоо-24	Нийцлийн тоо-28	Нийцлийн тоо-25	Нийцлийн тоо-20	
	Нийцсэн хувь-89%	Нийцсэн хувь-85%	Нийцсэн хувь-76%	Нийцсэн хувь-83%	
Үндэсний болон бүсийн хэмжээний бодлогуудын нийцтэй байдлын үнэлгээний нэгдсэн үр дүн	Шууд тусгагдсан-8	Шууд тусгагдсан-10	Шууд тусгагдсан-9	Шууд тусгагдсан-8	Хөгжлийн бодлогуудын зоригтууд нь хэмжигдэхүйц байж чадахгүй; цалин хөлс, зохистой хөдөлмөр эрхлэлтийн зарим асуудлууд орхигдсон; тогтвортой ажиллах боломжууд хангалтгүй байна.
	Агуулга уялдсан-16	Агуулга уялдсан-18	Агуулга уялдсан-16	Агуулга уялдсан-12	
	Огт тусгагдаагүй-3	Огт тусгагдаагүй-5	Огт тусгагдаагүй-8	Огт тусгагдаагүй-4	
	Нийцлийн тоо-24	Нийцлийн тоо-28	Нийцлийн тоо-25	Нийцлийн тоо-20	
	Нийцсэн хувь-89%	Нийцсэн хувь-85%	Нийцсэн хувь-76%	Нийцсэн хувь-83%	
	Шууд тусгагдсан-8	Шууд тусгагдсан-10	Шууд тусгагдсан-9	Шууд тусгагдсан-8	
	Агуулга уялдсан-16	Агуулга уялдсан-18	Агуулга уялдсан-16	Агуулга уялдсан-12	
	Огт тусгагдаагүй-3	Огт тусгагдаагүй-5	Огт тусгагдаагүй-8	Огт тусгагдаагүй-4	
	Нийцлийн тоо-24	Нийцлийн тоо-28	Нийцлийн тоо-25	Нийцлийн тоо-20	
	Нийцсэн хувь-89%	Нийцсэн хувь-85%	Нийцсэн хувь-76%	Нийцсэн хувь-83%	

Хавсралт 20. Хөдөлмөрийн салбарын орцууд

№	Хөдөлмөрийн салбарын орцын үзүүлэлтүүд	ТХ-ийн үзэл баримтлал	Төрөөс ХЭТББ
1	Нийт хүн амын тоо /хүйс, насны бүлэг, аймаг, сумаар/		
2	15 ба түүнээс дээш насны хүн амын тоо /хүйсээр/		
3	Хөдөлмөрийн насны хүн амын тоо /хүйс, насны бүлэгээр/		
4	Хөдөлмөрийн чадваргүй хүн амын тоо /хүйс, насны бүлэгээр/		
5	Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо /хүйс, насны бүлэгээр/		
6	Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо /хүйс, насны бүлэгээр/		
7	Эдийн засгийн байнгийн идэвхтэй хүн амын тоо /хүйс, насны бүлэгээр/		
8	Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо /хүйс, насны бүлэгээр/		
9	Нийт ажиллагчдын тоо /ЭЗ-ийн салбараар, хүйс, насны бүлэгээр/		
10	Ажилгүй иргэдийн тоо /Мэргэжил, хүйс, насны бүлэгээр/		
11	Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо /хүйс, насны бүлэгээр/		
12	Урт хугацаагаар ажилгүй байгаа иргэд /хүйс, насны бүлэгээр/		
13	15-24 насны ажилгүй иргэдийн тоо /хүйсээр/		
14	15-24 насны эдийн засгийн ивэдхтэй хүн амын тоо /хүйсээр/		
15	Хөдөлмөрийн чадвартай хөдөлмөрийн насны хүн амын тоо /хүйс, нас/		
16	Бүрэн бус хөдөлмөр эрхлэлт /хүйс, насны бүлэгээр/		
17	Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй 5-11 насны хүүхэд /хүйсээр/		
18	Хөнгөн ажлыг 7 хоногт 14-өөс дээш цагаар хийж буй 12-14 насны хүүхэд		
19	7 хоногт 43 ба түүнээс дээш цагаар ажил эрхэлж байгаа 15-17 насны хүүхэд		
20	Ажиллагчдын цалин хөлс /салбар болон ажил мэргэжилээр/		
21	Дотоодын нийт бүтээгдэхүүн /зэрэгцүүлэх үнээр/		
22	Хэрэглээний үнийн индекс, хувиар		
23	МСҮТ-суралцаж буй сурагчын тоо /нас, хүйс, мэргэжил/		
24	МСҮТ-ийн төгссөн сурагчдын тоо /нас, хүйс, мэргэжил/		
25	Шинэ ажлын байр бий болгосон төгсөгч, ажил олгогч /салбар, мэргэжил/		
26	Албан бус хөдөлмөр эрхлэлт /салбар, хүйс, нас, мэргэжил/		
27	ЖДҮ-ийг хөгжүүлэхэд зарцуулсан санхүүгийн дэмжлэг, сая төгрөгөөр		
28	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, мянгөн төгрөгөөр		
29	Ногоон ажлын байранд ажиллагсдын тоо /салбар, мэргэжил/		
30	Мал ах ахуй эрхлэгчдийн тоо /насны бүлэг, хүйс/		
31	Нийгмийн даатгалын шимтгэл төөөгчдийн тоо, мянгөн хүн /салбар, мэргэжил/		
32	Хаягийн бүртгэлгүй оршин сууж буй хүн амын тоо /аймаг, сум, хүйс, нас/		
33	ЭЗ-нийт салбарт цалинтай ажиллагч эмэгтэйчүүдийн тоо /нас, мэргэжил, аймаг/		
34	ХАА-н бус салбарт цалинтай ажиллагч эмэгтэйчүүдийн тоо /нас, аймаг/		
Нийт дүн болон дүнд эзлэх хувь		9 (26.5%)	10 (29.4%)

Хавсралт 21. Хөдөлмөрийн салбарын шалгуур үзүүлэлтүүд

№	Хөдөлмөрийн салбарын индикаторууд	Томъёолол	ТХ-ийн үзэл баримтлал	Төрөөс ХЭТББ
1	Ажиллах хүчний оролцооны түвшин, хувиар	5/3		
2	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувиар	9/3		
3	Ажилгүйдлийн түвшин, хувиар	10/5		
4	Залуучуудын ажилгүйдлийн түвшин, хувиар	13/14		
5	Дундаж цалин, мянган төгрөгөөр	20/9		
6	ЭЗ-ийн идэвхгүй байдлын түвшин	6/3		
7	Хөдөлмөрийн бүтээмж	21/9		
8	Хөдөлмөр эрхлэлтийн мэдрэмж	9%/21%		
9	Ногоон ажлын байрны эзлэх хувь	29/9		
10	Албан бус хөдөлмөр эрхлэлтийн түвшин, хувь	26/3		
11	Мал аж ахуйн эрхлэгчдийн хувь	30/3		
12	Хаягийн бүртгэлгүй оршин сууж буй хүн амын эзлэх хувь	32/1		
13	ХАА-н бус салбарт цалинтай ажиллагч эмэгтэйчүүдийн хувь	34/33		
Нийт дүн болон дүнд эзлэх хувь			2 (15.4%)	7 (53.8%)

Хавсралт 22. ТХЗ-той хамаарал бүхий зохистой хөдөлмөрийн үзүүлэлтүүдийн төлөв байдал

Монгол улсын хөдөлмөрийн салбарын хувьд “Тогтвортой хөгжлийн зорилт 2030”-ын хүрээнд тооцох зохистой хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд дэх ОУХБ-ын хариуцах ТХЗ-ын үндсэн 14 үзүүлэлтээс дараах 3 үзүүлэлт нь статистикаар гарахгүй байна. Үүнд:

- 8.8.2. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын конвенц, зөвлөмж болон үндэсний хууль тогтоомжид үндэслэн гарах эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон хамтын хэлэлцээртэй холбоотой хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтийн түвшин
- 10.7.1. Гадаадад олсон жилийн нийт орлогод тухайн ажилд ороход зарцуулсан зардлын эзлэх хувь
- 14.с.1. Институтийн орчноор дамжуулан ОУ-ын хууль, эрх зүйг соёрхон баталж, зөвшөөрч, хэрэгжүүлэх чиглэлд ахиц, дэшил гаргаж байгаа улс орнуудын байдал

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын оролцох тогтвортой хөгжлийн зорилтын үндсэн 4 үзүүлэлт байгаагаас манай улсад дараах 2 үзүүлэлт нь гарахгүй байна. Үүнд:

- 1.1.1. Ядуурлын олон улсын түвшнээс доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувь, хүйс, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, байршлаар
- 4.3.1. Сүүлийн 12 сарын хугацаанд албан болон албан бус боловсрол, сургалтанд хамрагдсан залуучуудын тухайн насны хүн амд эзлэх хувь, хүйсээр

Зохистой хөдөлмөр эрхлэлтийн бусад үндсэн үзүүлэлтүүдэд тогтвортой хөгжлийн зорилтын дэлхийн хэмжээний үзүүлэлтийн хүрээнд ордог хөдөлмөрийн салбартай холбоотой бусад үндсэн 48 үзүүлэлтээс одоогийн байдлаар манай улсад 33 үзүүлэлт нь тогтмол, 4 үзүүлэлт нь хэсэгчлэн гардаг бол 11 үзүүлэлт нь огт гарахгүй байна. Үүнд:

- Итгэл алдарсан ажил хайгчид, хүйсээр, насаар, хүний тоогоор
- Ажиллагчдын жилд дунджаар жинхэнэ ажилласан цаг
- Нэг ажилтанд ногдох ажил эрхлэлтийн цагийн нэрлэсэн зардал, эдийн засгийн үйл ажиллагааны төрлөөр
- Ажил олгогч болон цалинтай ажиллагчдын хамтын хэлэлцээрт хамрагдалт, хүйсээр, хүний тоогоор
- Ажил олгогч болон цалинтай ажиллагчдын хамтын хэлэлцээнд хамрагдалтын түвшин, хүйсээр, хувиар
- Үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдсанаас ажиллаагүй алдагдсан хоногийн тоо, хүйсээр, салбараар, хоногоор
- Ажил хаялт, ажлын байрыг түр хааснаас шалтгаалан алдагдсан ажлын өдрүүд, салбараар,
- Ажил хаялт, ажлын байрыг түр хааснаас шалтгаалан алдагдсан ажлын өдрийн хувь, салбараар, хувиар
- Хөдөлмөрийн хяналтад хамрагдах боломжтой бүртгэлтэй ажлын байрууд
- Ажлын байруудад жилийн туршид хийгдсэн хөдөлмөрийн хяналтын тоо, удаа
- Нэг байцаагчид ногдох хөдөлмөрийн хяналт, хувиар



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН

ТАЙЛАН

**Төвийн бүсийн Говийн дэд бүсийн Нийгмийн хамгааллын
салбарын хөгжил байршлын бодлогын судалгаа**

Улаанбаатар хот
2019

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын,
хөгжлийн төлөвлөлтийн зөвлөх:
Б.Энх-Амгалан Ph.D

Дэд профессор, Эдийн засгийн тэнхим, МУИС
Их сургуулийн гудамж - 1, Бага тойруу, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар
enkhamgalan@num.edu.mn

Энэхүү тайлан нь захиалагч болон санхүүжүүлэгчийн байр суурь бус, судлаачийн байр суурийг илэрхийлнэ.

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЭЛЭН

Гарчиг

Талархал	4
Товчилсон үгийн жагсаалт	5
Хүснэгтийн жагсаалт	6
Зургийн жагсаалт	7
Хураангуй	8
Судалгааны зорилго, зорилт, арга аргачлал:	9
БҮЛЭГ 1. Нийгмийн хамгааллын салбар дахь нөхцөл байдлын шинжилгээ.....	10
1.1 Нийгмийн хамгааллын салбарын олон улс дахь харьцуулалт	10
1.2 Нийгмийн хамгааллын салбарын өнөөгийн нөхцөл байдал	12
1.3 Нийгмийн салбарын 2030 он хүртэлх чиг хандлага	16
БҮЛЭГ 2. Нийгмийн хамгааллын салбарын хууль болон бодлогын уялдаа хамаарлын шинжилгээ	19
2.1 Монгол улсад мөрдөгдөж буй нийгмийн хамгааллын хууль болон бодлогын баримт бичгийн уялдаа.....	19
2.2 Орон нутгийн бодлогын баримт бичгийн уялдаа	22
БҮЛЭГ 3. Нийгмийн хамгааллын салбарын нөлөөллийн урьдчилсан үнэлгээ.....	27
3.1 Нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд онооны системийг тооцсон арга зүй	27
3.2 Аймаг, сумдын нийгмийн хамгааллын салбарын нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	28
Үр дүн	30
1. Үндэсний түвшинд	30
2. Бүсийн түвшинд.....	30
3. Аймгийн түвшинд.....	30
Дүгнэлт	31
1. Хөгжил байршил.....	31
2. Хөгжлийн бодлого төлөвлөлт ба хууль эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, цаашид сайжруулах талаар.....	31
Санал	32
Аймгийн хөгжлийн хөтөлбөрт тусгах санал	32
Төвийн бүсийн говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгах санал	33
Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгах зарчмын санал	33
Ашигласан материал.....	34
Хавсралт 1. Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн бодлогын баримт бичиг	35
Хавсралт 2. Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн бодлогын баримт бичигт байршлыг тодотгосон байдал.....	37
Хавсралт 3. Нийгмийн хамгааллын салбарын хууль эрх зүйн баримт бичгийн жагсаалт.....	38

Талархал

Энэхүү бодлогын судалгааны ажлыг амжилттай дуусгахад гүн туслалцаа үзүүлсэн ҮХГ-ын Салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга Д.Эрдэнэбаяр, Эдийн засгийн хүрээлэнгийн захирал доктор, профессор Х.Цэвэлмаа, “Оюутолгой” ХХК-ийн хамт олонд талархал илэрхийлье.

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН

Товчилсон үгийн жагсаалт

АХБ	Азийн хөгжлийн банк
АҮ	Аж үйлдвэр
БОАЖ	Байгаль, орчин аялал жуулчлал
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МСҮТ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв
НД	Нийгмийн даатгал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ПТК	Политехникийн коллеж
УУ	Уул уурхай
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХАА	Хөдөө аж ахуй
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд
ХНХЯ	Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын Яам
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
PPP	Purchasing Power Parity
SPI	Social Protection Index

Хүснэгтийн жагсаалт

- Хүснэгт 1.1. Нийгмийн халамжийн сангийн орлого (тэрбум төгрөг)
- Хүснэгт 1.2. Нийгмийн даатгалын сангийн орлого (тэрбум төгрөг)
- Хүснэгт 1.3. Мэргэжлийн боловсролын сургуулиудыг төрөлжүүлэх санал
- Хүснэгт 2.1. Нийгмийн хамгааллын бодлоготой холбоотой үндэсний бодлогын баримт бичгийн жагсаалт
- Хүснэгт 2.2. Говьсүмбэр аймгийн бодлогын баримт бичгүүдэд нийгмийн хамгааллын салбарын талаарх бодлого тусгагдсан байдал
- Хүснэгт 2.3. Дорноговь аймгийн бодлогын баримт бичгүүдэд нийгмийн хамгааллын салбарын талаарх бодлого тусгагдсан байдал
- Хүснэгт 2.4. Дундговь аймгийн бодлогын баримт бичгүүдэд нийгмийн хамгааллын салбарын талаарх бодлого тусгагдсан байдал
- Хүснэгт 2.5. Өмнөговь аймгийн бодлогын баримт бичгүүдэд нийгмийн хамгааллын салбарын талаарх бодлого тусгагдсан байдал
- Хүснэгт 2.6. Сумдын бодлогын баримт бичигт нийгмийн хамгаалал, хүн амын өсөлтийн чиглэлээр тусгагдсан байдал.
- Хүснэгт 3.1. Бодлогын баримт бичигт хугацааны ач холбогдлоор оноо өгсөн байдал
- Хүснэгт 3.2. Нийгмийн хамгааллын салбар дахь ач холбогдлоор оноо өгсөн байдал
- Хүснэгт 3.3. Говийн 4 аймгийн нийгмийн хамгааллын салбарын оноо
- Хүснэгт 3.4. Говьсүмбэр аймгийн сумдын нийгмийн хамгааллын салбарын оноо
- Хүснэгт 3.5. Дорноговь аймгийн сумдын нийгмийн хамгааллын салбарын оноо
- Хүснэгт 3.6. Дундговь аймгийн сумдын нийгмийн хамгааллын салбарын оноо
- Хүснэгт 3.7. Өмнөговь аймгийн сумдын нийгмийн хамгааллын салбарын оноо

Зургийн жагсаалт

- Зураг 1.1. Нийгмийн хамгааллын зардлын ДНБ-нд эзлэх хувь
- Зураг 1.2. Нийгмийн халамж, Нийгмийн даатгалын ДНБ-нд эзлэх хувь
- Зураг 1.3. Нийгмийн халамж авсан хүмүүсийн тоо
- Зураг 1.4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага (тэрбум төгрөг)
- Зураг 1.5. Говийн 4 аймгийн нийгмийн даатгалын сангийн орлогын өсөлт, хувиар

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН

Хураангуй

Энэхүү судалгааны ажлаар нийгмийн хамгааллын салбарын олон улсын хэмжээн дэх гол өөрчлөлт, салбарын өсөлт бууралт, салбарын 2030 он хүртэлх чиг хандлагыг тодорхойлох; говийн дэд бүсийн 4 аймгийн нийгмийн хамгааллын салбарын хувьд бүсчилсэн хөгжлийн болон нийгмийн хамгааллын салбарт одоо мөрдөгдөж буй хууль, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, уялдаа холбоо, зорилт зэрэгт шинжилгээ хийж, говийн дэд бүсийн 4 аймгийн нийгмийн хамгааллын салбарын хөгжил байршлын нэгдсэн зураглал боловсруулав.

Судалгааны ажлын эхний бүлэгт олон улсад нийгмийн хамгааллын үзүүлэлтийг харьцуулах 3 аргыг авч үзсэн. Гол арга болох нийгмийн хамгааллын зардлын ДНБ-д эзлэх хувийг авч үзвэл ЭЗХАХБ-ын дундаж 20.1 хувь байгаа бол Монголд 7.7 хувь орчимд байна.

Нийгмийн хамгааллын чиглэлийн хууль тогтоомжуудад газарзүйн байршлаар тодорхойлон заасан тусгайлсан заалт ховор байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.10-д нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох” заалт бий.

Нийгмийн хамгаалалтай холбогдон гарч байгаа зардлыг бууруулах, НДШ-ийн төлөлтийг нэмэгдүүлэхэд мэргэжилтэй ажиллах хүчний өсөлт чухал нөлөөтэй. Энэ утгаараа хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын гол зорилт нь мэргэжилтэй ажиллах хүчний өсөлт, тэдгээрийг бэлтгэх асуудал чухал байр суурьтай байдаг. Тиймээс мэргэжлийн боловсролын байгууллагыг газар нутгийн онцлог, цаашдын мэргэжлийн эрэлт хэрэгцээ зэргийг харгалзан үзэж төрөлжүүлэх шаардлагатай байгаа бөгөөд судалгааны ажилд Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй хийгдсэн судалгааны үр дүнг ашигласан.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д тусгагдсанаар ядуурлыг бүх түвшинд устгах, ЭЗХАХБ-ын дундаж хэмжээнд очихын тулд нийгмийн хамгааллын зардлыг жил бүр 24 хувиар нэмэгдүүлэх шаардлага гарч байна.

Манай улсын хэмжээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлыг тусгасан нийт 30 гаруй бодлогын баримт бичгүүд байгаагаас хугацааны хувьд хэрэгжиж дууссан нь 10 орчим, одоо хэрэгжиж буй 20 орчим хөтөлбөр байна. Эндээс нийгмийн халамжийн чиглэлээр өнөөгийн байдлаар Халамжийн тэтгэвэр, Халамжийн тэтгэмж, Халамжийн үйлчилгээ, Ахмад настны хөнгөлөлт тусламж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламж, Эхчүүдийн тэтгэмж, Хүүхдийн мөнгө, Хүнсний эрхийн бичиг, Үндэсний цөөнхийн тэтгэмж, Алдар цолтны нэмэгдэл гэсэн 10 хөтөлбөр 70 орчим арга хэмжээ хэрэгжиж байна.

Нийгмийн хамгааллын үндсэн чиглэл нь улсын хэмжээнд хууль, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгээр боловсруулагдсан байгаа ч аймгийн хөгжлийн хөтөлбөр, үндсэн чиглэл, засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг нарийн тусгасан зүйл ховор байна. Үүний гол шалтгаан нь нийгмийн хамгаалал, нийгмийн халамжийн бодлого нь босоо чиглэлийн удирдлагатай холбоотой байж болох юм.

Нийгмийн хамгааллын салбарын нөлөөллийн урьдчилсан үнэлгээг хийхдээ аймгийн түвшинд боловсруулагдсан бодлогын баримт бичигт нийгмийн хамгааллын асуудлыг урт, дунд, богино хугацаанд хэрхэн тусгагдсан байдлаар онооны системээр тооцсон.

Энэхүү онооны системийг аймгийн болон сумын түвшинд гаргахдаа нийгмийн хамгааллын салбарын ач холбогдлоор нь 1. Нийгмийн даатгал, 2. Нийгмийн халамж, 3. Жендер, 4. Хүн амын өсөлт, 5. Мэргэжлийн боловсролын асуудал гэж хуваан авч үзэв.

Эдгээр судалгааны үр дүнд үндэслэн Дүгнэлт хийж, Санал зөвлөмжийг аймгийн түвшинд, говийн дэд бүсийн түвшинд, бодлого боловсруулах түвшинд тус бүрд нь гаргасан.

Судалгааны зорилго, зорилт, арга аргачлал:

Судалгааны зорилго нь Төвийн бүсийн говийн дэд бүсийн дөрвөн аймгийн бүсчилсэн хөгжлийн болон нийгмийн хамгааллын салбарт одоо мөрдөгдөж байгаа хууль, бодлогуудын хэрэгжилт, уялдаа холбоо, тулгамдаж буй асуудлууд болон шийдвэрлэх боломжуудыг тодорхойлж, нэгдсэн санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулахад оршино.

Судалгааны зорилт

Нийгмийн хамгааллын салбарын олон улсын хэмжээн дэх гол өөрчлөлт, салбарын өсөлт бууралт, салбарын 2030 он хүртэлх чиг хандлагыг тодорхойлох; Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь, Дундговь аймгуудын нийгмийн хамгааллын салбарын хувьд бүсчилсэн хөгжлийн болон нийгмийн хамгааллын салбарт одоо мөрдөгдөж буй хууль, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, уялдаа холбоо, зорилт зэрэгт шинжилгээ хийж, говийн дэд бүсийн 4 аймгийн нийгмийн хамгааллын салбарын хөгжил байршлын нэгдсэн зураглал боловсруулах явдал.

Зорилтыг хангах үүднээс дараах чиглэлээр шинжилгээ хийв. Үүнд:

1. Олон улсын түвшинд, улсын хэмжээнд, бүсийн хэмжээнд, аймгийн хэмжээнд нийгмийн хамгааллын салбарын өнөөгийн нөхцөл байдал, гол гарч буй өөрчлөлт чиг хандлагыг тодорхойлох;
2. Нийгмийн хамгааллын салбарын өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан 2030 он хүртэлх ерөнхий чиг хандлагыг гаргаж ирэх;
3. Говийн бүсийн дөрвөн аймгийн хүрээнд боловсруулсан бодлогын баримт бичгүүдэд нийгмийн хамгааллын салбарын талаарх бодлого тусгагдсан байдал, бодлого хоорондын уялдаа, хэрэгжилт болон эдгээр бодлогын баримт бичгүүдийн залгамж чанарыг харьцуулан судлах;
4. Говийн бүсийн 4 аймгийн хөгжлийн бодлогын голлох баримт бичгүүдээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээнүүд нь нийгмийн хамгааллын салбартай холбоотой хууль, бодлого, хөтөлбөрүүд болон холбогдох бусад хууль, бодлогын баримт бичгүүдтэй хэрхэн уялдаж байгааг харьцуулан судалж, дүн шинжилгээ хийх;
5. Говийн 4 аймгийн нийгмийн хамгааллын салбарын хөгжил, байршлын нэгдсэн төлөвлөлт, зураглалыг боловсруулах үзүүлэлтүүдийг тодорхойлон гаргаж бодлогын баримт бичгүүдэд тусгуулах.

Судалгааны аргачлал, арга зүй

Тус судалгааг гүйцэтгэхдээ ажлын даалгаврын хүрээнд өгөгдсөн бодлогын судалгаа боловсруулах арга зүй болох “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 4-д заасан “Нөхцөл байдлын дүн шинжилгээ”-д тулгуурлахаас гадна баримт бичиг судлах арга, түүхэн ба логик арга, харьцуулалтын арга, хувьчлах арга, өсөлтийн хурдыг тооцох геометр дундаж, хүснэгт, график зэрэг аргыг ашиглав.

Судалгааны баримт бичгүүд:

Судалгаандаа бид Олон улсын нийгмийн хамгааллын салбарын үзүүлэлтүүдийг харьцуулах ЭЗХАХБ-ын баримт бичиг, АХБ-аас боловсруулсан нийгмийн хамгааллын индексийг тооцох арга зүй, говийн бүсийн аймгуудад хэрэгжүүлж буй аймгуудын хөгжлийн бодлого, хөтөлбөр, цогц бодлого; аймгуудын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл; аймгийн ЗДТГ-ын харьяа агентлагуудын бодлого, дэд хөтөлбөрүүд; аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөр зэргийг үндэсний болон бүсийн хэмжээнд мөрдөгдөж буй бодлогын баримт бичгүүд; нийгмийн хамгааллын салбартай холбоотой хууль эрх зүй, бодлогын баримт бичгүүд; эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх, төвлөрлийг сааруулах бодлого; Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого болон Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай харьцуулан судлах болно.

БҮЛЭГ 1. Нийгмийн хамгааллын салбар дахь нөхцөл байдлын шинжилгээ

1.1 Нийгмийн хамгааллын салбарын олон улс дахь харьцуулалт

Нийгмийн хамгааллын зорилго нь маш өргөн хүрээг хамардаг боловч товчоор баялагийн тэгш хуваарилалт, ядуурлыг бууруулах, нийгмийн эмзэг хэсгийг эдийн засгийн болон бусад гэнэтийн нөлөөллөөс хамгаалах явдал гэж тодорхойлж болох юм.

Улс орнууд нийгмийн хамгааллын талаарх бодлогоо тодорхойлохдоо олон улсын жишиг, хөгжлийн стратеги, эдийн засгийн өсөлт, ядуурлын түвшин зэрэг үзүүлэлтүүдийг гол болгохын зэрэгцээ өөрийн орны онцлогийг тусгаж байдаг. Тиймээс улс орнуудын нийгмийн хамгааллын бодлогыг шууд харьцуулахад төвөгтэй ч тодорхой түвшинд нийгмийн хамгаалалд зарцуулж байгаа зардлын хэмжээгээр нь харьцуулах боломжтой байдаг.

Өндөр хөгжилтэй орнуудын хувьд нийгмийн хамгааллын систем нь тогтвортой, бодлого чиглэл тодорхой, нийгмийн хамгаалалд зарцуулж буй зардал нь харьцангуй өндөр, зорилтод бүтэгтэй бүрэн чиглэсэн байдаг бол хөгжиж буй орнуудын хувьд эдийн засгийн нөхцөл байдал, хууль эрх зүйн орчин, улс төрийн тогтолцоо зэргээс шалтгаалан нийгмийн хамгааллын систем нь бүрэн тогтворжоогүй нийгмийн хамгаалалд зарцуулж буй зардал нь харьцангуй бага, зорилтод бүлэгтэй бүрэн хүрэхгүй байх нь элбэг байдаг.

Олон улсад нийгмийн хамгааллын үзүүлэлтүүдийг харьцуулахдаа дараах гурван аргыг түлхүү хэрэглэдэг байна.

1. Тухайн улсын нийгмийн хамгааллын зардлын ДНБ-нд эзлэх хувь,
2. Тухайн улсын нэг хүнд ногдох нийгмийн хамгааллын зардлыг худалдан авах чадварын тэнцвэр (PPP)-ээр илэрхийлж харьцуулах,
3. Нийгмийн хамгааллын индекс (SPI) Энэ индексийг Ази, номхон далайн орнуудын тоо мэдээг ашиглан 2005 оноос ашиглаж эхэлсэн бөгөөд нийгмийн хамгаалалд зарцуулж буй зардлыг нийгмийн хамгааллаас өгөөж хүртэж буй хүмүүсийн тоонд харьцуулдаг. Энэ индексийн гол зорилго нь бодлого шийдвэр гаргагчид өөрсдийн нийгмийн хамгааллын салбарын ахиц, дэвшлийг тодорхойлох, улс хооронд харьцуулалт хийхэд ашиглах явдал юм.


Нийгмийн хамгааллын зардлын ДНБ-нд эзлэх хувиар хэмжигдэж буй үзүүлэлт нь баялагийн хуваарилалт хэрхэн хийгдэж байгааг илэрхийлэх үзүүлэлт гэж үздэг.

Өндөр хөгжилтэй орнуудын хувьд нийгмийн хамгааллын зардлын ДНБ-нд эзлэх хувь өндөр байдаг. Тухайлбал, 2017 оны байдлаар Франц хамгийн өндөр буюу 31.8 хувь, Финланд 28.9 хувь гэх зэргээр ЭЗХАХБ-ын дунджаар 20.1 хувьтай байна.

Зарим өндөр хөгжилтэй улс орны хувьд энэ харьцаанд шүүмжлэлтэй ханддаг бөгөөд хувийн хэвшлийг хамгаалах замаар (татварын гэх мэт) нийгэмд зарцуулах зардлыг бууруулдаг, ажил олгогч хувийн хэвшлийн зүгээс халамжийн хөтөлбөрийг ихээхэн хэрэгжүүлдэг тул энэ харьцаа учир дутагдалтай гэх нь бий.

Манай улсын хувьд дундаж орлоготой орнуудын ангиллын 3 дахь шат болох доогуур орлоготой орнуудтай ойролцоо түвшинд байгаа бөгөөд 2008-2017 онд хэрхэн өөрчлөгдсөн талаарх динамикийг дараах зургаар харуулав.

Зураг 1.1. Нийгмийн хамгааллын зардлын ДНБ-нд эзлэх хувь




Эх сурвалж: ҮСХ, судлаачийн тооцоо

Энд нийгмийн хамгааллын зардлын ДНБ-нд эзлэх хувь тодорхой түвшинд хэлбэлзэлж байгаа боловч нийт нийгмийн хамгааллын зардал жил бүр тасралтгүй өсч байгаа.

Нийгмийн хамгааллын зардлыг дотоод бүрэлдэхүүн хэсэг болох нийгмийн даатгалын зардал болон нийгмийн халамжийн зардлаар задлан харвал:

Зураг 1.2. Нийгмийн халамж, Нийгмийн даатгалын ДНБ-нд эзлэх хувь



Эх сурвалж: ҮСХ, судлаачын тооцоо

Дэлхийн улс орнуудын жишгээс харвал бага болон дунд орлоготой орнууд нийгмийн халамжинд ДНБ-ийхээ 1.5 орчим, өндөр хөгжилтэй орнууд 1.9 орчим хувийг, ЭЗХАХБ-ын орнууд 2.9 хүртэл хувийг зарцуулдаг байна. Манай улсын хувьд нийгмийн халамжид зарцуулж байгаа зардал бусад улстай харьцуулахад бага 1-1.1 хувь байна.

Нийгмийн хамгааллын зардлыг худалдан авах чадварын тэнцвэрээр илэрхийлсэн үзүүлэлт нь гол төлөв ЭЗХАХБ-н байгууллагын хүрээнд тооцож харуулдаг. ЭЗХАХБ-ын нэг хүнд ногдох нийгмийн хамгааллын зардал нь 2015 оны дунджаар авч үзэхэд 7819.6\$ байгаа бол Монголын хувьд 2015 оны байдлаар ойролцоогоор 890.6\$ байгаа нь 8.8 дахин бага байна.

Нийгмийн хамгааллын индексийг Ази, номхон далайн орнуудын нийгмийн хамгааллын үзүүлэлтүүдийг харьцуулах үүднээс 2005 оноос хэрэглэж эхэлсэн бөгөөд 2010 онд шинэчилсэн арга зүйг боловсруулсан байдаг. Энэ үзүүлэлтээр Монгол улс Ази, номхон далайн орнууд дотроо харьцангуй өндөр байдаг бөгөөд 2007 онд хийсэн судалгаагаар 4-д, 2009 оны судалгаагаар Япон, Узбекистаны дараа 3-рт бичигдэж байна.

1.2 Нийгмийн хамгааллын салбарын өнөөгийн нөхцөл байдал

Нийгмийн хамгааллын орлого нь нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын сангийн орлогоос бүрддэг.

Хүснэгт 1.1. Нийгмийн халамжийн сангийн орлого (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бүгд	221.6	233.2	136.0	134.8	188.1	243.5	244.4	265.1	275.9	271.2
Улсын төсөв	221.4	232.9	104.1	133.9	187.4	37.5	35.2	35.4	33.8	35.5
Орон нутгийн төсөв						205.2	209.2	229.8	242.1	235.7


Эх сурвалж: ҮСХ *2013 оноос нийгмийн халамжийн сангийн орлогыг орон нутгийн эх үүсвэрээс бүрдүүлэх болсон.

Халамжийн сангийн орлогыг 2017 он хүртэлх 10 жилийн хугацаагаар авч үзвэл жилийн дундаж өсөлт нь 8.7 орчим хувь байна. Гэхдээ эдгээрийг хугацаа бүрд авч үзвэл 2010, 2011, 2017 онуудад халамжийн сангийн орлого буурсан байна.

Эдийн засгийн болон улс төрийн сонгуулийн нөлөө, улс төрчдийн нийгмийн халамжинд чиглэсэн олон амлалт, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой бодлогын үр дүнд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт авсан хүний тоо маш их хэмжээгээр өөрчлөгдөж өндөр хэлбэлзэлтэй гарч байна.

Ялангуяа энэ дүн хүүхдийн мөнгө олголттой холбоотой ихээхэн өөрчлөгддөг. Тухайлбал 2010, 2011 онуудад хүүхдийн мөнгөний олголт зогсоход ихээхэн буурсан. Нийгмийн халамж хүртэгсдийн тоо 4.8 дахин багасч 508.4 мянга хүрсэн ч 2012 оноос дахин сэргэхэд 2.4 дахин нэмэгдэж 1478 мянган хүн болсон байна.

Зураг 1.3. Нийгмийн халамж авсан хүмүүсийн тоо (мянга)



Эх сурвалж: ҮСХ

Нийгмийн халамж хүртэгсдийн тоо өндөр байгаа нь халамжийн бодлого зорилтот бүлэгтээ бүрэн чиглэж чадахгүй байгааг илэрхийлж байна. Тухайлбал, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар 2015 онд хийгдсэн судалгаанаас харахад нийгмийн халамжийн үйлчилгээ хүртэгсдийн 28

хувь нь амьжиргааны түвшин өндөртэй 40 хувьд хамрагдах хүмүүс хүртсэн байна гэж дурдсан байна.

ҮСХ-оос 2011 онд хийгдсэн судалгаагаар Говийн 4 аймгийн ядуурлын хамралтын хүрээ, ядуурлын гүнзгийрэлт, ядуурлын мэдрэмж гэсэн үзүүлэлтээр сумын түвшинд харах боломжтой ч тэрнээс хойш хийгдээгүй байгаа нь Нийгмийн хамгааллын бодлогод шууд авч ашиглахад төвөгтэй байна.

НДЕГ-аас -өндөр настны, -хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, -тэжээгчээ алдсны, -цэргийн гэсэн төрлөөр нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоогоор гаргаж байгаа тул үүнийг сумын түвшинд НДЕГ-т хандан гаргуулан авах боломжтой юм.

Нийгмийн хамгааллын бодлогын үр ашгийг дээшлүүлэхэд нийгмийн даатгалын санд шимтгэл төлөгчдийн тооны өсөлт, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын харьцааг зохистой түвшинд байлгах, сангийн удирдлагын оновчтой тогтолцоо чухал нөлөөтэй байна.


Хүснэгт 1.2. Нийгмийн даатгалын сангийн орлого (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018
Бүгд	422.6	457.0	622.7	755.5	799.2	1018.8	1140.6	1187.4	1314.6	1546.3	2403.0
Тэтгэврийн даатгалын сангийн	314.4	330.4	462.8	532.8	491.9	635.0	704.4	718.7	767.5	880.3	1703.8
Тэтгэмжийн даатгалын сангийн	13.0	15.2	18.0	25.1	35.5	67.3	78.4	81.1	86.9	112.7	130.0
Эрүүл мэндийн даатгалын сангийн	62.4	71.8	91.3	121.5	166.6	204.1	231.7	248.1	302.6	366.4	312.8
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	20.3	23.9	31.6	49.1	67.9	86.7	99.7	109.7	125.1	147.8	212.6
Ажилгүйдлийн даатгалын сангийн	12.5	15.7	19.1	27.0	37.3	25.8	26.3	29.8	32.5	39.0	43.7

Эх сурвалж: ҮСХ

Нийгмийн даатгалын сангийн орлого жил бүр нэмэгдэж байгаа ч зарлагын өсөлт нь орлогоос давж алдагдалтай гарах явдал сүүлийн жилүүдэд зонхилж байв.

Зураг 1.4. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага (тэрбум төгрөг)



Эх сурвалж: ҮСХ


Нийгмийн даатгалын сангийн зарлага 2011 оноос эхлэн нийгмийн даатгалын сангийн орлогоос давж гарсан бөгөөд 2013 онд нийгмийн даатгалын шимтгэлийг нэмсэнтэй холбоотойгоор зөрүү бага зэрэг болсон ч 2014 оноос хойш зөрүү эрчимтэй нэмэгдсэн. 2017 оны байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого зарлагын зөрүү 343.8 тэрбум төгрөгийн алдагдалтай болсон байна.

Засгийн газраас нийгмийн даатгалын шимтгэлийг 2018 онд 2 хувиар нэмэх, 2019 онд 1 хувиар, 2020 онд 2 хувиар үе шаттайгаар нэмж нийт таван пунктээр өсгөхөөр шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрийн дагуу 2018 онд нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оноос 55 хувиар нэмэгдсэн нь 2013 онд нийгмийн даатгалын шимтгэлийг нэмснээс хойшхи хамгийн өндөр өсөлт болж байна. Ингэснээр 2018 онд нийгмийн даатгалын сангийн зарлагаас орлого 257.3 тэрбум төгрөгөөр давсан нь 2011 оноос хойш 7 жилийн дараа анх удаа ашигтай гарсан үзүүлэлт юм.

Нийгмийн даатгалын сангийн орлогыг 2017 он хүртэлх 10 жилээр авч үзэхэд жилийн дундаж өсөлт нь 16.8 хувь, жилийн зарлага нь 19.8 хувийн өсөлттэй байсан нь орлогын хурдаасаа зарлагын хурд илүү байсныг илэрхийлж байна.

Нийгмийн хамгааллын салбарын өсөлт, бууралт нь нийгмийн халамжийн төрөл, түүнд зарцуулж байгаа мөнгөн дүнгээс ихээхэн хамаардаг.

Зураг 1.5. Говийн 4 аймгийн нийгмийн даатгалын сангийн орлогын өсөлт, хувиар



Эх сурвалж: ҮСХ, судлаачийн тооцоо

Нийгмийн даатгалын сангийн орлогыг аймгаар авч үзвэл 2017 он хүртэлх 8 жилийн хугацаанд Өмнөговь аймгийн дундаж өсөлт хамгийн өндөр буюу жилд дунджаар 18.8 хувиар нэмэгдсэн байна. Гэхдээ Оюутолгой төслийн үйл ажиллагааны идэвхижил сул байсан 2014, 2015 онуудад нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх жилээсээ буурч байжээ.

Говьсүмбэр аймгийн нийгмийн даатгалын сангийн орлого 8 жилийн хугацаанд жилд дунджаар 14.7 хувиар өсч байсан нь Өмнөговь аймгийн дараа орохуйц өндөр үзүүлэлт юм. Бас нэг давуу тал нь орлогын өсөлт саарах жил байсан ч нийт хугацааны туршид жил бүр орлого давж байжээ. Дорноговь аймгийн хувьд нийгмийн даатгалын сангийн орлого дээрх хугацаанд жилд дунджаар 13.9 хувийн өсөлттэй байсан бөгөөд 2015 онд өмнөх жилтэйгээ харьцуулахад орлого 1.7 хувиар буурч байжээ.

Дундговь аймгийн хувьд нийгмийн даатгалын сангийн орлогын өсөлтийн дундаж хэмжээ бусад 3 аймагтай харьцуулахад хамгийн бага буюу жилд дунджаар 8.6 хувиар нэмэгдсэн байна. Дундаж өсөлт бага гарахад 2012 онд орлого 19.6 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого эдийн засгийн нөхцөл байдалтай уялдаатай боловч орлогын тогтмол өсөлт эргээд нийгмийн даатгалын сангийн зардлын тогтвортой байдлыг хангах өсөлт болдог. Өмнөговь болон Дундговь аймгийн хувьд нөгөө хоёр аймагтай харьцуулахад нийгмийн даатгалын сангийн орлогын өсөлт өндөр хэлбэлзэлтэй байгаа нь зарцуулалтыг урт хугацаанд төлөвлөхөд бэрхшээл учрах талтай юм.

Нийгмийн хамгааллын чиглэлийн хууль тогтоомжуудад газарзүйн байршлаар тодорхойлон заасан тусгайлсан заалт ховор байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.10-д нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг хөгжлийн бэрхшээлтэй хүн аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгох” заалт бий.

Мөн хилийн застав, хилийн боомтод ажиллаж буй хилийн болон гаалийн албан хаагчдад хилийн нэмэгдэл олгох зохицуулалтыг Хилийн тухай хууль, Гаалийн улсын байцаагчид нэмэгдэл олгох тухай журамд тусгасан байдаг нь шууд бус утгаар нийгмийн хамгаалалтай холбогдох боломжтой юм.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 2016 оны хоёрдугаар сарын 05-нд оруулсан өөрчлөлтөөр “Аймаг, сумын төв нь нийслэл (Улаанбаатар) хотоос 550 км-ээс хол

байршилтай аймаг, суманд байнгын үйл ажиллагаа явуулдаг, бүртгэлтэй, орон нутгийн төсөвтэй харьцдаг, гурваас доошгүй ажлын байр бий болгож (нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажсан) байгаа энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.3-т заасан татварт ногдох орлогын албан татварыг 550 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 50 хувиар, 1000 км-ээс хол алслагдсан аймаг, суманд 90 хувиар хөнгөлнө” гэсэн заалт байгаа нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлж НДШ төлөлтийг нэмэгдүүлэх нэг боломж юм.

Нийгмийн хамгаалалтай холбогдон гарч байгаа зардлыг бууруулах, НДШ-ийн төлөлтийг нэмэгдүүлэхэд мэргэжилтэй ажиллах хүчний өсөлт чухал нөлөөтэй. Энэ утгаараа хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын гол зорилт нь мэргэжилтэй ажиллах хүчний өсөлт, тэдгээрийг бэлтгэх асуудал чухал байр суурьтай байдаг. Монгол улсын хэмжээнд мэргэжлийн боловсролын чиглэлээр сургалт явуулдаг нийт төрийн өмчийн болон хувийн өмчийн 91 политехникийн коллеж болон МСҮТ үйл ажиллагаагаа явуулж байна. Эдгээр мэргэжлийн боловсролын байгууллагыг газар нутгийн онцлог, цаашдын мэргэжлийн эрэлт хэрэгцээ зэргийг харгалзан үзэж төрөлжүүлэх шаардлагатай байгаа болно. Энэ талаар Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй хийгдсэн судалгааны үр дүнг дараагийн хэсэгт авч үзнэ.

1.3 Нийгмийн салбарын 2030 он хүртэлх чиг хандлага

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тусгагдсан ядуурлын бүх төрлийг эцэс болгоно гэсэн зорилтыг хангах, 2030 он гэхэд ЭЗХАХБ-ын жишигт хүрч нийгмийн хамгааллын зардлыг хамгийн багадаа ДНБ-ий 20 хувьд хүргэх шаардлагатай байна.

Монгол улсын ДНБ-ий хэмжээ 2000 оноос 2017 хүртэлх 17 жилийн хугацааны жилийн дундаж өсөлт 7.2 хувьтай байна. Өсөлтийн энэ хувь хэвээр хадгалагдана гэж үзвэл Монгол улсын ДНБ 2010 оны үнээр 2030 онд 40 орчим их наяд төгрөг болохоор байна.

Үүнийг ЭЗХАХБ-ын нийгмийн хамгаалалд зарцуулж байгаа зардлын ДНБ-нд эзлэх хувь өнөөгийн дундаж түвшин болох 20 хувь байна гэж үзвэл 2010 оны зэрэгцүүлэх үнээр 8 орчим их наяд төгрөг, жилийн инфляцийн түвшинг Монгол банкны зорилтот инфляцийн түвшингийн дээд утга болох жилийн 8 хувиар бодоход 37 их наяд төгрөгийг нийгмийн хамгааллын зардалд зарцуулах шаардлагатай болж байна.

Энэ нь одоогийн 2018 оны гүйцэтгэлд үндэслэсэн тооцоо болох нийгмийн халамжийн сангийн зарлагын жилийн дундаж өсөлт 9 орчим хувь 2030 он хүртэл энэ хурдаар зарлага өснө гэж үзвэл нийгмийн хамгааллын зардалд 19.6 орчим их наяд төгрөг зарцуулдаг байхаар байна.

Хэрэв төр засгийн зүгээс нийгмийн хамгааллын бодлогоо одоо байгаа түвшинд хэвээр хадгалвал 2030 оны зорилго биелэх боломжгүй бөгөөд нийгмийн хамгааллын зардал 2 дахин бага байна гэсэн дүр зураг харагдаж байна.

Иймээс 2030 онд ядуурлыг бүх түвшинд устгах, ЭЗХАХБ-ын дундаж хэмжээнд очихын тулд нийгмийн хамгааллын зардлыг жил бүр 24 хувиар нэмэгдүүлэх шаардлагатай.

Ядуурлыг бууруулахад мэргэжилтэй ажиллах хүчний оролцоо чухал бөгөөд цаашид урт хугацаанд ядуурлыг бууруулах, нийгмийн хамгааллын зардлыг бууруулж, НДШ төлөлтийг нэмэгдүүлэхэд одоо үйл ажиллагаа явуулж байгаа политехникийн коллеж болон МСҮТ-ийг төрөлжүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Энэ чиглэлээр АХБ-ы санхүүжилттэй ХНХЯ-ны захиалга бүхий “Skills for employment” төслийн хүрээнд мэргэжлийн боловсролын байгууллагыг төрөлжүүлэх стратегийн судалгааны үр дүнгээс дараах төрөлжүүлэлтийн санал боловсруулагдсан.

Хүснэгт 1.3 Мэргэжлийн боловсролын сургуулиудыг төрөлжүүлэх санал

№	Мэргэжлийн боловсролын байгууллагын нэр		Төрөлжүүлэх санал
1	Аймгийн МСҮТ	Баян-Өлгий	Барилга
2	Улаангом МСҮТ	Увс	Аж үйлдвэр
3	Хөгжил ПТК	Ховд	ХАА

4	Аймгийн ПТК	Завхан	Барилга
5	Тосонцэнгэл сумын МСҮТ	Завхан	Аймгийн ПТК-той нэгтгэх
6	Аймгийн МСҮТ	Говь-Алтай	Барилга (Завхан ПК-тай хамтарч шаталсан сургалт явуулахад анхаарах хэрэгтэй.)
7	Аймгийн МСҮТ	Хөвсгөл	Байгаль орчин, аялал жуулчлал
8	Аймгийн МСҮТ	Архангай	ХАА (МАА)
9	Аймгийн МСҮТ	Орхон	Барилга
10	ХАА-н МСҮТ	Орхон	Булган аймгийн ХАА-н МСҮТ-тэй нэгтгэх
11	Аймгийн МСҮТ	Булган	Орхон аймгийн МСҮТ-тэй нэгтгэх
12	ХАА-н МСҮТ	Булган	ХАА
13	Аймгийн МСҮТ	Өвөрхангай	Барилга
14	Аймгийн ПТК	Баянхонгор	АҮ (хөнгөн үйлдвэр)
15	Аймгийн ПТК	Сэлэнгэ	ХАА
16	Аймгийн МСҮТ	Сэлэнгэ	АҮ (хүнс)
17	Шаамар сумын МСҮТ	Сэлэнгэ	Аймгийн төвийн МСҮТ болон Зүүнхараагийн ПТК-той нэгтгэх
18	Аймгийн МСҮТ	Дархан-Уул	Барилга (МБ)
19	УУЭХПК	Дархан-Уул	УУ, эрчим хүч болон АҮ (салбар дундын)
20	Аймгийн ПТК	Дархан-Уул	Барилга (ТБ)
21	Аймгийн МСҮТ	Төв	АҮ (хөнгөн үйлдвэр болон хүнс)
22	Заамар сумын МСҮТ	Төв	Баянчандмань сумын МСҮТ-тэй нэгтгэх
23	Баянчандмань сумын МСҮТ	Төв	ХАА
24	Эрдэнэ сумын МСҮТ	Төв	Налайхын МСҮТ-тэй нэгтгэх
25	Аймгийн ПТК	Говьсүмбэр	Уул уурхай
26	Аймгийн МСҮТ	Дундговь	Барилга
27	Аймгийн МСҮТ	Дорноговь	ХАА
28	Аймгийн ПТК	Өмнөговь	Уул уурхай
29	Аймгийн МСҮТ	Хэнтий	ХАА (ГТ)
30	Бор-Өндөр сумын МСҮТ	Хэнтий	Жоншны үйлдвэрт ажиллах мэргэжилтэй ажилчдыг голлон бэлтгэдэг тул тус үйлдвэрийн газрын харъяанд буюу АА тооцоонд шилжүүлэх
31	Аймгийн ПТК	Дорнод	АҮ болон УУ
32	Аймгийн МСҮТ	Дорнод	Барилга
33	Аймгийн МСҮТ	Сүхбаатар	ХАА (МАА)
34	Налайх дүүргийн МСҮТ	Улаанбаатар	Барилга
35	Сэргээн засалт сургалт үйлдвэрлэлийн төв	Улаанбаатар	Тусгай хэрэгцээт сургууль
36	ҮҮПТК	Улаанбаатар	Соёл урлаг, Мэдээлэл технологи
37	Монгол-Солонгосын ПТК	Улаанбаатар	ПТК-АҮ, тээвэр
38	Барилгын ПТК	Улаанбаатар	Барилга

Эх сурвалж: “Skills for employment” төслийн тайлан 2017 он

Төрөлжүүлсний үр дүнд төрийн өмчийн мэргэжлийн боловсролын 30 сургууль (+1 тусгай хэрэгцээт)-тай болно.

– Барилга	11	(36.7%)
– ХАА	8	(26.7%)
– АҮ	6	(20%)
– УУ	3	(10 %)
– БОАЖ	1	(3.3%)
– Соёл урлаг	1	(3.3 %)

Төрөлжилтийн үр дүнгийн дагуу арга хэмжээг бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэхээс гадна тухайн бүс нутагт байгуулагдсан томоохон аж үйлдвэр, уур уурхай зэргээс хамааралтайгаар богино хугацаанд нэмж МСҮТ байгуулах шаардлага урган гарч болно.

Нийгмийн хамгааллын бодлогыг тогтвортой барьж байхад хүн амын өсөлтийг зайлшгүй харж, хүн амын өсөлтийг тооцоолж байх шаардлагатай байдаг.

Төрөлтийг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор олон төрлийн бодлогуудыг улс орнуудын зүгээс авч хэрэгжүүлдэг байна. Үүнд:

- ХАОАТ-ын хөнгөлөлт (Хүүхэдгүй бол илүү өндөр татвар төлнө)
- Сар бүр бэлэн мөнгө олгох
- Эд хэрэглэл олгох (Хүүхдийн хэрэглээний бүтээгдэхүүн, гэр ахуйн бараа гэх мэт)
- Ажлаас эрт явах боломжоор хангах (Гэр бүлийн өдөртэй болгож 7 хоног бүрийн тухайлсан өдөр ажлаас эрт явах боломж олгодог)
- Хосуудын өдөр зохион байгуулах
- Танилцуулах, гэр бүл болох зуучлах товчоог ажиллуулах

Эдгээрээс манай улсад тохиромжтой нь ХАОАТ, сар бүр бэлэн мөнгө олгох, гэр бүлийн өдөртэй болох зэрэг аргуудыг урт хугацаанд, бусад аргуудыг богино хугацаанд хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

БҮЛЭГ 2. Нийгмийн хамгааллын салбарын хууль болон бодлогын уялдаа хамаарлын шинжилгээ

2.1 Монгол улсад мөрдөгдөж буй нийгмийн хамгааллын хууль болон бодлогын баримт бичгийн уялдаа

Монгол улсын үндсэн хууль болон нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн холбогдох заалтууд нь нийгмийн хамгааллын талаар баримтлах суурь зохицуулалт нь болдог.

Нийгмийн хамгааллын бодлогын (төлөвлөлт, шийдвэр гаргалт, хэрэгжилт, хяналт гэсэн цикл хэлбэрээр явагдана) талаарх судалгааг хийхэд улс төрийн, эдийн засгийн, нийгэм соёлын гэсэн үндсэн хүчин зүйлсийг харгалзан үзэх шаардлагатай.

Монгол улсад хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын чиглэлээр нийт 33 хууль хэрэгжиж байна.

1. Ахмад настны тухай
2. Гэр бүлийн тухай
3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай
4. Хүүхдийн эрхийн тухай
5. Хүүхэд хамгааллын тухай
6. Хүүхэд харах үйлчилгээний тухай
7. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай
8. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай
9. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай
10. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай
11. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай
12. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай
13. Хөдөлмөрийн тухай
14. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай
15. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай
16. Ажлын таван өдөртэй долоо хоногт шилжүүлэх тухай
17. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай
18. Нийгмийн даатгалын тухай
19. Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай
20. Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай
21. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай
22. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай
23. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай
24. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай
25. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай
26. Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай
27. Нийгмийн халамжийн тухай
28. Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай
29. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай
30. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай
31. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай
32. Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай
33. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай

Эдгээр 33 хуулийг дотор нь хөдөлмөр, нийгмийн даатгал, нийгмийн халамж гэсэн үндсэн 3 хэсэгт ангилж харж болно.

Манай улсын хэмжээнд хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудлыг тусгасан нийт 30 гаруй бодлогын баримт бичгүүд байгаагаас хугацааны хувьд хэрэгжиж дууссан нь 10 орчим, одоо хэрэгжиж буй 20 орчим хөтөлбөр байна. Эндээс нийгмийн халамжийн чиглэлээр өнөөгийн байдлаар Халамжийн тэтгэвэр, Халамжийн тэтгэмж, Халамжийн үйлчилгээ, Ахмад настны хөнгөлөлт тусламж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламж, Эхчүүдийн тэтгэмж, Хүүхдийн мөнгө, Хүнсний эрхийн бичиг, Үндэсний цөөнхийн тэтгэмж, Алдар цолтны нэмэгдэл гэсэн 10 хөтөлбөр 70 орчим арга хэмжээ хэрэгжиж байна.

Эндээс харвал социалист системийн үед хэрэгжиж байсан нийгмийн халамжийн бодлогууд нь өнөөгийн нөхцөлд залгамж шинж чанараа алдаагүй бөгөөд өмнөх тогтолцооноос уламжилж ирсэн, тодорхой хугацаанд зогссон боловч дахин сэргэсэн, шинээр бий болсон бодлогууд орж байна.

Хүснэгт 2.1. Нийгмийн хамгааллын бодлоготой холбоотой үндэсний бодлогын баримт бичгийн жагсаалт

№	Хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Хэрэгжүүлэх хугацаа	Батлагдсан огноо, дугаар
Хэрэгжээд дууссан хөтөлбөрүүд			
1	Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал үндэсний хөтөлбөр	1998-2008	1998-07-29, 130
2	Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	1998-2003	1998, 41
3	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр	2002-2005	2002, 92
		2006-2010	
4	Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр		2003-10-24,41
5	Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр	2007-2008	2006-11-21, 282
		2009-2012	
		2013-2015	
6	“Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөр	2006-2008	2006-04-26, 91
7	Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого	2006-2008	2006-01-05, 01
		2009-2011	
		2012-2015	
8	Төрөөс малчдын талаар баримтлах бодлого	2009-2015	2009-06-04, 39
9	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр	2012-2013	2011, 303
		2014-2016	
10	“Ажилтай, орлоготой монгол хүн” үндэсний хөтөлбөр	2013-2016	2013-04-27, 154
11	Монгол улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого	2013-2018	2003, 16
12	Эдийн засгийг сэргээх хөтөлбөр	2017-2018	2016-11-24, 71
Хэрэгжиж буй хөтөлбөрүүд			
13	“Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр	2014-2017	2013, 416
		2018-2020	

14	Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого 2015-2030	2015-2030	2015-06-16, 53
15	Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	2016-2020	2016-02-05, 19
		2021-2025	
		2026-2030	
16	Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр	2016-2020	2016-02-04, 16
17	Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	2016	2016-06-06, 304
		2017-2019	
		2019-2021	
18	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого	2016-2020	2016-06-13, 320
		2021-2025	
19	Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр	2016-2025	2015-11-16, 447
20	Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2016-2020	2016-09-09, 45
21	Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого	2016-2025	2016-05-16, 261
22	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр	2017-2021	2017-04-26, 129
23	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 5 дахь хөтөлбөр	2017-2020	2017, 243
24	Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр	2017-2021	2017-09-20, 270
25	Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр	2018-2021	2018-06-27, 02
26	Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр	2018-2021	2018-05-23, 140
27	“Үйлдвэржилт 21_100” үндэсний хөтөлбөр	2018-2021	2018-01-31, 36
28	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр	2018-2022	2017-11-29, 321
Журам			
29	Малчинд тэтгэвэр тогтооход баримтлах журам		2018-03-14, 71
30	Даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоох насыг тодорхойлоход баримтлах журам		2018-03-14, 71

Эх сурвалж: legalinfo.mn

Манай улсын хувьд нийгмийн халамжтай холбоотой хуулийн дагуу хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдээс гадна улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан амлалтын шинж чанартай ажлуудыг хэрэгжүүлэх үүднээс нэмэлт үндэсний хэмжээний хөтөлбөрийг боловсруулж батлуулах замаар хэрэгжүүлж байна. Энэ нийгмийн халамжтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгүүдтэй зөрчилдөх асуудал харьцангуй бага боловч эдийн засгийн хувьд улс орны хэмжээнд зарим талаар хүндрэл учруулах нөхцөл болдог.

Нийгмийн даатгалын хувьд үндсэндээ хуулийн дагуу түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой нэмэлт тайлбар, журмаар зохицуулагдаж үндэсний хэмжээнд мөрдөгдөж байна.

2.2 Орон нутгийн бодлогын баримт бичгийн уялдаа

Орон нутгийн бодлогын баримт бичгүүдэд нийгмийн хамгааллын чиглэлийг илэрхийлсэн асуудлуудыг тусгайлан бүлэг эсвэл бүлэг дотроо зүйл, заалт хэлбэрээр тусган оруулсан байгаа боловч гол үйл ажиллагаа нь сургууль, соёл, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой асуудлуудыг түлхүү оруулсан байна. Нийгмийн хамгааллын асуудлын хүрээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх талаар тусгасан байна. Үндсэн санаа нь хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлыг бууруулах зорилтуудыг гол болгосон байна.

Нийгмийн хамгааллын үндсэн чиглэл нь улсын хэмжээнд хууль, тогтоол шийдвэр болон бодлогын баримт бичгээр боловсруулагдсан байгаа ч аймгийн хөгжлийн хөтөлбөр, үндсэн чиглэл, засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд нарийн тусгасан зүйл ховор байна. Үүний гол шалтгаан нь нийгмийн хамгаалал, нийгмийн халамжийн бодлого нь босоо чиглэлийн удирдлагатай холбоотой байж болох юм.

Говийн дөрвөн аймгийн мастер төлөвлөгөө, аймгийн засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн төлөвлөгөө гэсэн 3 гол баримт бичгийг аймгуудад батлан гаргаж хэргэжилтэнд үнэлгээ өгөх замаар хийгдэж байна.

Эдгээр бодлогын баримт бичгүүд нь хоорондоо хэрхэн уялдсан талаар аймаг тус бүрд нь хүснэгтээр илэрхийлье.

Хүснэгт 2.2. Говьсүмбэр аймгийн бодлогын баримт бичгүүдэд нийгмийн хамгааллын салбарын талаарх бодлого тусгагдсан байдал

Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)	Аймгийн засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр	Говьсүмбэр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэл
Ядуурлыг бууруулах бодлого	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлого	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан бодлого
Нийгмийн халамжийн талаарх бодлого	Зорилтот бүлэгт чиглэсэн дэд хөтөлбөр	Зорилтот бүлэгт чиглэсэн дэд хөтөлбөр
Нийгмийн даатгалын баазыг өргөжүүлэх бодлого		

Эх сурвалж: Говьсүмбэр аймгийн Засаг даргын тамгын газар

Нийгмийн халамжийн талаарх бодлого бүрхэг, халамжийн үйлчилгээ үзүүлнэ гэдгээр хязгаарлагдсан.

Аймгийн бодлогын баримт бичгүүдэд нийгмийн хамгааллын талаар авч хэрэгжүүлэх бодлого маш бага тусгагдсанаас гадна Мянганы хөгжлийн зорилт болон Тогтвортой хөгжлийн баримт бичигт тусгагдсан нийгмийн хамгааллын талаарх бодлогуудтай уялдсан байдал тааруу байна.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан гол бодлого нь хөгжлийн төв байгуулах, ажил эрхлэх боломжийг нэмэгдүүлэх гэдгээр хязгаарлагдаж байна. Мөн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой арга хэмжээнүүд тусгагдаж байгаа боловч МСҮТ-тэйгээ уялдуулах байдал бага байна.

Нийгмийн даатгалын хувьд хамрагдалтыг нэмэгдүүлнэ, үйлчилгээг сайжруулна гэсэн цөөн асуудлыг бодлогын баримт бичигтээ тусгажээ.

Ядуурлыг бууруулах бодлого нь халамжийн бодлоготой уялдаа бага, хөдөлмөр эрхлэх, сан байгуулах замаар бууруулах бодлогыг гол болгосон байна.

Хүснэгт 2.3. Дорноговь аймгийн бодлогын баримт бичгүүдэд нийгмийн хамгааллын салбарын талаарх бодлого тусгагдсан байдал

Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө (2011-2021)	Аймгийн засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
Хүн амын өсөлтийн талаарх бодлого	Нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ	Нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлнэ
Жендерийн тэгш байдлын талаарх бодлого	Нийгмийн даатгалын сангийн засаглалын сайжруулах	Нийгмийн даатгалын сангийн засаглалын сайжруулах
Ядуурлыг бууруулах бодлого	Зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа	Жендерийн тэгш байдлын талаарх бодлого
Мэргэжлийн боловсролын талаарх бодлого		Мэргэжлийн боловсролын талаарх бодлого
		Хөгжлийн бэрхшээлтэй зорилтот бүлэгт чиглэсэн бодлого

Эх сурвалж: Дорноговь аймгийн засаг даргын тамгын газар

Нийгмийн халамжийн чиглэлээр шууд тусгагдаагүй ч агуулгын хувьд тусгагдсан байна. Аймгийн бодлогын баримт бичгүүдэд нийгмийн даатгал, нийгмийн халамжийн чиглэлийн үйл ажиллагааны талаар оруулахдаа ялгаатай байдлаар оруулсан байна.

Хүснэгт 2.4. Дундговь аймгийн бодлогын баримт бичгүүдэд нийгмийн хамгааллын салбарын талаарх бодлого тусгагдсан байдал

Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр (2018-2028)	Аймгийн засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр	Дундговь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэл
-	Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн бодлого	Ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн бодлого
	Жендерийн тэгш байдлын талаарх бодлого	МСҮТ-ийн талаарх бодлого
	Нийгмийн даатгалын үйлчилгээг шуурхай болгоно	Халамжийн талаар "Цалинтай ээж" хөтөлбөр хэрэгжүүлэх
		Жендерийн тэгш байдлын талаарх бодлого
		Нийгмийн даатгалын үйлчилгээг шуурхай болгох асуудал

Эх сурвалж: Дундговь аймгийн Засаг даргын тамгын газар

Шинээр баталсан нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр 2018-2028-даа нийгмийн хамгааллын (нийгмийн даатгал, нийгмийн халамж) талаар тусгаагүй, аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдаагүй бодлогыг аймгийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлд оруулсан байна.

Хүснэгт 2.5. Өмнөговь аймгийн бодлогын баримт бичгүүдэд нийгмийн хамгааллын салбарын талаарх бодлого тусгагдсан байдал

Өмнөговь аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2020)	Аймгийн засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр	Өмнөговь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэл
Жендерийн асуудлыг дэмжсэн бодлого	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ	Ахмад настны болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах оролцоог нэмэгдүүлэх
Ядуурлыг бууруулах бодлого	Өрх гэр бүлийн хөтөлбөр хэрэгжүүлж амьжиргааг дээшлүүлнэ	Ядуурлыг бууруулах хөтөлбөр
Нийгмийн хамгааллын асуудлыг шийдэх хөрөнгө бүрдүүлнэ		
Зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйл ажиллагаа	Зорилтот бүлэгт чиглэсэн нийгмийн халамжийн үйл ажиллагаа	
МСҮТ-ийн талаарх бодлого	МСҮТ-ийн талаарх бодлого	

Эх сурвалж: Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар

Нийгмийн халамжийн зарим чиглэлээр асуудлууд тусгагдсан боловч нийгмийн даатгалын талаар асуудал тусгагдаагүй байна. Төрийн байгууллагад ажиллагсад мөнгөн болон орон сууцны нөхцлийг сайжруулахтай холбоотой нийгмийн хамгааллын чанартай хөтөлбөр хэрэгжиж байна.

Говийн 4 аймгийн сумдын түвшинд нийгмийн хамгааллын бодлого, жендер, хүн амын өсөлт, мэргэжлийн боловсролын талаар хэрхэн тусгагдсаныг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2.6. Сумдын бодлогын баримт бичигт нийгмийн хамгаалал, хүн амын өсөлтийн чиглэлээр тусгагдсан байдал.

Сум	Нийгмийн даатгал	ХБИ, Ахмад настны халамжийн асуудал	Жендэр	Мэргэжлийн сургалтын боловсрол	Хүн амын өсөлтийг дэмжих бодлого
Говьсүмбэр					
Баянтал	+	+	+	+	
Сүмбэр		+			
Шивээговь		+		+	
Дорноговь					
Их хэт	+	+		+	
Хөвсгөл	+	+			
Сайншанд		+		+	
Айраг	+	+			
Алтанширээ	+	+			
Даланжаргалан	+	+		+	
Дэлгэрэх	+	+	+	+	

Замын Үүд					
Мандах	+	+			
Өргөн	+	+			
Сайхандулаан	+	+	+		
Улаанбадрах	+	+	+		
Хатанбулаг					
Эрдэнэ	+	+		+	
Дундговь					
Баянжаргал	-	-	-	-	-
Говь-Угтаал		+			
Дэлгэрцогт	+	+			
Өндөршил	+	+		+	
Эрдэнэдалай		+		+	+
Дэлгэрхангай	+	+			
Дэрэн	+	+	+	+	
Луус		+		+	
Өлзийт	+	+			
Сайхан-Овоо		+		+	
Хулд	+	+		+	
Цагаандэлгэр	+	+			
Сайнцагаан		+			
Адаацаг		+	+	+	
Гурвансайхан		+	+	+	
Өмнөговь					
Даланзадгад		+			
Манлай		+			
Сэврэй	+	+			
Цогтцэций		+			
Баяндалай	+	+			
Баян-Овоо		+			+
Булган		+			
Гурвантэс		+			
Мандал-Овоо		+			
Ноён		+			
Номгон		+			
Ханбогд		+		+	
Ханхонгор	+	+		+	
Хурмэн		+			
Цогт-Овоо		+			

Эх сурвалж: Сумдын Засаг даргын тамгын газар

Сумдын бодлогын баримт бичигт тусгагдаж байгаа нийгмийн хамгааллын талын асуудлаас хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмад настны нийгмийн халамжийн бодлогууд тусгагдсан байгаа боловч гол төлөв эрүүл мэндийн үйлчилгээ, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх нөхцөл боломжийг бүрдүүлэх тал дээр анхаарал хандуулсан байна. Нөгөө талаас нийгмийн даатгалын сантай холбоотой үйл ажиллагаа нь аймгийн хөгжлийн хөтөлбөрт тусгагдсан заалтыг шууд авч тавьсан байна.

Сумын түвшинд хүн амын өсөлтийг хангах бодлогын талаар тусгагдсан зүйл бараг байхгүй бөгөөд ердөө говийн 4 аймгийн хэмжээнд 2 суманд л энэ талаар авч үзжээ.

Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх тал дээр мэргэжлийн боловсролын асуудлыг Өмнөговь аймагт 2 суманд, Дундговь аймагт 8 суманд, Дорноговь аймагт 5 суманд, Говьсүмбэр аймагт 2 суманд тус бодлогын баримт бичигтээ тусгасан байна.

Жендерийн асуудлыг 4 аймгийн хэмжээнд 7 суманд авч үзсэн бол бусад суманд энэ талаар тусгагдсан зүйл байхгүй байна.

Сумдын бодлогын баримт бичгийн хувьд гол төлөв аймгаас гаргасан бодлогын баримт бичгээс улбаалсан хэлбэртэй зарим бодлогыг шууд авч тавьсан байна.

ЭДИЙН ЗАСГИЙН ХҮРЭЭЛЭН

БҮЛЭГ 3. Нийгмийн хамгааллын салбарын нөлөөллийн урьдчилсан үнэлгээ

3.1 Нөлөөллийн урьдчилсан үнэлгээнд онооны системийг тооцсон арга зүй

Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-н 2.2.1. Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдал хэсэгт зааснаар Зорилт 1-д ядуурлыг эцэс болгох, Зорилт 2-д хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, Зорилт 3-д нийгмийн даатгалын сангийн бие даасан тогтолцоог бүрдүүлэхээр заасан байдаг.

Зорилт 3-д заасан үзүүлэлтийг үндэс болгон салбарын нөлөөллийн урьдчилсан үнэлгээг дараах байдлаар боловсруулж тооцоолол хийв.

Тооцооллын хувьд аймгийн түвшинд боловсруулагдсан бодлогын баримт бичигт нийгмийн хамгааллын асуудлыг урт, дунд, богино хугацаанд хэрхэн тусгагдсан байдлаар онооны системийг тооцож авч үзсэн.

Хүснэгт 3.1. Бодлогын баримт бичигт хугацааны ач холбогдлоор оноо өгсөн байдал

Урт хугацаанд	Дунд хугацаанд	Богино хугацаанд
0.5	0.3	0.2

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Энд урт хугацааны бодлогын баримт бичиг нь цаашдын нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн алсыг харах үндсэн бааз суурь тул ач холбогдол өндөртэй гэж үзэж 0.5, дунд хугацааны урт хугацааны зорилгыг хэрэгжүүлэх дунд хугацаанд нийгмийн хамгааллын салбар хөгжил ямар байхыг тодорхойлж байгаа тул 0.3, богино хугацаанд аймгийн түвшинд нийгмийн хамгааллын салбарын бодлого хэрхэн хэрэгжиж байгааг тодорхойлж байгаа тул 0.2 гэсэн үнэлгээг өгсөн болно.

Нийгмийн хамгааллын нөлөөллийн урьдчилсан үнэлгээг тооцоход Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан дараах 5 шалгуур үзүүлэлтийг авч үзсэн болно.

1. Нийгмийн даатгал (нийгмийн даатгалтай холбоотой үйл ажиллагаа)
2. Нийгмийн халамж (ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа)
3. Жендер (хүйсийн тэгш байдал)
4. Хүн амын өсөлтийг дэмжих бодлого
5. Мэргэжлийн боловсрол (Мэргэжлийн боловсрол болон МСҮТ-ийн талаарх бодлого)

Эдгээр үзүүлэлтийг нийгмийн хамгааллын салбар дахь ач холбогдолын түвшингөөр дараах байдлаар жин бүхий онооны системийг тооцож үзэв.

Хүснэгт 3.2. Нийгмийн хамгааллын салбар дахь ач холбогдлоор оноо өгсөн байдал

Нийгмийн даатгал	Нийгмийн халамж	Жендер	Хүн амын өсөлт	Мэргэжлийн боловсрол
0.5	0.2	0.1	0.1	0.1

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Хүснэгтэд харуулсан жинг ашиглан аймгийн болон сумдын бодлогын баримт бичигт тусгагдсан нийгмийн хамгааллын салбарын нөлөөллийн урьдчилсан үнэлгээг хийх боломж бүрдлээ.

Аймгийн түвшинд урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт нийгмийн хамгааллын асуудал бүрэн тусгагдсан бол 1 гэсэн оноог авна.

Сумдын бодлогын баримт бичиг нь аймгийн бодлогын баримт бичигтэй уялдсан, түүнд тулгуурласан байна гэдэг үүднээс аймгийн авсан оноог сумдын бодлогын баримт бичигт тусгагдсан оноогоор үржүүлж гаргана. Энэ тохиолдолд сумдын хувьд авах боломжит дээд оноо нь 1*1 буюу 1 гэсэн оноог авна. Энэ оноог говийн 4 аймгийн сумдын хувьд эрэмбэлэх замаар

нийгмийн хамгааллын салбарын бодлогыг хамгийн сайн, муу тусгасан сумыг тодорхойлох боломжтой болох юм.

3.2 Аймаг, сумдын нийгмийн хамгааллын салбарын нөлөөллийн урьдчилсан үнэлгээ

Өмнөх арга зүйд тусгагдсан онооны системийг ашиглан нөлөөллийн урьдчилсан үнэлгээг тооцсон үр дүнг харуулав.

Хүснэгт 3.3. Говийн 4 аймгийн нийгмийн хамгааллын салбарын оноо

Дорноговь аймаг	Өмнөговь аймаг	Дундговь аймаг	Говьсүмбэр аймаг
0.54	0.38	0.42	0.45

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Өмнөговь аймгийн хувьд хамгийн бага оноо авсан бөгөөд гол шалтгаан нь урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт нийгмийн даатгалын асуудлыг орхигдуулсантай холбоотой юм. Дундговь аймгийн хувьд бодлогын баримт бичигтээ урт хугацаанд нийгмийн хамгааллын асуудлыг огт тусгаагүйтэй холбоотойгоор онооны түвшин бага гарсан. Говьсүмбэр аймгийн хувьд дунд болон богино хугацаанд нийгмийн даатгалын талаарх бодлогыг тусгаж өгөөгүй байна. Хамгийн өндөр оноог Дорноговь аймаг авч байгаа боловч урт хугацааны бодлогын баримт бичигтээ нийгмийн даатгалын талаар тусгаагүй байна.

Сумын түвшинд нийгмийн хамгааллын салбарын асуудал бодлогын баримт бичигт тусгагдсан байдлын талаарх тооцоог урт, дунд, богино хугацаагаар гэж авч үзэх боломж байхгүй тул 2016-2020 оны сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн бодлогын баримт бичгийн тоон үнэлгээний жинг ашиглан тооцсон.

Хүснэгт 3.4. Говьсүмбэр аймгийн сумдын нийгмийн хамгааллын салбарын оноо

Сум	Оноо
Баянтал	0.45
Сүмбэр	0.14
Шивээговь	0.18

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Хүснэгт 3.5. Дундговь аймгийн сумдын нийгмийн хамгааллын салбарын оноо

Сум	Оноо	Сум	Оноо	Сум	Оноо
Баянжаргал	0.00	Дэлгэрхангай	0.34	Хулд	0.38
Говь-Угтаал	0.13	Дэрэн	0.42	Цагаандэлгэр	0.34
Дэлгэрцогт	0.34	Луус	0.17	Сайнцагаан	0.13
Өндөршил	0.38	Өлзийт	0.34	Адаацаг	0.21
Эрдэнэдалай	0.21	Сайхан-Овоо	0.17	Гурвансайхан	0.21

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Хүснэгт 3.6. Дорноговь аймгийн сумдын нийгмийн хамгааллын салбарын оноо

Сум	Оноо	Сум	Оноо	Сум	Оноо
Их хэт	0.49	Даланжаргалан	0.49	Сайхандулаан	0.49
Хөвсгөл	0.43	Дэлгэрэх	0.54	Улаанбадрах	0.49
Сайншанд	0.22	Замын-Үүд*	-	Хатанбулаг**	-
Айраг	0.43	Мандах	0.43	Эрдэнэ	0.49
Алтанширээ	0.43	Өргөн	0.43		

Эх сурвалж: Судлаачийн тооцоо *-файл нээгдээгүй, **-баримт бичиг байхгүй.

Хүснэгт 3.7. Өмнөговь аймгийн сумдын нийгмийн хамгааллын салбарын оноо

Сум	Оноо	Сум	Оноо	Сум	Оноо
Даланзадгад	0.11	Баян-Овоо	0.15	Номгон	0.11
Манлай	0.11	Булган	0.11	Ханбогд	0.15
Сэврэй	0.30	Гурвантэс	0.11	Ханхонгор	0.34
Цогтцэций	0.11	Мандал-Овоо	0.11	Хүрмэн	0.11
Баяндалай	0.30	Ноён	0.11	Цогт-Овоо	0.11

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Онооны эрэмбээр Дорноговь аймгийн Дэлгэрэх сум 0.54 оноо авсан байдлаар бодлогын баримт бичигтээ нийгмийн хамгааллын салбарын талаар илүү тусгасан байна. Эсрэгээрээ Дундговь аймгийн Баянжаргал сум бодлогын баримт бичигт нийгмийн хамгааллын асуудлыг огт тусгаагүй 0 оноо авсан байна.

Үр дүн

1. Үндэсний түвшинд

Улс орон бүрийн нийгмийн хамгааллын бодлого нь өөрийн орны онцлогоос хамаараад ялгаатай байдаг тул олон улсад харьцуулалт хийх, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход дараах 3 аргыг түлхүү ашигладаг.

1. Тухайн улсын нийгмийн хамгааллын зардлын ДНБ-нд эзлэх хувь
Өндөр хөгжилтэй орнуудын хувьд нийгмийн хамгааллын зардлын ДНБ-нд эзлэх хувь өндөр байдаг ба 2017 оны байдлаар ЭЗХАХБ (Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага)-ын дунджаар 20.1 хувьтай бол манайд 7.7 хувь байна.
2. Тухайн улсын нэг хүнд ногдох нийгмийн хамгааллын зардлыг худалдан авах чадварын тэнцвэр (PPP)-ээр илэрхийлж харьцуулах,
ЭЗХАХБ-ын нэг хүнд ногдох нийгмийн хамгааллын зардал нь 2015 оны дунджаар авч үзэхэд 7819.6\$ байгаа бол Монголын хувьд 2015 оны байдлаар ойролцоогоор 890.6\$ байгаа нь 8.8 дахин бага байна.
3. Нийгмийн хамгааллын индекс (SPI) Нийгмийн хамгаалалд зарцуулж буй зардлыг нийгмийн хамгааллаас өгөөж хүртэж буй хүмүүсийн тоонд харьцуулдаг.
Энэ индексийг Ази, номхон далайн орнуудад түлхүү хэрэглэдэг. Манай орны хувьд энэ үзүүлэлтээр Ази, номхон далайн орнууд дотроо харьцангуй өндөр байдаг бөгөөд 2007 онд хийсэн судалгаагаар Монгол улс 4-д, 2009 оны судалгаагаар Япон, Узбекистаны дараа 3-рт бичигдэж байна.

ЗГ-аас НДШ-ийг 2018 онд 2 хувиар, 2019 онд 1 хувиар, 2020 онд 2 хувиар үе шаттайгаар нэмэхээр шийдвэрлэсэн. Энэхүү шийдвэрийн дагуу 2018 онд нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оноос 55 хувиар нэмэгдэж зарлагаасаа 257.3 тэрбум төгрөгийн ашигтай гарсан. Нийгмийн даатгалын сангийн орлогыг 2017 он хүртэлх 10 жилээр авч үзэхэд жилийн дундаж өсөлт нь 16.8 хувь, жилийн зарлага нь 19.8 хувийн өсөлттэй байсан нь орлогын хурдаасаа зарлагын хурд илүү байсныг илэрхийлж байна.

2. Бүсийн түвшинд

Говийн дөрвөн аймгийн бодлогын баримт бичгүүдийг харвал батлагдсан хугацаа ялгаатай, 3 аймагт стратегийн бодлогын баримт бичгийн хугацаа дуусч байгаа бол нэг аймагт шинээр урт хугацааны стратегийн бодлогын баримт бичгээ тодорхойлон гаргажээ.

Эдгээр бодлогын баримт бичигт нийгмийн хамгааллын талаар тусгасан асуудал нь харилцан адилгүй. Тухайлбал шинээр батлагдсан Дундговь аймгийн 2018-2028 оны хөгжлийн хөтөлбөрт нийгмийн хамгааллын талаар бодлогын асуудал огт тусгаагүй байна.

3. Аймгийн түвшинд

Өмнөговь болон Дундговь аймгийн хувьд нөгөө хоёр аймагтай харьцуулахад нийгмийн даатгалын сангийн орлогын өсөлт өндөр хэлбэлзэлтэй байна.

Аймгийн түвшний бодлогын баримт бичгүүдээс харахад одоогийн байгаа түвшин, ирээдүйд хүрэх түвшинг нарийн зааж өгөөгүй байна.

Сумдын бодлогын баримт бичгийн хувьд гол төлөв аймгаас гаргасан бодлогын баримт бичгээс улбаалсан хэлбэртэй зарим бодлогыг шууд авч тавьсан байна.

Бодлогын баримт бичигт тусгагдсан нийгмийн хамгааллын талаарх бодлогыг тэгээс нэгийн хооронд утга авахаар оноожуулсан системийг ашиглан үр дүнг тооцож үзэхэд Дорноговь аймаг 0.54 (хамгийн өндөр), Өмнөговь аймаг 0.38 (хамгийн бага), Дундговь аймаг 0.42, Говьсүмбэр аймаг 0.45 гарчээ.

Говийн 4 аймгийн сумдын хувьд улсын хэмжээний болон аймгийн бодлогын баримт бичигт тулгуурлаж өөрийн сумын бодлогын баримт бичгийг боловсруулсан гэж үзэж оноожуулалтыг тооцсон болно. Онооны эрэмбээр Дорноговь аймгийн Дэлгэрэх сум 0.54 оноо авсан байдлаар бодлогын баримт бичигтээ нийгмийн хамгааллын салбарын талаар илүү тусгасан байна. Эсрэгээрээ Дундговь аймгийн Баянжаргал сум бодлогын баримт бичигт нийгмийн хамгааллын асуудлыг огт тусгаагүй 0 оноо авсан байна.

Дүгнэлт

1. Хөгжил байршил

АХБ-ы санхүүжилттэй ХНХЯ-ны захиалга бүхий “Skills for employment” төслийн хүрээнд мэргэжлийн боловсролын байгууллагыг төрөлжүүлэх стратегийн судалгааны үр дүнгийн дагуу арга хэмжээг бодлогын хүрээнд авч хэрэгжүүлэхээс гадна тухайн бүс нутагт байгуулагдсан томоохон аж үйлдвэр, уур уурхай зэргээс хамааралтайгаар богино хугацаанд нэмж МСҮТ байгуулах шаардлага урган гарч болно.

Нийгмийн хамгааллын бодлогыг тогтвортой барьж байхад хүн амын өсөлтийг зайлшгүй харж, хүн амын өсөлтийг тооцоолж байх шаардлагатай байдаг.

Төрөлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой олон төрлийн бодлогуудыг улс орноос авч хэрэгжүүлж байна. Үүнд:

- ХАОАТ-ын хөнгөлөлт (Хүүхэдгүй бол илүү өндөр татвар төлнө)
- Сар бүр бэлэн мөнгө олгох
- Эд хэрэглэл олгох (Хүүхдийн хэрэглээний бүтээгдэхүүн, гэр ахуйн бараа гэх мэт)
- Ажлаас эрт явах боломжоор хангах (Гэр бүлийн өдөртэй болгож 7 хоног бүрийн тухайлсан өдөр ажлаас эрт явах боломж олгодог)
- Хосуудын өдөр зохион байгуулах
- Танилцуулах, гэр бүл болох зуучлах товчоог ажиллуулах

Эдгээрээс манай улсад тохиромжтой нь ХАОАТ, сар бүр бэлэн мөнгө олгох, гэр бүлийн өдөртэй болох зэрэг аргуудыг урт хугацаанд, бусад аргуудыг богино хугацаанд хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

2. Хөгжлийн бодлого төлөвлөлт ба хууль эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, цаашид сайжруулах талаар

Монгол улс 2030 онд ядуурлыг бүх түвшинд устгах, нийгмийн хамгаалалд зарцуулж байгаа зардлын хэмжээг ЭЗХАХБ-ын дундаж хэмжээнд хүргэхийн тулд нийгмийн хамгааллын зардлыг жил бүр 24 хувиар нэмэгдүүлэх шаардлага гарч байна.

Монгол улсад нийгмийн хамгааллын чиглэлийн хуулиуд нь нийгмийн хамгааллын чиглэлийн хөтөлбөр, бодлогын баримт бичигтэй зөрчилдөх байдал харьцангуй бага байна.

Нийгмийн хамгааллын чиглэлийн бодлогын баримт бичиг, хөтөлбөрүүд нь улсын хэмжээний бодлогын баримт бичгээр гаргасан бөгөөд үүнийг бүсийн түвшинд, аймгийн түвшинд хэрхэн хэрэгжүүлэх талаар нарийн тусгасан зүйл байхгүй.

Говийн 4 аймгийн нийгмийн халамжийн үйл ажиллагааны талаар ихэнх бодлогын баримт бичигт хангалтгүй тусгасан байгаа нь нийгмийн халамжийн босоо тогтолцоотой холбоотой байж болох юм.

Нийгмийн даатгалын сангийн орлого эдийн засгийн нөхцөл байдалтай уялдаатай боловч орлогын тогтмол өсөлт эргээд нийгмийн даатгалын сангийн зардлын тогтвортой байдлыг хангах өсөлт болдог. Өмнөговь болон Дундговь аймгийн хувьд нөгөө хоёр аймагтай харьцуулахад нийгмийн даатгалын сангийн орлогын өсөлт өндөр хэлбэлзэлтэй байгаа нь зарцуулалтыг урт хугацаанд төлөвлөхөд бэрхшээл учрах талтай юм.

Аймгийн түвшний бодлогын баримт бичгүүдээс харахад одоогийн байгаа түвшин, ирээдүйд хүрэх түвшинг нарийн зааж өгөөгүй байгаа нь Мянганы хөгжлийн зорилтууд, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон бусад бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтуудын хэрэгжилтийг хэмжихэд бэрхшээлтэй болгож байна.

Сумдын бодлогын баримт бичгийг харахад Өмнөговь аймгийн хувьд бодлогын баримт бичигт нийгмийн хамгааллын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ дутагдалтай байна.

Санал

Нийгмийн хамгааллын салбарт хийсэн шинжилгээний үр дүнд үндэслэн говийн 4 аймаг тус бүрээр, говийн дэд бүсийн түвшинд, улсын хэмжээний буюу бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах гэсэн 3 түвшинд санал боловсруулж хүргүүлж байна.

Аймгийн хөгжлийн хөтөлбөрт тусгах санал

Говьсүмбэр аймаг

1. Нийгмийн хамгааллын салбарын бодлогод авч үзсэн 5 шалгуур үзүүлэлтийг аймгийн түвшинд тусгахдаа
 1. Хөгжлийн мастер төлөвлөгөөндөө бүрэн хэмжээгээр тусгах,
 2. Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт боломжтой бол бүрэн хэмжээгээр тусгах
 3. Аймгийн жил бүрийн хөгжлийн үндсэн чиглэлдээ хэрэгжүүлэх боломжтой байдлыг харгалзан үзэж бүхэлд нь буюу тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх бодлогоо тусгах
2. Урт, дунд, богино хугацааны хөгжлийн хөтөлбөрийн үзүүлэлтүүдэд жендер, хүн амын өсөлт, мэргэжлийн боловсролын асуудлыг огт тусгаагүй байгааг анхаарч бодлогодоо тусгах
3. Аймгийн түвшинд тусгагдаагүй бодлогууд сумдын түвшинд батлагдсан байгааг анхаарах
4. Сумдуудад нийгмийн халамжаас бусад нийгмийн даатгал, жендер, хүн амын өсөлт, мэргэжлийн боловсролын талаарх бодлогууд огт тусгагдаагүй буюу маш бага тусгагдсан байгаа тул бодлогын баримт бичигт нь энэ талын бодлогыг тусгуулах

Дорноговь аймаг

1. Нийгмийн хамгааллын салбарын бодлогод авч үзсэн 5 шалгуур үзүүлэлтийг аймгийн түвшинд тусгахдаа
 1. Хөгжлийн мастер төлөвлөгөөндөө бүрэн хэмжээгээр тусгах,
 2. Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт боломжтой бол бүрэн хэмжээгээр тусгах
 3. Аймгийн жил бүрийн хөгжлийн үндсэн чиглэлдээ хэрэгжүүлэх боломжтой байдлыг харгалзан үзэж бүхэлд нь буюу тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх бодлогоо тусгах
2. Сумдын түвшинд нийгмийн хамгааллын салбарын бодлогын 5 үзүүлэлтээс нийгмийн даатгал, халамжийн асуудал харьцангуй сайн тусгагдсан байгаа ч жендер, мэргэжлийн боловсрол, хүн амын өсөлтийг дэмжихтэй холбоотой бодлого ихэнх сумдад байхгүй буюу дутуу байгааг анхаарч бодлогын баримт бичигтээ тусгах
3. Онооны системд оруулсан үнэлгээгээр аймгийн хувьд бусад аймгаас хамгийн өндөр байгаа боловч урт хугацааны бодлогын баримт бичигтээ нийгмийн даатгалын талаар тусгаагүйг анхаарч тусгаж ажиллах

Дундговь аймаг

1. Нийгмийн хамгааллын салбарын бодлогод авч үзсэн 5 шалгуур үзүүлэлтийг аймгийн түвшинд тусгахдаа
 1. Хөгжлийн мастер төлөвлөгөөндөө бүрэн хэмжээгээр тусгах,
 2. Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт боломжтой бол бүрэн хэмжээгээр тусгах
 3. Аймгийн жил бүрийн хөгжлийн үндсэн чиглэлдээ хэрэгжүүлэх боломжтой байдлыг харгалзан үзэж бүхэлд нь буюу тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх бодлогоо тусгах
2. Шинээр боловсруулсан аймгийн урт хугацааны хөгжлийн хөтөлбөрт нийгмийн хамгааллын салбарт шалгуур болгон авсан 5 үзүүлэлтээс алийг нь ч тусгаагүй байгаа нь нийгмийн хамгааллын талаар бодлогогүй болж байгаа тул хөтөлбөрөө дахин авч үзэж бодлогодоо тусгах
3. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт мэргэжлийн боловсролын талаар бодлого байхгүй ч жилийн ажлын үндсэн төлөвлөгөөнд тусгагдсан байгаа нь бодлогын хувьд уялдаагүй тул засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах, мөн хүн амын өсөлтийг дэмжих бодлого бүх түвшинд оруулах
4. Сумдуудад нийгмийн халамжаас бусад нийгмийн даатгал, жендер, хүн амын өсөлт, мэргэжлийн боловсролын талаарх бодлогууд огт тусгагдаагүй буюу маш бага тусгагдсан байгаа тул бодлогын баримт бичигт нь энэ талын бодлогыг тусгуулах

Өмнөговь аймаг

1. Нийгмийн хамгааллын салбарын бодлогод авч үзсэн 5 шалгуур үзүүлэлтийг аймгийн түвшинд тусгахдаа
 1. Хөгжлийн мастер төлөвлөгөөндөө бүрэн хэмжээгээр тусгах,
 2. Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт боломжтой бол бүрэн хэмжээгээр тусгах
 3. Аймгийн жил бүрийн хөгжлийн үндсэн чиглэлдээ хэрэгжүүлэх боломжтой байдлыг харгалзан үзэж бүхэлд нь буюу тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх бодлогоо тусгах
2. Аймгийн хөгжлийн хөтөлбөр болон засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт Нийгмийн даатгал, хүн амын өсөлтийг дэмжих, талаар баримтлах бодлогыг аймгийн хөгжлийн хөтөлбөртөө оруулах,
3. Аймгийн хөгжлийн жилийн үндсэн чиглэлдээ аль болох нийгмийн хамгааллын салбарт авч үзсэн 5 чиглэлийг хамруулах
4. Онооны системд оруулсан үнэлгээгээр аймгийн хувьд бусад аймгаас хамгийн бага оноо авсан. Гол шалтгаан нь урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт нийгмийн даатгалын асуудлыг орхигдуулсантай холбоотой тул нийгмийн даатгалын бодлогоо тодорхойлж оруулах
5. Сумдуудад нийгмийн халамжаас бусад нийгмийн даатгал, жендер, хүн амын өсөлт, мэргэжлийн боловсролын талаарх бодлогууд огт тусгагдаагүй буюу маш бага тусгагдсан байгаа тул бодлогын баримт бичигт нь энэ талын бодлогыг тусгуулах

Төвийн бүсийн говийн дэд бүсийн хөгжлийн хөтөлбөрт тусгах санал

1. Аймаг бүрийн бодлогын баримт бичгүүдийн хугацаа ялгаатай байгааг анхаарч урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийг ижил хугацаанд гаргах, авч үзэж буй хугацааны интервалыг ижил болгох
2. Нийгмийн хамгааллын салбарт гол болгон авсан 5 үзүүлэлт болох нийгмийн даатгал, нийгмийн халамж, мэргэжийн боловсрол, жендер, хүн амын өсөлтийг дэмжих бодлогуудыг аймаг, сумын түвшинд жигд тусгуулах

Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгах зарчмын санал

1. Бүсчилсэн хөгжлийн бодлогод нийгмийн хамгааллын салбарын бодлогыг тусгах. Ингэхдээ нийгмийн даатгал, нийгмийн халамж, жендер, мэргэжлийн боловсрол, хүн амын өсөлтийг харгалзаж үзэх.
2. Одоог хүртэл батлуулж чадаагүй байгаа “Бүсийн нэмэгдлийн тухай” хуулийг УИХ-аар хэлэлцүүлж батлуулах

Өмнөх бодлогын баримт бичигт боловсрол, эрүүл мэнд, нийгмийн даатгал, хүн амын өсөлт, шилжилт хөдөлгөөн бага зэрэг тусгагдсан боловч нийгмийн халамж, жендерийн асуудлын талаар тусгагдаагүй байна.

Ашигласан материал

1. АХБ “Skills for employment” төслийн тайлан 2017 он
2. Дорноговь аймгийн хөгжлийн мастер төлөвлөгөө (2011-2021)
3. Дорноговь аймгийн засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
4. Дорноговь аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
5. Өмнөговь аймгийн хөгжлийн хөтөлбөр (2010-2020)
6. Өмнөговь аймгийн засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
7. Өмнөговь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэл
8. Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр (2018-2028)
9. Дундговь аймгийн засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
10. Дундговь аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэл
11. Говьсүмбэр аймгийн хөгжлийн цогц бодлого (2010-2021)
12. Аймгийн засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
13. Говьсүмбэр аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэл
14. Говийн 4 аймгийн сумдын хөгжлийн бодлогын баримт бичгүүд
15. www.legalinfo.mn эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем

Хавсралт 1. Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн бодлогын баримт бичиг

№	Хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримт бичгийн төрөл	Батлагдсан огноо, дугаар	Баталсан субъект	Хүчин төгөлдөр эсэх
1	Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал үндэсний хөтөлбөр	1998-2008	Дунд	1998-07-29, 130	ЗГ	Үгүй
2	Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	1998-2003	Дунд	1998, 41	ЗГ	Үгүй
3	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр	2002-2005 2006-2010	Дунд	2002, 92	ЗГ	Үгүй
4	Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр		Урт	2003-10-24, 41	УИХ	Үгүй
5	Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр	2007-2008 2009-2012 2013-2015	Дунд	2006-11-21, 282	ЗГ	Үгүй
6	“Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөр	2006-2008	Дунд	2006-04-26, 91	ЗГ	Үгүй
7	Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого	2006-2008 2009-2011 2012-2015	Дунд	2006-01-05, 01	УИХ	Үгүй
8	Төрөөс малчдын талаар баримтлах бодлого	2009-2015	Дунд	2009-06-04, 39	УИХ	Үгүй
9	Хүүхдийн хөдөлмөрийн гэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр	2012-2013 2014-2016	Дунд	2011, 303	УИХ	Үгүй
10	“Ажилтай, орлоготой монгол хүн” үндэсний хөтөлбөр	2013-2016	Дунд	2013-04-27, 154	ЗГ	Үгүй
11	Монгол улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого	2013-2018	Дунд	2003, 16	УИХ	Үгүй
12	Эдийн засгийг сэргээх хөтөлбөр	2017-2018	Дунд	2016-11-24, 71	УИХ	Үгүй
13	“Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр	2014-2017 2018-2020	Дунд	2013, 416	ЗГ	Тийм
14	Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого 2015-2030	2015-2030	Урт	2015-06-16, 53	УИХ	Тийм
15	Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	2016-2020 2021-2025 2026-2030	Урт	2016-02-05, 19	УИХ	Тийм
16	Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр	2016-2020	Дунд	2016-02-04, 16	ЗГ	Тийм
17	Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	2016 2017-2019 2019-2021	Дунд	2016-06-06, 304	ЗГ	Тийм
18	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого	2016-2020 2021-2025	Дунд	2016-06-13, 320	ЗГ	Тийм
19	Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр	2016-2025	Дунд	2015-11-16, 447	ЗГ	Тийм

20	Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2016-2020	Дунд	2016-09-09, 45	УИХ	Тийм
21	Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого	2016-2025	Дунд	2016-05-16, 261	ЗГ	Тийм
22	Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр	2017-2021	Дунд	2017-04-26, 129	ЗГ	Тийм
23	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 5 дахь хөтөлбөр	2017-2020	Дунд	2017, 243	ЗГ	Тийм
24	Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр	2017-2021	Дунд	2017-09-20, 270	ЗГ	Тийм
25	Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр	2018-2021	Дунд	2018-06-27, 02	ЗГ	Тийм
26	Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр	2018-2021	Дунд	2018-05-23, 140	ЗГ	Тийм
27	“Үйлдвэржилт 21_100” үндэсний хөтөлбөр	2018-2021	Дунд	2018-01-31, 36	ЗГ	Тийм
28	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр	2018-2022	Дунд	2017-11-29, 321	ЗГ	Тийм

Хавсралт 2. Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн бодлогын баримт бичигт байршлыг тодотгосон байдал

№	Хөтөлбөр, бодлогын баримт бичиг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримт бичгийн төрөл	Байршлыг тодотгосон эсэх
1	Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал үндэсний хөтөлбөр	1998-2008	Дунд	Үгүй
2	Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	1998-2003	Дунд	Үгүй
3	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр	2002-2005 2006-2010	Дунд	Үгүй
4	Монгол улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр		Урт	Үгүй
5	Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр	2007-2008 2009-2012 2013-2015	Дунд	Үгүй
6	“Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөр	2006-2008	Дунд	Үгүй
7	Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого	2006-2008 2009-2011 2012-2015	Дунд	Үгүй
8	Төрөөс малчдын талаар баримтлах бодлого	2009-2015	Дунд	Үгүй
9	Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах үндэсний хөтөлбөр	2012-2013 2014-2016	Дунд	Үгүй
10	“Ажилтай, орлоготой монгол хүн” үндэсний хөтөлбөр	2013-2016	Дунд	Үгүй
11	Монгол улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого	2013-2018	Дунд	Үгүй
12	Эдийн засгийг сэргээх хөтөлбөр	2017-2018	Дунд	Үгүй
13	“Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр	2014-2017 2018-2020	Дунд	Үгүй
14	Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого 2015-2030	2015-2030	Урт	Үгүй
15	Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	2016-2020 2021-2025 2026-2030	Урт	Үгүй
16	Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр	2016-2020	Дунд	Үгүй
17	Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	2016 2017-2019 2019-2021	Дунд	Үгүй
18	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого	2016-2020 2021-2025	Дунд	Үгүй
19	Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр	2016-2025	Дунд	Үгүй
20	Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2016-2020	Дунд	Үгүй
21	Монгол улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого	2016-2025	Дунд	Үгүй
22	Жендерийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр	2017-2021	Дунд	Үгүй
23	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 5 дахь хөтөлбөр	2017-2020	Дунд	Үгүй
24	Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр	2017-2021	Дунд	Үгүй
25	Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр	2018-2021	Дунд	Үгүй
26	Монгол улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр	2018-2021	Дунд	Үгүй
27	“Үйлдвэржилт 21_100” үндэсний хөтөлбөр	2018-2021	Дунд	Үгүй
28	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр	2018-2022	Дунд	Үгүй

Хавсралт 3. Нийгмийн хамгааллын салбарын хууль эрх зүйн баримт бичгийн жагсаалт

№	Хууль	Батлагдсан он	Нэмэлт өөрчлөлт	Баталсан субъект
1	Ахмад настны тухай/Шинэчилсэн найруулга/	2017-01-26		УИХ
2	Гэр бүлийн тухай	1999-06-11	2018-06-21	УИХ
3	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай	2016-12-22	2017-12-21	УИХ
4	Хүүхдийн эрхийн тухай	2016-02-05		УИХ
5	Хүүхэд хамгааллын тухай	2016-02-05	2018-06-27	УИХ
6	Хүүхэд харах үйлчилгээний тухай	2015-07-02	2017-11-10	УИХ
7	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай	2017-05-18		УИХ
8	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай	2016-02-05	2016-11-10	УИХ
9	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай	2011-02-02	2017-02-09	УИХ
10	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай /Шинэчилсэн найруулга/	2011-06-17	2017-02-02	УИХ
11	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай/ Шинэчилсэн найруулга/	2009-02-13	2017-12-21	УИХ
12	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай	2001-04-12	2017-02-02	УИХ
13	Хөдөлмөрийн тухай	1999-05-14	2017-04-21	УИХ
14	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай	2008-05-22	2018-06-27	УИХ
15	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай	2010-04-16	2015-12-04	УИХ
16	Ажлын таван өдөртэй долоо хоногт шилжүүлэх тухай	1997-12-04		УИХ
17	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай	2003-12-18	2016-11-08	УИХ
18	Нийгмийн даатгалын тухай	1994-05-31	2018-06-27	УИХ
19	Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай	2012-09-04		УИХ
20	Ирээдүйн тэтгэврийн нөөц сангийн тухай	2016-01-22	2018-11-02	УИХ
21	Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай	1994-07-05	2015-01-30	УИХ
22	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай	1994-06-07	2018-11-02	УИХ
23	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай	1999-06-10	2015-05-14	УИХ
24	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай	1994-06-07	2015-01-30	УИХ
25	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай	1997-01-16	2018-02-02	УИХ
26	Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай	2017-02-02	2018-11-02	УИХ
27	Нийгмийн халамжийн тухай/Шинэчилсэн найруулга/	2012-01-19	2018-06-27	УИХ
28	Алдар цолтон ахмад настанд төрөөс нэмэгдэл, хөнгөлөлт олгох тухай	2017-02-02		УИХ
29	Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай	2010-06-25	2011-05-27	УИХ
30	Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай	2017-06-30		УИХ
31	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай	1994-06-13	2018-10-19	УИХ
32	Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай	2002-11-21		УИХ
33	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай	2005-12-08	2013-02-07	УИХ

